


Д. ПҮРЭВДОРЖ

БИДНИЙ
МОНГОЛЧУУД



БОР
ТЭРШИЙНЭ
БОТӨ

Бор гэрийн богд

Зохиолч: Д.Пүрэвдорж

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Бор гэрийн богд

(Эмзэглэл, эрэгцүүлэл)

“Угтал” хэмээх ацаг бүлэг

Нэг. “Би”

Батмөнх даян хааны отгон хөвүүн Гэрсэнз жалайр хунтайжаас угсаалсан Түшээт хаан Чахундоржийн хүү Байнжуурдоржид Манжийн хаан хошуу хишиглэснээс тооцвоос Далай гүний хошууны аравдах ноён Алтанхуягийн албат дор хүйлсэн нь миний “Би”. Хүмүүн далайн бичил нэгэн дусал энэхүү “Би”-г нутгийн санваартан Дансран гэлэн гуай “Пүрэвдорж” хэмээн Түвд судраас сугалан оноожээ. Энэ нь “Гадас чулуу гариг” гэж болохоор гэж төвдөч нар тайлдаг. Хэрэв өөр нэгэн хэлтгий захтан таарсан бол энэ нэр ондоосох байсан биз. Ингэхээр нэр гэдэг бол хэн нэгэн “би”-гийн дуудлага оноол аж.

Нэгэн сурвалжлагч надаас миний өөрийн хэн болохыг хэлүүлэх гэхэд “Би өөрийгөө таниагүй л явна” гэж өжүүлснээ санаж байна. Оргүй юм огт биш ээ.

Хорьдугаар зуунд ангийн дайсан арай болчихолгүй сэжигтнээр үлдсэн маань зөвхөн сохор азын тохиол бус “хулхи коммунист” явсны хугацал болов уу. Гэтэл миний шүүрхийг гайхаж, шүүсийг шахаж явсан “Жинхэнүүд” өнөөдөр өнгө гуужааж “бид коммунист байгаагүй” гэж тас гүрийгээд өөрсдийгөө бараг л ардчиллын аав гэх болов. Арай ч дээ. Хөрвөөж болох чиг хөрсөө эргүүлж болдоггүй” гэдэгсэн бус уу.

1961 онд хойд намын “суртлын атмаан” Михаил Суслов “Монголын коммунистууд” хэмээн адилсхахад алгаа самбайртал ташиж, амьд яваагийн бахыг хангаж л байсан даа. 1965 онд Леонид Брежнев Цэдэнбалд “олон улсын коммунист хөдөлгөөний гарамгай зүтгэлтний” сахил хүртээхэд улайстлаа уухайлаад л байсан. Намынхаа их хурлыг “монголын коммунистуудын дээд чуулга” гэж байснаа мартчихдаг юм байх даа. Ингээд бодоход бурхан болооч Цэ дарга бүтэн, би хугас коммунист болж таарах нээ. Цаг төрийн үймээнд цагаан ч болдог, улаан ч болдог улс төрийн урлаг гээч нь юм байлгүй дээ. Харин би марксист байгаагүй. Марксын сургаалыг судлаа ч үгүй, ухаарааа ч үгүй. Манай “ил” марксистуудаас чухам хэн гуай нь ном нэвтэлсэн юм бол? Намын сургуулийн багш Камбаар, орчуулагч Бүрэнгийн Бирваа хоёр л “капитал”-ыг бүрэн уншсан гэлцэх юм билээ.

Шинэ цагт гэвэл би хөрөнгөтний газар зорчиж насанд хүрэгсэдийн бүлгэмд суугаагүй болохоор харийн дээлийн хуулга нөмөргөх гэвэл ярдаглана. Даяаршил руу хоёр нүд тас аньж хоршооны хонь шиг туулгахгүй гэж би хэгжүүрхэнэ. Бид чинь морьтон хөөдөг нохой шиг дагаж далбаганаад халширлаа шүү дээ. Орос нударган хэмээх нь манайд хар шар феодал гээч дээр тусч модыг нь бариулсан. Хамтрал нь хазгай хэлээр “хомуун” болж малчдын малын хишгээр махан овоо босгосон, ангийн дайсныг илрүүлж байгаа нь энэ гээд ард түмнээсээ аймаглан устгасан. Бурхан номоо шатааж, сүм дуганаа түлсэн, намын эсрэг бүлэг гээчийг нам цохиж, америкийн империализмыг амаар сөнөөсөн гээд салхи залгиж, сархинагны салбан болсныг тоолшгүй ээ.

Социалист орнуудтай ойртон нягтрах гэж нэгэн үе баахан дүрэмдсэнийг би мэднэ. Дэлхийгээс хаяа ханзлах гэсэн дэврүүн санаархал байлаа. Одоо даяаршил гээд даган дарвиж байна. Даяаршил нь бүдүүн тоймоор хэлбэл “хавтгайдаа” гэсэн буюу хуучнаар бол “Танай манай хамаагүй, тамхи байна уу таваарш аа” гэдэг шиг өнгө бий. Үүний наана нь айлсал, цаана нь үндэстний үгүйтгэлийн урхаг буйд хорвоод бас цөөнгүй хүн цэрвэж байнам бус уу? Тиймээс би солонго хөөсөн хүүхэд шиг гуяа алгадаж гүйхгүй. Энэ бол “Би” бүхнээс ухаарал нэхэх алхам байх учиртай.

Урхил бол улс төрийн байна уу, эдийн засгийн гэнэ үү хоолой холгоно шүү дээ. Коммунистууд бүх хүний “Би”-г нэгэн хэвэнд цутгаж аж төрөх ёс, зорилго, хүсэл, мөрөөдөл, сэтгэлгээг тумлайдах гэж оролдсон. Хүмүүсийн “Би”-г нь бүрэлгэж хүүхэлдэй болгох гэсэн хүчирхийлэл. Хүүхэлдэйгээр яаж ч тоглож болно. Тэр байтугай мөчлөөд хаяж ч болно шүү дээ. Загвар өмсөгч байж болох чиг өөрөө загвар байвал өлгүүр л болно

...Монголдоо

Монгол байж

Үндсэрхэж

Ясархаж

Цусархаж

Амь сүнс хоёроо би

Алдуурахааргүй уяж

Аргамжаанд чинь хатнаа

Эрх орон минь! гэсэн мөр надад бий.

Эх орон гэдэг хийсвэр үг гэж айлдах нь сонсдох болов. Юутай мулгуурал вэ. Үндэсний “Би” бол амьсгалах агаар, уух ус, гишгэх газар буюу бичил орон зайн орчинд төрдөг. Тэгвэл “би”-нүүдийн нийлбэрийг ард түмэн, төрсөн тоонотын нэгдсэн орон зайг эх орон гэж ухаарах учиртай. “Би”-гээс “Би” уламжилдаг тэрхүү мөнхийн хэлхээнд эх орон оршдог. Тэгэхээр эх орон бол хийсвэрлэл гэж буй хүн өөрөө хий үзэгдэл. Ямар ч атугай их хааны айлдсанаар “итгэж болохгүй” нэгэн. Нүд далд болгохгүй гэхэд нүүр өгч болохгүй.

Монгол эх орон гэдэг санаагаа морьтой ч, явган ч зүрхэндээ би тээж, кобвой бүрх, тааран гуявч, өдөн хүрэмний шүншиг төдий болж өрөөлийн үгээр өөрийн бодлыг үрэн таран хийхгүй. Үүгээрээ би үндэсний ардчилсан үзэлтнүүдийн тоосонд багтана. Харин миний “Би”-гийн бусад чанар нь хуучин шинийн хугалбар агаад эвлэрэл тэрслийн эрхшээлд элэгдсэн, цагийн хүрдний тохуурхал л болжээ.

Миний мөлхөж гэтэлсэн хорьдугаар зуунд “Би”-гийн дээр тэнгэр бус нам байсан. Иргэний цорын ганц шалгуур нь намд хязгааргүй үнэнч байх, үгүй ядахдаа үнэнч юм шиг харагдах

хүлцэнгүйрэл байв. Үргэдэггүй л бол үхэр адуу нь хамаагүй намч, зарчимч, шударга, үнэнч боловсон хүчин гэгдэж ширээ тэврэнэ. Ийнхүү иргэний зориг нь ишигний эвэргүй костюмтай “номгочуулын” бүхэл бүтэн үеийн царцаамал буй болсон. Миний “Би” энэ дотор живсэн шаар төдийгөөс хэтрээгүй. Хөвсөн нэг нь хөлөө тушуулж хэлээ зангидуулж бэртэгчин, буртагчингийн дөнгө зүүж амьдралын ёроол руу шидүүлсэн. Тэрхүү ёроолын цаг хугацаагүй мэт харанхуйд орчин нь тамлага, хяхлага, цөллөг, шорон, егүүтгэл. Үүнээс бүлхэлзэж миний “би” аймхай мөгөөрс болж амиа хоохойлохын хоргонд өөрийгөө хорьсон нь өмөөрөл үгүй ээ.

Хэн нэгний “би” бол, овог, удам, зүс, араншин, үзэл, зорилго, намтар төөрөг, эхлэл, төгсгөлийг агуулсан өөрийн “гэрлэн гүнгэрваа” бүхий бодгал, оршин тогтнол мөн. Улс үндэстний бие даасан энэхүү бичил цөмийн хэлхээс нь бид юм. Гэтэл “Ард түмэн та нар төрийн эзэн” гэж мөгдорлоод гэрийн тэжээмэл амьтан болгодог нь дарангуйллын башир заль мөн. Бидний “би” явах газар хүрээтэй, хэлэх үг хэмжээтэй, малгайгаа байтугай толгойгоо өгөхдөө “мандтугай” гэж хашгирах ёстой байлаа. Олон хүн ийм лоозонтой буудуулсан. Харин Архангай аймгийн дарга асан Буянтогтох гэдэг хүн “мандтугай” дээрээ “улаан яргачин, махчин Чойбалсан сөнөтүгэй” гэж хашгираад буудуулсныг би хэрхэн мэдэхсэн билээ.

...Түүхт ялалт дотоод яамандаа

Түүний удирдагч Чойбалсан та

Төр засгаа бататгасныг чинь

Ай түмэн арууд чинь хүрээлээд байнаа.

гэсэн дуурхуу юм гонгинож байснаас цаашгүй. Олон хүн хууртаж гэмээн оорцог хүний онгуу боол больюу. Бараа сураггүй коммунизмыг “харчихлаа” гэж, байгуулаагүй социализмыг “барьчихлаа” гэж хуурмаглах нь иргэний үүрэг байв даа. Худлыг мянга давтахад үнэн болдог гэгцгээх юм. Бид тэрбумаар давтсан. Тэгэвч үнэн болоогүй. Ийнхүү бид итгэл алдсан. Итгэлгүй амьд явах нь сүүдэртэй сүг гэсэн үг. Хүчирхийлэл, дарангуйллын хар балгийн нэг нь энэ лавтайяа мөн. Энэ яваа нас үнэгүй, эргэж төрөх мөргүй, олдсоноо хивж, орон дээр хөрхийн жаргал гэж юусан билээ.

Итгэлээ алдсан хүний амьдралын утга учир, үнэ цэн аягатай хоолонд нь багтдаг. Санах сэрэх нь түүнд лай бөгөөд сажлах нь дээд хурд болдог. Эрхий хуруугаа хазаад ч энэ минийх гэж тэр үнэмшихгүй. Гунигт үгүйрэл шүү! Иймээс бид төр хойморлосон хэн бүхэнд хандаж, түмэн буянд булхуулахаа байг гэхэд, иргэнийхээ итгэлийг хулууж, ирээдүйг нь бүү сохол! гэж тулган шаардах эрхтэй. Эс дагаваас морилон тонилмуу хэмээн эелдэгхэнээр, тэгэхдээ элдэв өчгийн нэхэлгүйгээр тэдэнд айлтгаж сурья.

Нангиадын түүхэнд Хүннү нарыг хэрцгий боол гэж хорсон тэмдэглэсэн гэдэг. Монголын шинэ үе номхон боол байж чадахгүй. Харин бид хулчгар, худалч, итгэлгүйн олдмол гурван муу өвчнөө тэдэнд халдаалгүй, хойч үеэ дархлаатай болгох юмсан.

Миний өчүүхэн “би” дотуур, хувьсгал завхрал, хуурай гүжир, шорон, дарга бурханчлахын

бузар, дайсанд тохоон нөхдөө яргалсан хядлагаанхны эмнэлэг, сургууль, атрын будаа, алтан үеийнхэн, архагшсан дарангуйлалын булай, алдарсан эрх чөлөө, ардчилалын ялалт цөм л аймшиг, цөхрөл, нулимс инээдээр нэвтрэн гарлаа. Түүгээр ч үл барам хорвоогийн түгшил, түйвээл ч тойрсонгүй. Аврорын домог, Ильичийн тачигнал, Сталины тамлал, Черчилийн ихэмсэл, Хитлерийн тахал, дайны түймэр, цөмийн хяравас, Хрущевийн гүлгэрэл, Брежневийн гөлрөл, Кеннедийн үхэл, Мао-гийн моншрол, Горбачевын сэнсрэл, Клинтонь сээтэгнэл, Садам Хусений сагуурал, Бин Ледены сүйтгэл цөм л гайхшруулж гамшиглаж өнгөрлөө.

Хүмүүн төрөлхтний бүлд хөл толгой хөшиж яваа цагт үл өртөх “Би” үгүй бөгөөд гадаад дотоодын хоймсон нөлөөнд хомроготой. Энэ бүхэнд миний өөрийн “би” төөрсөн учир таних танаггүй болжээ.

Бидний үеийнхний “Би” хэмээх нь ийнхүү шинэчлэл хуучрал, урагшлаа, ухраа, өшил хясал, оноо осол, ордон гяндан, цэцэрхэл солиорол, бадрал гансрал, бүтээн байгуулалт бас бүрэлгэл ажаам.

Дэлхийг тив алгасан хувьчилсан Зөвлөлтийн эзэнт гүрэн задрана чинээ бид санаагүй. Цул ган л гээд байсан...

Дээлтэйгээ гүйгээд хүрчихнэ гэж байсан социализмын сүйрлийг бид таагаагүй. Хаалга нь онгорхой байна, ор л гээд байсан... “Манай наран” Сталин, “Чимэг болон хайрлагдсан Чойбалсангийн мутар цустайг хараагүй. Бидэнд харуулаагүй. Энэ хэр багцаагаар 20474 иргэний голыг гогодсон гэдгийг бид мэдээгүй. Мэдүүлээгүй. Энэ тоо эцсийнх бишээ. 2002 онд Хамбын овооноос илэрсэн булшинд хагас дутуухан тоогоор зургаан зуугаад хүн хядуулсан нь “До” яамны архивг ороогүй байв. Гэтэл ийм ил далд үхээр хэдийг хэлэх аргагүй. Сураггүй гэх нь хэд билээ. Ингээд багцаалахад тавин мянга дөхөх вий. Зүрх зүссэн тоо.

Гарамгай удирдагч Цэдэнбал маань тусгаар тогтнолоо наймаацах элдэв навтрага үзэглэж суусан гэж бодоогүй. Зөвхөн Давст уул бус 7000 ам км газрыг эх орны минь цогцноос өмлөн Оросод сөхөрсөн юм билээ. Тэгээд бүр сайд Аварзэдийг шавдуулж “Өг. өг. Наад газрыг чинь бүр дээр үед хичээнгүй сайд Цэрэндоржийн үед Зөвлөлтөд өгөхөөр тохирчихсон юм шүү дээ. Чи зүгээр л гарын үсгээ зур” гэж байжээ. (Го.Аким. Эр хур харцгын дууль”) Үүнийг бид мэдээгүй, мэдүүлээгүй. Энэ явдалд большевикуудын эрээ цээргүй дээрэлхэл, оросын шовинизм хаяа хадарсныг үгүйсгэхгүй. Тэртээ 1912 онд орос-монголын хэлэлцээрийн үед цагаан хаант оросын гадаад явдлын яамны сайд С.Сазанов монголчуудыг “...тэвчишгүй зэрлэгүүд” гэж зүхэж байсан тухай зараал элч асан И.Коростовец “Чингис хаанаас Зөвлөлт улс хүртэл” номдоо бичжээ. Тэрвээр Монголын тусгаар тогтнолын тухай томъёололтой манай талын гэрээний төслийг ширээн дээрээс шүүрч шалан дээр хаяж байснаа ч нуусангүй. Ам дамжсан яриагаар дэвссэн гэх боловч арай зөөлрүүлж бичсэн байж магадгүй. Тэгвэл “улаан хааны” сайд асан В.Молотов Монголын сайд С.Аварзэдэд “Алга дарамхан газраас юунд зууралдаад байгаа юм бэ. Танай орон чинь бүхлээрээ манайх байж байх тийм үе байсан юм чинь...” хэмээн сүрдүүлж байсан эл хоёр тулгаас сайхь гүрний төрийн төмөр авдарт нэгэн үзүүр холбоотой. Ийнхүү хүчинд автсан байлаа чиг бүх ард түмний “Бид”-ийн орон зайнаас “ганц би” дур мэдэн харьд ханзлаж өгснийг зөвтгөх эрх надад байхгүй.

Хилийн завсар дахь эзэнгүй зурвас газрыг авья хэмээсэн Дүнхүүгийн элчид хэрхэн

хариулахыг Модун Шаньюй түшмэлүүдтэйгээ зөвлөлдөөд зөвшөөсөнд нь хандан “Газар бол улсын үндэс суурь мөн билээ. Түүнийг бусдад өгч яахин болох вэ” хэмээн хилэгнээд толгойг нь авсан гэдэг. Эх нутгийн ширхэг шороо амины үнэтэйг их эрт дээдэс минь сануулсан юм билээ. Гэтэл манайхан нутгаа өгснийг нь хөшөө дурсгал босгон өргөмжилж, өгөхгүй гэж тэмцсэн сайдаа хөсөр хаясан нь шударга ёс уу? Энэ асуултад эх оронч та хариулаарай.

1992 онд Б.Сумъяагийн эрхлэн хэвлүүлсэн “Гэрэл сүүдэр” (Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс) номыг хэзээ хойно сөхөхдөө би балмагдсан шүү.

1953 онд Сталиныг нутаглуулахаар Ю.Цэдэнбалыг очиход В.М.Молотов хүлээн авч тэдний хооронд ийм яриа болжээ. –”Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот улстай нэгдэх гэсэн асуудлын тань талаар тантай ярихыг надад даалгасан юм. Танай энэ шийдвэр бол бүдүүлэг алдаа юм. Одоо цаг нь бишээ. ...Олон улсын байдлыг та нар мэдэж байгаа шүү дээ. Зөвлөлтийн империализмын тухай дахиад л ярих болно. Энэ шийдвэрээ цуцлах хэрэгтэй...”

Цэдэнбал хэлсэн нь: Шийдвэрээ цуцалъя... гэв. Энэ бол гарын тэмдэглэл. Эрэгцүүлье л дээ.

Энд “цуцалъя” гэсэн үгийн чанд шийдвэр гаргасан нь тод байна. Хэн? Эл цуцалсан шийдвэрийг ам бичгийн алинаар гаргасан болон өдгөө хаа ч юм бэ, хав дараастай, эсхүл тухайн цагт устгасан эсэх нь үл мэдэгдэнэ. Ямар ч атугай энэ удаад их гүрний хүчинд автаагүй, хүсэж гуйсан нь илт байна. Нэгэн цагийн ОХУ-ын ерөнхийлөгчийн улс төрийн хэлмэгдэгсдийг цагаатгах комиссын дарга А.Н.Яковлев, Москва дахь монголын радиогийн сурвалжлагчийн асуултанд “Танай намын улс төрийн товчооны гишүүдийн дийлэнх нь КГБ-ийн туршуулууд байсан гэдгийг итгэлтэй хэлж чадна” гэжээ. Тийн ахул ийм шийдвэр гаргасанд нь гайхашгүйн зэрэгцээ, дэндүү их юм мэдэж байсан гэрчүүдээ тэд эмнэлгийн нэртэй эрлэгийн ширээнд цаазаар аваачсан буй за.

Ард түмнээс далдуур голомтыг нь самрах гэсэн дээдсийн хуйвалдааныг гутамшиг гэхэд ч гоёдоод байна. Үүнтэй холбоотойгоор прокурор Жамбалдоржийн нэр гардаг ч тэрвээр нэгдүгээр хүн байгаагүй. Ганцаараа шийдсэн гэвээс зөвхөн түүнд л хариу өгөх ёстой. Тэгвэл “тэд” хэмээх бүлэгт багтах арван харын чандын нүгэлтнүүд хөх туурганд сүүдэр байтугай сүнс багтах гэж үү. Үүнийг бодохул 1653 онд түрүү урвалгын шанд Манжийн хаанаас засаг чин вангийн хэргэмийг мөлхөж тоссон Түшээд хан Гомбодоржийн хүү Бунтар сүүдэгнэж гол хөрөөдөөд байгаа юм. Би энд бүрлээч даргыг харлуулах гэсэн нь бус, ах дүүгийн найрамдал, пролетарийн интернационализм мэт сурталд автаж, харийн эрхэнд монгол “Би”-гээ бүрэлгүүлсэн үйлийн үрийг нь үнэний мөрөөр нэхэхдээ хойч үеийнхэнд ухаарлын унацыг нь бодсон болой.

Ю.Цэдэнбал, 1973 оноос мартамхай болсон, бүр арав, арван таван минутын өмнө бодож байснаа мартчихдаг болсон тухайгаа бичиж үлдээжээ. Ийм болтол нь түүнийг улсын толгойд дархлан талхалсан нь ард түмний бус албан тушаалын албин бялдуучдын балаг шүү дээ. Тэд түүнд ард түмний “аугаа их хүү” хэмээн өргөмжлөл өмсгөж, түүнд хайртайдаа бус өөрсдийгөө өлгийдөхийн тулд үнэн мөний сэжүүрээс цухуйлгах гэсэн бүхнийг үзэл суртлын “үхэр буугаар” буудаж, олон сайхан аавын хүүгийн “Би” заяаг хугалсан шүү дээ. Тэр байтугай 1956 онд МУИС-ийн оюутан Ховдын Чойжамцыг Цэдэнбал даргыг өвдлөө гэж зүүдэлснийх нь төлөө бусдын ховоор найман жилийн хорих ялаар шийтгэсэн бөгөөд сайхь Чойжамц

гутарч гуниад үхсэн тухай Ц.Дамдинсүрэн гуай 1962 оны тавдугаар сарын найманд МАХН-ын Төв хорооны улс төрийн товчоо зохиолчдыг хүлээн авахад улаан нүүрэн дээр нь хэлж байсныг санаж байна. Хэрэв “үхэж” хэмээн зүүдэлсэн бол буудах байж л дээ. Энэ бол Цэ даргын даалгавар бус “бялдуучдын хүрээлэн”-гийн зулаггүй зусар. Монгол хүн зэвүүцэхээрээ “эзнээ алд” гэдэг. Энэ бол “Би”-гээ алдагдсдыг халгасан хараал. Чухамхүү тийм эзнээ алдагсад л Цэдэнбалын хормой дор хоргодон алдрын хоосон цууриагаар хөөрөгдөн ард түмний гарамгай удирдагч, академич, маршал, баатар мэтийг овоолсоор улаан ахынхаа урт саварт базуулан академич Чазовын тариагаар балайруулан орос хайрцагт таглаж монгол шороонд гудрах замыг шулуутгасан бус уу. Эргүү түшмэлүүд эзнээ хөнөөдөг хойно доо. Эгдүүцэл нэмэхэд оросын улаан хаан Монгол улсын ерөнхий сайд “Монгол би” Бодоо, Гэндэн, Амар болон лам хар үй олныг улайдан хөнөөсөн нь цагаатгашгүй гэмт хэрэг бус уу. Аймшигт хэлмэгдлийн ард улаан тахар Э.Ринчино, Я.Блюмкин, И.Вакунаеваас эхлээд мэргэжлийн алуурчин Фриновский, Ежов, Берия, бүр Сталиныг хүртэл мангасын махны машины хүрдэн хутгыг эргүүлсэн яргачдын хэлхээ байсныг бид мэдээгүй. Тэр байтугай харийн чоно дагасан гэрийн нохдоо хоймортоо тахиж алтан ургийн цусаар тэжээж байснаа мэдээгүй.

1935 оны арван хоёрдугаар сарын 30-нд Сталин нар монголын төлөөлөгч Гэндэн, Дэמיד, Намсрай нартай уулзахдаа,

-Нөхөр Гэндэн Намсрай нараа. Та нарт лам нартай тэмцэх дур хүсэл алга байна. Идэх л юм бол арааныхаа шүлсийг гоожтол идэх хэрэгтэй...” гэж ташуурджээ. Тэр ёсоор арааны шүлс байтугай цусыг цувтал хивсэн юм билээ. Гэтэл өчнөөн хүний амь нас өнчин ишигний нэхэлгүй өнгөрөх ёстой юм гэнэ үү?

Эрдэмтэн Майский монголын хүрээ хийдийн эд баялагийг Аляскийн болон Алеутын хойгийн үнийн нийлбэрээс дээгүүр тавьсан баримт бий. 1923-89 онд Монголоос Зөвлөлтөд 5,5 сая үхэр 76 сая хонь ямаа нийлүүлсэн тухай эрдэмтэн Д.Сүрэнжав дурдсан нь бий. Үүн дээр уул уурхайн баялаг, Мардайн ураныг нэмээд газар нутаг хүн ардын амь амьдралын хохирлыг улаан даавуугаар бүтээж “Найрамдал дружба” гэж бичээд түүхийн түнэрт мартах ёстой юм уу?

...Ховдог японы дээрэмчид

Хуучин феодалын үлдэгдэл

Хувалзан харгис лам нарын

Хутга мэсийг илрүүлвээ...

гэж Улаанбулангийн тайзнаас улиглаж байсан дуу устгалын гайхуулал байж л дээ.

Бидний хувьд энэ бүхнийг харах нүд бүрхээстэй, сонсох чих бөглөөстэй, бодох ухаанд суртал чихээстэй “Би” маань битүү чанасан толгой байжээ. Ийнхүү бидний “Би” балгас болсон юм чинь элэнцэгний нь улсын эзэн, төрийн эрхийг барьсан ард байхав дээ. Өөрийн “Би” үгүйдсэн цагт утсан чинээ улаан гол байтугай улс гэрийн гал унтрахдаа тулдгийг эрх чөлөөнд

хөлчүүрэнхэн яваа энэ цагт санах сэрэхийн хонх болгон чих бүхэнд уях юмсан.

Улс орны явайгүй байгааг удирдлагын сэлгээнд сэхээрсэн төдийд л дээрээс дэглэхэд дороос “Бидний дунд нам ард түмний дайсанд байр байхгүй” гэж егүүтгэлийг дэвэргэн найрал бахираан болдог байсан нь юутай мунхаглал вэ. Сэхээрэгсдийг тамласан нь байтугай тавласан нь одон туузалж, олбог зузаалаа биз дээ.

...Гуутай бурхан

Буутай чөтгөрүүд...

Коммунист ахтайгаа улангасан ард түмний минь цусаар Азийн цээжийг намагласныг өмгөөлөх бус өдөр бүр ясаа янгинаан яллан санах, сануулах учиртай. Эр нөхрөө хилсээр буудуулсан эх хүний энгэр рүү урссан нулимс хөхний нь сүүг ээдээж эцэггүй үрээ амлуулж байсныг хүлцэн тэвчигч бүхэн алсын хань бишээ.

Хэлмэгдэл! Энэ бүхний тоогоор эх орон уйлж, эзэн цагаан сүлд дальдарсан юм шүү! Өнөөдөр ч гэсэн гав хангинуулагсад “Ганц худагийн” цаана хоёр худаг ухах гэж заналхийлж байгааг бид хараад л сууж байна. Суудал таргадах гэж үг бий. Эзнээ олоогүй бууны сум нь энгүүн яваагийн зүрхэнд тусдгийг мэдмээрсэн дээ.

Хэлмэгдлийн тухай үг цухуйлгахаар улирсан баларсан юм ухаж төнхлөө гэж өөрт нь ял тулгах гээд байгаа юм шиг урваганах хүн тааралддаг. Уг нь өнөө үеийнхэнд нүгэл үүрүүлэх нь бус өмгөөлөгч байх гэж тэд мугуйдлаад хүмүүсийн зүрхийг хөргөөд байгаа юм. Цаг төрийн гамшиг дайрах аваас ийм хүмүүс цагаан гартай байна гэж үрэгдээчдийн үр удам үнэмшиж чадахгүй. Хөнөөдөгөөс гадна “инээдэг” дайсныг ч бүү мартъя. Өөрийн үндэсний “Би”-г өмгөөлөе, хамгаалъя, хадгалая хүмүүс ээ!

1956 онд “Миний хүү, намдаа санал бодлоо илэн далангүй хэл дээ. Яах ч үгүй” гэж ам мэх хийгээд “Сэхээтний төөрөгдөл” гээч нүх ухаж түлхэн үндэсний “Би”-г сүйтгэсэн.

МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооны 1956 оны 12-р сарын 5-ны өдрийн 413 дугаар тогтоолд нэр заагдсан Ж.Төмөрбаатар, Д.Лхамжав, Ш.Бат-Очир нарыг би танина. Тэд дараад байхаар дайсан байгаагүй, улс орноо хөгжүүлэх чин санаа өвөрлөж сэхээрсэн сэхээтнүүд байсан юм. Тэднийг хожим нь Д.Төмөр-Очирын болон намын эсрэг бүлгийн хамсаатан гэх мэт дөнгө зүүж тарчлаасныг олон хүн гэрчилнэ. Тэр үед санаа бодлоо хэлж асан хожмын нэрт эрдэмтэд Л.Жамсран, Г.Сүхбаатар нарыг хорин дөрвөн жил шүд зуугаад 1980 онд “БНМАУ-ын түүхийн дээж бичиг”, “БНМАУ-ын түүх” номоор нь ял тулгаж залхаан цээрлүүлсэн билээ. Энэ тухай дээр өгүүлсэн “Тэрэл сүүдэр” номд Ю.Цэдэнбалын бичсэн тэмдэглэлд нь “Академийн Жамсран, Төмөр-Очирт Бээжинд үйлчилж байсан. Сүхбаатар мөн адил. Далай Жамсрангийн найз” гэжээ. Дайсныг “олж” холбоо сүлбээгээр ховлон хорлодог улс төрийн энэхүү бузар хонзогнол одоо ч урхагшин өөрөөр бодож сэтгэх гэсэн бүхний нэрэнд хөө түрхсээр л байна.

1964 онд намын эсрэг бүлэг буюу Лоохууз, Нямбуу, Сүрмаажав нарыг болон түүний хань хамсаатан хэмээгсэдийг цусгүй алж, усгүй цөлсөн. Би эднийг сайн танина. Эд нар эсэргүү

байгаагүй. Байхаар ч хүмүүс биш, бие даасан “би”-нүүд л байсан юм. Энэ бүхэн монголын сэхээтнүүдийг “Цогнойгоод ир цохиод өгье” гэсэн далайлга байлаа. Гэвч хүмүүсийн сэтгэлд үндэсний түймрийг хөллүүлсэн билээ.

Олон жил нурмалсан энэ түймэр 1990 оны нар зөв салхинд ардчилсан хувьсгалын дөл болов. Үнэн ийм тул МАХН ардчиллыг үүсгэсэн бус харин цус асгаруулж дараагүйг түүх бичиглэн үлдээнэ.

Ардчилсан хувьсгалаар, хүмүүн чанарын зайгүй болтлоо үзэл сурталжсан “Би”-нүүдийн агуулга хумхирхуйд тэд бурхан царайчлахад нүүр халуун, чөтгөр хүлээхэд амь хайран болсон нь хувь заяаны эмгэнэл. Он цаг ороолон бусгахад хохирол, хожлын холбиролтой аж. Манай ардчилсан хувьсгал хүчирхийлэлийн бус баруун зүгийнхний “хилэн”, “улбар” гээд байгаагийн угтвар загвар болж цусгүй давалсан нь мөнх тэнгэрийн түшил дор монголчуудын байгуулсан гавьяа гэж боддог. Сүүлийн үед “яргуйн” хувьсгал гэж нэрлэх болсон нь зээлдсэн санаа байж мэднэ. Би бол цагаан морины хувьсгал, цас мөсний хувьсгал гэж хэлнэ. Хүмүүсийн сэтгэл зориг булгиж, нийгмийн цэвдгийг хагалсан хилэгнэлийн хүчит тэсрэл улаан цайзыг уулгалсан билээ. Сүхбаатарын талбайд үй түмэн хүний амьсгаа агаарт дэгдэн галт уулын дэлбэрэлийг санагдуулж байсан нь одоо ч, хойшид ч сэтгэлд унтрахгүй ээ.

Ардчилсан хувьсгалаас хойш цаг хугацаа улирсан ч бидний үндэстэн илааршаагүй л байна. Даргамсал, хэргэмсэл, авилгал, баярхал, хувхайрал, золбирол, зэрлэгшил тэнгэрлэг заяанд минь тэрссээр л байгаа нь аюул.

Хөх үндэсний их цогцноос ганц ширхэг “би” тасарваас гарз. Амьд эс эмтрэн унах бүрийд эх орон өвдөнө. Энэ тухай төр, олон нийтийн байгууллагын түмэн амны яншаа чихний чимэг гэхээсээ чийр болжээ. Хоосон үгээр хооллохгүй, худал амлалтаар хувцаслахгүй, яам нэмснээр ядуурал буурахгүй, сайд үржсэнээр сайн засаг бүрдэхгүй. Өөрийн “би”-гээ олоогүй хүн өрөөлийг хөтлөхгүй ээ.

Нэгэн биеийн “би” ину давтагдахгүй орь ганц бөгөөд эмзэг, өртөмгий, буртамхай авай.

Өнөөдөр өчнөөн төчнөөн “Би” эвдэрч, зэвэрч, гэмт хэрэгтэн, авилгачин, архичны хар сүрэг монголыг минь боорложээ. Ховор зэврийн гай, хоноцын орхидосоос болж удам “Би”-г умайд нь хядаж байна. Эмс охидын энгэр мөнгөнд задарч, үндэсний цус булингартаж өмдөөрөө авсан өвчин, дархлааны тахал нүүрлэлээ. Айл гэрт хүүхдүүдийн шуугиан аниршиж гараас нь хөтлөх ганц нэгээс илүүг ад үзэх болжээ. Мах идэхийн тулд малын хорогдол ярихыг би буруутгахгүй. Харин хүнс хэмнэхийн тул хүн цөөлөхтэй эвлэрч чадахгүй. Бид чинь монгол туургатны голомт сахиж суугаа шүү дээ. Эцэг дээдсийн өвлөж үлдээсэн эх нутаг маань эзгүйр ч малгүй, бүлгүй айлууд магтаад байгаа суурьшил руу сул асгаран овоохойлж байна. Энэ бүхэн үндэсний “Би”-д нүүрлэж буй үгүйтгэхийн зуд бус уу?

“Би” хэмээх нь хайр халамж, хамгаалалын гачаалд өртсөөр байвал улсын үндэс хэврэгшихийг үндэстний хувь заяа түгшин өгүүлж байна.

“Би”-гийн тухай эрэгцүүлэхэд гайхах хүн үгүй биз. Монголчууд “дотор хүнтэйгээ ярих” гэж хэлдэг. Энэ нь гаднын өдөл сэдлийг авах, гээхийн алин болохыг өөрийн “Би”-д тунгааж

өөртэйгөө ярьж буй хэрэг. Өөртэйгөө ярьж үнэнийг олохын үлгэрийг үзүүлсэн ганц хүн бол эртний Грекийн гүн ухаантан Платон байсан юм биш. Тэгвэл нийгмийн бурталд үл автан өөрийн “Би”-г эзэгнэх нь хүн бүхний эрмэлзэх нэгэн зүйл мөн.

Хүний эрээн дотроо гэдэг нь дотоод сүүдэр буюу “Би”-гийн хиртлийг хэлсэн санаа. Өнгөөр далдлавч дотрын буртаг үл арилна. Бохир саванд хийвээс сүү ээдэх лугаа буртаг санаанаас булингар л гарна.

Эрхэм та чин шударгаар өөрийн “Би”-гээ өнгийж нэг хараарай. Өөгших гэмшихийн алинд ч өөнтөглөх хэрэггүй. Монголчууд “Би”-гийн бие даахыг “хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зовох”, “Баяныд банхар байхаар барлагийнд жингэр байх”, “Өнөөдөртөө өөрийн бөндгөр мөрөн дээр” гэх буюу “Би”-гийн гэмийг “үйлсээ алдах”, “заяа гүдлэх” зэргээр илэрхийлдэг нь энгүүн агаад гүн ухааны шившлэг ажээ. Өөрийгөө таних өөрийн үндэсний “Би”-г өвтэгш байлгах нь амьдрахуйн цагаан үүд авай.

Өтөл бичээчийн гаслангаар гагцхүү өөрийн “Би”-г өмөөрөөгүй, цагийг үргээж өөрөө үжирсний хувьд “Би”-гийн үзэл бодлоо цагаан цааснаа хар бэхээр хантайрав.

Пүрэвдорж хэмээхийн молхи “Би” яруу найргийн ертөнцөд бядан явсны эрхэн дор 1961 онд булшин дороос ясан хэлхээ босож хэлмэгдлийг өчиглөсөн “Голомт” найраглал, 1962 онд “Чингис”, “Тусгаар тогтнол” шүлгээр үзлийн хаяа ханзарч, үй олон хүнийг үнгэж хаясан нүглийг үл тэвчихийн учир хуучин дэглэмийн хойноос нулимс унагаагүй, ургах цагийн өөдөөс шороо цацаагүй ээ. “Экс коммунистууд” дотроос оюуны чинээтэй олон хүн нийгмийн шинэчлэлийн түүчээнд залуу үетэйгээ мөр түшилцэн явсныг хүндэтгэн дурсъя. Ардчиллыг өмчлөж болохгүй гэж хичнээн цовхроод ч анхны шан татсан залуусаас түүчээ булаах гэвээс магнайн тоосоо яахсан билээ гэдгийг ч бас саная. Энэхүү хоёр санаанаас гогцоо татахул шинэ дэвшлийг сэхээрч байгаа л бол өөрийн “Би” амьд сэрүүн байгааг мэдэж болох агаад нас нам хоёр цорын ганц шалгуур биш ээ. Харин өөд нарыг үл үзэгч хуучин бороохойн хугархай төдий бол нийгмийн сэтгэлгээг аргамжин амьд гадас болдгийг бид харж байна. Гэвч гадсыг газрын өргөс гэсэн нь сугалж, эс тоосон нь тэр чигт нь хаядаг. Энд цохоход монголчууд бүгдээрээ коммунист байгаагүй. Намайг багад “хөгжсөн намын аравдугаар их хурал” гэсэн дууны үгийг “хөгцөрсөн ламын арван шуудай хар гурил” гэж завхайлж байсныг санаж байна. Энэ бол дуугаа хураасан хөх харчуулын дотоод

“Би”-ийн хяхуу байсан нь гарцаагүй. “Юу л гээчийг үзэх юм бол доо, Бурхан минь!” гэж шүүрс алдаад таг болдог байсан тэр хүмүүс дэлбэрлээ хүлээсэн галт уулс байжээ.

Өөрийн “Би”-г эрэгцүүлсэн өчүүхэн миний гэмшилийн шүлэг ганцхан намайг дайрсан гай гэж би бодохгүй байна.

Омогшил

Униарт хонд шөнөжин тэвэрсэн

Ургуул уулын хайрын увидас

Уурагт энгэр өнжин дэвтсэн

Уялган бэлийн харвуул үндэс

Би бол би.

Хөдсөн өлгийд одтой орчсон

Хөх тэнгэрийн хөх зүүд

Хөвд өвснөөс аргамж хүйлж

Хөл алдуурсан хорвоогийн нууц

Би бол би.

Эмээлийн дөрөөнд хар дарсан

Эзэнт гүрний бурхан учиг

Элэнцийн буурийг элээж сахьсан

Эх нутгийн буурал өчиг

Би бол би

Өрөөлийн зоргоор өнгөгүй жаргасан

Өчигдрийн хатавчинд баян боол.

Өөрийн эрхээр мөнгөгүй дургисан

Өнөөдрийн хойморт гуйлгачин хаан.

Би бол би.

Гэр амьсаж харь халгасан

Гэрэл сүүдрийн бүүдэн сүлээн

Гэнэн сүсэгтний зуланд шандсан

Гэм буяны тарлан шүтээн

Би бол би

Хорьдох зууны цаазын хаадыг

Хоймортоо тахьсан буруу номтон

Хоол голж, хормой шилж

Хорвоод төөрсөн нүгэлт хоноц

Би бол би

Улалзахад минь үгүйсгэв гэвч

Унтрахад минь намайг үгүйлнээ.

Унаган хүү нь илүүгүй л юм бол

Улс надаар дутахаа л дутнаа.

Би бол би

Хэн нэгэн дудрайн хэлснээр

Хэрэв би нохой юм бол

Монгол улсаасаа уяатай

Модон идүүртэй угаадастай шүү.

Би бол чи биш

Би бол би!

2002 он

Бие даасан “Би”-гээр бүрдсэн улс орон тусгаар тогтнон сэргэж мандаж чадна.

Өнөө үеийнхэнд түүхийн үнэнийг сануулж хэлэх үүрэг бидэнд бий. Үүнд зальхай булхай хэрэггүй. Эрт, эдүүгээгийн түүхээс тасархай шинэ үеийнхэн гарч ирлээ. Эх орон, эрх чөлөөний үнэ цэнийг тэдэнд үнэнээр нь хүргэе. Энд ямар нэгэн, өс хонзон хараал гутаалын тухай хаацайлал байж болохгүй. Өнөөдрийн “Би”, өчигдөрийн бидний алдаа гавьяа хоёрыг мэдэж баймаажин, өрхөө цэлийтэл татаж гэртээ гэрэлтэй амьдарна. Түмэн явдалд намчирхдаг юм гэхэд түүхийн үнэнийг наранд үлдээе. Би, Чи, Та гурвыг “Бид” хэмээн зангидаж

...Өргөн цээж чөлөөтэй

Амьсгалж яваа агаар дээр

Өөрийн толгой мэдэлтэй

Амьдарч яваа заяан дээр

Тусгаар тогтнол чамайг

Тунхаглан бичье!

Ардчиллаас юу хүртэв гэж надаас асуувал би огтхон ч эргэлзэхгүйгээр миний “Би”-г өгсөн гэж хариулна. Авах юм нь энэ л юм чинь!

“Улаан гэрийн хоригдол” нарны оршин тогтнолыг үзэж явна.

Одоо би “Бор гэрийн Богд”!

Хоёр. “Би” уулсын дууль

Монголын утга зохиолын бядгүй элч би вээр оюуны оргил зэрэгцсэн хоёр мэргэн буурал уулсын хормойноос зүүгдэж явсны хувьд бэсрэгхэн учирлал бичиж үлдээхээр зүрхлэв. Өөрийн гэх сургаалаар явар ядуу надад их өтгөсийн тухай ийнхүү бичиглэх эрх үүргийн аль аль нь бий.

Цэндийн ДАМДИНСҮРЭН

Хар авдранд ном бий

Хазгар өвгөнд эрдэм бий

Ц.Дамдинсүрэн

Дамдинсүрэн гуайн “Буурал ээж”-ийг бидний үеийнхэн цээжээр дуржигнуулдаг байв. Иймэрхүү тэлмэсэн шүлэг үндэсний язгууртай сэтгэлд хөг нийлэлтэйн улмаас ухаанд хоногшсон буй за.

...Халх монголын малчин

Хатгин овгийн нүүдэлчин

Харц язгуурт Дамдинсүрэн...

гэсний “хатгин” овог гэдгийг тэр үед ухаараагүй. Хожим “Монголын нууц товчоо” руу шагайваас Алунгоо эхийн хөвүүн Буха Хатигийн уг сурвалж юмсанж. Тэд Чингис хаантай тэрсэлдэж Жадран Жамухыг “Гүр хаанд” өргөмжлөх, Найман аймагтай булагнах зэргээр самуурсан боловч мөхсдөн номгорсон аж. Манай нэрт гүүш хатгин Аким үүнийг тайлахдаа: “Дээдэс минь Чингис хааныг ирлэсэн гэдэг” юм. Аким маань овгийн шүтээнээ чоно хэмээн сүсэлдгээс цагаан чонын эрэлд үе үе хатавч өнөө гайхал нь түүнд баригдах бүү хэл харагдаагүй л байна. Харин Дамдинсүрэн гуай бол цагаан биш “улаан чонотой” ураглаж ч явсан, уруулж ч явсан билээ.

Дамдинсүрэн гуай бол тэнгэрийн нохойтой огтхон ч төсгүй талын болжмор лугаа адил учир тэнгийхэн нь “бор шувуу” гэдэг байлаа. Өөрөө ч “Богд ууланд ниссэн бор шувуу” гэж шүлэглэсэн. Хянгандуу хамартай, давжаахан атлаа дотуур тэнхээтэй “хи хи” гэсэн инээд нь өргөстэй, дэндүү эгэлхэн энэ эрдэмтэн, номын хутаг олсон мэргэн дээдэс яах аргагүй мөн.

Дамдинсүрэн гуайн эцэг Цэнд өдгөөгийн Өвөрхангай нутгийн Гарьд хэмээх газар Бээжин Улиастайн өртөө хашиж алба сайн залгуулсны хишигт залан болсон юм билээ. Үүн дээр эх Уламбаяр нь Аюушжав захирагчийн ач охин гэвээс “харц язгуурт” гэсэн нь мөчиг тачигхан угсаа улбаатай нь түүнийг феодалын гаралтай болгочих вий гэж халгаасан байж болно. Тиймээс өөрийн овгийн “цагаан дээлт” Дамдины хүүтэй ижилсэн ядуу ардын хүүхэд хэмээн өвдөг цоорхойгоо харуулаа биз. Түүний хүчинд л удам угсааны тухай шохоорхоогүй болов уу.

1938 оны 12-р сарын 20-нд “до” яаманд өгсөн мэдүүлэгтээ Дамдинсүрэн гуай

-...Цэвээнжамсранновоос надад хэлсэн нь: Ер монголд дарангуйлан захирах хатуу засаг ард түмэнд нь тохироогүй учир монголын ерөнхий сайд Гэндэн, Дэмид нар толгойлж хувьсгалын эсэргүү байгууллага болох ажлыг зохиож явуулж буй учир чиний бие эл эсэргүү ажилд оролцох хэрэгтэй хэмээн элдвээр ухуулан ярьсан. Миний бие дуртай зөвшөөрч уул эсэргүү бүлгэмд 1936 оны хавар цагт Жамсранновт элсэн орсон нь үнэнтэй болохыг батлан мэдүүлнэ гэсэн бол 1939 оны 6-р сарын 23-нд байцаагдахдаа

-Миний бие урдах байцаалтанд мэдүүлсэн мэдүүлгүүдийг батлаж чадахгүй. Миний тэрхүү мэдүүлгүүд нь ямар ч ор үндэсгүй хиймэл зохиомол мэдүүлэг болох учраас батлаж үл болно... Байцаагч Намхайжанцангийн зодуур жанчуурыг олон хоног цагаар хүлээн тэсвэрлэх аргагүй болсон... гэж үнэнээ хэлжээ. Бүрэлгэлийн хар шуурганд Дамдинсүрэн гуай 15 сар ийнхүү өртжээ.

Дамдинсүрэн гуай бол яруу найрагч, үргэлжилсэн үгийн зохиолч, судлаач, орчуулагчийн дөрвөн тотго тэгширсэн хорьдугаар зууны Монголын соёлын хийморлог эзэн мөн. Тэрвээр эрдэнэ эрсэн олсон азтай хүн. Түүний хэл найруулга утга санаа нэвт харагдахуйц энгийн агаад уншсан хойно ухаарлын өгөөжтэй. Мэргэн ард гэсэн нэр түүнд яг таарна.

Дамдинсүрэн гуай” Буурал ээж”-ээрээ найраглалын, “Гологдсон хүүхэн” туужаараа хүүрнэлт зохиолын айд шинэчлэл хийсэн гэж би хэлнэ.

“Гологдсон хүүхэн” туужийг олон хүнд уншуулж санал авсаар Баян Болдын дүрийг анх санаснаасаа өөрчилж харлуулсан юм билээ.

Уг туужийн анхны хэвлэлийн зургийг марзан Шарав гуай зурсан нь учрал. Зохиолыг уншсан Чойбалсан сайшаасан бол намын хянан байцаах комиссын дарга Вандуй гэгч “Хятад үлгэр шиг дэмий юм бичлээ гэж бүгд хурал дээр шүүмжилжээ. “Солийг сольсон нь” өгүүллэг бас “Феодалын дурлал” гэсэн хоч авсан. Ер нь Дамдинсүрэн гуайн аль өртсөнийг тэр гэхэв. “Бух Гомбо”, “Чемодантай юм” өгүүллэг нь бүү хэл сахал нь хүртэл зэм дуулсан. Энэ бол ёстой л үхэх огтоно муурын сахлаар оролдоно гээч болсон аж. Эмнэлэгт хэвтэж сахал ургуулсан эрдэмтэн Уулын амны хүлээн авалтад очиход Бал дарга авгай хоёр “Чингисийн сахал тавьсан байна. Авч хая гэхэд “Чи төрөө мэд, би толгойгоо мэдье” гэж хэдэрлэжээ. Түүний дараа ойр

тойрныхондоо “Дарга авгай хоёр Чингистэй уулзсан юм байна. Сахлы нь таньж байна” гэж егөөдсөн гэдэг.

Чингисийн мэндэлсний 800 жилийн ойгоор нөхөд нь түүнийг үг хэлнээс холдуулахаар салхинд хамт гарчээ. Налайх орж үхрийн тагалцагнаас өөр юмгүй учир худалдаж аваад голын захад ирэхэд тэнгэр хохилзоод тав алдуулжээ. Хот руу эргэж улсын номын сангийн хажуугаар өнгөрөх гэтэл амьтан хөлхөж байж. Учрыг мэдэхээр очвоос олон түмэн дээшээ гэсээр 106 дугаар танхимд оруулж дээш залснаас дуугай суух аргагүй болсон гэдэг. Гэвч тэнд үг хэлсэн нь албан шаалтаар бус сэтгэл зүрхний тушаал байсан юм.

Зохиолчдын III их хурал дээр “...Монголын дунд сургуульд Македоны Александр, Францын Наполен нарыг сурагчдын чихийг дөжиртөл заагаад Монголын их жанжин нэгдсэн Монгол улсыг байгуулсан Чингис хаан, баатар эмэгтэй Мандухай нарын тухай шивнэж ч хэлдэггүй нь харамсалтай байна...” гэж хэлж байсан хүн тэр хурал дээр тэснэ гэж байхгүй л дээ. Тэр хурал дээр: Чингис хааны тухай үнэн зөвөөр үзүүлсэн зохиол бүтээл гарахгүй байгааг зөвлөлтийн зохиолч Ян-аар жишээлж “Чингис хаан бөөвийсөн муусайн морьдоо унаад жартгай ярдаг хатнаа дагуулаад...” гэх зэргээр бичсэн байх юм. Чингис хаан бүх Монголыг, бүх Азийг эзэлсэн хаан байсан тул аль сайн морийг шилж унаж аль сайхан хүүхнийг шилж авч явсан юм. ...Зохиолч Ян манайхны хар нүдтэй улаан хацартай хүүхнийг муу муухай гэж боддог юм бол бид тийм хүүхнээ сайхан гэж боддог юм. Бид баруун зүгийн хонгор зүстэй, ногоон нүдтэй хүүхнийг муу муухай гэж ямар ч зохиолдоо яасан ч доромжлохгүй. Монголын морь муу ч гэсэн энэ морийг унаж яваад монголчууд дэлхийг донсолгосон юм...” гэхчлэн хэлсэн байдаг. Үүнийг ёзоороор нь ухааж бодъё л доо. Энд Ян зохиолчоор зөвлөлт улсыг төлөөлүүлж нудархдаа орос эхнэртэй дарга нараа бас сэжээд авсан юм биш байгаа? Өвгөний егөө их цаана шүү дээ.

Дамдинсүрэн гуай 1945 онд маршал Чойбалсангийн 50 насны ойд зориулсан ерөөлөөр, 1947 онд “Монголын нууц товчоо”-гоор, 1950 онд Сүлд дуулал зохиосны учир, төрийн шагнал гурвантаа авсан. “Хоёрыг нь надад өгсөн, нэгийг нь би өөрөө авсан” гэж түүний хэлснийг та нэг бод доо. Харин 1986 онд “Ардын уран зохиолч” цолыг нам засаг сүүлчийн амьсгаа буюу сүнс сүүдэрт нь шидсэн юм. Өчнөөн жил энэ цолыг харамлаж тохойгоор нь хатгасаар нүглийн нүд маажиндсан л хэрэг. Цаг алдсан шан харамж цаасны бөөс төдий ажээ. Зарим нэг мяндагтан тэр үед “Нам засгийн хайр зохихгүй Дамдинсүрэн даварч байна” гэж зандарч байсан нь бишгүй.

1970 оны 3-р сарын 10-ны өдөр болсон улс төрийн товчооны хурал дээр Намын хянан шалгах хорооны дарга Н.Лувсанравдан

-Хувьсгалын жилүүдэд хавчлаганд байсан гэж байна... Нам засгаас танд хавчлагаас өөр дэмжлэг өгөөгүй юу? гэхэд

-Хэдэн одон өгсөн. Шоронгоос гаргаж тавьсан.. гэж хариулсан байдаг. Үүний цаана “Та нар мөн их хайрлаваа” гэсэн егөө байна.

1969 онд Дамдинсүрэн гуай (А.Лувсандэндэвийн хамт) “Орос-Монгол толь” хэвлүүлэхдээ “Мянган жилийн харьцуулсан хүснэгт” хавсаргаснаас болж дээр өгүүлсэн хурал болж

“дайсныг” дарсан хэрэг. Гэвч дархан цолыг түүх тэдэнд өгсөнгүй. “Богд хаан, Ленин хоёрыг нэг дор бичсэн нь “ангийн байр суурьгүй” гэж буруутгажээ. Үхэх төрхийн жамд хүртэл, үзэл суртал хөндөлджээ. Тэгвэл Хитлертэй “онжав” болсон коммунист боож үхэх байсан хэрэг үү? Одоо цагийн хүний ой тойнд орох аргагүй.

Уг толийн хүснэгтийг уруулж шатаагаад Дамдинсүрэн гуайгаар 5297 төгрөг төлүүлсэн билээ. Энэ тухай буурал эрдэмтэн “...Орос-Монгол толь”-ийг Лхамсүрэн даргын тушаалаар урж тасдаад Сүхбаатарын талбайн зүүн хойт өнцөгт Хэвлэх үйлдвэрийн хашаанд шатааж байна гэж сонслоо. Бээжин, Улаанбаатарын төв талбайд яасан адилхан түймэр ноцож байна вэ...” гэж дуу алдсан байдаг. Юутай эмгэнэл. Юутай харанхуй хаанчлал!

Бямбын РИНЧЕН

Мундахгүй эрдмийг сурахад нас юутай богино

Мунхагуудын дунд амьдрахад нас юутай урт

Б.Ринчен

Монголын оюуны соёлын нэгэн шүтээн Ринчен гуай билээ. Түүнийг сэвтээх гэж мөн ч олон чөтгөр самардсан даа.

Тэрвээр гучин хоёрхон наснаасаа эцсийн өдрөө хүртэл ад зэтгэрийн хорлолтой ач тач үзэлцсэн юм. Дарангуйлаачдад түүнийг намнахад бүх зэвсэг, гарт нь байсан ч дутсан юм нь оюун ухаан. Ер нь алив ноёрхогчийн нохойд барьдаг мод нь хар хүчин байдаг. “До” яам, бялдууч түшмэл, зулгуйн сайчуул тэнд шадарладаг.

Ринчен гуайг тэд бараг тавин жил тамласан юм. 1939 оны 4-р сарын 4-нд Дотоод явдлын яамны онцгой бүрэн эрхт комиссын тогтоолоор цаазаар авах ял оноож байсан удаа бий. Түүнд “Японы тагнуул” гэсэн хэрэг тулгаж зовлого болтол нь зодож жанчиж “ногоон малгайтнууд” чоно шиг боорлосон. 1941 оны 12-р сарын 31-нд 10 жил хорих ял түүнд өмсгөөд 1942 оын 3-р сарын 30-нд Х.Чойбалсан Ю.Цэдэнбал нарын заавраар тусгай тогтоол гаргаж ялыг тэнсэнгээр сольжээ. Үүнээс хойш түүнд амар заяа үл үзүүлэн алахаас наагуур амьдаас цаагуур бүүрлэхсэн билээ.

Ринчен гуайг “До” яамны туршуул, хөлсний цувчуул хоёр ангаалан мөрдөж, алхсан газры нь шорооноос атгаж, ангайсан бүхнийг нь тоолж ад шоо үзсэн нь алийг тэр гэхэв.

1954 оны 8 дугаар сарын 6-ны өдөр Дотоод явдлын яамны орлогч сайд Нансалжаваас бүрдүүлсэн “танилцуулга, справка” хэмээхийг сөхөж харья.

-”...1946 онд хэвлэх үйлдвэрийн дарга байхдаа... “Ленинизмийн асуудал зохиолыг маш үзэмжгүй хэвлүүлсэн...”

-”Зохиолч М.Чимидээс өөрийн бичсэн “Цэвэгийн охин” гэдэг жижиг найруулгын эцэст агуу их удирдагч Чойбалсан гэж бичсэнийг үзээд Чойбалсан ч дээ гэж хэлээд агуу их гэдэг үгийг

хассан байна.

-”Ц.Дамдинсүрэн нь шинэ үсгийн дүрмийг зохиогоод Төв хороогоор зөвшөөрүүлэн хэвлүүлэхээр Рэнцэнтэй уулзахад түүнээс “Чи хошног арчихад ч хэрэг болохгүй юм хийгээд түүнээ хэвлүүлэх гэж юунд яарсан юм бэ. Зав байхгүй” гэж байжээ.

-”1948 онд 4-р хорооны хөдөлмөрчдийн тайлан сонгуулийн хурал дээр Рэнцэнгээс шүүмжилсэн нь: Таван жилийн төлөвлөгөө гэнэ. Үүний дотор малыг 31 саяар хүргэнэ гэсэн байна. Мал ч яахав өсөх л юм биз. Хүнийхээ тухай нэн анхаарах ёстой байсан гэж би боддог юм” гэжээ.

-”1949 онд Рэнцэн ярьсан нь: Манай бичиг бол 1000 гурай жилийн түүхтэй бичиг мөн... Дээд өвгөдийнхөө өв соёлыг бид залгамжлан аваад сэргээн хөгжүүлэх үүрэгтэйгээс биш, доройтуулах, бууруулах, орхих ч хэрэг биш. Нэр төрөө бодох хэрэгтэй тул сүвээ онгойлгож хожмыг бодох явдал чухал... гэхчлэн олон зүйл залгаад “Рэнцэнгийн сэжиг бүхий харилцааны талаар гээд тоочсон байна. Үүнд:

-”Рэнцэн нь монголын ард түмний жигшүүрт дайсан буриад Галсанов, Бадамцэрэн, Ишдорж, Сампилон нар болон Амар, Лувсаншарав нартай дотно харилцаатай байсан. Сүүлийн үед л Япон, дотоод монгол, Унгар, Чехословак, Америк зэрэг гадаадын хүмүүстэй харилцаатай байгаа нь илэрч байгаа этгээд юм. 1952 оны 5-р сарын 17-ны 15 цагт “Алтай” буудлын коридорт монгол Чехийн найрамдлын долоо хоногийг тохиолдуулан Бээжингээс Улаанбаатарт ирсэн Гризличкотой уулзаж монгол хэл дээр бичигдсэн “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл” зохиолыг Юлиус Фучикийн эхнэрт өгнө үү гэж өгөөд түүний хамтаар ресторанд хоол идэх зуур Рэнцэнгээс хэлсэн нь Прага хотын монгол хэлний тасгийн багш Пуха (Поуха) гэдэгт хэвийн харилцаа тогтоовол зүгээр байна гэж түүнд хүргэнэ үү гэж өөрийн зохиол “Үүрийн туяа” нэг ширхэгийг нүүрэн дээр нь Рэнцэнгээс Гризличкод гэж чех хэлээр, бусдыг монгол хэлээр бичиж өгсөн байна...

-Америкийн Бостон хот дахь Гарвардийн их сургуулийн номын сангийн дагалдах эрдэмтэн Андрей Д.Осборингоос 1951 оны 5-р сарын 16-нд Рэнцэнд ирүүлсэн захидлын дотор дурдсан нь: Бид сургуулийнхаа ном хэвлэлийн нэрсийн жагсаалтын нэг хувийг танд хүргүүлэхдээ баярлах тул тэр жагсаалтаас үндэслэн таны сонирхох номыг солилцох журмаар явуулж байж болох юм... гэх мэтээр бичсэн байх бөгөөд энэ захидал англиас бусад хэлээр орчуулагдахгүй үг 18 оржээ хэмээсэн байна.

Та бод доо. Зэвүү хүрч ой гутмаар байгаа биз. Тагнаачид эрдэмтний яриаг чагнаж, шууданг хулуун задалж, зочид буудлын өрөөг түлхүүрдэн номын дээр бичсэн үгийг хуулж байсан нь ил байгаа биз. Харин “...англиас бусад хэлээр орчуулагдахгүй 18 үг” гэдэг нь харь үгийг монголоороо хэлтлэж үл чадах тэд шүдтэй тулам болохыг харуулнам бус уу.

Зөвлөлтийн Гадаад яамны алс дорнодын хэлтсийн эрхлэгч М.В.Зимянинаас, монголд суугаа өөрийн элчин сайд Молотовг 1958 оны 3-р сарын 15-ны өдрийн №282 тоот бичигтээ “...Сүүлийн үед бидний авсан зарим мэдээнээс үзвэл... Зөвлөлт Монголын найрамдлын эсрэг ихээхэн дотуур тамиртай зорилго тавьж байгаа нь мэдэгдлээ... Тухайлбал тэрвээр БНМАУ-ын нөлөө бүхий хүмүүсийн дэмжлэг хүлээхгүйгээр Мао-Цзедунд захидал бичиж зүрхлэнэ гэдэг

магадлал бага юм. Ринчений явууллагын жинхэнэ мөн чанар зорилгыг илчлэх талаар ямар нэг арга хэмжээ авч байна уу үгүй юу гэдгийг нэгд нэгэнгүй ажиглаж байгууштай байна” гэжээ. Үүний хариуд “...Ринченг “Монголын сонин”-оос зайлуулж... Ринчений өгүүллийг... бусад сонинд нийтлэхгүй байна. МАХН-ын Төв Хороо Ринченг хилийн чанад томилолтоор явахыг бас түдгэлзэхээр шийдвэрлэсэн... Ринчений бас явууллага нь монгол бичгийн тухай маргаанаар хязгаарлагдахгүй энэ явууллага үндсэрхэг төдийгүй зарим тохиолдолд үнэнхүү зөвлөлтийн эсрэг шинжтэй нь тодорхой байна... Түүний ажил явууллагыг анхааралтай ажиглан мөшгөж байх болно” гэж өвгөн Молотов ам гарчээ.

Эдгээр баримтыг зангидваас монгол, орос хоёр хавсайдан их эдэмтнийг хувааж зулгааж, хугасалж зажилж байсан нь тодохой. Уг нь төр хэмээгч нь иргэнээ өмөөрөх ёстой бус уу? Гэтэл нам нь төрөө сандайлсан улсад нааш харах нүүр нь шир байсан цагийн цөв юунд эс арилна вэ? Гадаад орон гүрэн ганц иргэнийхээ төлөө дайлаар мордохоос сийхгүй атал манай яам тамга, элчин консул мэт нь хар элгийн газар хад мөргөсөн иргэнээ гарзын турсага мэт гаргуунд нь хаясаар буй нь дэлхийн шившиг бус уу. Зөвхөн мал бус хүн нь төрийн хамгаалалтанд байх ёстойг “цэвдэг нь цээжинд, авдаг нь бөгсөнд” буй төрийн албаны төө сэтэртнүүдэд энэ дашрамд эгдүүцэн сануулья. Бид цөөхүүл гэдгийг битгий март!

МАХН-ын Төв Хорооны улс төрийн товчооны 1959 оны 7-р сарын 13-ны 251-р тогтоолоор “Доктор Ринчений сүүлийн үеийн зохиолууд дахь зарим харш үзэл санааны тухай” хэмээн сүржигнэж түүний “Өмнөд этгээдэд зорчсон тэмдэглэл”, “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” хоёр номыг хогтой хутгаад “...манай нам ард түмний үзэл суртлын үндэс марксизм-ленинизмийг ойшоон үздэггүй, өөрийн оронд социализм байгуулж байгаад сэтгэл зориг нь төдий л хөдөлдөггүй... өөрийгөө “Эх оронч” гэж гайхуулан магтдаг нь хоосон чалчаа үг болохоос хэтрэхгүй байна” гэж Ринчен гуайг лаахайджээ.

Та бод доо. Дарга нарын гайхуулж байсан нөгөө марксизм-ленинизм, социализм хаачлаа? Тэд тийм тууштай коммунистууд юм бол “алтан сургаалаа” адсагалан гишгэж социализмаа сохор зоосны үнэгүй хаяад “хөрөнгөт ёс” гэдэг дайсныхаа үүдээр хөлөө ч арчихгүй орох байсан гэж үү. Тэгвэл өнөөдөр урвагч шарвагч гэж улаан нүдлэн хэн нэгэн рүү дайраад яанам билээ. “Үнэн” сонины 1959 оны 12-р сарын 9-ний №289-д “Бидний эгнээнд хөрөнгөтний үзэлтэнд байр байхгүй” гэсэн өгүүлэлд юу гэж бичсэнийг оочин цоочин саная.

-Б.Ринчен бол аугаа их октябрийн хувьсгалаас цочин дүрэвсэн хөрөнгөтний сэхээтэн гаралтай, шинэ нийгэм байгуулж байгаа монголын ард түмний дунд хар элэгтэй...

-Монгол орныг ертөнц дахинаас салгаж ангид зайдуу бөглүү газар хуучны хоцрогдмол байдлын үзэсгэлэн болгон үлдээх оролдлоготой.

-Түүнд санаж сарвайх энхрийлэх хайрлах дотно нандин юм байхгүй.

-Цагаачийг цагаа хатгана

Цагаан морийг ногоо хатгана гэгчээр тусыг усаар хариулж байдаг

-Марксизм-Ленинизмийн үзэл санааг түмэн олноосоо жожигрон тасарсан ганц Ринчен л

зөвшөөрөн хүлээж аваагүй.

-Бидэнтэй цуг яваач гэж Ринченгээс огт гуйхгүй... сэнхэрвэл зол нь эс сэнхэрвэл хохь нь, бидэнд бүү саад бол, замаас зайл...

Энэ өгүүлэлийг Дамдинсүрэн гуай “бузар хуудас” гэж нэрлэсэн юм. Эгүүлэн тайлаад үзье.

-Ринчен гуайн эцэг Бямбаевийн байшинд МАН-ын анхдугаар хурал болсон. Түүнийг Хиагтын Черняевын цагаан гвардынхан буудан хороосон (М.П.Хабеев) Ринчен гуай бол монголын ард түмний дунд халуун элэгтэй эх оронч соён гэгээрүүлэгч мөн.

-Ринчен гуайг хараагчид л Монгол орныг ертөнцөөс тасалж большевизмын чангаланд цагдсан.

-Ринчен гуайн “нэрээ нуугаачид” гэж нэрлэсэн тэр бүлэглэлийн цорын ганц нандин юм нь эрх дарх, алдар нэр байсан.

-Ринчен гуай цагаач бус монгол туургатын уугуул еншөбү овогтон

-Марзсизм-Ленинизмээс ганц Ринчен гуай бус цөм татгалзав.

-Тэдэнтэй хамт явья гэж Ринчен гуай гуйгаагүй, бидэнд саад болж байснаараа тэд замаас зайлав...

Энэ тайлалыг би бус түүх нэгэнт хийжээ.

-”Үнэн” сонины энэ жудаггүй хараалыг эрээчигсэд “нэрээ нууж” үлдсэн бөгөөд тэд өөрийгөө илчлэхээс үнхэлцэг хагартал айж, өнгөрсөн үеийн “Өлзийхүү” болж эзэнгүй бууринд гээгджээ.

Ринчен гуай тухайн үед Цэдэнбал, Хрушев нарт захидал бичиж эртний ромынхны “AUDI ALTERAM PARTEM” буюу “бусдын үгийг сонсож сур” хэмээх сургаалыг сануулсан боловч коммунистууд ухаантай үг уудлах савгүй гээч л болсон доо. Ерөөс тэдний оёг нь алдаагаа хүлээх чадваргүй мугуйдал, дээрэлхэл, бусдыг газрын гаваар булах өсөрхөл, биеэ магтах саймшрал, нүд чих хуурах хоосон сүржигнэл бөгөөд өдгөө ч урхагшин үлджээ.

Мэргэн буурал Ринчен гуайг хэдийвээр насан эцэс болтол нь хэмлэж, тэнгэрт халихын цагт нь ч хүн ёсоор хөдөөлүүлэхэд нь хөл хорьж асан дээдэс сүр хүчээ гайхуулсан боловч зэс зэвээрээ, алт өнгөөрөө үлдэхийг бид үзлээ.

Ринчен гуай 1933 оны 9-р сарын 9-ний өдөр бичсэн “Цаг ирвээс” хэмээх сэтгэмжийн бичил өгүүлэлдээ “Би цэцэрлэгч бөлгөө... Гагц, цаг ирвээс миний цэцэрлэгийн хаалга өөрөө нээгдэж, журамт амраг орогсодоо босгын өмнө бахданхан угтаж хүжсийн үнэр анхилсан цэцэрлэгтээ удирданхан оруулмуу би. ...Тэгээд эрдэнэсийн сан минь түмний түгээлийн сан больюу” гэж айлджээ.

Цаг иржээ. Түүний цэцэрлэгт түмэн уншигч хөлхөж, эрдэнэсийн сангий нь бишрэн авай.

Ринчен гуай сахал самбайг хийсгэн салхи сөрөн алхаж буй омог бардам, оюун гиймэл тэр л дүрээрээ, ангийн дайсны бус ардын гэгээнтний алдар сүрээр мөнхөрчээ. Улсын төв сангийн өмнө Ринчен гуайн сүрлэг хөшөө сүндэрлэв. Тэнд байсан Сталины хөшөөг булгалж хаясан буурь дээр шүү.

...Яргыг дарга хийж

Ялыг түүх оноох... нь энэ. Үүнийг давж заалдах эрх үгүй. Гагцхүү хэзээ хойно хэлбэр өөрчлөн хэрцгий санаатнууд хажуухнаас ханцуй шамлахаа сийхгүй. Сэтгэл дутаачтай замд явахад сэрэмж илүүдэх гэж байхгүй. Ард түмэн гэж хашгираачийн амны гоод бүү хууртагтун.

“Би” уулсын дуулал хэрхэн уулсын дууль болсон учрыг уншигч авгай та тунгаан бодоорой гэж гуйх л надад үлджээ.

Гурав. Бидний “Би”-гийн улирал

Бидний улирал бол хорьдугаар зуун. Монгол улсын сэхэл, зутралын он цагийн хуудаснаас өөрсдөө зайцан үлдэх гарцгүйтэй адил хэн нэгэн биднийг хүчирхэн тасдаж бас чадахгүй. Өнөөдөр бид нүгэл буяны дэнсэн дээр нүцгэн зогсож байна. Юугаа ч нуухсан билээ дээ.

Бидний хувьд “Монгольская Советская Социалитеская республика” мэтийг үзээгүй минь аз. Байгуулаагүй ч баллаагүй гавьяа минь тусгаар тогтнол! Харин бүрэн эрхт орны хугас эрхт иргэн явсан төөрөл маань хохь мөн. Бага буурай улс орон барлагийн заяатай гэдэг “онол”-ыг би ад үздэг нэгэн.

Хүн төрөлхтний түүхийн сэжүүрээс зохиолчдын хувь тавиланг сөхөж харваас, зандалчдад өргөлийн дуулал хайлж ихсийн зэрэгт шадарласан нь байхад ухааны зоргоор тэрсэж цаазын илдэнд зарим нь тасар цавчуулжээ. Нөгөө хэсэг нь төр цагийн үймээнээс төвөгшөөж уран бүтээлийн агуйд нямбалж, үлэх нь умартахын хязгаарт одсон байх юм билээ. Хорьдугаар зууны монголын зохиолчдын хувьд үүнээс гажсангүй.

Бидний улирал хар, улаан үүдтэй байлаа. Улаанаар нь шургаж чадвал өөрийгөө худалдах, хар руу нь хөөгдвөл тамын тогоонд даргилах бөгөөд гуравдах гарц байгаагүй. Ийм нөхцөлд золоор тохиосон хүмүүн заяа, амь, амьдралаа хярваслаагүйн төлөө бийр түшээчийг буруутгах хэцүү. Эзэрхлийн дэглэм нь торгонд боосон илд байсан гэдгийг одоо л бид омогдуухан хэлж зүрхлэх болжээ.

Бичгийн мэргэдийн эрсдсэн амь, эвдэрсэн хувь заяаны туурин дунд миний үеийнхэн айдас нөмөрч утга зохиолд орсон юм. Уран бүтээлээс гадна хайрын болзоонд тонгочих зүрх, уруулын дарсанд ухаан алдан согтуурах эрх, бороотой шөнө аашаа эвдэх жаргал, үрийн зулай үнэрлэх гэгээн мөрөөдөл бидэнд байсан шүү дээ. Босоогоороо үхэж чадахгүй байсан аймхайрал маань амьдралаас уяатай хоргодол л байсан юм.

Энэ бол хүлцэнгүйрлийн цайлгал мөн агаад бишээ.

Авьяас зэвэрч, аргацаач алтарч, оюуны хөмрөгт рашааны дусалтай шаар асгасан булайралд

миний ч буруу бий. Үүнийг баатарлал гэх нь бус үнэнийг гүйцээгүй эцэл гэвээс зохино. Гэвч хожуу боловч ухаарал хонгилд үхсэнээс дээр. Сайн сөнөхийн оронд муу амьд явсан миний үлгэр хойч үед загвар бус ч санамж болог.

Утга зохиолын мэргэд үзэл сурталд угнуулж хүйтэн доож балгаж явсан чиг бурангуйг бурханчлан шүтэлгүй зүсүүлсэн зүрхнийхээ ховдолд гэрэл гэгээ хадгалж явсныг би гэрчлэнэ. Энд би жинхэнэ уран бүтээлчид утга зохиолын түүчээний тухай ярьж байна.

Эхлээд Орост дараа нь манайд зохиолчдын эвлэл гэдэг уран барилгыг Сталины зураг төслөөр барьсан. Наран талдаа цонхгүй, намын талдаа ганц цонхтой энэ байгууламжийг коммунизмын барилгын бөөрөнд наасан нь тун нарийн бодсон гайхамшигтай зохиомж байв. Зохиолчдыг нэгэн үзэл сурталд хөгнөсөн ийм бүтцийг бодож олсон коммунистуудыг тэнэг гэж яахин болох билээ.

Ц.Дамдинсүрэн гуайн дурсамжийг сөхье.

...1929 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр МАХН-ын Төв Хорооны суртлын хэлтсийн өрөөнд, төв хорооны нарийн бичгийн дарга Ө.Бадрах, Дунгарын Чимид, С.Буяннэмэх нар таниулга хийж зохиолчдын бүлгэм байгуулжээ. Эдгээр нь:

- 1.Дунгарын Чимид-Алтанбулагт багш байсан КУТВ хэмээх дорно дахины их сургуульд суралцсан.
- 2.Гэндэн-Намын Төв хорооны ажилтан асан
- 3.Бадрах-Дөрвөдийн нэгэн хошууны мэйрэн зэрэгтэй түшмэл. НТХ-ны нарийн бичгийн дарга
- 4.Бага Дамдинсүрэн-Академич Ц.Дамдинсүрэн
- 5.Мөрдэндэвийн Ядамсүрэн-КУТВ-д суралцаж ирсэн. Улсын прокурор байсан.
- 6.Сономбалжирын Буяннэмэх-Улс төр, нийгмийн зүтгэлтэн зохиолч
- 7.Бас Дамдинсүрэн буюу Жанцангийн Дамдинсүрэн-Эвлэлийн Төв хорооны дарга байсан.
- 8.Дугаржав-ТХ-ны суртлын хэлтсийн эрхлэгч. Гэгээрүүлэх яамны сайд асан.
- 9.Наваанжамжил “Өвгөн бичээчийн өгүүлэл”-ийн зохиогч
- 10.Цэндсүрэн-КУТВ-д суралцсан. НТХ-ны хэлтсийн эрхлэгч асан
- 11.Бямбын Ринчен-Академич, зохиолч
- 12.Очир буюу Дэндэв-Очир-КУТВ-д суралцсан. Эвлэлийн төв хороонд ажиллаж асан
- 13.Дашдэмбэрэл-Алтанбулагт багш. Эвлэлийн Төв хороонд ажиллаж асан.

14.Хорлоо-Цэргийн комиссар асан

15.Шагдарсүрэн-НТХ-д ажиллаж асан

16.Я.Цэвэл-Ардыг гэгээрүүлэх яаманд эрхэлсэн түшмэл асан...

17.Ж.Догсүрэн-Судар бичгийн хүрээлэнгийн Жамъян нар байжээ.

1939 оны 9-р сарын 9-нд МАРЗ буюу “Монгольская ассоциация революционных зохиолчид” гэсэн гурван орос үгэнд ганц монгол сүүл наасан “Монголын хувьсгалч зохиолчдын нийгэмлэг”-ийг байгуулж товчооны даргаар М.Ядамсүрэн, нарийн бичгийн даргаар Д.Нацагдорж тохоогджээ. Хожимхон мөнөөх “зохиолчид” гэдэг монгол сүүлийг нь тайрч оронд нь “литераторов” хэмээн МАРЛ гэх болсон байна. Үүнээс барьц атган гажисхийхэд тэр үед орос үгийн товчлол бүхий “Монголтранс”, “Монценкоп” гэх тээвэр худалдааны бас олон улсын хувьсгалчдад туслах байгууллага буюу “МОПР” гэж байсан юм билээ. Өдгөө ор тас мартагдсан “МОПР”-ын дуунд:

-Баг хурц уриатай

Баатар хувьсгалч нөхдүүд

Баруун зүгийн тивүүдийн дор

Бадарсан хувьсгалыг шатаажээ

Хувьсгалч баатар эрчүүдийн

Хурц зориг нь шантрахгүй

Хувьсгалыг сэдсэн ардууд бид

Хүчийг нэгтгэн туслана.

Айл бүрий дор туслахаар

Ардын МОПР-ыг байгуулсан юм

Алтан дэлхийгээр

Хувьсгалын санг хөгжүүлье.

гэсэн нэлээд хэдэн бадагтай байжээ. Дээвэр дороо төдийгүй дэлхийн хувьсгалыг бадруулах энэ санааг умраас нэвтрүүлэн улаан туяа цацруулж байсны улбаа юм даа.

Ахмад дипломатч Баярын Жаргалсайхан гуайн дурсаж өгүүлснээр оосор бүхий хайрцаг хүзүүндээ өлгөсөн хүмүүс тусламжийн бадар барьж явсан юм гэнэлээ. Энэ нь дэлхийн хувьсгалд дээж өргөх гэсэн дэврэл байжээ.

1925 онд Ардыг Гэрээрүүлэх яамны сайд Максим Горькийд захидал бичжээ. Үүнийг Эрдэнэ-Батхааны гэж нэрлэх нь ч бий. Уг захидлын санаа нь гадаадын утга зохиолоос орчуулах талаар зөвлөлгөө өгөхийг хүссэн бололтой. Горький түүний хариуд “идэвхтэй зарчмыг номлосон” утга зохиолоос орчуулахыг зөвлөжээ. Тэгээд ч “Арван таван наст капитан”, “Чин зоригт баатарлаг биет адгуус амьтны үлгэр”, “Салават баатар” зэрэг номууд хэвлэгдсэн буй за. Харин Горькийн үгийг манайхан социалист реализмын тухай сургаал болгон хэвийлгэжээ. Харийн ноёрхол, шашны будангуйд номойрсон манай уншигчдын хувьд “идэвхтэй зарчим” бол үнэтэй үг байсан агаад одоо ч утга учраа алдаагүй мэт.

МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн 1943 оны 4-р сарын 8-ны 29 дүгээр тогтоолоор “...Хувьсгалт уран зохиолчдын эвлэлийг байгуулсугай” гэжээ. Хэдий тийм боловч Монголын Зохиолчдын Эвлэлийг 1929 оны 1-р сарын 9-ний өдрөөр тогтоон ой хийж одон мэдүүлэг болсон юм.

Зохиолчдын эвлэл бол ийнхүү эхнээсээ намын харъяалал бүхий улстөржсөн байгууллага.

Нэгэн цагт “Маарамбын уяа” байсан эл газар хөл татарч хоёр шонгийн хоорондох хэц төдий үлдсэн нь цагийн засаглал.

Зохиолчдын хороог “Монголын утга зохиолын жанжин штаб” гэдэг байв даа. Улс төрийн товчоо хүрч даргы нь тохоодог бөгөөд мань мэт ярсхийтэл гар өргөнө. Эс өргөсөн нь “эмзэг бүлэгт” шилжинэ.

Зохиолчид бол хэн нэгэн дээдсийн өмд шувгарсныг хараад хашгирч мэдэх гайхлууд тул Ленин багштан “намч, ардач, ангич чанар” хэмээх гурмасын чөдөр зангидаж өгсөн юм. Сталин түүнийг нь дөрмөслөж, намын Төв хороо, “До” яам, хэвлэл утга зохиол хянах газар, Зохиолчдын хороо гэсэн дөрвөн алгатай болгож сул мөч үлдээгээгүй. Үүнийг нь манайх үгсэн дууриаж билээ.

Бид ийм л “штаб”-тай утга зохиол руу орж хожим “Сэнгээгийнхэн” гэж зарим хүн цэхвэлзэж До яамны нохой Сэнгээгийн “новшнууд” гэх нь холгүй юм болж билээ. Дашзэвэгийн Сэнгээ дотоод яаманд хэлтсийн нарийн бичгийн дарга асан бөгөөд түүнтэй холбоотой нэг л баримт байдаг юм.

1939 оны 9-р сарын 19-нд Жамбалдоржийн баталсан 39-р ордероор Д.Сэнгээг баривчилж мөн оны 12-р сарын 14-ний өдөр байцаагчаас,

-Сэнгээ таны бие эх орноосоо уравсан хувьсгалын эсэргүү японы тагнуулын байгууллагын гишүүнээр элсэн орсон явдал чинь нэгнээ хуулийн газраа баримттайгаар илэрсэн тул одоо чиний бие чухам хэзээ хэнд хэрхэн элсэж орсон явдлаа нуулгүй тоочин мэдүүл гэхэд Д.Сэнгээ:

-Миний бие хувьсгалын эсэргүү япон тагнуулын байгууллагад элсэн орж ажилласан явдал огтхон ч үгүй билээ. Харин миний бие өөрийн эрхэлсэн ажил дээр гаргасан алдаа дутагдлаа урьд нэгэнтээ хүлээж мэдүүлсэн бөгөөд энэ явдал нь миний хяналт болгоомжгүй буюу цалгар назгай байсан зэргээс тийнхүү үзэшгүй ичгүүртэй дутагдлыг гаргасан нь туйлын үнэнтэй

болохыг дахин давтан мэдүүлэх бөгөөд харин миний бие хувьсгалын эсэргүү ажилд оролцон эх орноос урван тэрсэлсэн зүйл огт үгүй болохыг хуулийн өмнө батлан мэдүүлж, өөрийн хэргийг даруй нэгэн тийш болгож өгөхийг хамтаар хүсэж мэдүүлье гэсэн байдаг.

Дараагийн мэдүүлэгтээ: Гар үйлдвэрийн төв холбооны оёдлын артелиг шалгаж байхдаа цэрэг ногоон цамц арав гаруйг гологдол болгосныг хорлон сүйтгэсэн мэтээр зандарч айлгасан. Мөн 1938 оны улсын баяраар арьс ширний үйлдвэрийн манаач унтаж байсанд дахаар нь боож сүрдүүлсэн, бас ажилчдыг загнаж зандарснаа хүлээсэн байдаг. Энэ нь дээр өгүүлсэн “ичгүүрт дутагдал” юм билээ. Миний бие “XXI зууны судар” таван ботийг эмхлэж байхдаа хэлмэгдсэн зохиолчдын мэдүүлгийг “До” яамны архивг олон жил ажилласан судлаач Дуйнхоржаваар гаргуулсан бөгөөд Д.Сэнгээтэй холбогдсон өөр баримт сэлт олоогүй гэсэн билээ.

Албан тушаал асаргүй, омголон залуу эр дүвчигнэж байснаас бус алж хядаад байсан баримт байхгүй. Д.Сэнгээгийн тухай анх хэлсэн хүн нь “Өвгөөдэй” хэмээх Дамдинсүрэн билээ. Бидний мэдэхээр Дамдинсүрэн гуайг улс төрийн хилс хэргээр ял эдлээд гарахад нь Д.Сэнгээ зохиолчдын хороонд ажилд авч, улмаар “Өвгөөдэй” олон жил сонин сэтгүүлд ажиллан “Соёлын гавьяат” болсон сон. Чухамхүү сайхь хоёрын хооронд ямар тооцоо байсныг хэн ч мэдэхгүй.

Зохиолч Л.Ванганы аав Ламжав гуай Улсын Бага хурлын нарийн бичгийн дарга байхдаа хэлмэгдэж өнчин хүүхдүүдтэй учир амь хэлтэрч хорих ял эдэлсэн. Түүнийг мөрдөнд байхад нь “хэргээ хүлээвэл амь гарч болно” гэж Д.Сэнгээ ятган байсан тухай Л.Ванган надад ярьсан нэгэн зүйл бий. Энэ мэтээс өөр мэдээлэл, алаач талаач гэж түүнийг хараадаг хүмүүст байдаг гэхэд одоо болтол ил гаргасан нь үгүй.

Зохиолчдын хорооны дарга байсан хүмүүсийн дотроос залуу зохиолчдыг хамгийн их халамжилсан нь Д.Сэнгээ гэдгийг Б.Явуухулан, С.Эрдэнэ, С.Дашдооров, Л.Түдэв, Д.Мягмар нарын олон нөхөд бишгүй гэрчлэн бичсэн билээ.

Хахир хагуу цагийн халыг өгүүлсэн онигоо мэт нэгэн аман яриа үлдсэн нь сонин. Л.Ванган улсын циркт ажиллаж байхдаа, тус цирк үндэслэгч Раднаабазар гуайд нэг өдөр аяга тагш юм хувааж ууя гэхэд цаадах нь “Юуны чинь идэж уухтай мантай, “До” яаманд байцаагдаад ирлээ. Эсэргүү Дэמידээс гар буу авсан гэж тулгаад алах шахлаа. Уг нь Дэמיד жанжин хойшоо явж ирээд надад хүүхдийн тоглоомын гар буу өгснийг чи мэднэ. Түүнийг л жинхэнэ буу гэж мушгаад арайхийн саллаа. Тэгээд ч надад архи уух мөнгө байхгүй” гэж ундууцжээ. Ванган өврөөсөө мөнгө гаргаж “Үүнийг хоюулаа улаан мөнгө үлдээлгүй ууна” гээд хамт гарчээ. Раднаабазар гуай балгаж суухдаа “Чи энэ мөнгийг хаанаас олоо вэ” гэхэд Ванган “Чамайг матсан хүн чинь би. Шагналд нь үүнийг авсан юм” гэж хоюулаа инээд наргиан болсон гэдэг. Энэ бол тэр цагийн нэгэн тодосгол юм даа.

Бидний утга зохиолд хөл тавьж байхад аймшгийн манан арилаагүй байсан юм шүү. Цэл залуу насны минь омгийг цочоож гавлаа цоо буудуулсан М.Ядамсүрэн, цаазын газрын замд бүтээж алсан С.Буяннэмэх нарын толгой ойрмогхон өлгөөстэй байв. Цэндийн Дамдинсүрэн, Бямбын Ринчен нарт хувьсгалын эсэргүү хэрэг тулгаж буй ногоон малгайтны зэрлэг тачигнаан чихэнд хадаж байв.

1938 оны 11-р сарын 4-нд Н.Насантогтохын баталсан 312 тоот ордероор дайчлан баривчилсан “эсэргүү” Цэндийн Дамдинсүрэнгээс “энэхүү хувьсгалын эсрэг бүлгэмдээ хэзээ хэрхэн, хэн хэнийг элсүүлэн авч байсан бэ?” гэсэн байцаагчийн гөрдлөг сонсдож байв.

1937 оны 8-р сарын 28-наар өдөрлөсөн “заговор №1” гэж орос хэлээр бичсэн, даруй дайчлан баривчлах 115 хүний нэрсийг ЗХУ-ын Дотоод яамны ардын комиссариатын орлогч дарга М.П.Фриновский авчирч, БНМАУ-ын Дотоод явдлын яамны сайд маршал Чойбалсанд гардуулсны 77-р дугаарт бичигдсэн эсэргүү Бямбын Ринченгээс “Японы тагнуулын байгууллагад та хэзээ хэнээр элссэн бэ” хэмээн асуун орос хороомон гутлаар өшиглөж буй зандалчны хар дүр үүдэнд сүүдэгнэж байв.

Дашдоржийн Нацагдорж найман удаагийн байцаалтад “...Нэр Нацагдорж овог Дашдорж. Монгол, хар, тайж, нас 26. ...1925 онд Ленинградад боловсрох ажлаар, 1926-29 онд Германд сургуульд явсан... бага Гомбожавын гэрт удаа дараагаар нийлж энэхүү Гомбожав, Лооройсамбуу, орос Никулин, Хас-Очир, Наваан, Аюуш зэрэг нөхдийн хамтаар хөзрөөр мөрийцөн наадаж байсан... Швед улсын сургагч тус хотын төмрийн заводын модны тасагт сургагч байсан Карандуйн гэр орноор эхнэртэй нь сайн танил учир орж гарч байсан... Лейпцик хотын дээд сургуулийн багш Кениш гэгч хүн лүгээ 19 онд нэгэн удаа захидал бичиж латин үсгийн цагаан толгой нэгийг явуулсан... мөн сургуулийн сургагч багш Барохоогоос Герман хэлний тайлбар толь 1, гадаад хэлний толь зэргийг надад ирүүлсэн амуй...” гэх зэрэг мэдүүлгийн шивнээ сэтгэл урж байлаа.

Эх орны тэнгэр нартай атал буруу үүднээс арайхийн булзсан Донровын Намдаг, Төмөрийн Нацагдорж, “баатар ван” хэмээгдэх Наваанюндэн, Лувсандэндэвийн Цэнд-Очир гуай зэрэг мэргэн өтгөсийн царайг тасар татуулсан хувь заяаны сүүдэр таллаж буй нь бидний нүдэнд ил байлаа.

Энэ аймшиг зүүдэнд орж байхад зүрхэнд бас шар ус хураахаа “дээдэс” мартсангүй.

1969 онд Ринчений Чойномд холбогдох 564 тоот хавгаст хэрэг нээв. Энэ бол бидний хонгонд түлсэн гал буву “хохь чинь шүү” гэсэн сануулга байв.

Өвөрхангай нутгийн Очирхуяг буюу “таван сул” хочтой шүлэг бичдэг дэндүү эмхгүй боольхойн дээр бас балгах дуртай нэгэн байв. Түүнд очих ёстой нэгэн захиаг Баянхонгорын “хэцүү нэрт” хэлтсийн дарга Дорж, сургуулийн хичээлийн эрхлэгч Балдандоржийн аяганы ширээн дээрээс олж ангийн дайсан илрүүлжээ.

“Алт живж холтос хөвдөг хуультай

Алаг цоог энэ нийгэмд энэ хорвоод

Авьяастай нь зовж, нүгэлтэй нь жаргах жам байна...

гэсэн мөр бүхий тэр гар бичмэлүүд Р.Чойномынх байжээ.

Чойном хэмээх сөрөвгөр сахал өрөвгөр үстэй, бүргэд хамартай, сүрьеэгийн эмнэлэг дамжиж

явдаг эцэнхий шар хархүү үг дуу цөөнтэй, харахад доожоогүй тул авьяастай яруу найрагч гэдгийг цөөн хүн олж харсан боловч мөлхөж явахад нь мөрөө түшүүлж босгосон нь төдий л үгүй. Аяга тагш юмны нөхөд амьдралд түшиг болдоггүй билээ. Ардчилсан хувьсгал гараагүй бол түүний бүтээл нар салхи үзэхгүй байсан юм.

Чойном бол монгол зохиолчдын дотроос хамгийн хүчтэй “дисидент” хэмээх тэрс үзэлтэн. Амьдралын ёроолоос бичсэн түүний шүлэг улаан дарангуйлалыг үзэн ядахын туйлд дэлбэрсэн бөмбөг байв. Энэ нь эзнийхээ толгойг цусдах байсан бөгөөд тэр ч ёсоор болсон.

Чойномыг хоёр зуун хорин хоног мөрдөөд шоронгийн мухарт шидэж орхисон эрлэг нь хэн байв?

...Ядамсүрэн, Буяннэмэхийг, яруу найрагч Нацагдоржийг хөрснөөс тасдаж хэн үхүүлсэн бэ? Та нар шүү дээ!.. гэж түүний бичсэн, нүгэлтнүүд бол цагтаа өөрсдийгөө коммунистууд гэж омгорхож байсан гайхлууд!

...Хамаг бүхэн хаалттай

Хатуу чанд заалттай

Солгой хөгжим шиг энэ үед

Согтуурах шиг жаргал алга...

...Эсэргүү гэж гучаад онуудад

Эрдэмтэй бүхнээ хядсанаас хойш

Малын тоо хэтэрхий өсчээ.

Манай засаг ч цэцэн юм даа...

...Хаан ширээ рүү таван зуун жил гэтээд

Хатан Мандухайд тархиа хага харвуулаад

Хувиа бодож суусан дөрвөн өөлдийн үлдэгдэл

Хувьсгалын далимаар эзний ширээнд гарсан юм...

...Өвөг Чингист хонзонтой оросуудыг хүндлэж

Өэлүн эхийн угсаатан мань бүгдийг хавчиж

Өөрийн тэжээвэр нохойг ад үзэн хөөж

Өлөн хөх чоноор хотоо мануулж байна...

Чойном ийнхүү бичжээ. Ийм хүнийг гучаад онд бол гурвантаа буудах байсан биз. Эрхбиш умрын гүлгэрлийн амьсгаа арай тасраагүй байсан болохоор дөрвөн жил чанга дэглэмтэй хориход чандлан алгуурхан голы нь гогодсон билээ. Бидний дотоод улирал ийм байлаа.

Гадаад улирал хэмээвээс бидний бэлчээр социалист хэмээх орнуудын хилийн дээсэнд буюу хүйтэн дайны “Төмөр хөшиг” дотор байв. Түүний наанаас бид цаанаас дэлхийн зохиолчид төдий л нэвтрээгүй. Тавиад оны эхээр зөвлөлтийн зохиолч Илья Эренбургтэй хамт Жорж Амаду, Николас Гильен нар ирсэн юм билээ. Түүнээс хойш алгуурласаар хөрөнгөтөн орноос хөл тавьсан нь Италийн Альберт Моравиа. Нас тогтож ухаажсан өрнийн дээдсийн соёлтон түүнд бараа болж миний бие Өмнөговьор аялсан юм. Монголын говь түүний байгалийн унаган төрх, газраас эгц дээш ургах нар, одод яралзан хөмөрсөн шөнө хээр хонох сар, зэрэглээнд тасарч нийлэх гандирсын уулс, цэлсхийн мэлтрээд үгүй болох зүүдний тэнгисээрээ гайхуулж билээ. Алберт Моравиа анх удаа малчны босго алхаж, гэрийн зохиомжийг гайхан, ингэний ундаа, бас нэрмэл хүртэж, нүүдэлчдийн өвөрмөц аж төрлийг нүд оройлон гайхсан юм даг. Ёлын амыг үзэж явахдаа ёлын домгийн тухай сонсоод Эсхилийн “цовдлуулсан Прометей”-г санагалзан хүн төрөлхтний соёл иргэншлийн хил хязгааргүй урсгалын тухай бид хуучилж явлаа. Харин тэрвээр социализм байгуулаад коммунизмд орчихно гэсэн бидний бардам яриаг даанч тоогоогүй дээ.

Английн зохиолч Жеймс Олдриж “Гайхамшигт монгол морь”, Унгарын Молнар Габор “Сая зоригтны орон”, Оросын Константин Симонов “Зэвсэг нэгт нөхөд” роман бичсэн бөгөөд тэднийг манай оронд айлчлахад би уулзаж учирч явсан хүний нэг.

Социалист орнуудын зохиолчид гэвэл орж гарсан нь олон. Нэртэйгээс Хиргисийн Чингис Айтматов ирж уулын аманд буугаад үйлчилж явсан манай С.Эрдэнэ төсөв хэтрүүлж хэл аманд орж байсныг санаж байна. Тэрвээр хариад “Баатруудын орон” гэсэн тэмдэглэл бичсэн. Гэтэл 2003 онд Казахстаны яруу найрагч гэх Шахановтай хуучилсан ярилцлагадаа Чингис хааныг яргачин дээрэмчин гэж хараасныг нь уншаад би гайхсан. Үүний нь хариуд Казахын нэгэн нэртэй зохиолч “Чингис” гэдэг нэрээ солих болжээ гэж егөөдсөн тухай ч сонсдож билээ.

Евгений Евтушенкогийн тухай цухас дурдах нэгэн учир бий.

Евтушенко бид хоёр чацуутан. Тэрвээр жар далаад онд Оросыг шуугиулж, Политехникийн музей, Лужникийн цэнгэлдэхэд уншигчдыг уухайлуулж явсан “эстрадын” гэх найрагчдын нэгэн түүчээ. Тэрвээр Сибирыг төрж өссөн, омголон, этгээд ааштай, эргэшгүй зөрүүд нэгэн. Евгений Долматовскийд зориулсан

Би Евгений

Та Евгений

Би еврей

Та еврей

Би суутан биш

Та суутан биш

Би баас

Та баас

Та үхсэн Баас

Би амьд баас...

гэсэн хэдэн мөрийг Горькийн дээд сургуулийн оюутнуудаас би дуулсан.

Евгушенко наадмаар ирсэн юмдаг. Гэтэл наадмын талбайд нэвтрэх пропускийг Авто техникийн хэрэг эрхлэх газрын дарга өгдөггүй. Тэр үед төв хорооны гадаад хэлтэст ажиллаж байсан дипломатч Очирбалд илтгэвээс “надтай ярьсан гээд ав” гэлээ. Очтол нөгөө дарга “Очирбал байтугай Цэдэнбал хэлсэн ч чадахгүй” гэж хямсалзав. Аргаа барахдаа Төв хорооны захиргааны хэлтсийн дарга Санжийн Батаа гуайд утсаар, зохиолчдын хорооны төдийгүй Цэ даргын зочин болохыг учирлан “матваас” удалгүй очоод ав гэсэн хариу өгөв. Намайг очиход нөгөө дарга минь нүүрнийхээ бүх үрчлээг тэнийлгэн мишээж нэгдүгээр зэргийн үнэмлэх барин угтав. Бодвол хурандаа мөрдсийг нь мулталж хувин малгайгий нь хураана гэсэн байлгүй. Уг нь хар хүчний элч гээд харанхуй байх албагүй юм шүү.

Евгушенкод манай дарга нарын баталсан төлөвлөгөөг танилцуулахад “Найз минь би насаараа төлөвлөгөөгүй амьд яваа” гэж яхирласан. Засгийн газрын хүлээн авалтад орохгүй гэж ярдаглахад нь тэр үед “Известие” сонины суугуул сурвалжлагч асан Шинкарёв бид хоёр бараг чирч аваачив. Ороод шууд зуун грамм коньяк нэхэж байхгүй бол явлаа гэж бас айлгасан. Би үйлчилгээ аж ахуйн дарга Болод, ёслолын Сүх-очир гуай нараас гуйж амыг нь цавлатал ашгүй Цэ даргийн комиссар ирж түүнийг дээдсийн хойморт аваачсанаар зовлон салж билээ.

Би түүнийг үйлдвэр үзүүлж социалист бүтээн байгуулалттай танилцуулах гэхэд “Тэр яахав, миний найз секслогч эмч ирсэн. Бид усан замаар буцах ёстой юм. Харин чи тэр эмчтэй уулз. Чалх сайжруулах эмтэй яваа” гэж билээ. Дэлхийг тойрон тэнэж жаран наймдах орондоо ирж буй түүнд миний социализмын ололт нохой хориогүй шүү. Бид чинь амьдрал хүрэх нигуургүй аугаа их ирээдүйн зэрэглээнд өөрсдөө үнэмшиж бас өрөөлийг итгүүлэх гэж мунхаглаж явсан билээ.

Монголын зохиолчдын дотоод гадаад энэхүү улирлыг тогтоож намдаа гавьяа байгуулсан байгууллага бол Монголын зохиолчдын хороо юм. Энэ байгууллага 1990 онд улаан бүрээсээ хуулсан гэх боловч өнөөг хүртэл лоозонгийн тасархай өлгөөстэй байж болохгүй. Олон ургалч үзлийн сарнианд зохиолдчыг төвлөн удирдах санааны шавхруугаар яах ч билээ. Тэмээний

“эврээ” тээр жил алдсан шүү дээ.

2000 онд их хурал дээр “Мэргэн шовгорууд” тодорлоо л гэсэн. Гэвч тэдэнд уран бүтээлийн ардчилалын зураг төсөл байтугай хуучин байшингаа эзэгнэх аж ахуйн хөлстэй ухаан байгаагүй. Ямар ч атугай социализмын буурин дээр булай болохыг эцэслэж, шинэ цагийн дэвжээнд тортоггүй тооно өргөхөөс өөр сэхэл байхгүй. Үндэсний утга зохиолын тусын тулд үгсэх нэгсэх зам байх л ёстой.

Монголын Зохиолчдын болон Чөлөөт зохиолчдын эвлэл мянгаад гишүүнтэй юм гэнэлээ. Ийм тооны зохиолч манайд бүү хэл дэлхийд байхгүй. Жинхэнэ зохиолч гэдэг улаан номд орохын дайтай цөөхөн байдгийг бурхан гэрчлэнэ.

Харин дээр өгүүлсэн зуу зуун сонирхогч бол утга зохиолын хүрээг буй болгож түүнээс тодорсон нь зохиолч болж бусад нь зохиолчдын бус, уншигчдын “эвлэлийн” хүндэт гүшүүний тэргүүн эгнээнд залрах учиртай. Хэрэв “зохиолчдын эвлэл” байх юм бол энэ мэт дэг жаяг эрхбиш хэрэгтэй. Эс тэгвээс манз цавны банди нар гавьж нарын толгой дээр дэвхцээд байх болно. Үүнийг иргэний эрхээр далайлгах аваас уран бүтээлийн эрх гэж бас бий. Энэ бүхнээс нягтлан бодоход эвлэрэхэд хэцүү. Чөлөөт уран бүтээлчдийн үзэл бодол, хүсэл зоригийн нэгдэлд тулгуурласан олон эвлэлүүд бие даах буюу нэгэн шүхэр дор тал талаас цуглан зөвших мэт зохист хэлбэрийг хайх нь өлзийтэй. Ямар ч атугай нэгдлийн хонь шиг бүхнийг нэг хашаанд хурааж ган батын домог ярьж суух бидний улирал оджээ.

2004 онд болсон зохиолчдын эвлэлийн 75 жилийн ойн хуралд дээр “Бид үүрдэг ачаагаа үүрсэн. Одоо залуус та нарын ээлж. Бид та нарт зохиол хэрхэн бичихийг заахгүй, бас заалгахгүй...” гэж би хэлсэн.

Өнөө үед шинэчлэлийг модернизмтэй холбож ярих боллоо. Moderne гэдэг нь францаар шинэ, шинэхэн гэсэн үг. Энэ нь манайд шинэ сэргэг мэт боловч зуун насны зулагтай урсгал. Үүнээс урган Символизм (билгэ тэмдэг) импрессионизм (сэтгэгдэл), Экспрессионизм (илэрхийлэл) сюрреализм (ер бусын реализм), постмодернизм (дараагийн буюу шинэ модернизм) гэх мэт олон урсгал буюу “изм”-ийг тоолж болно. Эдгээрийн язгуур нь сэтгэлийн өнгө аяс, сэтгэхүйн дур зорго уран бүтээлч “Би”-гийн чөлөөт илэрхийлэл, зүй тогтлын үгүйсгэл, зөн бэлгийн итгэл хорвоогийн хоормог чанарыг илчлэх мэт үзэл онолын үзүүртэй. Тэгэхдээ алив онол сургаал нь “орон бүхний пролетари нарыг нэгтгэх” хууль биш л дээ. Ницше, Бергсон, Ясперс, Сартр, Фрейд Юнг мэт гүн ухаантнууд болон дээрх урсгал чиглэлээр алдаршсан зураач зохиолчдыг нуршилгүй өгүүлэхэд анхдагч нь агуу их байдаг бөгөөд давтагч нь хумслаач төдий юм. Дорно дахины яруу найраг өвөрмөц утгыг илэрхийлэх үгийн зохицол, хэмнэл нь яруу эгшиглэнг буй болгож цаасан дээр амилдаг. Номын хуудаснаас өндийж чадахгүй хэвтээ шүлэг бол үхдэл. Жишээ нь монгол шүлгээс үндэсний онцлог бүхний нь авч хаяваас хуурын чавхдасыг тасар татах лугаа адил. Эгшиг цацахгүй хөгжмийн зэмсэгээр яах юм бэ. Яруу найрагт үндэсний онцлогоос гадна хүн төрөлхтний нийтлэг шинж бий. “Бидэнд тав бус, тавь, таван зуун мэдэрхүй байдаг ч болоосой” гэж Раблегийн дуу алдсан нь бидэнд харь хахир юм огт бишээ.

Утга зохиолын уван, цуван гарч ирсэн урсгалуудын номлол нь үгүйсгэл буюу “урдахыг ул, хойдохыг зул” болгох нэг л агуулга жамтай байдаг. Үүнээс илүү дэвшилтэй нь үлдэж, бусад нь

цагийн хөлд гишгүүлдэг. Энэ нь шинэ гэж тунхагласан бүхэн нь бус, шинэчлэж чадсан нь оюуны настай гэсэн үг.

Үгүйсгэхийн тулд үндэсний утга зохиол байхгүй гээд хэлчих амны бардаа байв гэхэд үүсгэлийн авьяас, оюуны бэлгүй аваас алслаж эс чадьюу. Өрнийн ертөнцөд өчнөөн олон урсгал чиглэл гарсан гээд Рафаэль, Рембрандит, Моцарт, Бетховен, Бальзак, Шекспир мэтийн суутнуудыг умартаагүй. Их утга зохиол урлаг түүнийг тойрсон урагтай уялдан оршихуйн үлгэр энэ бөлгөө.

Алив “изм” нь үхэх төрөхийн зайны цэг таслал бүхий хүмүүний амьдрал оюун санааны шууд болон дам тусгал, бодитчилсон буюу хийсвэрлэсэн туйлиудын мэдрэмж авай.

Дэлхийн утга зохиолд байсан буюу байгаа шинэчлэл, хуучрал оноо алдааны мэдээллийг бид тарничлан цээжлэж, загварчлан хуулаад яахсан билээ. Тэдгээр урсгал чиглэлийг огт өөр нүүдлийн соёл иргэншлийн хөрсөнд лаахайдан суулгав гэхэд харийн жимс л ургана. Миний хувьд шинэчлэлийн бус загварчлан хуулахыг нээлт гэж үздэггүй, хүний хуучин хөлстэй малгай духдуулахаас сэжиглэдэг. Харин монгол хаягтай шинэчлэл үндэсний утга зохиол, улмаар дэлхийн утга зохиолд тодрвоос магнайн үрчлээ тэнийхсэн билээ.

Бидний улирал хангирсан одож шинэ улирал шилжрэн ирэв. Нам зохиолчдод зөвхөн улаан будаг өгөөд монголыг, улмаар дэлхийг нял гэх болон дарга нар өөрсдөө зогсож байгаа мөртөө биднийг дагаад урагшаа гэж уриалж байсан цаг нэгэнт улирчээ. Одоо бидэнд хэн бугай ч нэгэн өнгийн будаг өгөөд нялуулах юм уу, “Миний хойноос” гэж хашгирах гэвэл санахын гарз. Уран бүтээлч хүн элдэв харийн урсгалд хөвж явахаар эх нутгийнхаа шороог нөмрөөд энгүүн чигтээ нойрссон нь дээр ээ.

Эртний Грекийн Олимпийн уулыг Сүмбэр уул, онгодын хүлэг Пегас хэмээх далавчтай морийг нь гуурст хүлэг, Аполоныг Янжинлхам болгож барлах хэрэггүй. Хүн төрөлхтний соёлын үнэт зүйлс өөр өөрийн өнгөөрөө байг. Цэвэр алтыг шижир, шаарыг нь сааз гэдэгсэн бус уу.

Монголын утга зохиолд шинэ улирал ирж ахуйд ийнхүү улиглаж байгаа маань үлдэх хүн ачаа татах гэсэн нь бус үг дайсан нь болой.

Миний бие суртал номлож сургаал айлдах гэсэндээ бус сайн хүнд санаа илүүдэхгүй муу нэгэнд мугуйд дутахгүй гэдгээр үлгэрлэн өчүүхнээ чамлалгүй өмөлзөн өчвэй. Болгоогтун.

“Ургамал” хэмээх эгшиг бүлэг

Нэг. Намбардагва буюу Гонжийн дог

Намбардагва овгоо Ожноо гэнэ. Эхийнх нь нэр л дээ. Эцэг нь нутгийн явган ховоор бол Яндаг гэцэл гэлцэнэ. Яндаг гуай цав амхарсан гэвч зах тэгшилсэн хар хүн. Амин зуулгын хэдэн малын хойноос хормой өшиглөсөн сиймхий гэрт, сэгсгэр авгайтны нэг. Хулгай зэлгий хийхгүй, хулгар шарыг хавхаар барина. Хоосон хонохын даваанд хонины амь хоролчихож чадна. Эрүү хэлнээсээ болж элдэвт орооцолдохгүй гэсэндээ амаа цоожлоод түлхүүрий нь гээчихсан хүн гэж болно. Тийм хүнээс Намбардагва таны хүү юү гэж асуух хэрэггүй. Тэгээд ч хэлэгддэг хоёрын хооронд хуц, хурганы төс би л лав хараагүй.

Намбардагва бол эрээн булчингий нь ухааж авсан богтос шиг цорой татанхай бөгцөг гайхал. Эрүүний дорхи эрхий дарам хар мэнгэнээс нь хэдэн ширхэг улайвар цайвар үс сэрвийх агаад нүд хөнхөр, дух мөргүү, хамар мөгнүүл. Шүд нь унаж хоёр ширхэг дорсгой шар шүд үлдсэн болохоор би нэг удаа “Өвгөн Дорсгойн хууч буюу даалууны гуншин” гэсэн юм бичиж хэвлүүлээд нэртэй хүний зүстэй хүүг хорвоо үлдээсэн шүдээр нь дайрлаа гэж хохилзуулж билээ.

Намбардагва бид хоёр бага дунд сургуулийн осгоруут жаалууд. Тэрбээр тоонд бузгай тул гэрийн даагавар хийхэд би царайчлана. Харин биеийн тамирын хичээлд би нохой хорихгүй. Намбардагва модон моринд лоовууз тавьж харайна. Сүүлдээ “сонс Гомбосүрэн” болно гэж савлуураас олгой шиг дүүжлээстэй байдаг, бас хэд эрэгдэг болж билээ. Тэрвээр долоовордож, нүдээ жартайлгаж байгаад өдөрт л нэг хоч бидэнд зүүнэ. Би хариуд нь арзгар үстэй, нусгай түүнийг “сааргай”, “самалдаг” гэхэд “Сайхан үс босоо л биз самалдагны шүүс дусаа л биз” гээд халгаахгүй. Хожуухан “Гонжийн дог” гэсэн амны уншлагтай болж түүгээрээ насан турш цолшсон билээ. Энэ үгийг “ямаат” чавганцаас сурсан гэж цаашлуулахад “Царай муутай охиноо, цайн сүүний ямаатай хоёр үгээр холбож өгсөн юм. Сайхан хүүхэн сармай дээлийн өвөрт тогтдоггүй, торгонд боодолтой, тогооны бариул болдог юм” гэж ханхалзана. Залуу зандандаа хонины бэлчээр хотны захад охид хүүхдийг үргээж цочоосоор “ямаат чавганц” хэмээхийн ганц шар охинтой хөл хэрсэн юм. Эхнэрээ цаашлуулж бурхны солгой гарын хишиг гэнэ. Дөрвөн ханатай гэртэй, гурван шар жаалтай болохоор нэг хана дутаад нэмэх гэхээр нэмнээ хүрэхгүй байна гэж алиалдаг сан.

Намбардагва сэтгэл цагаан, тусархуу, хажуу хавиргандаа хал балгүй. Харин ам гэж там, хэл гэж шөвөг. Үүнээсээ болж сум, намд дуудагдаж хааяа хошуу хайруулах боловч үгээр хожиж үнэг шиг бултаад зайлчихна. Сумын дарга түүнд амаа татаж яв гэхэд “Уг нь үдчихмээр байна, уух идэх хоёроос л болоод байна” гэсэн гэдэг. Ноосны дутууг нэхэхэд “суга салтаа хоёроос өөр газар сул үс байхгүй” гэж хэдэрлээд намын даргаас банга авч гараад “зүсгүй малаас үс хурааж, зүүгүй утсаар дээл хавах гэнэ” гэсэн гэдэг. Нэгэнтээ их замд тулж буусанд багийн дарга бөөдий Ойдов гуай “аймаг хотоос яваа албаны хүн ороод мань мэтийг гоочлоод байж магадгүй. Чи жаахан буурь сэлгэж үз” гэхэд “Орьё гэвэл омгор овоохой байна. Оочъё гэвэл сэтэрхий шаазан байна. Залхуудаа биш ядуудаа замын хөлөөс хишиг горьдсон юм. Захиргааны үгэнд орох тэнхээ алга. Засаг хүчтэйгээрээ замаа холдуулаг” гэж л дээ. Ойдов гуай үгээ барж чамайг яая даагэвэл “Хоршооны хоньтой холбоот руу туучих, тураг нь байвал туранхайдаа

зүгээр гэсэн байхаа” гэж таглажээ. Сумын шинэхэн эмч буугаад “ариун цэвэр муу байна. Хир тоосноосоо салахгүй бол хатуу ярина шүү. Би биш нам хэлж байна” гэж дүрэмдэхэд “Доодосдоо бараан миний дүү дотроо угаачих. Гадаа гантай ус байгаа, Гадраа би аргалая” гэж хэгжүүрхжээ. Таван сумын төлөөлөгч Раднаабазар гуайг ороход аягаа долоогоод хормойгоо арчаад цай хийж өгснөөс сэжиглэж, цаадах нь дахиж шагайгаагүй юм гэнэ лээ. Би түүний ийнхүү балайрсныг зэмлэхэд “элээ дасвал ээзгий шүүрнэ, хэрээ дасвал нүд ухна. Үргээхгүй бол үг зөөгөөд болохгүй” гэж дарвайтал инээж билээ. Нэг удаа ам цуурсан хэргээр суманд дуудагдахдаа “Энэ муу морь эмээлээ аваад буцах болов уу” гээд морджээ. Сумын даргад:

-Уутанд хийх тамхигүй

Ууранд нүдэх цайгүй

Хананд наах эсгийгүй

Хавирганд наах даавуугүй гэж

Заяагүй толгойгоо хэлсэн болохоос засгийг хэлээгүй гэж мултарсан нь өөрийн нь бус зэргэлдээ сумын “шувуу Даш” гээчээс зээлдсэн үг гэж надад хэлсэн юмдаг.

Тэрвээр нэг хэсэг даалууны дон тусч явсан юм. Миний санаанд үлдсэнээр бажгар арвыг

...Банчин богдын балин хар

Багийн даргын банхар хар

Ах ламын арсаг хар

Авгай хүүхний барсаг хар...

Бөхөөн дөрвийг

..Ор дэрний холио

Оймс гутлын солио...

Улаан есийг

...Улаан есөн жадуухай

Усан хулгана шалдуухай

Ухаан алдам цээмээхэй

Уран хуруут сээмээхэй

Урд хормой унжаахай

Угж хөхөөд унтаахай...

гэхчлэн нутгийн даалуучдын гуншин дээр түүний хачир бишгүй байв. Харин ойрмогхон хэлдэг даалууны гуншингийг нь энэ номын сүүлэнд хавчуулав.

Гонжийн дог охид хүүхнүүдийг ичээж “алтан түлхүүр мөнгөн цоожиндоо тааруулаад авгай болоод ав, айлд очиход амар” гэж цаашлуулаад

...Ямаатын хүргэний амыг

Яр идэх нь яав

Яр идсэн хойно нь

Ялаа баах нь яав...

гэж дуу гаргуулж явсан удаа бий.

Харин тэр зэвүүгээ хүрэхээр “явгий бух маад” гэсэн орос хараалын сэгтэй болсон. Үүнийг хэнээс сурсныг мэдэхгүй.

Гонжийн дог долдугаар ангийн гэрчилгээ хумхиж өвөртлөөд, эхээ орхиж чадахгүйн эрхээр цөвдөл төдий малын хойноос цөлхөлсөөр цэрэгт явсан. Эргэж ирээд нэгдлийн унжуурга горьдож шөлний хэдээ нийгэмчилж, хувьсгалт намын гишүүн болсон ч гавиагүй. Газар алгадахын даваанд хот бараадаж морь тэрэг чирж эхнэр хүүхдийнхээ нуруу цорой хоёрыг арай нийлүүлчихээгүй. Бөмбөгөн дугуйтай арал дээрээ албаны дугаартай тэргээ “Овьёос идэж ус уудаг, орос мэдэхгүй монгол зим” гэж гашуулдаг байсныг нь санаж байна. Одоо хүүхдүүд нь өсч барж биш харж цадах хоолтой, долоон буудалд хашаатай, амбаартай довоо шарлуулж яваа.

Гонжийн дог эрдэм нэвтгүй ч эрийн хар ухаантай. Түүнийг элэг барьж болохгүй. Ном унших донтой хүн гэвэл тэр. Айл амьтнаас царайчилдаг юм нь ном. Сонин цаасханаар хулдаж гамтай уншаад хэлсэн амандаа эргүүлж өгнө.

Гонжийн дог намайг дагаж тавиад оноос тэр үеийн зохиолчидтой хөлхөлдөн дотор халааж уран зохиолд холбооссон хорхойтон.

Дамдинсүрэн гуай, Ринчен гуай хоёрын сүрэнд дарагдаад ойртож чадаагүй, тэгээд ч цаадуул нь элдэв шалдиргүй, эрдмийн эн ихтэй болохоор Гонжийн дог хүзүү гүрдийгээд ч хүрээгүй. Хоёр өвгөн бол түүний хувьд хоол зооглодог бурхад. Тэр хоёрыг дайрах тоолон тэрлэгэн дотроо цээж хэмхэлж “Наранд ульж саранд хуцдаг тэнэгүүдийн толгойгоор тэвэг өшиглөхсөн” гэж гаслан хорсоно. Энэ нь зөвхөн түүний этгээд ааш бус элдэв, бусчирт монгол элэг дөрдийх унаган хар ухааны хаялага. Хар ухаан хэмээх бол амьдралын гүн ухаан мөн.

Намайг Бээжингээс ирэхэд хамгийн түрүүнд Гонжийн дог хаалга үүд сэвж мэнд мэдээд

шингэн сүүний ээдэмцэр хөөрөг сарвайнгаа,

-Зургаан жил зулраад, зулгаа элэгдэхээр нутгий шороо руу мөлхөв үү. Хубилай хаан шиг хужаа хүүхэн, гүнцэг хоёрт хуухнаг, ходоод хоёроо уяулчихалгүй яаж мултраа вэ гэж мар мар инээсэн юм.

Би түүний хариуд:

-Үс цайж үе царцаад үнсэн дээрээ хөрвөөх гэж ирлээ гэж цаашлуулбал

-Гонжийн дог! Чи тэнд бичсэн нэг шүлэгтээ “Монгол улсаасаа уяатай, модон идүүртээ угаадастай нохой” гэсэн байна лээ. Болж дээ. Үйтэн хуар дээр биш үхрийн адсаган дээр өсөө биз дээ. Улаабаатарт доож горьдож сууснаас Эрээн ууландаа очиж дээж хүртвэл яасан юм бэ. Энд чи өнгөрснөө өмөөрч хороо хорины хурал дээр хошноогоо эргэтэл бахирсан төгцөг болохоос өөр юу л хийгээ аж. Шүлэг зохиолын чинь шүд унаа биз.

-Уг нь өвгөрчихгүй санаатай уллаад үзлээ. Гэвч уулын чулуу бэлд буудаг гэдэг дээ. Тэр яахав, хот хүрээгээр сонин юу байна даа.

-Толгой эргэж тогоогоороо шанагаа хутгаж л сууна. Жасрай сайд нүхний цаана гэрэл байна гээд байдаг ч над мэт нь нүд гүйцэж харахгүй юм. Тэр хашир халзан бурхи аль тусаалын амаар шагайсныг бүү мэд.

-Эвслийнхэн яаж байна вэ?

-Өөрсдөө цээж дээгүүр өрдөг болохоор өвгөн ах хөл рүү нь орчихдог бололтой юм.

-Харь оронд бол халагдах солигдох гэдэг Яндаг гэцлийн ямаа муулахаас амархан байдаг бололтой юм.

-Манайхан ямар бух солихоо мэдэх биш... Зовлогоо даахгүй болсон амьтны өмнүүр үнээгээ гилчихээд ирэх жил нь ихэр тугал горьдож суудаг улс. Гэцэл гэснээс өөөдсөн гэнэлээ.

-Чи толгойгий нь түшээ биз дээ.

-Үгүй чиш. Эцгээ би мэдэхгүй. Эрхбиш хүн юм болохоор эр сүвтэй юмны буу алдсан буг л биз. Хөдөө газар хөлстэй тохом хөглүүлэхийг алийг тэр гэхэв. Чи ч гэсэн Цэндээхүүгийн шилбүүрт гувруу гүйж л байсан даг.

-Чи чинь Буянзаяа наймааны охинтой нохойтдог л байв даа.

-Сайхан амьтан байсан даа. Олон жил ор дэрний зай харсан юмсан. Намын гишүүн болж байж л больсон. Засчих гээд байсан шүү.

-За за, намын дарга чинь багт гарахаараа Бадам гуайн охины орны банзыг үйрүүлж байсан л гэдэг.

- Тэгж ярьвал Маршал Чойгоосоо эхлээд малгай тавьж явсан гэдэг биз дээ. Харин муу Бал дарга л байцааны шөлтэй шувтарсан байх. Танай Сэнгээ, Чимид хоёр ч тамхилчихдаг л байсан. Мартсанаас талийгаач Пэрэнлэйн Лувсанцэрэнг “самсаа нь шарлаад, энэ л миний шийрийг хатаана гэж Чимид хэлсэн гэдэг үнэн үү.
- Тэгж ярьдаг л юм. Одоо ч гэсэн чи охидын хормойг нүдээрээ сөхөж л байгаа биз.
- Цөг! Авгай хүүхэн аль хэдийн аманд ороод арьяабал болсон. Тэр яахав. Манай нутгийн хэдэн дөмөг хүүхнүүд дандаа давхар ханьтай байсныг чи мэднэ. Тэгэхдээ эрчүүл хоорондоо ам муруйхгүйг нь яана.
- Одоогоор бол нууц амрагийн ил хэлбэр юм даа.
- Тэр сэкс гээд “жогоо”-г л хэлээд байна уу даа. Харин чамаас сониныхон асуухгүй юм уу?
- Нэг удаа оролдсон. Тэгэхэд нь би наад асуултанд чинь хариулчих надаас тэнэг хүн олон бий гээд нүүр өгөөгүй. Харин чи нүглээс гарсан бол хийд бараадвал яасан юм бэ?
- Гонжийн дог. Тэнд чинь сахилаа салтаалсан нь олон байдаг юм биш үү.
- Тэртээ тэргүй танай намыхан бурхны шавь болсон биз дээ?
- Танай ардчиллын бухандайнууд ч гэсэн бурхан ширээ шөргөөлж л байгаа харагддаг. Энд нар цөм Эрээний бараа! Ярих үг алга. Харин залуу насаа дурсахад заамаа ярж цээж рүү салхи орох шиг болдог.
- Тэр цаг дэндүү холдож дээ.
- Тэмээн дээрээс нар ойрхон гэдэг шиг орон дээрээс охид ойрхон байж. Одоо бол ширээн дээрээс шивэгчин ойрхон гэдэг болоо шив.
- Яана гэнээ?
- Яах юу байхав. Дарга нарын үүдэнд суудаг охидын тогоо бөгсөнд эзэд нь эзэгийг буцалгадаг л гэлцэх юм.
- Дарга бүхэн тиймгүй байх.
- Чи ч яахав, даргад хайртайн ачаар далавчтай яваа хүн. Би бол хамраа духандаа зангидаж, айлын худгаас азаргаа усалсан тэр дамшигуудыг харахаар нүд хорсдог хүн.
- Шинэ цагийн дага нар өөр болоо биз.
- Хулхидах, хуухнагдахаараа бол хоорондоо нэг сүлбээртэй хоёр ходоод.
- Чи чинь цуурдаг хэвээрээ юмаа?

-Гонжийн дог ам цуурсан хэргээр аваачаад хийчихдэг нь аядсан. Тэгэхдээ “До” яамны доогуур харцтай гөлтгөрүүд улан дор нүдээ, утсан дотор чихээ дэвсдэг гэнэлээ.

-Өөрчлөлт, шинэчлөлт болсон шүү дээ.

-Гонжийн дог, өөрчиллөө гээд өмхий ёзоор нь хаачих вэ. Улсын эрх ашиг гэж донгодоод улаан хоолойд хутга хавирч чадна.

-Чи тэгээд юу ч өөрчлөгдөөгүй гэх үү?

-Улаан, цагаан хоёр нохойтой л болсон юм уу даа.

-Өмч хувьчлалаар чамд өвчүүний хуруу олдсонгүй юу.

-Юу олдох юм бэ. Хувааж гудраад хуурай сайран дээр намайг хаячихсан. Хөдөө малгүй байсан болохоор хөгшин хонины шээнгий ч надад олдоогүй. Хотод орон сууцгүй болохоор хороололын шороо ч алган дээр ойчоогүй. Ард түмэн гэдэгт нь над шиг юм ам дансгүй юм байлгүй. Чи ч гэсэн олон жил эзгүй байсан болохоор чигчий ороох сур үлдээгүй. Намайг бодвол нар бороо хаах чулуун хайрцагтай л үлдээ юм биз.

-Олон засгийн газар солигдоод ч нэмэргүй юу?

-Дүндээ дүн. Энхсайхан гээд л хуйв тэсгээдэггүй эсгэл шиг зүтгэдэг нэг хүү байлаа. Дараа нь даллаганы сав шиг Элбэгдорж гээч хүзүүгүй банди гарлаа. Тэгээд Наранцацралт гээч намрын ооно шиг хархүү. Одоо Амаржаргал гэж морин харцага шиг залуу байзнаж байна. Уг нь эрдэмтэй сайхан залуус. Даанч толгой хаялж байгаад хүний өөрийн нохойд хүү татуулчих юм.

-Ирэх жил сонгууль болохоор учир нь олдоно биз?

-Юу л базаав гэж. Хуучин дээлээ их л удаж сэгсэрч нөмрөнө биз. Хулхин дээр яргуй ургатал худлаа шааж мордоод, дөрөөний нь сур тэсвэл дөрвөн жил шогшино биз. Энэ хугацаатай чинь зүгээр юм хө. Аяга нь биш ч гэсэн ам нь солигдох юм.

-Муу хөгшин чинь амьдралаас тасарч гүйцсэн болохоор одоохондоо учраа олоогүй л байна. Уг нь зах зээл гэдэг ч зөв юм шүү.

-Гонжийн дог. Зах нь нэлийсэн, зээл нь талийсэн бололтой. Манайхан хойно дэлхийгээр хэсч, ногоон мөнгө гуйгаад нохойд бариулчих гээд явдаг гэж дуулдах юм. Худлаа үнэн гөрж хэдэн юм салгаад, хуваагаад залгичихдаг юм даг уу даа.

-Чи ч бүр улс төржиж гүйцжээ.

-Гонжийн дог, тогоо харлахаар толгой цайрдаг юм байлгүй.

-Намын гишүүн хэвээрээ биз дээ.

-Хуучин улаанаа хураалгаагүй. Нүүр дахлаж нүгэл халхалж байсан юм шүү. Одоо ч олон жилийн өрний “обилгооз” болж. Өдий насанд нам солиод там солихын нэмэр. Харин надаас бусад нь нам байгуулчих шиг боллоо. Архичдын нам, амрагийн нам хоёр л дутуу байгаа даг. Хөөрхий тэр Зориг гээч хүүг алчихлаа. Чи дуулаа л биз.

-Дуулсаан. Эзэн нь олдоогүй л байна уу?

-Гэрч нь дэргэд байхад, гаднаас сураглаад байгаа бололтой юм. Яахав дээ тэгж байгаад нэг үйлтэй амьтанд өмсгөөд олчихлоо гэж орилно биз. Тэгээд л хамсаатан эрж, өстэй бүхнийхээ өвчүүг хадах байлгүй.

-Төр түмэн нүдтэй, олдох байхаа.

-Цагдаа тагнуул хоёр тэр нүд нь юм бол цагаан уначихсан байлгүй. Сохор амьтад тэмтэрч яваад тээглэж үхдгийн даваан дээр онь тааруулж одон шүүрээд л данс дугуйлах байх даа.

-Чи арай үзмэрч болсон юм биш биз?

-Зурагтын Гүрбазар л зууны мэлмий гэж нэг дэлүү шиг юм суулгаад л ус цутгаж уулан доогуур шагайлгаад байсан даг. Үзмэрч л юм гэнэ.

-Манай Дашбалбарын найз шүү дээ.

-Тийм байх аа. Гэрлэнд нь орчихоод гэрээ олохгүй айлд хонож явна л гэлцсэн.

-Хотын ховыг яасан сайн мэдэг юм бэ.

-Хөнжил гудас, хөх дэлэн болсон сонингийн тасархай шагайдаг юм. Худалдаж авах мөнгө байхгүй болохоор ганзгын сонины дэргэд зогсч байгаад сохолздог гэх үү дээ.

-Оюуны хулгай шүү дээ

-Ухаанаар биш унгадагаараа цоохорлодог цаас. Удаан шагайвал өмхий үнэртнэ гээч.

-Чөлөөт хэвлэл гэдэг их олз.

-За даа мэдэхгүй. Аль нэг мөнгөтэй эзний ар өврөөс уяатай улихчаа болж байдаг юм биш үү.

-Сэтгүүлчид бузгай ажиллаж байгаа шүү.

-Гонжийн дог. Бүтэн нэртэй хүн үлдээлгүй бүгдийг шүлсдэж орхилоо. Гадаадынхныг дууриаж галуу ч болдог хэрээ ч болдог, хэдэн дуучин хөвгүүд охидын дотоожийг шиншлэж байдаг бололтой юм.

-Мисс-үүдийг...

-Аа тийм. Хэдэн шалдан охин жагсаагаад хэн нь хөөрхөн бэ гэж шовойлгодог гэнэ. Зурагтаар

харахад зүс үзсэнээс дуучин Хайдав, танай дэлдэн Бадарч хоёр амсаж үзээд аль таалсандаа алт мөнгөн сэрээ өлгөдөгөөс гараа гэж үү.

-Чи дандаа давсыг нь ихдүүлдэг шүү.

-Солио ихдэхээр холио хэрэггүй болдог юм байна. Чихэр хийгээд байхад л чинжүү дарвигнана гээч.

-Загвар өмсөгч хөөрхөн охидтой болжээ дээ.

-Гонжийн дог. Буянаа барчихмаар олон огтоохой, навсайхай сольж өмсөх юм билээ. Өлгүүр болгож гуя хасы нь гялалзуулаад, өмнүүрээ ёндогонуулж байгаа харагдах юм. Өгдөг авдаг нь тачиргүй бол өл залгах шуу юм биз. Энэ ч яахав. Том дэлэнтэй эм шалгаруулж байгааг яах гэв.

Өвдгөө хүрсэн дэлэнтэй нэг хөгшин мамыг харуулна билээ. Базарваань. Тэр лүд дээр над шиг юм гарвал үнээний хондлойд суусан шаазгай болох байлгүй Явгий бухмаад...!

-Тэрийг нь хэн шалгадаг юм бэ?

-Танай зохиолчид хаа очиж харагддаггүй юм. Шавилддаг байлгүй.

-Чи бүгдийг нь танихгүй шүү дээ.

-Чиний нөмөрт хоргодож хэдэн сайцуулд нь хэлээ зангидуулж үзсэн. Одоо ч олон жаал шулганаж байх юм. Овьёос нь юм уу, авьяас нь юм уу би яаж мэхэдэв. За за больё. Байдгийнхаа барааг харж, бариул шиг чавганцыгаа бантанг долооё. Эр эм хоёр өтлөхөөрөө элгээрээ нийлэхээ байж эмээлийн бүүрэг шиг араараа нийлдэг юм байна. Хорвоо гэдэг хүнээр тоглоод уйдахаараа хоёр тийш харуулж байгаад хойд энгэр рүү чулуудчих юм даа. Орж гарахад ойрхон боллоо. Хөгшин чинь хөл солбиж байвал, хааяа нэг шургаж ханзархайгаа шидүүлж онгорхойгоо оёулж байя. Ам халсан дээр бас нэг юм бурах уу?

-Чамд чадахгүйн зовлон байх биш дээ.

-Гонжийн дог. Цаг эргэхэд царцаа бүргэд болдог шиг байна. Цаад хотонд чинь гөлөгнүүд боргоод байгаа юм биш үү. Чи эрхбиш урд хойдын завсар утаа тавьж байгаа ухаантай юм бол “жов” гэж хэлмээр юм. Уран зохиолд олон жил дэлүүрсэн болохоор хоёр их буурлаас эхлээд өчнөөн зохиолчийг нулимаад байхаар өмөөрөхсөн гэж өр таталтаад байх боллоо. Түүхий хүү бэрс болж, түрийний бөөс толгойд тоглох болоогүй л болов уу. Тэнгэрт харавсан, газарт гавлуулсан аль нь ч чамтай зулай дараагүй гээд зураг нийлсэн шүү дээ. Яллагчаа байя гэхэд ядахдаа гэрчийн мэдүүлэг гэж бий. Явгий бухмаад...!

Би цочирдосхийгээд түүнд товтой юм хэлсэнгүй.

Намбардагвад хайрцаг янжуур, дүлий манан хөөрөг ганц ваар хатуу юмаар гар цайлгахад,

-Гонжийн дог! Явсан хүний ясны тос зуулаа. Янжуур тамхийг татаж янлиу миглүү хүртэх

өдөр байж л дээ. Тэр яахав, чамайг цаас битгий шагай гэлтэй биш. Муу хөгшин нь бичиж бардагсан бол зохиолчдын талаар хэдэн үг хэлхмээр санагдах юм. Надад донгосохоос өөр долоох юмгүйг чи мэднэ. Харин чамайг бичвэл хоёр улцандаа дуран зоогоод ч болсон уншихыг бодно. Их хүнийг бага нь сургах гэдэг илүү гэрт эхнэр авчрахтай адил. Тамхи олдож талх холдов гэж үглэсээр үүдэнд очсоноо эргэж

-Би чамаас нэг юм асууя. Хэн нэгний чинь сэглэж байхад хэлээ сугалуулчихсан юм шиг та нар боргосон уу. Хоёр маршалын чулуудсан хоосон булуунд буйлаа ураад л хэвтэж байсан. “Ардын дайсан” гэхэд нь алга хавсраад л номыг нь ноцооход галд нь гараа ээгээд л сууж байгаагүй гэх үү. Ер нь та нар хэнийг өмөөрөх юм бэ? гэж хяламхийгээд арилав.

Энэ үг намайг цочоож, хэдэн үг хэлхэх санаа сэдсэнийг дашрамд өчсү.

Хоёр. Уянгын ургамал

Гонжийн догийн шар тэгтэл гозойж байсныг би санахгүй юм. Түүнээс хиншүү ханхлах шиг болсон шүү.

Тэрвээр аяга цай амхраад л,

-Гонжийн дог, голионы мого гэж цэхвэлзэв.

-Чи чинь юу болоод хуурай агсамнах нь энэ вэ?

-Цаана чинь “Болор цом”-ын хэдийн борви тойгоор шөл ууж байгааг чи мэдэхгүй байгаа юм уу. Мэдсэн ч мэлхий шиг мэлтийж суугаа юм уу?

-Яахав, хүүхдүүд зүтгүйтээ л биз. Нисч яваа шувуу руу чулуу шидсэн хүн өрсөж зайлахгүй бол өндрөөс унахдаа өөрийн нь толгойд гэдэг.

-Чиний цэцэрхэл, чихний нүх онохгүй байна. Яруу найрагчдыг ялааны баас болоосой гэж би боддоггүй хүн. Нацагдорж, Буяннэмэхийг нас гүйцэж мэдэхгүй. Сэнгээгийн салхинд дальдарч, Чимидийн шуурганд уруудаж, цоохор Лхамсүрэнтэй ганхаж, Дооровт дооглуулж, Цэдэндоржийн амнаас үг унагах гэж ядаж, Чойномтой гудамж метрлэж явлаа. Одоогийн чөмөгтэй хэдийг нь жилд ганц удаа харах юм. Ном авах уранхай янчаангүй мань мэт нь зурагтаар шүлэг чагнаж болохгүй юу. Бас хэн ч гэнэв нэг банди “Монголд яруу найраг байхгүй. Надад арав манай авгайд хориод юм бий” гэснийг би үсэглэж байгаад уншсан.

-Тэнгэр тэмтэрдэг яруу найрагч гэсэн байх шүү.

-Хэн тэгээ вэ?

-Дэгдээхэй Батбаяр.

-Танайхны нэг нь “Дэлдэн Бадарч энгэр тэмтэрнэ, Дэгдээхэй Батбаяр тэнгэр тэмтрэнэ” гэсэн нь тийм учиртай юм уу?

-Чамд дуулахгүй юм байх нь яадаг юм?

-Хоёр навч минь одоохондоо онгорхой байна. Чи л намайг тоодоггүй болохоос бус “Халгай” Цэрэнжамцаас эхлээд хамраа зангидчихаагүй хамууд надад бий.

-Халгай нь ч юу вэ дээ?

-Хэн мэдэхэв. Халуун шатаж хажуудахаа түлж явдаг гэсэн юм байгаа биз.

-Чи ер нь яруу найрагч болох байж гэм.

-Гонжийн дог! Нойтон толгой нь номонд эвэрсэн бол нохойд барих модтой яваа ч билүү.

-Гонжийн дог минь! Хэрэггүй юмны төлөө хэнхдэг маажгаад яахав дээ.

-Улсад хэрэггүй цээжийг урагнаа ч яадаг юм бэ. Ганц жин ноолуурын үнэтэй тэтгэвэрийн зовлогыг гал руу хийнэ үү, ус руу шиднэ үү гарз байхгүй. Өмөөрхөө аргад, өслөхөө тархид гэдэг. Тэр Цоодолын хэлээд байгаа навсгаруудад чинь би сүжигтэй хүн. Бавуугийн бавзага байна. Үс хялгас нь ногтроод, үнс утаа цацаад чичигнэж, татганаж байх нь харын бөө шиг харагддаг. Тэр гайхал Хөхөчү билүү нөгөө Тив тэнгэрийн сүнс байлгүй. Чи асуусан уу?

-Үгүй чиш.

-Төрөхөд нь Өнжүүлийн хөх билүү хагарч, хаш чулуун бийр янтай гарахад Хангарьд шүүрээд тонон дээр нь “яруу найрагч” гэж дуу алдахдаа тогоотой сүүнд нь унагачихсан юм уу?

-Яана гэнээ?

-Гонжийн дог. Тэр Цоодол гэж хэл нь жижигдсэн луугар жингийн лут хар хонх шиг дамшваа, Бадарч гэж чихнээс нь хүртэл нулимс гоожно. Тангадын Галсан гэж наян найман намжир, Цэндийн Чимиддорж гэж дэлий нь талалсан Дэрэнгийн билүү хар азрага, Дамбын Төрбат гэж хуйхалсан таахай, Хулан гэж хуван хөөрөг, Ичинхорлоо гэж хулсан сүмбэ, Мөнхцэцэг гэж тортой хэрэм. Бүгдий нь би өхөөрддөг. Хөөрхий муу Очирхүү, Доржпалам хоёр насалсангүй. Бас танилцаж амжаагүй хэн хэн ч билээ?

-Цаадуул чинь нэр төрөө сэргээлгэнэ гээд мөнгө нэхвэл яана.

-Гонжийн дог. Ээдэм нь эгшиж эргээ нь гарсан улс тэгдэггүй юм. Харин чи эднийхээ тухай хэдэн үг хэлхээд чулуудчихаач гэж хэлнээс чинь чангаая. Шартай нь шазвалзаж шархтай нь татвалзаг. Хондлойд агссан сүүлий нь хоёр борвинд нь буулгахгүй бол хошног нь хөлдөнө. Явгий бухмаад!

-Цухалдаад яахав. Залуу насанд заан шүүрч арслан руу чулуудмаар санагддаг шүү дээ.

-Аархаад араа ургахгүй, сайрхаад санчий нэмэхгүй гэж Яндаг гэгцэл хэлсэн гэдэг юм. Талийгаач чинь чойго өвөртлөж чойрт хурсан юм гэнэ лээ. За за хазаарын амгай дөлрөөд хадуурдаг нь боллоо. Миний гуйсныг ходоодныхоо мухарт хийчихээрэй гэсэн юм.

Би түүний үгийг хааяа санавч залхуугийн гар завагт хүрэхгүй байсаар зовон зүдэн эвлүүлэгчээ болов.

Яруу найрагч гэдэг нь грекийн Poilsis (бүтээх хийх) гэсэн үгээс оросын стихи гэдэг нь грекийн stichos (мөр) үүдэлтэй. Манай шүлэг гэдэг нь самгардаас сунжирсан бадаг хэмээх үг юмсанж. Дэлхийд яруу найргийн гол нурууг өрнө дорнын гэсэн бүдүүвчээр ялгах нь буй.

Энэтхэгийн гайхамшигт судар “Шрирамш-чандраан тууж”-д “Яруу найрагчийн ур ухаан минь үзэсгэлэн төгөлдөр сувдыг агуулах лавай буюу” гэжээ. (Ж.Гэндэндарамын орчуулга) Үүнд дорнын цал буурал яруу найргийн тайлал оршжээ. Ур, ухаан гэдэг хоёр үгийн нийлэмж нь сэтгэлийн эгшигт утгыг нийтгэн чухамхүү яруусган өгүүлэхийг шүлэг хэмээх санаа энд тод байнам бус уу.

Монголчууд нэн эртнээс яруу найргийг эрхэмлэж ирсэн нь дээдсийн сургаал, гүн ухаан, элчийн үг зэргийг шүлэглэн хэлж, хүний ой тойнд хүргэдэг байжээ. Үүнээс уламжлан бичгийн яруу найраг буй болсон гэхэд ташаагүй. Зарим хүн Монголд бичгийн утга зохиол ерээд онд үүссэн мэтээр “онолдож” буй нь мань мэтээс төдийгүй, түүнээс алсын дээдсийг бичиг үсэг үл мэдэгчийн хэмжээнд аваачиж байгаа хэрэг. Бурхан багш сургаалаа айлдсан хэлийн дотор Хүннү ордог гэвээс Монголын бичиг соёлын түүхийн сурвалжийг лав л хоёр мянга таван зуун жилийн чанадаас эрэх нээ. Харалган хүн хараа хүрээгүй бүхнээ байхгүй гэдэг юм гэнэлээ. Мөхс би бол тэдний үнэлгээгээр аман зохиолч юм гэнэ. Яахав дээ үндэсний яруу найргийн угж хөхөж өссөн нь үнэн. Муу бичдэгээ хүлээнэ. Харин унаган хэл болон бичгийн тухайд гэвэл бидний хооронд уурга, шилбүүр хоёрын зөрөө бий гэж бардамхан хэлнэ. Үүнийг үл өгүүлэн өүүлэх ину:

Болор цомтнууд бол эрх дарх, эд агуурсын илүүцгүй, гагцхүү өөрийгөө өрдөж, шатаж дуусах хувьтай яруу найргийн борчуул. Тэд алдар шагналд ивлэж бус амьдралд өөрийгөө толхиж, авьяастай төрснийхөө төлөө аз жаргалаа хугаслах үйлийн үртнүүд. Уншигчдаас урмын хишиг, утга зохиолын саарал урсгалаас атаархлын булингар цацуулсан тэд цагаан хар ачаатай цагийн буулганд өөрийгөө хөллөсөн алжаалаас салж амаршлыг олох төөрөггүй.

1983 онд молхи би “Болор цом” нэрийг оноож анхны наадамд нь “начны найраа” гэдэг шиг “Хүн төрөлхтөнд өргөх үг” хэмээх нийтлэлийн шүлгээр торгон бус тоостой жолоо өргүүлсэн юм. Энэ шүлэг дайн дажныг давшлан зандарсан учраас үнээ алдсан гэхэд үнэнийг алдаагүй юм. Түүнээс хойш хорин жилийн дараа Нью-Йоркт тэнгэрийн хос багана хэмээх худалдааны цамхаг булш болж Испани, Саудын Араб, Ирак, Орост амьд бөмбөг дэлбэрч үй олон хүнийг үнс болгож буйг цагаатгаж болно гэж үү. Иракт дарангуйлал, түрэмгийлэл хоёр цусаар “наадаж” Бин Ладены хар савар дэлхийн голыг тэмтэрч, Изриаль, Палестин хоёр үхлийн хурим хийж буй нь падгүй гэж хэлэх эрх одоо ч надад байхгүй. Шудрага бусын орчлон алагчлалгүй болж ариусах тухай мөрөөдөхөд ч эрт байна.

...Алтан нарны хүүхдүүд ээ

Аугаа их хүн ард аа

Аажуурвал аюултай

Амь нас байтугай

Амьтны гэрэлт ертөнцийг

Алдаж болох аюултай... гэдэг анхааруулгыг өчигдөр хэлэхэд эртдэхгүй, маргааш бол оройтно.

2000 оны “Сэрүүлэг” сонины хуудсанд Ж.Баяржаргал хэмээгч “Болор цом, хамгийн муу шүлэгтэй хамгийн болхи яруу найрагч дээгүүр давхидаг. Жишээ нь Д.Пүрэвдорж гуайн “Хүн төрөлхтөнд хүргэх (өргөх) үг 1983 онд түрүүлж байлаа... Нэг бодлын инээдтэй л байхгүй юу” гэжээ. Энд би өөрийгөө өмөөрөхгүй. Харин “Болор цом”-ын хамгийн муу шүлэгтэй болхи яруу найрагчдын хажуугаар магнайдаа тоосгүй өнгөлж чадаагүй морины цолыг дуудаж чадахгүй. Өршөөж хайрла! Мөн “81-р суваг” сонинд Аюурзана авгай “Эл яруу найргийн наадам нь завхарсан балай юм болоод...” хэмээн ширэвгатаад ичдэгээ гайхжээ. Энэ үнэн бол гутамшгийн жигшлээс дутаан гайхамшигийг бүтээх агууралд өөрий нь ирлэсэн байгаасай. Эс тийм болвоос салхины өөдөөс сарих нь өөрийгөө шивтгэрлэхээс үл хэтрэхсэн билээ.

Анхны цомыг орхиод тоолоход Б.Лхагвасүрэн, Ц.Чимиддорж, Б.Ичинхорлоо нар хоёр удаа, Д.Цоодол гурван удаа, П.Бадарч, Т.Очирхүү, Т.Галсан, Д.Төрбат, Б.Доржпалам, Ц.Хулан, Г.Мөнхцэцэг нар нижгээдээр хорьдуур зуунд багтжээ.

2000 оны дайрлагаас хойш цомын эзэд энэ наадмын замаас зайлж Ц.Бавуудорж, А.Эрдэнэ-Очир, Д.Урианхай нар тодорсон байх юм. Эл бүх найрагчдыг хог дээр хаячихаад далд суутнууд далавчаа дэлгэлээ гэхэд уншигчид уухайлан огторгуйн оломгүйд ойлгон өргөмжлөх нь юу л бол. Үгүйсгэл бол эзнээ эргэж үнсэлдэг шүү дээ.

1921 оны хувьсгалын дараа өв соёлоо феодалын хэмээн адлаж устгасныг өдгөө сэргээж ядаж сууна. Үгүйсгэгчид үндэсний соёлыг түйвээгчийн үйлээр түүхийн ял сонсож байна. Бүтээхийн тулд бүрэлгэх нь хайрлахын тул хазахтай адил. Дэлхийн уран сайхны соёлын ертөнцөд мөнхөрсөн суутнууд өвөрмөц нээлтээр өв соёлоо баяжуулж байснаас бус, өмнөх үеийнхээ сэтгэлээр хөлөө угааж байгаагүй.

“Болор цом”-ыг боорлоочид дэлхийд ийм найргийн наадам байдаггүй гэж далайлгадаг. Хорвоо эрээн. Нэгээхэн буланд нь байхгүй юм нөгөөд нь байж болно. Хоол хурдан гудардаг ховдгийн уралдаан, хоёр уруулаа зулгартал озолдоочдын тэмцээн болж л байна. Байж болох болон боломгүй юмаар хүний орчлонгийн хүрд эргэж байна.

“Яруу найраг бол нийтийн бус элитийн соёл, Бид “философдоно” гэж цээж сөхөж байна. Монголын хувьд яруу найргийн хөрс мянган жилийн яргаастай буюу аж төрөл, ёс заншилтай нь амин хүйтэй. Нийтийн он тоололоос бүр өмнө Монгол туургат аймгууд бичиг үсэгтэй байж. Ардын дуу, ерөөл магтаал, бөөгийн дуудлага, тамлага, дайралцаан, гуравт, дөрөвт шүлгүүд үрэгдсэн нь их гэхэд үлдсэнийг чамлахаар чанга атгая.

Монголын соёлын түүхийг тасдах гэвээс илд нь байлаа гэхэд ир нь даахгүй л болов уу. Харин “Элитийн” хэмээх эрхэм дээдсийн яруу найрагч байхыг үгүйсгэхгүй. Их нь ихтэйгээ, бага нь барлагтайгаа л байна биз. Оюуны оргилд одтой тоглох нь тоглог. Орчлонгийн тоосноос мань мэт нь сугарч чадахгүй. Муусайн шүлэгтэй мунхаг уншигчтай гэж бидний дээрээс шүлсээ

хаявал хаяг. Тэр нь бидний зулайг онож ороод гэгээрлийн рашаан болж гийгүүлсэн цагт өөхийгөө халцлан сунаж мөргөмз. Тэр болтол хүлгэлзье.

Өөрсдийгөө шинэчлэгчид хэмээх хүмүүс яруу найргаас хэл, сэтгэл, уянгыг нь авч хаях гээд ч байх шиг. Хөлдүү цээжнээс халуун амьсгал гарах юм болов уу. Харин нэг ч уншигчгүй байж болно гэдгийг сөргөөх аргагүй. Хүнд хэрэггүй юм хийх эрхийг нь хүндэтгэнэ. Гэтэл ядахдаа “тоглоом”, “зугаа” болохгүй юм бол ерөөс шүлэг бичиж яах юм бэ.

Р.Уэллек, О.Уоррен нар “Утга зохиолын онол” номонд “Яруу найргийн зорилго олон талтай агаад үүрэг нь ч мөн тийм гэж бид үзнэ. Хамгийн гол нь өөртөө үнэнч байх явдал мөн” гэжээ. Тийм байлгүй дээ. Яруу найрагч бол тэнэж яваад тээглэж үхдэг элий балай амьтан биш ээ.

“Болор цом” бол алдар нэрийн арсалдаан бус яруу найргийг уншигчдад хүргэх жим. Түүгээр явах эсэх нь шүлэгчийн эрх. Томроод байгаа хүнийг тохой дэвсэж гуйдаггүй. Харин морин уралдаанд монгол заншлаар илжиг хөтлөж очих цээртэй. Шүлгийг барьж уншихаас гадна бас сонсч болно. “Чихнү чимиг болсон монгол хэлээрээ” шүлэг хайлахыг чагнаж сэтгэлийн таашаал авдаг хүнийг “эргүү бяруу” гэж дордчилох гэвэл тийн өгүүлээч бурхан ч байсан би мөргөхгүй.

2003 онд “Болор цом”-ын хорин жилийн ой болж улсын маань анхны ерөнхийлөгч П.Очирбат, удаах ерөнхийлөгч Н.Багабанди нар хойморлож олон уншигч уухайлж буйг харахад үндэсний соёлын өвөрмөц нэгэн баяр болж дээ гэсэн бодол зурсхийж билээ. Одоо цагт орох орохгүй үүдээ ялгах эрхтэй болсон болохоор найргийн наадам руу хошуурч байгаа уншигчдын зам дээр ямар ч аварга голио хэвтгээд яанам билээ.

“Болор цом”-ын хорин жилийн ой тохиосон цагаан сараар Монгол Улсын ерөнхийлөгч Нацагийн Багабанди, тэргүүн хатагтай Оюунбилэг нар цомын эздийг гэр бүлээр нь урьж золгосон нь төрийн хүндэтгэл байсныг энэ ялдамд талархан өчсүгэй.

Яруу найрагч бол од бус мод гэж миний өчсөн нь учиртай. Өнөөдөр манайд тээглэж унамаар олон од тэнгэртэйгээ ойчсон юм байлгүй. Шар сонин бор телевизүүд шагшаад л байх юм. Үүгээр бол сансрын холхийг дурандаач эрдэмтэд манайд ирж од барьж, ярьж, бас “бааранд” орох биз. Аальгүйчүүдийн аягаар ёстой “яг ш дээ”.

Яруу найрагч нь оюун санаа руу онгодоор тэмүүлсэн уянгын ургамал. Мод гэсний тайлал энэ. Хувь тавилангийн эрхээр ургасан хөрсөө урагсаж, газарт ургаж, сэтгэлд унаюу.

Намбардагва бол суманд гамгүй биелэх, чихлэх нь их чиг хааяа барьсандаа онодог хүн. Энэ удаад би түүний үгийг хэрэгшээж “Болор цомтны” хэдэн бичил хөрөг хэлхэв. Энэ бол эрдэм судалгааны зүгшрэлгүй, амин зуурын ажиглал, нөхөрсөл юм шүү.

Бавуугийн ЛХАГВАСҮРЭН

Бавуугийн Лхагвасүрэн бол өөрийгөө даргилааж ширгээж амилсан яруу найрагч. Тэрвээр яруу найрагт өөрийгөө олох гэж амьдралд авгай Баасангаа олж арваад хүүхдийн аав болохоос

илүү зовсон гэхэд хилс нь үгүй. Үнэхээр тэр удаан эрсэн. Үгүйлэгдэхгүй болтол ужиглан эрснийг би мэднэ. Харин тэвчээртэй эрлийн үзүүрт тэнгэрлэг найрагт өөрийгөө алдахааргүй олсон юм.

Лхагвасүрэн, ургуулсан хийсвэр дүрслэл, ухаарлын цараатай, уянгын агсрал, хүчтэй санаагаар сэтгэлд уулгалах сэтгэхүйн шуургаар нээлт хийсэн гэж би боддог. Тэрвээр бидэнтэй дэндүү адилхан, тэс ондоо эгэлшил, өөрөөсөө бусдыг үл тоомсорлох хүндэтгэл, аргадахуйн нулимстай хилэгнэл мөн. Хүнийхээ хувьд Лхагвасүрэн дэндүү цэгцтэй хэтэрхий замбараагүй аашаараа мяндарсан торго, адайраараа адсага буюу жинхэнэ яруу найрагчид зөвхөн байдаг этгээд араншин бүхний чуулбар мөн. Ер нь өөрийнхөө өнцөг бүхнийг мөлийлгөсөн, өнгөгүй зэлгээн номой эрүүл этгээд бол найрагч байж чаддаггүй. Сурагчийн дүрмээр өсөөд намын дүрмээр өтөлсөн шүлэгч улаан тугны ишнээс тас зуураастай унтарч байв. Ингэж гандсан их авьяасыг ч би мэднэ.

Яруу найрагч бол эрэгцүүлэл, эмзэглэл, хямрал, тэрсэл, уярал мөн. Уран бүтээлийн яс шархирсан шаналал, цөс хавиргаа дэлссэн омогшил, үхсэн ч сөгдөхгүй зөрүүдлэл, цагаас өрсөх адгал, тэр байтугай гайхаш тасрам солиорол нь жинхэнэ бүтээлчийг хэвшиж дагтаршсан амьдралаас сугаран уран бүтээлийн тойрог замд оруулдаг. Сайн найрагч байна гэдэг усанд ноцож, түймэрт хөлдөх лугаа адил. Үүнийг үглэхийн учир гэвээс миний хөргийн таталварт, яруу найрагчдын дүр төрх араншингийн замбараагүй зураас сараачих гэсэнтэй минь бөөр нийлнэ.

Яруу найрагчийн онгод авалцах газрын цэнэг бол дурлал. Лхагвасүрэнд уянгын эрхэлж хэлгийрсэн шүлэг бий. Тэрвээр цочсон юм шиг огцом дурлаж Бенгалийн галт хүж шиг сүржигнэсэн оч цацлаад унтрахдаа авгайгаа аргадсан шүлэг бичиж тайтгархаа бас мэднэ. Түүний хайр сэтгэлийн мэдрэмж хуйсгануур агаад романтик алслалтай. Зүүдэндээ, тэнгэрийн дагиныг зүрхээрээ хучиж саран дээр нойрсуулаад амьсгалын бүдэг чимээнд нь бүүвэйлсэн үүлэн дээр үүрэглэх мэт үлгэрийн төгсгөлтэй. Энэ ч бас л шүлэг.

Онгодын тухай ам нээснийх нэгэн зүйл нэмье. Онгод бол урлахуйн үүдэнд тэсрэх цэнэг, авьяасын алтан агшин. Гэтэл хэн нэгэн онгодгүй бүтээдэгээ гайхуулсан байдаг. Энэ бол үүлэн борооны цэнгэлд ханан дээрх бясаа нядааж асан хошигнолтой адил. Хорвоогоос холбоос тасарсан төвлөрөл, хойшлуулж үл болох дотоод эрчим хүчний цахил үгүйгээр амь тэмцэж төрөөгүй бүтээл бол зулбас. Үүнийг үл мэдэгч бол зүгээр гурилтай хоолны шалгарсан баатар төдий авай. Лхагвасүрэнг Хөхчү бөөгийн сүнс гэж Гонжийн дог голтой буудсан. Үнэхээр тэр бол бөөгийн онгодтой дошгин савдаг.

Лхагвасүрэн анхны хоёр номоороо “эврика” гэж дуу хадаахад бид сортосхийж зарим хүн цочсон билээ.

Монгол шүлгийн тогтолцоог эвдсэн дэвхцэж, цовхчсон этгээд шүлэг хэмээн шүүмжлэгч зандрав. Гэвч үгийн өө сэв эрснээс бус утгын чанад өнгийж чадаагүй. Лхагвасүрэн толгой холболтын дэгийг ончтой санаагаар цөмлөсөн нь эвдэх бус бүтээх эрэлхийлэл байв. Үндэсний яруу найргийн нөөц нь түүний үсрэлтийн тулах цэг гэж би хэлнэ. Учир гэвээс тэрвээр харийн соёл хулуун гайхуулаагүй, эрсэнтэйгээ, олсонтойгоо монгол найрагч. Түүний шүлэгт эхийн уургийн амт, эрмэг хүлгийн үүрсээн, уулсын ихэмсэл, талын алслал, зүрхний

ханьсал шүтэлцсэн ерийн агаад ер бусын өөриймсөл бий.

...Ухаантай мөртөө гэнэдүү

Уудаггүй мөртөө согтуу

Сагуу хэрнээ чамбай

Саларцаг хэрнээ нямбай

Эмхгүй атлаа дэгэрхүү

Эрэлхүү атлаа халирхай

Адсага гэтэл торго

Арслан гэтэл банхар

Буурал дээдсийн тэнэмэл угсаа

Бурхан багшийн тэнгэрлэг алдаа!... гэсэн миний хэдэн мөр бий. Үүнд би өөрийн санаагаа шавайлсан ухаантай юм.

...Энхрийхэн нялх хүний үр

Эхийнхээ дуунаас уяатай хөлд орно

Налгар цагаан гэрээ тойрсон анхны мөр нь

Нар сарны тэгийг газарт зурна.

Энэ бол 1980 онд бичсэн “Уянгын тойрог” хэмээх шүлгийн төгсгөл. Тэгвэл хорин таван жил өөрийнхөө тойрогт уншигчаа гүүргийлж чадна гэдэг яруу найрагч бүхний сачий бишгээ.

“Боржгины бор тал” бол түүний түүчээ шүлэг гэж би боддог.

...Шүлгээ би чам дээр

Хүн чулуу шиг орхиод

Сүүдрээ дарж унахдаа

Элгий чинь цөллөн шингэнэ

Боржгины бор тал минь!

Энэ бол эх орончийн өчил. Бидний мөнхийн сэдэв бол Монгол орон минь билээ. Эх орны тухай шүлгээр яах юм бэ гэдэг шүлэгчийн өөдөөс “Чамаар би яах юм бэ” гэж чулуу хашгирна.

Эх оронд ихэрхэж болдоггүй.

Лхагвасүрэн өөрийгөө:

Би-

Цаг тооны үргэлжлэл

Цагаан сүүний ургамал гэж бичсэн. Хүн газар хоёртоо хүйсэж чарласан нь энэ. Түүний эхийн тухай шүлгүүдэд ч энэхүү халуун элгэмсэл бий.

...Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам

Цэцэг нар хоёртоо бахардсан наадам

Ижийтэйгээ үзсэн тэр жилийн наадам

Чихэр инээд хоёртоо бялуурсан наадам...

...Дун цагаан үс нь

Намрын салхинд хийсэж

Дуутын шаргал хөтөл дээр

Намайг харуулдаж зогсоо

Ижийг минь

Мөнхийн усаар шагна!

Шагна!

Эхийн тухай шүлэг яруу найрагчийг зүрхний чулуужлаас аварч түүнийг хайлж хүмүүнлэг энэрэнгүй болгодог. Эс тэгвээс эршүүд өнгөнд хөг нийлэх уяхан хөг үгүй болж солгойрдог ажаам.

Лхагвасүрэн найрагчаас гадна жүжиг, киноны зохиолч. Би түүний “Тамгагүй төр” жүжгийг хадагтай урилга анх удаа авч үзсэн. Үйл явдлын эвсээрхэн ээдрээнд зохиогч үгээр зодож, Жамсранжав, Цэрэндагва хоёр дүрээр сөхрүүлж байна лээ. Надад бас л нээлт санагдсан. Лхагвасүрэн харин хүүрнэлт томоохон зохиол бичихгүй болов уу. Түүний яруу найрагчийн тэвчээр богинодох биз ээ.

Лхагвасүрэнд бас хурдтай цэц бий. Үүнийг шүлгээс нь төдийгүй үг сөргөлцөөнөөс ч анзаарч болно. Түүнийг өвөө болоход нэг нөхөр нь

-Өвөө болох сайхан байна уу гэвэл

-Сайхан юм. Эмээтэй унтах л эвгүй юм... гэсэн гэдэг. Түүний тухай дүрээр бүтээсэн хамгийн сүрхий хошигнол бол “Лхагвасүрэн хаан дайлаар мордсон нь” нэртэй. Өгүүлэх нь:

...Бавуугийн Лхагвасүрэн нэгэн өглөө сэрвэл, Хамаг Монголын хаан болчихсон байх гэнэ. Мэргэн түшмэл Дарамын Батбаяр бараалхаж:

-Хаантаан! Юунаас эхлэх вэ гэвэл,

-Аян дайн, аян дайн... гэхэд нь Батбаяр чих хатуу тул “аяндаа” гэж андуу дуулаад “аяндаа болно. Гениально” гэж байна гэнэ. Хаан хилэгнэж “битгий дүлийдээ найдаж унга” хэмээн зандраад ховын сайд Ш.Цогтыг дууд гэжээ. Хаан Цогтод

-Салхи хаанаас байна вэ?

-Мэдэхгүй.

-Тэр конус хараад ир!

-Юу байдаг юм бол, хаантаан?

-Онгоцны буудал дээр байдаг эрээн гондоом!

Салхины чиг мэдсэн хаан “урагшаа малууд аа, зөвхөн урагшаа” хэмээн чичирснээ,

-Тэнгэр тэтгэлээ. Хөдлөө! Миний хойно их хатан Баасан явна. Жороо цоохор гүү унуул. Түүний араас алтан сондор шиг сүйхнүүд хэлхээд өг! Мал аа! Олон тусмаа сайн. Эхний сүйхэнд Чимид-Цэеэг зал. Хатан хувцастай шүү. Бусдад нь нөгөөдүүлийг нэг нэгээр нь шургуул. Бүгд нүцгэн байг! Хөшгий нь битгий тат. Хөхний нь товч харагдаж байг. Араас нь цэргүүд! Бүх цэргийн жанжин Шандын Гөлөгдэй баатар (Ш.Гүрбазар) аа тийм нөгөө сэгсчүү бөө (Ц.Чимиддорж) урд нь яваг. Миний баруун зүүн гарт мэргэн түшмэл Д.Урианхай, Д.Батбаяр хоёр явна.

Шандын Гөлөгдэй баатар:

-Хаашаа явах вэ, хаантаан?

-Битгий талчигнаад бай. Би мэдэж байна. Богд уулын зүүн сугаар урагшаа бороо шиг асгарч шороо шиг бос!

-Тэгээд хаантаан?

-Эхлээд Дайдууг эзлэнэ. Дараа нь Шанхайг дайна.

-Тэнд яахсан бол?

-Алаад өгнө. Дэлхийн эмсийн хүрээлэн байгуулна!

Ийнхүү цэрэглэн мордож Хоолтын даваан дээр гартал Хятадын усан ваймлий буу панхийж хаантан тэнгэрт нисэн одов гэнэ. Удсангүй тэнгэрээс туг хар үс, савхин хүрэм, америк жинс өмдний тасархай бууж ирэхэд Шандын Гөлөгдэй баатар самсаа шархирч

Хаан эзэн минь

Хангарьдын жигүүр бус

Хараацай шувууны

Живэр болж одов

Сайн эзэн минь

Сахал үсний хялгас

Сармай хүрэмний

Самалдаг болон одов.

Багын насандаа богтолсон

Баасан үжиний энгэр

Балын чавцууд шүрэгсэн

Балчир оддын хормой

Өлгий сүүний асгар

Өнгөт хорвоогийн тойрог

Өсөхдөө үлгэж ивэлгэсэн

Өнжүүлийн хөх чулуу

Бодол хэлхэж цовхорсон

Боржигины бор тал

“Болор цом”-ын дэвжээнд

Бохь шигажилсан шүлэг

Ахын хишиг горьдсон

Арван наймтын гижиг

Ардын зохиолч мэдүүлсэн

Албан газрын бичиг

Энэ бүхэн эгшиж

Эзэн таныг хүлээж байна.

Хасаг тэрэгний дугуйг

Хангирсан эргүүл гэж

Үгийн сэвсээр булавч

Үл хөдлөв гэнэ

Одоо яанаа гэвэл

-Одны төөрөг гэж

Урианхай түшмэл

Унхайв гэнэ

Тэгээд яахав гэвэл

-Тэнгэр тэмтрэг гэж

Батбаяр түшмэл

Баясав гэнэ

Хаачих вэ гэхэд

Хар дэлт сэгсчүү бөө

-Харьцгаа!

Төгөлдөр, төгөлдөр... гэжээ

Ийнхүү Их, Бага хаадаас хойших адаг хаадын үлгэр төгсөж амар сайхандаа жаргав гэнэ...

Хэрэв Лхагвасүрэнг мэддэг хүн үүнийг уншваас “Мөн байна л гэж хэлнэ.

Зохиолчдын наргиан бол зөвхөн үнэний ихсгэл ажаам.

Пунцагийн БАДАРЧ

Пунцагийн Бадарч Төв аймгийн Баянжаргалан сумынх. Тэрвээр эрт үс цайснаараа гул барьж өвгөрхөх дуртай болохоор нөхөд нь түүнийг Пунцаг гуайн аав буюу “өвөө” гэнэ. Насархах гэсэн ёнзгонд нь намба жаахан дутна. Цооргонын навч шиг хоёр чих нь жихэрсэн адууных шиг хулмалзаад ирэхээр залилах, шоолохын нэгийг заавал хийнэ. Залиа авгай хүүхэнд гоц гаргана. “Сайхан амьтан” гэсэн магтаал, дусал нулимстай чулуудахад ямар ч яхир эхнэрийн цоожны өргөс торхийж гожин юм урд нь гозойно. Харин шоолохдоо мань мэтийг тамтаглана. Түүнийхээ шанд өөртөө бас лай хураана. Би тэр бүрийг санахгүй юм. Лав л:

“Ичинноровын эрх шар

Эрдэнэсантын бэрх шар

Цэнхэр дэлгэцийн сэвдэг шар

Цэргийн чуулгын савдаг шар”... гэдэг

Харин Ардын зохиолч болсон найр дээр нь:

...Хан уулын шанага шар

Хатан туулын халбага шар

Баян сумын хул шар

Баруун хорооллын хундага шар

Торгон хилийн дэлдэн шар

Тоодон миссийн шалдан шар

Яруу найргийн зальхай шар

Яанжинлхамын задгай шар... гэж нэмнэ билээ.

Манайхан уур хүрмээр тоглоомтой ч маасайж суухаас өөр аргагүй шүү.

Энд нэгэн зүйл тодлоход Төв аймгийн Эрдэнэсант сумын клубын эрхлэгч байхад нь надаас нэгэн зурвас очсон гэнэ. Түлээ хагалж байхад ирсэн гэдэг шиг санаж байна. Тэр нутаг аргал хөрзөнгөөр гал залгадаг атал хаанаас мод олсныг мэдэхгүй. Дархан цаазтай Батхаан уулснаас дам гулсуулсан болов уу. Магадгүй, хөрзөн хагалж, хөх аргал хэмхэлж байснаа дэврүүлсэн байхаа ядахгүй. Тэр зурвасанд “Ном чинь төлөвлөгөөнд орсон” гэсэн мэдээ байсныг хараад дэвхрэхдээ тэнгэр мөргөчихсөн шахуу юм хэлдэг юм. Яруу найрагчид анхны ном, анхны хайр хоёр адил гэдгийг бодоход тэнгэр бус гэхэд тотго мөргөсөн байж болох юм.

Бадарч “Есөн эрдэнийн орон” хэмээх найраглалаа монголчуудын дээдэлдэг есөн эрднээр бэлэгдэн аж төрөлтэй нь сүлжин холбосон болохоор монгол сэтгэхүйтэй хүний сэтгэлд унасан юм. Ер нь олны санаанд ургаж үлдсэн зохиол хөрвөж чаддаг даа. Энэ зохиолыг эзэнд

нь эргүүлж,

...Навчин чихэнд тохсон

нарны шил минь улаан

Найргийн дэвжээнд зүүдэг

гоёлын зангиа минь улаан

Нанчидын дугараанд ноцсон

навшин хамар минь улаан...

Наснаас эрт цайсан

үсний минь сам улаан

Би шүрэн эрдэнийн билээ... гэж дам дамшигласан нь оргүй юм бишээ.

Бадарч өөрөө, олон оймс элээсэн он цагийн гэрч хэмээн хэвлүүтэж байгаад “өвөө” хочтой болсон хэрнээ заримдаа залуурхаж гангамсах санаатай. Тэрвээр нэг үе улаан зангиа, улаан хүрээтэй шил, улаан сам, улаан цамц гээд улаанаар дарцаглаж цагаан хөхөлтэй улаан туг шиг болсон нь үнэн. Тэр үедээ лонхонд ч хамаагүй тольдож хэдэн буурлаа самнаж, үнэ хямдарсан үнэртэй усаар, усан хулгана болтлоо булхаж үзсэн. Онгод нь орсон, оройтсон хайртай орооцолдсон алин болохыг мэдэхгүй.

Бадарч ногоон намын зүтгэлтэн гэх боловч өнчин мөчир газар шигтгэж, өрөөнийхөө цэцгэнд ус дусаагаагүй гэлцдэг. Сорви нь хөндүүрлэдэг юм уу, сонгууль болохоор, экологийн асуудлаар төртэй үзэлцэнэ гэж дөрвөн жилд ганц удаа дөрөөн дээрээ цогнойно. Тэгээд удахгүй, санчигаар нь салхи тоглоод өнгөрнө. Би түүний ногоорлыг яруу найрагчид зохиомжийн өнгө гэж тоодог юм. Онгон байгаль гэж сайрхах хүн олон боловч ойгоо халзлаж, газраа халцлаж, усаа угаадаслаж гүйцлээ дээ бид чинь. Ганц ч болов зохиолч газар дэлхийгээ өмөөрч яваг даа.

Бадарч “тэмээ” шүлгээрээ “Болор цом” авсан юм. Сүр бараатай мөртөө сүжирхүү, амгалан тэр сайхан амьтны тухай монгол шүлэгч л бичиж чадна.

...Саалийн үнэр ханхлуулсан

Бүсгүй хүн хөөслөж

Салхинд ч эгшиглэдэг хуураа

Учирлуулан татаад өгөхөөр

Сайхан хүрэн нүднээсээ

Нулимс мэлмэрүүлэн гэмшдэг...

хэмээн ботгоо голсон ингэний тухай сэтгэл урсгасан байдаг билээ.

Молхи би вээр сэтгэхүйн болон сэтгэлийн уянгын хос утас уянгалж байг гэсэн бодолтой хүн. Цэвдэг хүйтэн шүлэг унших нь үл таалсан хүүхэн үнсэхтэй адил. Сэтгэлийн урсгал ухаарлын давалгаатай зүрхний тосгол руу хурлан буугаасай. Яруу найргаас сэтгэлийг танаваас, дуунаас аялгууг авч хаяхтай агаар нэгэн буй за.

...Ижий нь хүүгээ

Их санах юм даа

Араг савар хоёроо

Зөрүүлж байж бодлоо

Аргал чулуу хоёрыг

Анддууран түүж саналаа...

гэж “Эхийн сэтгэл” шүлгэнд нь бий. Өр зөөлөн хүнд бол өрөвчийн хишиг энэ шүлэг өгнө. Хүмүүсийн элэг хатингарч байгаа энэ цагт өрөвчийн зөөлөл хэрэгтэй. Монгол шүлэгч ээжийнхээ тухай ингэж бичих эрх бий. Үүнийг хазаарлах гэвэл Өэлүн эхийн сүнс өндийж ирээд халаглах буй за.

Намайг эзгүйд хөгжмийн “цэцэн хан” Лувсаншаравтай хөөрөг зөрүүлж зиндаархах санаатай Бадарч,

-Буурлууд буцаад явчихлаа. Үерхэх хүн олдохоо байлаа. Одоо хоюулаа ходий байя гэж л дээ.

Лувсаншарав нь:

-Хн гэж тамшаагаад Пүрэвдоржийг амьд байхад чи болоогүй ээ гэх маягийн юм хэлж амы нь алгасан гэдэг наргиан байдаг юм. Хоюулаа хэлдгийг бодоход ортой дог.

Бадарч зөвхөн жин өгсдөггүй бас хасдаг гайхал. Хулан, Ичинхорлоо, Мөнхцэцэг гуравтай үеийн юм шиг үзэлцэхээс сийхгүй. Ганц гэм нь гадуур шилэрч яваад харихдаа эхнэрийнхээ эрүүний шөлийг уухгүй ов зохиож, энэ гурвын хэн нэгнийд байсан гэж жанжин молиго үмхүүлнэ. Шүлэгч охид адтай болохоор, “Манайд наргиж байгаад явсан” гэж гэрчийн мэдүүлэг хэнэггүй өгч цагаан толгойноос нь цаазын цалам мултлана. Яруу найрагчид гэдэг иймэрхүү л улс хойно доо.

Бидний залуу зандан байхад Алтай, Туул гэж байгаад Улаанбаатар, Баянгол хоёр нэмэгдэж дөрөв болж билээ. Дөрвөн ресторан хөндий ханхайж байхад Чимид, Гайтав, Явуу, Эрдэнэ, Дашдооров биднийг эхнэр, нам хоёр эрлийн зовлонгүй олж намын хараа, гэрийн хорионд ордог байлаа. Ер нь Монголд гэрийн хорио гээчийн үүслийг манайхан тавьсан даг. Гэвч

зохиолч гэдэг гэрийн бүү хэл, төрийн уяанд тэр бүр тогтдог амьтан биш. Уран сайхны тэлүүлэлээр уяагаа чирээд арилна. Гэхдээ зарим нь намын шон дээр өөрийгөө сойгоод тураалдаа хүрснийг алийг тэр гэхэв. Уг нь зохиолчид дуртай дошин дээрээ дуулахдаа дуулж уйлахдаа уйлж явах нь тэнгэрийн таалал.

Яруу найрагчдыг би сэтгэлдээ тоос бүү тогтооосой гэж хүсдэг. Хэрэв ясны найрагч мөн бол өнгөө бус дотроо ариусгаж нулимс нь хүртэл тунгалаг байдаг авай.

Зах зээлийн үерээс хулширч үлдсэн манай зохиолчдын хорооны буурин дээр Долгорын Нямаа нь дарга, Бадарч нь уран бүтээл эрхэлсэн зөвлөх гэх боловч өөрийгөө орлогч дарга гэж оодгонох дуртай байж л дээ.

Дашдооров, Долгорын Нямаа хоёр хэн нэгэн “Хар юмтай” зоогийн газарт буу халж байтал Бадарч ороод очиж гэнэ.

Дашдооров:

-Яасан сайн юм. Танилц. Буриадын зохиолчдын хорооны орлогч дарга Борис Хинганов. Чамтай л нэг зиндааны дарга гээд сахалтай ч билүү, нөгөө хар юмыг зааж гэнэ.

Бадарч, “Хоёр улсын хорооны удирдлага” хэмээн ихсийн зэрэгт шадарлаж халаасаа эргүүлж гөвөөд халамцсандаа нөгөө хар юмны нүүрийг дэлэн болтол үлгээд маргааш өглөө ажил дээрээ хүлээн авахаар юм болоод найр таржээ.

Бадарч өглөө нь хүндэт зочноо хүлээж авах санаатай улаан самаар, цагаан хялгасаа мяндаслаад л суугаад байж гэнэ. Гэтэл нөгөө Хинганов нь ирсэнгүй.

Дашдооровоос асуувал,

-Хэ, хэ. Тэр чинь жолооч л доо. Ням бид хоёрыг дааж байсан чинь чи урдуур нь ороод төлчих чинь билээ гэжээ. Түүнээс болоод учрыг тайлж өгөөгүй Нямаа даргадаа гомдож “Энэ чинь Нямаа биш Ням. Нэр нь хүртэл гурван гийгүүлэгчээр бүтсэн хүн шүү юм биш” гэж шилбүүрджээ.

Бадарч гэнэхэн цайлган болохоор хоёрдохоо Дашдооровт хийцлүүлж буй нь энэ ажээ.

Урд нь арми сурталчлах ажлаар Дооров, Батын Нямаа, Бадарч нар цэргийн чуулгын болон армийн томчуултай Алтайд очжээ. Очсон оройгоо зуух яндан угсарцгааж өглөө хөдөө сум руу явах гэтэл Дооровын яндан хөрөөгүй байсан тул орхиод явжээ. Хөдөөнөөс иртэл зочид буудлын жижүүр “Нямаа, Бадарч нарт Бигэр Чулуунаас” гэсэн зурвас бүхий тус бүр нижгээд гожин юм өгч гэнэ. Бигэрийн Чулуун бол алдартай нэгдлийн дарга, хөдөлмөрийн баатар хүн. Тэднийхэн хармагаар архи нэрж шарз, хорз хийдэг, бас зохиолчдын их анд байсан болохоор хишиг хүртээж хэмээн баярлахаас яахав. Үдэш нь Бадарч чуулгынхаа ганц нэг бүсгүйг “Бигэрийн Чулууны хишиг амс” гэж өрөөндөө уриад лац ховхолж аягалаад амсвал ус байж. “Араараа модтой Биндэръя” романы эзэн Батын Нямаагийнх бас л тийм байжээ. Орхиод явсны хариу авахын тул Дооров ажил тарьж аймгийн хүнсний үйлдвэрээр ус савлуулж,

лацдуулсан юмсанжээ.

Бидний аль гэнэдэхийг тэр гэхэв. Гэвч гэнэн байх нь тэнэг байхаас дээр. Цаана нь цагаан санааны ёзоор байдаг болохоор зохиолч биш юмаа гэхэд хүн байх нигууртай.

Бадарчийн хайртай муур нохойд бариулан эрсдсэн тухай нэгэнтээ шуугиан болсон юм. Тэрвээр талийгаач муураа, жимсний жижиг хайрцганд торгоор баринтаглаад эхнэртээ зургий нь бариулж, өөрөө ард нь шарил тэвэрч бэдэрсээр Шаргаморьтын энгэр түшүүлэхдээ шалбааг тунатал уйлсан юм гэнэлээ. Түүгээр үл барам дөчин ес хоногийг нь хурааж муур нохой хооллож уй гашуу тайлсан гэдэг. Энэ нь хачирхалтай боловч чанадын эмзэглэл. Чухамхүү энэ дотоод ертөнцийн эмзэглэл бол найрагчийн дээд мэдрэхүй бөгөөд түүнийг хөлдүү сурталтай адилтгах аргагүй бодгал болгох авай.

Дөнгөтийн Цоодол

Дөнгөтийн Цоодол бол Төв аймгийн Бүрэн сумынх. Төрөх үед нь Өвөрхангайн алдуулын эрэлчин ч юмуу, адууны тэнгэр ч юм уу нэгэн тааралдаж нутгийн нэрнээсээ бэлчилсэн гэдэг. Уг нь уртхан нэртэй байсан бол аятай юу. Гэхдээ аавынхаа нэрийг урд нь залгаж сунгаад уурган шилбүүр болгодог юм.

Төв аймгийн эвлэлийн хороонд ажилтай гэх боловч товчооны гишүүний хүрэн пальтотой хархүү зохиолчдын хороогоор дамналдаж яваад “нутгийн зургаан өнгө” хэмээх анхны номоо гаргахад Б.Явуухулан түшсэнийг санаж байна.

Эхэн үедээ түүний шүлэг үгийн өнгө дагнаасаар гангарсан хийцтэй байв. Энэ нь зөвхөн нутгийн ерөөлч Нарангийн Тэрбишийн хаялага бус яруу найрагт түлхүү байсан магтаалын нэгэн улбаа. Энэ үе бол Д.Сэнгээгийн аж байдлын шүлэг Б.Явуухулангийн уянгын хайлалд халаа өгч байсан зааг гэж болно. Хоёрдох буюу “Алаглан харагдах уулс” номон дээр нь би нэрээ тавьсан нь малгай барьж зогссон засуул төдий л юм.

Дөнгөт гуай найрын эхэнд хадагтай дугараа өргөж ая барьдаг асан гэвээс Цоодолд тэр хоолой нь солгойлж, шүлгээр тэгширсэн биз ээ.

Д.Цоодол дуу байваас “гуунан хар” юм гэнэлээ.

...Гуяндаа дарсан тамга нь

Гурван цомын хэлбэртэй...

...Ташаандаа дарсан тамга нь

Таван хошуу хэлбэртэй... гэнэ.

Д.Цоодол “Болор цомыг” гурвантаа авч харьсан бол нэг хэсэг “төв хороодож” суртлын хэлтэст сухай шиг улайж явсан өдөр бий. Гэхдээ тэр намчирхлын дон шүглээгүй, үзэл сурталд үнгэлдэж хуучраагүй, ирж яваа цагийн өөдөөс шороо цацаагүй юм.

...Цэцэн Равжааг адлаж, Нацагдоржийг тамласан, Цэндийн Дамдинсүрэнг хорьж номыг нь шатаасан... балар ёсыг яллаж найрагчийн хиймороо сэргээсэн билээ.

Д.Цоодол бол “Муусайн найз нараа” буюу “Уужуу Дондог”, “Ороо Рэнцэн”, “Буруу Довдон” мэт борчуулыг өмөөрсөн найрагч болох нь шүлэг, дуулийн хос уянгаар танигдана.

...Хуучин дэр мод би бол:

Мод нэртэй төмөр

Эр мод оо!

Монголоо гэсээр дуусах

Дэр мод оо!.. хэмээн “Хуучин дэр модны дуульдаа” яргаасан энэ санаа бол түүний дотоод ертөнцийн ширээс мөн. Яруу найрагч бол хүний зовлон жаргалын хөсөгт хөвчирсэн дэр мод байхад юуны буруусан билээ. Энэ бол түүний төрөлх чанарын илэрхийлэл бас мөн.

Д.Цоодол машинд шүргүүлээд жолооч хархүүд: “Онгоцноос ойчсон биш дээ. Ахыгаа хүргээд өгчих” гэсэн гэдэг. Хэдэн сар бэртлээ бороолуулж гэр мухарлахдаа хэл ам татлаагүй. Гуниггүй толгой буюу гүндүүгүй эр хүн.

Яруу найрагч бол улс төржсөн уймраа чавганц биш ээ. Ясанд нь хутга хавирч байхад үнэний дуутай үхэж чадах зориг, хөшөө нэхэлгүй хөөгдөж буцах амь байх учиртай. Шүлгээрээ мөнхрөөгүй гэхэд шүүдрийн дуслар цэцгэнд уусах амьсгал.

Цоодол намайг “Сүргийн манлай” гэж даваадуулдаг. Энд ахмад гэснээс гадна, адуу буюу мал гэсэн ёгтлол нуугдаж буйг мэддэг ч миний гоморхох нь илүү зан. Түүний охин Хулангийн “Би дургүй” шүлэгт

...Яруу найрагч дэндүү урт насалахад

би дургүй...” гэсэн мөр бий.

Нөхөд маань “Даржаа гуай та хоёрыг хэлж байна” гэдэг ч би эмзэглэдэггүй. Жинхэнэ найрагч оч мэт үсэрч, од мэт харавдаг атал, хороо хорины шүлэгч над мэт нь хорвоог залхаадаг нь үнэн. Энэ нь ноцож байгаа дээрээ бичиж унтарсан хойноо утаа бүү тавь гэсэн ухаан.

Дөнгөтийн Цоодол бол Бадарчаас тэс өөр. “Эзнээ алд” гэж хараах нь миний аавтай адил. Энэ ер нь төв халхын хараал гэхээсээ үгүйсгэл, үл тоомсорлолын өнгөтэй ширвэсхийсэн үг л дээ. Цоодол бол өндөр ганагар, халхын хүрэн царайтай сайхан эр. Цэвэлмаагаасаа өөр бүсгүй хүнд бүдгэрч үзээгүй гэдэг юм. Юу л бол. Робинзон Крузогоос ялгаатай нь хорвоод хоюулаа цөлөгдсөн юм байлгүй дээ.

Цоодол, ясны шооч хүн. Шингэхэн хялгасарсан инээдээр дүйвүүлж байгаад голцуу дам дуулсан үг дамжуулж буй сайн нөхөр царайлан давслаж бүр чинжүүлэх нь үсний үзүүр

ирвэгнүүлнэ. Хошигнол мушилзал найрагч амьд байгаагийн шинж. Цоодолын ёж, сонжоо бүтээлд нь уусаж хавсан байдаг.

...Манай чавганц бурханд

Цайны сүүгээ өргөөд барлаа

Машинтай дарга

Овоо хэд ирлээ

Мал минь таргалдаггүй

Хачин юм... гэх “Буруу Довдон”

...Цагаан сараар дээлээ

Алдаг оног сольж

Царцаан даль шиг бүрээстэй

Гэртээ зовж жаргах... “Ороо Рэнцэн”

ч юмуу, ер түүний шүлэгт шогчилсон аяс бүхий дүрийн араншин нийгмийн эмгэгээр илэрдэг гэж болно. Яруу найрагт уянгын “Би”-гээс гадна “Чи” гэж бас бий. Үүний алинд ч миний олзуурхаад байгаа хошигнол нь шүлэгт амьд нэхээс байгаасай гэж би хүсдэг. Учир гэвээс үхдэл инээмсэглэдэггүй.

Дөнгөтийн Цоодол хэмээх хотны урт хар буу шиг найрагчид гэгэлзэл, иргэншил, хатуурхал, инэвхийлэл аль алины амсуурга бий. Бурхан түүний хольцыг дэнсэлж хийсэн юм байлгүй. Харин хайр сэтгэлийн шүлэг ховордуу. Энэ нь дурлалын цэнэггүй гэсэн хэрэг хараахан бус бөгөөд бурхантай тэр бүр уулзаж байхыг нь энэ хэр харсан хүнгүй тул төгс ариуслыг олсон гэхэд хилэнцэт хорвоо яаран итгэхээс цааргалдаг юм билээ. Гэхдээ Цоодол бол Явуухулан, Бадарч хоёртой адил шийдвэрээ гүйцэтгэл гэж зарлах хүн биш болохоор “үнсэх минь шүлэг шүү дээ, үгээр буулгавал үнээ алдчихна” гэж инээдээр илбэж чадах л вий.

Дөнгөтийн Цоодол бол найргийн ажнай. Охин Хулан нь аавыгаа “Маарын хээр” гэж нэгэнтээ хэлнэ билээ. Улсад олон удаа айргаар мялаалгасан хүлэг гэсэн санаа. Хүлгийг хонь хариулахад унадаггүй билээ.

Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбат Цоодолын энгэрт төрийн шагналын тэмдэг зүүж өгөхдөө ханхар цээжийг нь магтсанд,

-Цаана нь зай бий шүү гэсэн юм гэнэлээ.

Соёлын гавьяат болсон хойно нь харахад “Ардын зохиолч”-ийн зай үлдсэн байна лээ.

Тангадын ГАЛСАН

Тангадын Галсан нь Баянхонгороос тодорсон хувилгаан. Тэрвээр овор сууж өглөө болгон хоймор олбоглож, мөнгөн аягатай цайны дээж тосч хүртээд “Бунд хоролд” мөргөн гарч ганган тэрэг шилж бариад Гандангийн хүр рүү салхи татуулан буудаг, үг байтугай үсэг газар гээдэггүй өөлд өвгөн, өөрийгөө эрхлүүлж яваа нэгэн.

Зохиолчдын Хорооноос ахмад зохиолч Доржийн Даржаа гуайг Баянхонгорт очиход залуу зохиолч Галсан хөөрч хөлөө төдийгүй гараа хугалах шахаж, өмнө нь өнхөрч, хойно нь холбирон хүндэлжээ. Энэ бол хотоос ирсэн зохиолчийг хоймортоо залдаг орон нутгийн залуу зохиолчдын нийтийн жишиг.

Галсангийн хэлдгээр “өндөр багштайгаа” хүж барилцаж хэдэн бор шүлгээ уншжээ. Түүний дотор

...Далай олонтойгоо явсан бол

Далан давхарт булаарай

Ард олноосоо тасарсан бол

Алтан өлгийд залаарай... гэсэн бадаг байв. Өндөр багш нь хүч оруулж...

...(Дандаа хүн тасардаггүй) далан давхарт булаарай

(Амьтан хүн халгадаггүй) алтан өлгийд булаарай гэж засаад буцжээ. Тийн 1965 оны 1-р сарын 30-нд болсон Монголын зохиолчдын III бүгд хурал дээр “Өндөр зохиолч” нөгөө дөрвөн мөрийг нь ишлэж байгаад “...Энэ бол манай нам төрийг илэрхий дайрч нам ард хоёрын холбоог таслаж байгаа хэрэг бус уу... Иймэрхүү байдлыг хараад зүгээр өнгөрч болох уу? Болохгүй ээ, яасан ч болохгүй” гэж хөрсөө эргүүлээд муу Галсанг тэмээчин болох замыг засчээ. Түүний “төрсөн хүүгийн чинь үг” номоор араас нь сор залан шатаасан гэдэг. Гарын бус галын үсгий нь уншигч та таньж байгаа биз.

...Үнэнийг одоо өмөөрөхгүй бол.

Өнөө чи нүүр улайна

Үр удамд нэр улайна

Үхсэн хойно яс чинь улайна...

гэж Галсан хэлж чадсан. Эр хүн! Тэрвээр өөрөө “тэмээчин болсноос бус тэмээ” болоогүй гэдэг. Тэр бас үнэн.

“Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбат танаа

Хэлмэгдсэн нь үнэн бол цагаатгаж хайрла.

Хэрэв худал бол цаазалж хайрла.

Тангадын галсан” гэсэн өргөдөл бичжээ. Энэ бол Гиннесийн номонд орж болохоор товч өргөдөл. Нөгөө талаар авьяас чалчиж чаддаггүйн жишээ. Тэрвээр энэ эрчмээрээ “Жирмийн сүлжээ” хэмээх гурван дэвтэр хэвлүүлсэн нь үндэсний шад шүлгийг энэ цаг үед шинэчилсэн буурь бүтээл болсон гэж би боддог. Тэгээд ч төрийн шагналд дэвшсэн юм билээ. Анхны сонгон шалгаруулах хэлэлцүүлэгт П.Хорлоо, Ш.Сүрэнжав бид гурав утга зохиолоо төлөөлөн оролцов. Гэтэл нөгөө хоёр мань тэс хөндлөн хэвтчихдэг байгаа. Бид гурвын хувьд гурван боть байтугай, гурван мөрт гурамсалж чадаагүй гэдгийг хэн хүнгүй мэднэ. Уг нь зохиолчдын хоёр байгууллага хамтарч хуралдаад тогтоол гаргасан байв. Тэгсэн атал ийнхүү гацсан учрыг би мэдээгүй, мэдэх ч гээгүй. Харин тэр хурал дээр “Хоёр хүн муудалцахад нэг нь өөрийн гэмийг өмөөрч би байтугай бурхан алддаг” юм гэхэд нөгөө нь “Чи тэгвэл бурхны алдааг хэл” гэвэл “Чамайг бүтээсэн явдал” хэмээсэн тухай зохион хэлээд “олон алддагаараа би хүн байя” гээд л орхисон. Үүнийг энд дурдахын учир бол хэн нэгнийг муучлах гэсэн нь огт бус. Төрийн шагнал олгох дүрэмд “Зохиолчдын эвлэлүүд хамтран хуралдаж нэр дэвшүүлэх тухай заалт хэлтгийдсэнийг дайх гэсэн юм. Үзэл бодол үл дүйцэн өрх тусгаарласан зохиолчид нэг нь нөгөөгөө барьцаалж “дундаа хийх” зохимжгүй гажиг гарчихаад байгаа юм л даа. Үүнийг хувьсгалт нам, ардчилсан нам хоёр дундаасаа нэг хүний нэр дэвшүүлэхтэй адилтган төсөөлж болох юм. Бас төрийн яаманд шигшээний комисс нарийвчлахыг заагаагүй учир Ерөнхийлөгчийн тамгын газар өөхтэй булчирхайтайгаа очиж тэнд ялгаа салгааны чирэгдэл гардаг нь ч хүсмээр юм биш тул нягтлан үзүүштэй хэмээн санана.

Би эл бүхнийг яншихдаа Галсангийн сайхь бүтээл хольцоо нь үгүй шижир гэж нотлох гээгүй, оносон, гээсэн аль алин бий. Ер нь уран бүтээл бол өндөг биш.

Галсангийн бүтээлийн онцлог гэвээс хошин аяс, егөөдөл, тайлалын холбоонд байдаг. Тэрвээр ардын ухаан, уламжлалыг яруу найрагийн шинэчлэлд нээснийг ажиглаж болно. Бас хэн нэгэнтэй бус өөртэйгөө адилхан өвөрмөц өнгө хийцтэй, цэцтэй байдаг. Түүнийг Омар Хаиям, Рудаки ч юм уу, японы Хайкутай жишиж аль нэгэн цусны бүлэгт багтаах гэж дурандаад ч яахсан билээ.

Галсан “алтаар урс” гэсэн амны уншлагатай. Үүнийг хараал ерөөлийн алин болохыг миний мэт нь ялгахгүй. Гарынхаа үсгийг өөрийн шоглоом зургаар зурна. Гадаад үгийг заавал монголчлоно. Микрофоныг “дуу цацруулагч”, “Кофе”-г “боргол” гэх мэт. Яриа нь Жагар хоол шиг чинжүүтэй, явдал нь тэмээрхүү боловч суудал нь бурханлаг. Энэ мэт гаж гэхээр зан нь түүнийг чимж өдгөө монгол өвгөний хөөрхөн цуглуулга болжээ. Галсангуудын тухай тэрвээр

...Орос хэлтэй Онхор Галсан

Монгол хэлтэй Мөнхор Галсан

Немц хэлтэй Тува Галсан

Нэг ч хэлгүй сувай Галсан...

хэмээх буюу “Сүрэнжав бид хоёрын зургийг хар цагаанаар авахад өнгөтэй гардаг. Хар Пүрэв,

Хар Зана хоёрын зургийг өнгөтэй авахад хар цагаан гардаг” гэх мэт нохойтно. Нөхөд нь түүнийг “Тангад гуай Галсанг бүтээхдээ хамарт нь гар татаагүй бульджээ” гэнэ. Үнэхээр ч түүнийг цогшсон хөрзөн шиг хамар, цоолборлосон мэт нүд, сарьсандаа хавчуулсан сахал, нагал хоёр эзнээ гоёогүй гэхэд зохиогүй чимэг биш.

“АПУ”-гийн заранд түүнийг харсан хүн “Архи уувал ингэж хамаржина” гэсэн сөрөг сурталчилгаа учир оюуны өмчийн газар хориглодоггүй гэдэг. Ортой ч байж мэднэ.

Шогийн мэдрэмжтэй зохиолч шонгийн мод шиг хувхайрдаггүй. Тэгээд ч Галсан хөгширлийн эсрэг элдэв тос түрхдэггүй агал тэнхлүүн яваа. Санаа дагаад ч тэр үү сайд байвал гэж зүйрлэж болдоггүй. Харин хувраг байвал хүүхнүүдийн судас барьж “эхийн уурагтай, энэ хоёр угжийг чинь илбэл заяа тэгшрэнэ, “Алтаар урс” гэж “маарамбадаж” чадна. Зохиолч хүн байх гарвис бүхэн түүнд бий. Хүүдий байна уу, шуудай байна уу хамаагүй хүний сав хоосон буцаахгүй. Нэгэнтээ ногоон нүдтэй бүсгүй түүний хамрыг тохуурхаж “Галсан гуай! Шүр байвал өгөөч гэхэд –Ээ алтаар урс. Миний дүү ийм хоёр сайхан оюутай байж, ахынхаа ганц шүрээр яах нь вэ дээ” гэсэн гэдэг. Өнгөц бодвоос өчиг алдаагүй гэхээр боловч түргэн сэтгэх чадвар юм. Ерөөс яруу найрагчид байх ёстой бас нэг “гажиг” гэвэл од шүүрэх огцом ухаан даруй мөн. Эс тэгвээс санаа оловч барьж чадахгүй хулжаадаг.

1988 онд Галсан “Болор цом” авч билээ. Түүний дөрвөн мөртүүд ирж буй цагийн урийг амьсаж байлаа.

...Дээлээ даахуйцаа болсныг нь сургууль аваад явчихсан юмаа

Дээврээн даахуйцаа болсны нь цэрэгт татаад авчихсан юмаа

Тэмээ адуу дутаасны нь шүүх дуудаад авчихсан юмаа

Дээхнэ үеийн малчид диваажинд залагдаад одсон юмаа...

хэмээн “Манайд малчин ховордсоны учир” шүлгээ дуудаж билээ. Энэ бол цаг үеийг тосох мэдрэмж, цаана байгаа бараан үнэн хоёрын сүлжээс мөн. Ямар ч байсан Галсан “Цагаан толгой” ходоод хоёр нь хоосон мөртөө, цаггалан байна” гэж худлаа гөрж, ангасан амаа ардчиллыг зүхсэн хараалаар цавласан амьд борц болж өтлөхгүй биз ээ.

Галсанбугай гэж...

Гал ус гуай... ажаам.

Тоомойн ОЧИРХҮҮ

Засагт хааны хөх харчуул гэх юм. Алтайхан үүнд орох мөртөө тэдний зүсийг би л лав оноож чаддаггүй. Чадраабалын Лодойдамба, Лодонгийн Түдэв, Санжийн Пүрэв, Далхаагийн Норов нарыг цагаан гэхэд хэцүү бол Мишигийн Цэдэндорж, Лувсангийн Пүрэвдорж, Тоомойн Очирхүү нар барааны айд багтахгүй. Алтайн нар, салхи нэгийг нь дайраад нөгөөгий нь тойрсон гэхэд үнэмшилгүй. Гэвч үүнийг үл анзааран зүсээрээ бус зүрхээрээ бид ижилсжээ.

Тоомойн Очирхүү бол биерхүү, цагаан шар хархүү. Сэрвээгээр үл ялигхан бөгтөр нь өлгий, өөжин хоёрын өөнтөг биз. Тэрвээр цэл залуугаараа бууралтсан онгон үстэй нь цагаас өрсөн цагаан сэтгэлийн хяруу байсан юмсанж.

Очирхүүгийн анх бидэнд уншсан шүлгийг би санахгүй байна. “Оюутан цагаа дурсана уу” хэмээх олноо түгсэн дууны шүлэг түрүүч бүтээлд нь лавтай орно. Тэрвээр яруу найргийн өгсүүр замаар алгуурхан явсан боловч хором зогсоогүй. Эмчийн тангараг өргөж байхдаа ч шүлэг бодож байсан гэхээр тийм үнэнч асныг манайхан мэднэ. Чагнуураа хожуухан авдраас гаргаж хувийн эмнэлэг байгуулахдаа ч шүлгээ бичиж л байсан.

Очирхүү ихэвчлэн иргэнлэг шүлэг бичсэн ч “Самбуу ах минь хаа явна”, “Худгийн Дамбий” зэрэг дүрийн шүлэг ч бий. Найраглал ч бичсэн. Түүний тоонд “Сэгс цагаан Богдын” хариу буюу “Улаанбаатар минь баяртай” орно. “Өвөө Шагдар” гэж аятайхан найраглал бий.

Тоомойн Очирхүү бол уулын яруу найрагч. Уулынхаа чулуугаар сэтгэлээ өрөөд буцсан юм.

1986 онд “Чулууны магтаал”-аараа цом авсан.

...Өвдөг тулж мөлхсөн

Өлмий тулж боссон

Сэтгэл хүлэг хоёроо аргамжсан

Сэрүүн Алтайн минь ширхэг чулуу

Өөрийг минь элээж

Өлгий дээр минь босгох

Эхний бөгөөд эцсийн чулуу

Энэ чулуу-миний чулуу...

Энэ бол чулууны дуулал. Бууринаасаа хөдөлсөн чулуу гурван жил уйлдаг гэдэг бил үү. Тэгвэл чулууны нулимсыг зөвхөн яруу найрагч л арчиж тайтгаруулдаг. Очирхүү тэгж чадсан юм.

Хүний сэтгэлийг сүлсэн хань нөхдийнхөө зовлонд элэг нь эмтэрч, жаргалд магнай нь тэнийдэг тос даасан сэтгэлтэй Тоомойн Очирхүү хадаг шиг хүү. Түүний яруу найрагт хөл тавих цагаас дараа болоогүй бараа болсон төдийд намайг ахдуулан багшийн зэрэгт огшоож, шинэ ном гарах бүрийд халуун үг дайж хадагтай барина. Цагаан сараар эхлээд хадам аав Дугарсанжаадаа (гавьяат жүжигчин) золгоод Энхээтэйгээ миний тохойг өргөнө. Тэд хос ангир шиг хаана ч хамт байсан даа.

Очирхүү олон жил нийтлэлийн цагаахан шүлэгт зүгширч аснаа “Алтан нулимс шиг навч” номоороо өөрийгөө дахин нээсэн юм. Энэ нь шинэлэг, бас яагаад ч юм бэ явах хүний захиас мэт. Та ажигла даа.

“Надад юм бүхэн хамаатай” шүлэгтээ өөртөө бүхнийг хамаатуулаад

...Хамаагүй гэвэл надад юм бүхэн хамаагүй

Харин

Олж ирээд

Од шиг харвах

Онцгой ганцхан

Монгол нутгийн минь

Тохмын чинээ хоёрхон зай л хамаатай

Тоомойн хүүд өөр юу ч хамаагүй...

“Гуутай бурхан шиг Монголдоо” шүлэгт

...Өөр хаана ч биш өрлөг дотно Монголдоо

Өрхөө бүтээн буцах шигээ

Өрхөө татаж ирмээр байна

Өршөө хүүгээ! Монгол минь бурхан минь!..

“Найрагчийн гэргий” шүлэгт

...Өргөө гэр нь шатаад эргийн чулуу хайлахад ч

Өвгөнийхөө гар бичмэлийг нь аваад уйлж гүйж явсан гэдэг...

Нэг л гайтай өдөр тэд маань тохмын чинээ хоёрхон зайд шингэсэн юм. Гэр нь хайлахад Энхээ нь эрсдэж, Очирхүү маань гэмтлийн эмнэлэгт байгаа мэдээ авангуут бид халаг хуухайлан очив. Эмнэлгийн оронд хуйхлагдан хэвтээ түүнийг хараад өрц өмөрсөн хэрнээ, эмч сувилагчийн эргэлзээтэй үгэнд тайтгарахыг эрхбиш хичээсэн. Бидний хувьд амь гарчих болов уу гэсэн горьдлого байсан ч ханиа алдсаныг мэдээд Очирхүүгийн минь өрөвчхөн зүрх ончирлийн харуусалтай эвлэрч чадаагүй бас,

...Бүсгүй хүн орчлонгийн бүх дууг дуулалцаад

Бүүвэйн дуу дээр нь нэмж дуулдаг...

гэж шүлгээ зориулсан Энхээгээ гал дотроос гар нооргийг нь аваад унасан Энхээгээ ганцаар явуулахыг түвдэлгүй одсон доо.

Очирхүүгийн хүүрнэлээр бичсэн цор ганц ном нь “Тоомой панз миний аав” хэмээх дурсамж. Энэ номыг их яарч Цэрэнпилийн Гомбосүрэнтэй эвсэн “Интерпресс”-ээр барлуулсан. Энэхүү адгал нь бас зөн совингийн шавдуулал байсныг бид хэрхэн мэдэх билээ.

Харанхуй хүн харихдаа сэтгэлд сүүдэр хаядаг бол Очирхүү бидний сэтгэлд цагаан гэгээ үлдээсэн билээ.

“Хүмүүс ээ! Бие биендээ урам хайрла” гэсэн түүний гайхамшигт мөр монголчууд байсан цагт сэтгэлийн тэнхээнд нь эрчим нэмэх болно.

Барнангийн ДОРЖПАЛАМ

Яруу найргийн танхимын шигшээнд орж ирсэн багахан цолтой, баргилдуу офицер Барнангийн Доржпалам байв. Цэргийн дэгтэй, гүндүүгүйхэн энэ хөвүүнийг шууд л танхимынхаа ахлагчаар бид сонгочихсон юм.

Доржпаламын шүлэгт, санааг буйлуулж буцааж, эвдэж эвлүүлсэн буюу “би явж байгаа юм, ирж яваа юм. Холдох тусам би ойртож яваа юм” гэсэн шиг өвөрмөц эрэгцүүлэл гаж гэхээр дүрслэл хэллэг содон байв. Харин түүнийг би хайлуулж, хатуужин тогтсон хэвэнд цутгах гээгүй. Ер нь залуу авьяастныг гялсхийж буй өчүүхэн боловч очноос нь зоргоор хөгжөөхийг би эрхэмлэдэг. Эс тэгвээс тулгар авьяас гаднын нөлөөнд урсан алдуурахаар хэврэг гэдгийг би эрдмийнхээ бус элэгдсэний хэрээр ажигласан гэх үү дээ.

Эхлэн бичигчид голцуу эцэг, эхийн ачийг бичдэг. Энэ нь сэтгэлээ шүлэгт юүлэх үүсгэл болдог. Дараа нь дурлалын шүлэг. Энэ үед дотоод ертөнцийн эрчмээр шүлгээ чивчлэнэ. Тэгээд амьдралын зангилааг тайлах бясалгалаас ухаарал, сэтгэлгээний гүн рүү нэвтрэнэ. Энэ бүхэн хууль биш гэхэд тохиолдлын дийлэнх нь тойроогүй.

Барнангийн Доржпаламын хувьд миний дээр өгүүлсэн эрэмбийг түргэн товчилж чадсан билээ.

“Миний ээжийн улаан буурал гал” шүлэгт

...Галыг анх эвийг нь олж хөлд нь суун

Гаднаа гурван чуулугаар чөдөрлөсөн аавын ухаанд биширнэм

...Үсний шанх хөдлөх төдийхөн салхинаас

Үрэгчих шахам байж асдаг гал...

...Будаатай цайны уур савсуулсан буурал гал минь

Буусан хүний өөдөөс харж инээд алдсан хонгор гал минь...

“Морьд эргэх агшин” шүлэгт

...Билүү чулуутай хөндийд

Хуй салхин шидэлцэж

Битүү туурайтай морьдын хөлд

Хул халзан зам янцгаана...

“Тарааж цуглуулсан эх орон минь” шүлэгтээ

...Тал дээр нүүсэн үүл тараасан

Тал дээр бэлчсэн зээр тараасан

...Зээрэн хүрнийхээ хөлөөр

Зэрэглээ тарааж өссөн... гээд

...Тэнгэрийн дуутай хамт

Мөндөр тарааж гүйхдээ

Тэртээ холын бороонд

Өөрөө тардаг байсан

Би өөрөө танаар нэг тарсан... гэх мэтээр эх орноо тарааж, өөрөө тарж, цуглуулсан тухай өгүүлдэг. Энд эсрэг харьцуулалын нэгдэлд шүлэг амилж хөдөлж байна. Яруу найргийн хөдөлгөөнт чанар нь уншигчийг хөшөөлгүй дагуулах хөдөлгүүр мөн. Унтаахай гөлгөр шүлэг бол үгийн хүлээсэнд үхьюү.

Зохиолчдын нэгэн их хурлын үдэш Доржпалам маань хамгийн хайртай уншигчтайгаа манайд ирлээ. Тэр өдөр Дашбалбар намайг гүжирдэн дайрсан ч би хөх инээд чулуудахаас хэтрээгүй. Харин Доржпалам маань машид гутарч заслын сэтгэл өвөрлөж очсон юм билээ. Би түүнийг тайтгаруулж “Чавхны чулуу чадалгүй” гэж инээсэнд их л гайхаж, бас халаглаж суусансан. Түүний сэтгэл тэгтлээ хиртсэнийг ажихад тунгалагийн эмзэглэл байсан даа.

Барнангийн Доржпалам бол манай яруу найрагт нэгэн зүйл аяс авчирсныг хүмүүс анзаарч 1995 онд “Хөөрлийн шүлэг” нь цомын хишиг хүртсэн билээ.

...Өөрөөс минь үүсдэг

Дөрвөн зүг үзүүргүй

Өндрөөс минь дээшээ

Өсөж үргэлжилсэн

Босоо шулуун төгсгөлгүй... гэжээ.

Үнэхээр Доржпалам орон зайн явцуурлаас гарч эс төгсөхүйн хутаг олжээ.

Дамбын ТӨРБАТ

Дамбын Төрбатын “Цог хийморийн зүг” номын титэмд түүнийг би “нарны чулуу” гэж нэрлэсэн юм. Энэ үгэнд халуун агаад хатуу гэсэн утгын сүлбээр бий. Тэрвээр иргэнлэг омголон найрагч. Төрбат цагдаа байсан болохоос байх хүн биш. Гав, бороохой хоёрыг гар нь даавч сэтгэл нь даахгүй. Уран зохиол бол түүний хутаг, хишиг, хувь заяа.

...Аваа өгөө хоёр дээр ус асгаж

Атаа жөтөө хоёр дээр цус асгаж

Алдар хүнд хоёр дээр сүү асгаж

Авьяас билэг хоёр дээр дуу асгах ...нь

Түүний андгай.

Би түүний хэдэн бор шүлгийг уншаад эргүүлж өгөхдөө “хэвлэлийн төлөвлөгөөнд орсон. Дэлдэн Бадарч, эрхлэнэ. Түүнтэй уулз” гэсэн юм билээ. Энэ үед эвэр ганшаагүй асан бол өдгөө хат суужээ.

1996 онд “Ижий шүлгээрээ” цомын наадамд цойлсон.

...Цугтаа амийг тусдаа болгож

Цустай хүйг тасдаж хайчлахад

Ижий минь сүү болж

Над руу урсаж эхэлсэн

Ижийдээ би хүү болон

Нар руу ургаж эхэлсэн...

гэсэн уг шүлгийн мөрөнд эршүүд, уянгын түрлэг бий. Тэр бүр хүн зүрхлээгүй “Үхлийн магтаал” түүнд бас бий.

...Хамаг амьтны хараалын бай болсон

хар үхэл чи байгаагүй бол

Хяслан ч үгүй

Хүслэн ч үгүй энэ амьдрал шиг

Хямдхан юм орчлонд үгүй байхсан

Үүний төлөө би

Үхэл чамайг магтана гэжээ.

Үнэхээр амьдрал нь үхлийн бус үхэл нь амьдралын үнэ цэнийг нэмдэг. Энэ нь дагаар орох бус, дарагдахгүй дардайхын далд санааг илтгэнэ.

Төрбатын хатуурхалд бас уясал бий.

...Гэрий минь гийгүүлж ирсэн чинийхээ

Гэрэлд нь би шүлгээ бичдэг...

гэсэн аргадал үүний гэрч. Тэгэхдээ энэ нь зөвхөн аваалийнхаа гэрэлд аргамжаатай суудаг гэсэн үг биш. Яруу найрагч гэрийн буг байж чаддаггүй. Орчлонгийн сайхныг халиах нүд, хайлах сэтгэл үгүй аваас онгодын тэнгэрээс од буухгүй. Гоо сайхны сатаарал шүлэнг нь уран бүтээлчийн мөнхийн ус мөн.

Иргэнлэг аясын шүлгээс дайжсанаараа суутан болдог ч юм биш. Чанга дуугарч өмөөрөх юм чамд үгүй бол хол явахгүй гол гарахгүй хоосон цэцэрхлээр яах юм бэ. Яруу найргийг зөвхөн өөрийн дээлэнд хүрдэг өрөөл даавуу гэвэл өнгө хүрэвч дотор дутна.

...Хаяа нийлсэн их гүрнүүдийн дунд

Халаасны өрөө шиг эх орон минь ээ

Цадиг түүхтэй дээдсийн үрсийг

Царайчилж сургахгүй юмсан. Яадаг юм билээ гэж

Төрбат шүүрс алдсан байдаг. Хүлцэнгүйрэл, боолын бохирол нь хүний идэш нохойн хэвтэш болгоно гэсэн сануулга. Монгол улсыг авч явах маргаашийн эзний дөрөөнд сүүтэй үг дайх эрхээс гадна үүрэг бидэнд бий. Надаас хойш нар ойчсон ч яадаг юм бэ гэх гэвгнөө нь төөлүүр хорхойн мөлхөө төдийгөөс үл хэтэрнэ. Хайрын өмнө шалдаа бууж царайчлах, харгислалын өөдөөс шазуур зууж зандрахын аль алиныг үгүйсгэж болохгүй. Дэлхийн бүх шувуу нэг янзаар жиргэдэг бол чихэнд чимэг нь юусан билээ.

Дамбын Төрбат бол яруу найраг, хүүрнэлт зохиол, тайз дэлгэцээр тарж гүйцсэн зохиолч. Би энд зөвхөн цомын эзний жишгээр нэгэн сэжүүр атган өгүүлэв.

Уран бүтээлээс гадна Төрбат утга соёлын санд их жин тээж явна. Түүний эрхэлсэн “Монголын уран зохиолын дээжис-108” боть хэвлэгдэж гүйцлээ. Энэ бол илүү дутуугүй ганц үгээр хэлэхэд гавьяа. Үүнд садаа мундаагүй. Элдвээр гоочилж, эврийн ёзоороор мөргөсөн ч

хүмүүс бий. Гэвч ганц ботийн тэн даахаар нь тэдэн дотор байгаагүй. Хоолны ховдгийн амнаас унасан хорхой үг үнэгүй.

Энэхүү таталбарын эхэнд ишилсэн үгийнхээ төгсгөлд “Дамбын Төрбатын шүлгийн аадаршил, цэлмэл, ноцож бас жихүүцэх эргэлт яргаснаас гадна түрэмгийлсэн санаа, нийтлэлийн болон уянгын аяс зэргийг би цомойлон бодоод түүнийг тэнгэрлиг найргийн нарны чулуу хэмээн нэрлэмээр санагдсанаа өчсүгэй” гэж цэглэсэн юм.

Тиймээ. Төрбат нарны чулуу, найргийн халуун чулуу.

Цэндийн ЧИМИДДОРЖ

1989 онд “Мал маллахаа марксизмаар заалгахгүй” гэж аашлаад Чимиддорж болор цом аваад явчихсан. Зохиолчдын ихэнх аргалын утаа үнэрлэсэн болохоор малчдын тухай манайд хонь ямаан сүрэг шиг олон шүлэг бий. Гэтэл Чимиддоржийн “Малчин” гэрийн мухарт гэмтэн мэт хоригдсон бодлоо тайзан дээр ташуурдсанд уншигчид уухайлж билээ. Энэ бол ардчилалын салхинд ам хагарсан шүлэг.

...Албаны тамгатай бичгийг униндаа хавчуулаад мартавч

Адууныхаа тамгыг хадганд боож залсан...

гэж хөдөөгийн хөх малчин агсарваас ам цуурсан хэргээр “аавын хаалга” татах болов уу гэсэн айдас үргэснийг зарласан ч гэж болно.

Биднийг томголож байсан үзэл сурталчид бүү хэл “До” яам, цагдаа нь хулмалзаж, матаачид нүхээ алдсан хулгана шиг гүйлдэж байсан тэр үед инээд уур хоёр зэрэг хүргэсэн иймэрхүү шүлэг олон гарсан.

1988 онд Чимиддорж “Сэлбэ” гэсэн шүлгээр заргалдаж наадамд аман хүзүүдсэнийг эргэж нэг саная.

...Тогтоол зарлиг дундуур урсаж байгаа хотын номхон голыг

Тогтоож чадахгүй уурга шиг чиргүүлэн алдаж байж

...Зэрэглээ залгисан халтар говийн

Бидэрээ гээтэл цахилах хуланг тогтоох юм гэнээ

Битгий сэрүүн зүүдлэж

Сэрж мартцагаа! гэж омогдсоныг олон хүн санаж байгаа.

Чимиддорж шүлгээр аашлах бүү хэл зоддог хүн. Түүнийг “Дэрэнгийн хар азрага” гэдэг. Адууны тухай бичдэг, азрага шиг дэлээрээ гайхуулдаг болохоор тэгээ биз. Тэрвээр өрөөлдөж зогсоод өрөвлөгөө цацлаад шүлэг уншихаараа бөөлөх баалах хоёр зэрэгцэнэ. Тэр хэмнэлдээ ч

шүлгээ тааруулж бичдэг шиг байгаа юм. Заримдаа замаас гарч хадуурна. Агсарч байгаа бас асгаж байгаа нь тэр.

Чимиддоржид “Майга” гэсэн шүлэг бий. Түүндээ бүх юмыг “архидтай” хүүхэд шиг матаж майгалж бичсэн юм. Монголын бүх юм майга гэнэ. Унь тооно, уурга, хуйв, тэр байтугай Чингис, Чимиддорж хоёр хоюулаа майга гэж дуйлуулдаг. Морь унадаг монголын шинж юм байх. Одоогийн савхан хөлтэй хүүхдүүд түүнийг хэрхэн ухаархыг бүү мэд. Энэ шүлгэнд оносон сум нь тэнэсэн сумаа хаацайлаад сонсоход чих илбэдээд өнгөрч билээ.

“Цагаан зээр” гэсэн өмөөрлийн шүлэг:

...Хүний гарт орж хүзүүгээ мушгиулснаас

Хөх чонын хоол болсон минь дээрээ

Би-

Цуутай дорнын цагаан зээр

Цус үзсэн улаан зээр! гэж төгсдөг. Хайрлах сэтгэл хагдарч сохор зоосоор солирсон өнөө үед хаданд ч болсон хашгармаар үг.

1999 онд Чимиддорж “Элсэн тасархай” шүлгээр хоёрдох цомоо шүүрсэн.

...Тэнгэрийн заадас руу нурж буйлсан

Галав элээсэн алтан бүргэдэс

Тэмүүжиний хөсөгтэй нүүж туусан

Морь болгон нь тамгатай

Монгол газрын тасархай... гэсэн мөрүүд бий. Элсэн тасаорхай бол бичиглэгч миний нутгийн сэжүүр бөгөөд олон удаа орж гарсан атлаа би тэмтэрч чадаагүй хоцорсон юм. Нүд дасахад сэтгэл үүрэглэнэ гэдэг. Яруу найрагч “байдаг л юм” гэж гар савахгүй “өөр байж болохгүй юу” гэсэн асуулт өөртөө тулгаж хариулт эрэхгүй бол гангийн тойром шиг хатна.

Чимиддорж адууны аадар шиг шүлэгтэй, бас адуу бичих дуртай. Шагайг хүртэл морь буулгах дуртай. Шагай цуглуулна. “Морь буусан шагай” гэж номтой. Өөрөө бол тэр бүр адуутай бус заримдаа тэмээтэй, бүр ямаатай төстэй харагдах үе ч бий. Энэ бол яруу найрагчийн төрхийн хувьсал. Уг нь шүлгийг уйлж дуулж уурлаж инээж, учирлаж зандарч, ухаарч бясалгаж бичих учиртай. Төрхийн хувьсал нь дотоод ертөнцийн давалгаа мөн.

Гурван марал

Болор цомын болхи харчуулын дунд уншигчийн нүд хужирлах гурван бүсгүй буюу гурван марал бий. Би эднийг тусгайлан хөрөглөж чадаагүй нь бидний хоорондуур өнгөрсөн цагийн

урсгалд хоёр эрэг холдсонтой холбоотой. Тэгээд ч холбоостой ихрийг сиамын гэдэг бол гурвыг хэрхэн нэрлэдэгийг би мэдэхгүй. Сац бас яруу найргийн эрихний хэлхээнд Цоодолын Хулан, Баярхүүгийн Ичинхорлоо, Гомпилдоогийн Мөнхцэцэг гурван марал шиг тусдаа мөртөө хамтдаа. Эрчүүд шүлгийг цусаараа бичдэг бол хүүхнүүд сүүгээрээ бичдэг. Бүсгүй хүний бүсээрээ чандалсан сэтгэлийн нууцлалыг тайлах цор ганц түлхүүр эмэгтэй яруу найрагчид бий. Охин заяа эх болон эхнэр байхын үйлээр хорвоог эрээлж эмгэн буурайд цайрнам бус уу. Энэ бол ертөнцийн талыг ноёлсон эхийн эзэгнэлээс эмийн бардамнал хэмээх сайхан үг гарсан биз. Христийн номоор бүсгүй хүнийг Адамын хавиргаар бүтээсэн гэдэг бол бид арга билгийг шүтэлцүүлсэн бурхны туйрвал гэнэ. Аль нь ч байлаа гэсэн амьдралын халуун чихийг атгаж байдаг бүсгүй хүн гэдэг орчлонгийн төгөлдөржсөн гайхамшиг мөн. Яруу найраг бол эрчүүдээс, хүүхнүүдийн сэтгэлийг эхлэн уудлаж олсон эрдэнэ авай.

Монгол утга зохиолын сан хөмрөгийг шагайхад эмэгтэй найрагч нүдний гэм. Нүүдэлчдийн ахуйд гал, удам хоёрыг ахайтнууд манаж байсан болохоор тэдний аявьяас ер бусын их түүртэлд дарагдсан байж болох юм.

Хорьдугаар зуунд хүүхнүүд яруу найрагт аванхайлсан боловч Шагдарын Дулмаа эгчирхэнэ. Бавуугийн Лхагвасүрэн, Цэдэнжав гуайг буриадчлан шоолохдоо “Ча Дулмаа байна чүү Дэмжээд өгвөл хөдлөөд өгөх хүүхэн байна чүү” гэж чарласан гэж элэглэдэг. Үүнд үнэний гогцоо нь дэмжлэг гэсэн үг юм. Энэ нь зөвхөн зохиолчдын талаас бус, эр нөхрийн дарамттай ч холбоотой байж болно. Харчуулын хоцрогдол хайртынхаа шүлэг бичихийг шалиглал гэж цэхвэлзэх, урлагийн хүүхнүүд алдуурамхай гэдэг муруй амны нэрмээс бас хачирласан л болов уу. Түүн дээр бидний гайхуулдаг цэвэр ичимтгий аалийн цаана нуугдсан эмэгтэйчүүдийн бүрэг ноймойрол ч тотгорлоо биз ээ.

Манай цомт хүүхнүүд дээр өгүүлсэн элдэв садааг эрэмгийлэн нэвтэлсэн юм.

Цоодолын Хулангийн шүлэг эзэн шигээ эршүүд иргэний хатуурхал, омог бардам гэж би санадаг. Эцгээсээ ялгаатай нь аргадахаар тархид гэсэн аяс нь үхээнц доройг тас шилбүүрдэх түүний зан чанар, буюу нүүрнээс гал манартал үнэнийг хэлж чаддаг тачигнасан араншингийн тусгал мөн.

Бурангуй нь үнэнийг дарангуйлсан буурал хорвоод нудрага зангидан зодолдох эрх бас үүрэг ч шүлэгчид бий. Тийм ч учраас тэмцэгч яруу найрагчид нь тэрслүү үзэлтэн болж таван хаанд нүүрээ бардаг жишээг уран зохиолын түүхээс ухаж төнхөлгүй олж болно.

Хулангийн “нэрийн хуудсанд”

...Харц минь зөөлөн зан минь омголон

Хайр минь удаан, дурлал минь үнэн

Салхитай өдрийн өвсийг ч өрөвддөг

Сахиус зүүдэггүй нэгэн Гэлэнмаа гэжээ.

Өөрийгөө танилгүй өнгөрнө гэдэг хайран Хулан өөрийгөө таньсан омголон мөртөө сахилгүй хүүхэн хутагт.

...Хуурай газрыг нортол уйлая

Хулан гэдэг цэцэг энд ургана

Тэр цэцгийг чи тасдаж аваад

Энгэртээ зүүж гэртээ хариарай

Эхнэр чинь асуувал битгий хэлээрэй

Элгэндээ чимээгүй тэвэрч

Цэцгийн зулай дээр үнсээрэй... гэж хэлэхэд бурхан хилэгнэхгүй. Хайр сэтгэлийн танхайрал ёс суртахууны хилийг зөрчих нь нэхэл дагалын орчлонд нээлт хаалтын аль нь ч бишээ. Дар-эх тэвэрсэн бурхан байдаг шүү дээ.

Амар заяа үл үзүүлэх амьдрал гээчид орооцолдож яваа яруу найрагч, амрагийн хөнжилд амаршлыг эрэх цорын ганц цоорхойтой гэвэл алдас.

Өрөөлийн төлөө өөрийгөө золиослох, үнэний төлөө үхэх зориг тэдний хувьд гавьяа биш, эхийн эр зориг мөн.

...Тэнгэрийн дор сэтгэл амар үхнэ гэдэг

Тэрэн шиг худлаа юм найрагчдад алгаа...

гэсэн хоёр мөрнийхөө хооронд Хулан багтана.

...Аливаа гуниг баярт сэтгэл залуу хэвээрээ

Амьдрал зул мэт. Би эрвээхэй мэт шатнаа...

Тиймээ. Хулан шатаж явна. Хар атаархал түүн рүү ус цацавч унтраах бүү хэл дальдрахгүй ноцож явна. Гал өөдөө!

Баярхүүгийн Ичинхорлоо Арвайн талын тоосоор гоёж ирсэн юм. Хаваас нь татсан хөх дээлтэй, ханцуйтай гараар хамраа шударсан шунхан улаан хацартай охин олны өмнө анх удаа хормойн чичиргээнд шүлгээ уншиж байсныг би мэднэ.

Анхны гэнэн хонгор шүлгээс авяасын оч үсрэх элбэггүй. Учир гэвээс авьяас бол хүмүүн хэмээх хүдэрт яргасан байдаг бөгөөд урлан бүтээхийн уйгагүй эрлээр тунгааж шижирсдэг билээ. Харин Ичинхорлоогийн хувьд цэвэр олдоц биш гэхэд судал нь ил байсан юм.

...Миний нутгийн тэнгэрт өдөлсөн шувуу

Бусдын тэнгэрт өдөө цацдаггүй

Миний монголын тэнгэрт өссөн бүргэд

Будант газар ясаа тавьдаггүй...

гэсэн энэ бадгаар тэр найргийн хэлд ороод

...Сүүмэн сүүмэн буцсан жингийн тэр л цуваанд

Сүүтэн сүүтэн буусан гунигаа дайгаад явуулахаас даа

хэмээн хэвлүүрхсэн билээ.

Түүний “Хязгаарт хүрэхүй” номын үүдэнд би “Ичинхорлоо онгодын дөл омог атган дүрэлзэхдээ эрэмшиж, цогшихдоо ухаажиж сэтгэхүйн хулжил авьяасны танхайрлаар, хязгаарт хүрэхийг зорьж явна гэж бичсэнээ санаж байна. Энэ бол зорьсондоо хүрчээ, зовох хэрэггүй хэмээн алмайдуулсан нь огт бус.

...Хувь заяагаа хуурч чадахгүй

Худлаа амьдарч сэтгэлгүй бичихгүй...

...Үнэндээ гэвэл гашуун жаргахаас

Үхсэн нь дээр...

...Өндрийн салхинаас уйдахдаа

Өнгөт нугыг шилэх

Өө чи минь Шонхор

Өвөрт унах шувуу...

...Айдасаа давалгүй зүрхээ дараад

Ард үлдэгсэд миний төлөө залбирна.

Амиа зольж олсон бүхнийхээ

Амтыг би тэдэнд л үлдээнэ.

...Цэх ширтээд уравснаа хэлээрэй

Цээжний минь нөмөрт алдаатайгаа багтаарай...

Ичинхорлоогийн ганзганы эдгээр мөрүүд эрхбиш танд эрэгцүүллийн шалтаг болох буй за.

Түүний шинэ ном эрэл мөний тул олох төөрхийн олз олиг хоёрыг алгасаагүй байна лээ. Бодрол эрэгцүүлэл, халил, тасалдал бас ой тойнд буух, оньсого шиг таах эвдэрсэн эвлэсэн шүлгүүд энэхүү “Хязгаарт хүрэхүйн” номын өнгө талстууд юм билээ. Яруу найрагч өөрийгөө эвдэж, мөн эвлүүлж чаддаг байгаасай гэж би хүсдэг. Эрэл бол мөнхийн зовлонгоос олж харах инээвхийлэл мөн. Эрэхгүй бол элэгдэж өтлөж өгөршинө. Ичинхорлоо эрснээ олж чадах адтай, авьяастай авхаалжтай Янжинлхамын аравнайтай яруу найрагч тул яваг, зовог, олог, баясаг.

Гомпилдоогийн Мөнхцэцэгийг говийн дошгин ноён хутагт Данзанравжаагийн онгодын хишигтэй болов уу хэмээн санана. Тэрвээр амьдрал, найраг хоёрын амтыг арван зургаан насандаа авсан гэж ам алдсан байна лээ.

...Шар торгон дээлтэй

Шүүдэр бөнжигнүүлсэн дурдан бүстэй намар

.....

Арван зургаан нас минь

Хормойд зүүгдэж хоцорсон...

гэсэн түүний өчил бол тэр намар хүүхэд насаа орхиж хүүхэн болсноо хүлээсэн мэдүүлэг. Харин хэн хүний үр түүнийг хээрийн хэц дэрлүүлж балчир насыг нь байлдан эзэлснийг мэдэхгүй, мэдээд ч яахсан билээ.

...Арван зургаан насны минь намар

Аргадмаар, сөгдмөөр зөөлхөн байсан гэж хэзээ хойно үл мартагдах аялгуу сэтгэлийг нь хөглөснийг бодоход тэр учрал яруу найргийнх байсан буй за. Үүнээс үүдэхэд сархадын шүүдэртэй цэцгийн бал хүртэж, шүлэг дурлал хоёрт шатсан Дулдуйтын Равжаагийн хойт дүр биш гэхэд хожмын үр нь бидний энхрийхэн Мөөжөг мөн шиг байгаа юм. Энэ нь хэдийвээр өнгөндөө хийсвэрлэл мэт боловч үндэснийхээ соёлоос үрлэж ургах уламжлалаас угсаа залгах тэрхүү үл тасалдаж холбоонд Мөнхцэцэг төрж, өсжээ. Ийм хувь зохиол бол шүлэг бичихгүй байх түүний эрхийг хассан биз ээ.

Мөнхцэцэг нь Хулан, Ичин хоёроосоо аядуу дөлгөөн урсгалын шүлгээрээ ялгардаг. Зөөлхөн дугардаг шигээ цөөхөн шүлэг бичдэг. Тэгэхдээ ирээ толхиж сэтгэлээ нэрж удаан дуншдаг нь ажиглагдана.

Мөнхцэцэг “Чамаас олсон эх орон минь” шүлгээрээ цомын эзэн болсон.

...Ижийнхээ нурууг амрааж хөлд орохын цагт минь

Ивж ургасан өвс нь налж сөгдсөн эх орон минь

Ижийгээ би чамаас олсон

...Бусдаас гуйхгүй үхлийг хүртэл чамаас олохын цагт

Бурхад чинь хүртэл намайг булаалдана эх орон минь!

Энэ шүлэгт уясал, ухаарлын уянгын хос утас хөг нийлж буй нь Мөнхцэцэгийн бичлэгийн өөриймссөн өнгө аяс болж байна. Өнгөө олсон шүлэгч өдөр цагийн хөсгийг тэнгүй явуулж болохгүй. Үүнийг найргийн шинэ нутагт бууж сайхан цайны дээжтэй, шүлгийн цацлаа өргөхийг чинь хүлээж суугаагаа энэ ялдамд эрхлүүлэн өчсү.

Би энд зөвхөн хорьдугаар зууны цомын эздийн хөргийг татлав. Үүнийг сонжоо буюу сэжээ гэхээсээ мушилзсан учирлал элгэмсэл гэдгийг дахин хэлье. Төгсгөлд нэг наргиа нэмье. Биднийг монгол ардын дуугаар хочилсон даажин гарсан байна лээ. Намайг “Хүрэн толгойн сүүдэр”, гэсэн нь хуучирсан, их сүүдэртэй бага толгод гэсэн шиг байгаа юм. Лхагвасүрэнг “Баатар Цогтын нагац”, Цоодолыг “Гунан хар” Бадарчийг “Задгай цагаан үүл”, Галсанг “Дүнгэр Да лам”, Чимиддоржийг “Их л дэлтэй борлог”, Хуланг “Эрүү цагаан болжмор”, Ичинхорлоог “Хулсан ташуур”, Мөнхцэцэгийг “Хар торгон хамжаар” гэж оноожээ. Өөрөөсөө бусдын тайлалыг би олоогүй. Уншигч та таахыг бодоорой.

Монгол туургатан “Болор цом”-гүй амьдарч болох чиг яруу найрагчгүй бол явдал, суудлын алинд ч оюун сэтгэлийн онч дутна. Тэдний хувьд яруу найраг бол өөрдсийн нь мөнхийн эзэгнэлт өмч мөн.

Энэхүү бүлгийг би эвхэхдээ монгол яруу найргийн эзэд нь зөвхөн “Болор цомтнууд” хэмээн булагнасан нь огт бус, хар хэл амны халгааг төвөгшөөн нь болой. Орчин үеийн утга зохиолд өрхтэй үүдтэй олон түмний өргөмжилсөн олбог түшлэгтэй Шаравын Сүрэнжав, Долгорын Нямаа, Дамдинсүрэнгийн Урианхай нарын тухай энд гачир нэмсэнгүй. Сүрэнжавын үерлэсэн тэлмээ, Нямаагийн тарни мэт шивхнүүн уянга, Урианхайн этгээд сэтгэлгээний бясалгал тэдний хувь нээлт мөн. Харин уянгын тухай мөчигхөн атугай ч цухуйлгамаар санагдав.

Яруу найргийн охь булаг нь янагийн шивнээ, эхийн бүүвэйн уянга мөн. Түүний энэхүү хүмүүнлэнгийн зэргэмцээ нийгмийн амьдрал иргэнлэг чанараар зуузайлжээ. Хайрлах, дайсагнах, эрэгцүүлэх, бясалгахын аль алиныг бодот болон хийсвэрлэн илэрхийлэх өвөрмөц хэлбэр байхаас бус гуравдах гольдролыг би хараагүй л байна. Иймээс алив шинэчлэл агуулгын гэхээсээ хэлбэрийн хандлагатай гэж мунхаглана.

Уянга бол хүн хүндээ ивлэх хайлал бас хажиглах харшилын ондоосолтой. Үүнээс мэлмэрсэн уянгын тухайд нэхэл хатуурхмаар байна. Сэтгэлийн хургүй хуурайшил яхир яншаа, үлбэгэр үглээ, хоосон цэцэрхэл залхаах болов. Энэ тухай “гурван марал”-ын хэсэгт дайж буй маань эмэгтэй найрагчдаас “Эхлэг” уянга горьдож буйтай холбоотой. Бүсгүй хүний илбэсэн сэтгэл, бал мэдрэмж адтай хүүхэмсэл, дурлалын гэгэлзэл, хямсалзсан бардамнал, наалинхайрсан номгорол аль аль нь уянгын алдууралтай. Чухамхүү эндээс булган уянга сортоосой гэж би хүснэ.

Улаан нүүр рүү түйрэн шавхуурдсан юм уу, ухааруулахаасаа горойлгосон богинохон ухааны боргоос хүмүүс уйджээ. Хорвоогийн хахирганыг зөөллөх аргадсан хайрласан амьд уянгын

шүлэгт уусмаар байна. Хүний дотоод ертөнц цэвдэгшин, нүнжиг цөвдөллөж буй энэ үед цэцгийн шүүдэр мэт хайрын уянгад авгаж байгал эхийн энхрий хүүхдийн ёсоор эрхлэхийн жаргал эдлүүлээ ч хэмээн найрагч нөхөддөө наманчлан мөргөө. Монгол уншигчид ясны яруу найрагч, дуучин, тансаг таашаалтай төдийгүй мал нь хүртэл шүлэг аялгуу хоёрт шүтэн уярч, нулимс унагадаг уянгын заяалтай билээ.

Тэнгэрлэг хайрын гэгээн тамд тарчлах, энгэр зөрсөн эхний шөнийн дэрэнд шархдах, өөрийгөө өвчсөн үрийг өлгийдөө үнэгчлэхийг хараад зүрх хайлах ер сэтгэлийн алив уйтгар, тайтгарт автахгүй юм бол хохь шүлэгч хорвоод хоргодоод яах юм бэ. Яруу найрагч байтугай ямарч зандалчин үүнд үнгэлдэлгүйгээр үхэж далдраагүй бус уу.

Уянга бол дарс нулимс, мишээл тэчъяал бас мөнхийн ус мөн.

“Уймрал” хэмээх гийгүүлэгч бүлэг

Нэг. Нээнтэгтэй шаантаг

Хар өглөөгүүр хаалганы хонх чарлуулаач гайхал Гонжийн дог байв. Тэрвээр үг сүггүй,

-Цаана чинь нанчидын галав юүлж намын гишүүд живж байна гэх нь тэр.

-Яана гэнээ?

-Ялалтын баяр! Манай Ху намын үүдээр хуурай толгойтой хүн алга. Муу хөгшин чинь ардчилалынхныг тавлаж байгаад амьтны хишигнээс жилбэн цохьчихлоо. Энэ сонгууль танайхны арьсыг хуулаад хамар дээр нь унжуулчихаж. Хоёр гурван шийр л үлдсэн юм байх. Ардчилсан намын үүдээр өнгөрөхөд адуугаа алдчихсан айл шиг л байна.

-Яахав дээ нэг нь дийлж, нөгөө нь дэлдийгээ л биз.

-Тийм нь ч тийм. Хоймор дүүрэн бурхантай айлд хотонд хуцдаг нохой байдаг.

-Чи чинь хувьсгалт намаа худалдчихаа юу?

-Гонжийн дог. Онгорхой цоорхой ихтэй ч олон жил хоргодсон овоохой гэж мэдэх үү. Гэм нь гэвэл манай нам толгой дээр гаргахаар малгай руу сариад байдаг юм. Харин чи манайд маасайх болоо юу?

-Нам салнаас бус найзууд салаагүй. Сайхан нөхөд олон бий. Аяга цайны ээлжгүй болтлоо ар өврөөрөө хараад яах юм бэ...

Намбардагва хуучин руугаа хургаатай, би шинэ рүүгээ шилрээтэй болохоор бид хоёр билүү занууны ялгаатай. 2000 оны сонгууль ханархыг би гадарлаж байсан ч арай ингэж алга эргэнэ чинээ санаагүй.

Би Гонжийн догийг сөрмөв.

-Чи намайг дийлж дээ

-Гонжийн дог. Танайхан засгийн газраараа тэвэг өшиглөө биз дээ. Энхсайханыг мөргөж эврээ хугалаад, Элбэгдорж дээр цээжгүй, Наранцацралт дээр нуруугүй, Амаржаргал дээр ахар сүүл нь үлдсэн дэг. Толгойд нь малгай, тогоонд нь тос тогтдоггүй түрхнүүд. Нэрээ түлэхээр гэрээ түл гэдэггүй сэн үү.

-Ардчиллын гавьяаг алдаагаар нь арчиж болохгүй.

-Гонжийн дог. Хэдэн хүүхэд харангадаж үхэх гэж хэвтсэний хүчинд юу болсныг хүн бүү хэл мал мэднэ.

-Тэгээд?

-Танай манай хоёр нам нэг нь баруун тийшээ, нөгөө нь зүүн тийшээ явж байна гэх юм. Хаачих гээд байгаа юм бэ?

-Түүнийг би байтугай хэлж байгаа хүмүүс нь мэдэхгүй.

-Тэгвэл манай намыг болохоор “Ху” нам, бусдыг нь ардчилсан хүчин гэлцэх юм. Манай нам ардчилаагүй гэсэн үг үү?

-Танайд нэг тарлан бух байсан биз дээ.

-Айлын зэл хэсээд үнээ сувайруулчихдаг амьтан байлаа, хөөрхий.

-Тэгээд хөнгөлж амраа биз дээ.

-Бух ч биш шар ч биш болсон доо зайлуул. Ингэхэд чи манай хэдийн түнгэрцэгийг сугалах гээ юу?

-Бүгдийг нь биш ээ.

-Танайхнаас ч гэсэн бузгай хэдий нь ялгаж аваад бусдаар нь хуц хариулгавал таарна. Явгийг бухмаад...

Шаантаг. Гонжийн дог сүүлийн үед аминдаа зөв улс төржиж байн байн намайг нээнтэглэх болов. Би улс төрч биш гэж бултах гэхээр “мухар үхэрт эвэр эрээгүй, муруй модонд залуур хайж явна. Чи улсын зохиолч юм бол ухааны тагжраа зэтгээд өг” гэж моготгоно. Айхавтар ухаантан биш энэ гайхал ганц нүдтэй гавал биш. Түүн дээр үг нь үерлээд ирэхээр толхилцох хэцүү. Амыг нь дагуулах, хамры нь сөргөөхийн аль алинаар үзэлцээд арга мухардахдаа түүний нээнтэгийг би шаантаглая гэж шийдсэн юм.

Нээнтэг. Гонжийн дог:

-Санхүүгийн сайдыг таних уу? Сарвуу хийлгэх юмсан.

-Хиймэл мөч хийдэг газар очихгүй юу.

-Гонжийндог. Манай хэдэн гишүүн гар өргөөд л байх юм. Ард нь амьсгааны хэрэг байгаа юм уу. “Хонооп” дарахаар гозосхийдэг хэдэн шуу байвал мөнгө их гамнана даа.

-Тэд чинь дор бүрдээ толгойтой улс!

-Харахад халимагтай гээгтэй ч хамагчтай дөртэй юм биш үү.

-Намын бүлэг гэж байдаг юм.

-Гонжийн дог. Тэгвэл тэр хэд нь байг л даа. Мань мэтэд, өнчин зоосны унжуурга унаг.

-Чи хоолны хишиг горьдоод байгаа юм уу?

-Үгүй чиш. Цаадуул чинь “дойлор” гүнцэглэдэг гэсэн биз дээ.

-Амны хишиг!

-Амны биш, авлагын хишиг. Чимхэж өгөөд атгаж авна гэдэг энэ.

-Төрд хэрэгтэй зайрангууд шүү.

-Даллуулсан мөндөл шиг хэдэн юм хошгороод тахалтай бурхи шиг бусад нь дуугарахгүй л юм байна даг.

-Тэдний дотор эрдэмтэн докторууд олон бий.

-Гонжийн дог. Ширэн дээлний эрдэмтэдийн хойноос ширээ сандлых залгаж л дээ. Хагас эрдэмтнээс хайдаг ямаа дээр. Зурагт шагайсаар байгаад хуучин гишүүдээ хэн нь хэн бэ гэдгийг гадарлах болчихлоо.

Манай хоёрыг Асар, Басар гээд байх болж. Тэд чинь ураг гээгүй барих гээд байгаа биз дээ. Намын батлах хараад намайг орхино. Чамайг бол чацархайгаар чинь хойт ам руу хөтлөж мэднэ. Нөгөө зурман Гочоотой адилхан харагддаг чинь хэнсэн билээ. Гочоо чинь сайн байна уу гэхэд “хуцаж бай” гэдэг байв даа. Чиний яахав, чихнээс бусад нь бөөрөнхий. Бас нэг нь хөдөсний шар цавуу шиг зунгааралдаад салахгүй. Нөгөө хэн онголзоон дандаа ортой юм хэлнэ. Манай нэг утаатай авдар шиг хүн байдаг юм. Дотор нь юу байдгийг мэдэхгүй. Бас нэг тойг шиг хүүг ардчиллын тагнуул гэцгээх юм. Бэрс гарч мэдэх хүү. Идүүлчих л байх даа. Танай “далайн шуурга” үнэн юм хэлдэг ч үгэнд гамгүй харагдаад байдаг юм. Охин хөөрхий орох үүдээрээ орчихоод ондоо хаалгаар гарчих гээд байх бололтой юм. Нар биш чиг үүл хаачихгүй бол гэгээтэй хүү бий. Бусдыг нь мэдэхгүй. Буудсан ч ганхийхгүй томоонууд. Хүүхнүүд яахав. Нэг нь охин даргын овор суух гээд хагас үгээ хамраараа гоожуулаад байдаг болчихож. Нөгөө “гэдгэр” Жамбын эхнэртэй адилхан чинь хэн билээ? Муу Жамбынд бүтэн шаазан байдаггүйсэн.

-Эхээс төрсөн мөртөө эмэгтэй хүнийг элдэвлэхэд би дургүй. Жендер гэж чи дуулаагүй юу?

-Чив, сүв хоёр чи би-дээ тулахыг хэлээд байгаа юм биш үү. Хороон дээр харайсан ямаа, хоймор цамнасан эм хоёрт би сүжиггүй. Хөгширсөн хойноо хөгийн юм үзлээ. Манай хамар хашааны хархүү ардчиллын салхи, авгай нь хувьсгалт намын хулхи. Тэгсэн чинь хорооны нэг муу хогжруу өрхийн тэргүүлэгчээр эхнэрийг нь бүртгэнэ гэсэн байгаа юм даа. Муу ёр. Явгий бухмаад!...

Шаантаг. Манайхан капитализмыг огил зөөллөж “хүмүүнлэг ардчилсан” гэдэг хүзүүвч зүүв. Яая гэхэв дээ, “чонолог” гэлтэй нь биш. Гэтэл өнөө гайхал нь урдаа гэрэлтэй ардаа сүүдэртэй юмсанж. Социализм, капитализм хоёрын хав дөрвөлжин золгоог шилжилтийн үе гэдэг гэнэ. Ийнхүү би шилжилтийн хүн болсон болохоор эрхэм гишүүдийг элдвээр гочлоод яахсан билээ. Харин тэд “ард түмэн ямар бол төлөөлөл нь тийм. Бид бол та нар

муусайчуулын байж байгаа царай” гэж ноцох болов. Үгүй шүү. Тэд бол бүлэглэлийн бүүдэгнэл.

Монгол ардын дуунд “тавхан үгэндээ танигдаад байна” гэдэг дээ. Үгний үзүүрээр хүнийг шинжих эртний энэ ёсыг сонгох сонжихтой холбож болох мэт. Үүнийг наргиа, бас доргио болгоод үзье. Сонгуульд нэр дэвшигчид энд тэндгүй бядан явдаг. Тэдний ааш зан аялаг ялдам, ам өчиг алтаар гулгих мэт өгөөмөр. Гэрт гадаагүй гэгээ татуулсаар сонгогдсон хойноо солонго шиг баригддаггүй. Тэгээд л “буруу хүн сонгочихжээ” гэж мань мэт нь халаг түлэг болдог. Ноднин хонь идсэн чоныг энэ жил эрээд яахав дээ. Алдсан хойноо амаа барихын оронд “тэр гуайгаа” эхлээд таних нь өлзийтэй. Гэвч тар таних хэцүү тул үзэгдээд өнгөрхийн зуур үгээр ядахдаа шинжвэл юутай вэ гэж санах.

“Тэр гуай” та нарын төлөө үхнэ л гэх вий. Худлаа шүү. Ганц олдох амиа олзонд үйхээс гарзанд хаяхгүй. Биднийг тамд орхиод диваажинд очихоо мэднэ.

-”Тэр гуай” ард түмний итгэлийг хүлээсэн, ард түмэн намайг сонгосон гэж дуу хадаах вий. Үгүй шүү. Нутгийн тойргоос тодорсон түүнийг сонгоогүй бусад нь амны угаадас биш.

-”Тэр гуай” асуудлыг олон өнцгөөс нь харж шийднэ гэх вий. Ухаантай хүн нүд буландаггүй хар цагааныг ялгана.

-”Тэр гуай” асуудлыг хөндөнө гэх вий. Халыг мөлт хүрэхээс биш хариуцахгүй.

-”Тэр гуай” механизм олно гэх вий. Унь өлгөж чадахгүй байж мөнхийн хөдөлгүүр бүтээхийг горьдсоны гарз

-”Тэр гуай” тэгдэг л байхгүй юу гэх вий. Мэдэмгий царайт мэргэн нь үгүй.

-”Тэр гуай” энэ утгаараа гэх вий. Нөгөө утга руу салаалж бултах гэж байгаа нь тэр.

-”Тэр гуай” баяр хүргэмээр байна, баярлаж байгаагаа хэлмээр байна гэх вий. Үнэ цэнгүй үнэрхэл томорхол гэдэг энэ. Хүргэсэн хүргээгүй хүн түүгээр дутахгүй.

-”Тэр гуай” ойлгож байгаа гэх вий. Худлаа шүү. Хувийн бодлоо хэлсэн гээд худраганаас мултрах мэх.

-”Тэр гуай” өөрийнхөө шудрагыг гайхах вий. Хуурамчаа нуух хулгавчин баг. Худалчийн нээрэн олон.

-”Тэр гуай” бусдыг зүхээд унах вий. Муу хүний мухар нүх шиг санаа хороо цацаж байгаа нь тэр.

-”Тэр гуай” буян амлаад унах вий. Өгөхгүй. Хайр ширгэсэн хар дэлэн алгадаж байна гэж мэд.

-”Тэр гуай” халтар өгүүлбэр хэлээд “тийм ээ, тийм ээ” гэж тэнэг тулгаас хийгээд байх вий. Хүнд хишиглэх оюуны өгөөжгүйн харгай.

Энд би эгэл хүмүүсийн ойр зуур ам халдаг сонжоог эвлүүлэв. Монголчууд мориноос гадна хүн шинждэг хур эрдэмтэй.

Өрөөлийг ийнхүү өөчлөхийн сацуу бид бас өөрийг сөрмөж засах нь мөнхүү өтгөсийн эрдэм. Хүнд хүнцэл залгиулаад өөрсдөө өөх үмхэх гэвээс “ижил годил, ихэр шидэл” болно.

Бидний гэм барагдаж, гэнэн арилдаггүйн жишээг сонгуулиар жишье л дээ. Бид чинь сайнаас сайчилдаггүй, муу дарга нарын дотроос сайн дарга эрдэг. Яаж олдохов дээ. Өдгөө цагт төрийг хэн түших нь намд хамаатай ч сонгогч хэмээгдэх та бидний саналтай сагалдрага холбоотой. Нэгэн цагт Чингис хаан “Уст хожуулаар галыг сөнөөж, ухаангүй хүнээр элч болговоос улс эвдэрюү” гэж айлдсан билээ. Хааяа ч гэсэн хаан эзнийхээ үгэнд орж байя л даа. Бид дээдсийнхээ сургаалыг хоцрогдлын хог руу шидэж элдэв номлолд ээнэглээд тийм их хожсон бил үү?

“Маркс, Лениний сургаалийг

Магад үнэнээр биелүүлээд”... ангийн тэмцлийн цусанд ард түмнээ үйсэн биз дээ. Элдэв онолд эргүүтэгсдийг эх сургаалаар нь “догматикууд” гэдэг юм гэнэлээ. Одоогийнхоор тэд улс төрч гээч нь л байжээ.

Улс төрч гэдэг нь төрийн мэргэн бодлогчийг хэлдэг юмсанж. Тэд аль нэг намын ам дансаар төрд янгиа тохдог учир намчид болдог аж. “Энэ утгаар” нь албан тушаалч гэхэд андуугүй.

Улс төрч хэмээх нэгэнээс “эх орны төлөө юу хийж байна даа” гэхэд “тийм аар саар юм бодож байх зав алга” гэсэн гэдэг. Ээ чааваас! Үүнээс дөрлөөд толь бичиг шагайвал улс төрч гэдэг үг байх юм. Бас “политикан” гэдэг нэр орос хэл дээр байвч “жавшаанч” гэж монголчилжээ. Ц.Дамдинсүрэн гуай цэцтэй болохоор хулхинд нь зоосон буй за. Хэн нэгэн өөрийгөө мэргэжлийн улс төрч, бэлтгэгдсэн улс төрч гэж ёндойх нь дуулна. Энэ нь цаанаа мэргэжлийн буюу бэлтгэгдсэн “жавшаанч” гэдэгтэй үйлийн үргүй адилхан буугаад байна шүү. Бурхан минь!

Ардчилсан хувьсгалын цагаан морь, цоохор болсны учир үүнд буй ажээ.

2000 оны сонгуулиар өвөө нам хойморлосон нь тэдний буруу биш. Ардчиллынхан алдаагаараа сэнтий засч өгсөн. Ам булаасан давлиурал, албан тушаалын хэмхэлцээн, агуурсын дэнэмгийрэл, атгаалжилсан арван таван толгой нь тэдний тэнгэрийн барьцыг алдуулсан юм.

Хамгийн олон боловсон хүчинтэй хэмээх “ху” намын хагас нь “бүдүүлэг хүчин” харьцангуй залуу гэх ардчилсан хүчний хагас нь “түүхий хүчин” болжээ. Үүний балгаар төрд намын “хоноц” олширчээ. Тэгээд ч хоноцод хорхойсол байхаас сэтгэл байдаггүй шүү дээ.

Нээнтэг. Гонжийндог

-Цагдаа нар Гүндалай гээчийг хэмхэж байхыг очиж харав уу?

-Үгүй чиш.

-Цаана нь цанхлаад байгаа манай сайд тагнуул юм уу?

-Хавханд хөлөө хийсэн юм болов уу даа.

-Тэгээд мөчөө тас хазаад арилаа юу?

-Чонын эр зориг хүн бүхэнд байдаггүй.

-Гонжийн дог. Тагнуулч чинь илжигтэй хятадаар, морьтой монголоор, арслантай ангилаар, баавгайтай оросоор ярьдаг гэх ухааны юм хэн нь ч билээ хэлсэн байна лээ.

-Бас буутай гэсэн байх шүү.

-Гонжийн дог. Тэгвэл мань мэтийн тэвнийн сүвэгч байтугай, тэмээний салтаагаар гарч чадахгүй, хазгай монголоос өөр хэлгүй, халдганаас өөр зэвсэггүй жулдрай горьдохын гоомой юм байна. Харин манай сайд төмөр зажилж гал залгидаг байлгүй. Уурлахаараа ухаан нь нисчихдэг юм биш байгаа?

-Яаж байна вэ?

-Ардчиллынхнаас тэрбум төгрөг авч тагнуулын газар өгнө гэж байна лээ.

-Яах гэж...?

-Хай л даа. Хавгастай юмаа салгаж авах гээ юм болов уу.

-Тэгж хэлээгүй байх шүү.

-Тэнэгийн дотор тэгж л буусан даа.

-Сүрдүүлээ биз.

-Гонжийн дог. Ишгүй сүхээр ирээгүй түлээг хагалдаг юм уу? Манай сайд их эрдэмтэн хүн үү?

-Хэн тэгж байна вэ?

-Өөрөө...

-Хүнээр хэлүүлвэл зүгээр үг юмсанж.

-Даргагүй нам яаж сонгуульд ордгийг үзнэ гэж байна лээ. Энхсайханыг алаад өлгөөд өгнө гэсэн үг үү?

-Хэлсэн хүнээс нь асуу...

-Бас хөл дээр гишгэнэ гээд байгаа.

-Яалаа гэж?

-Хууль алхлаа гэж...

-Худлаа байлгүй дээ. Толгойгүй хөл алхахгүй. Толгойгий нь гишгэнэ гээ биз.

-Тэр ч дүүрчээ. Төрийн нууц гүтгэлэг гэж юуг хэлээд байгаа юм бэ?

-Аль ч үед би амаараа унгах дургүй. Чи нэртэйгээр нь торгон дээлтэй чоно үзсэн үү гэж асуу...

-Чи битгий тал засч тохой тат. Би сайдыг танихгүй. Таниад ч яахсан билээ. Байсхийгээд Багабанди ерөнхийлөгч рүү дайрах юм. Өөрөө том бандгай юм уу?

-Чи надаас чөтгөрийн гоймон нэхээд байна уу. Нохой хуцах тоолон нойроо хугаслаж гүйж гардаг нь би биш.

-Цаадахыг чинь би танай талын тагнуул гэсэн хар буугаад байгаа шүү.

-Чиний толгойгоор чихмэл хийх болж гэм.

-Арзаганах тоолондоо, ардчиллынхны үнийг нэмээд байна шүү дээ.

-Ус нь тус болж байгаа юм байлгүй.

-Чи ер нь холбоонд тогтдоггүй шоомон хонь шиг мултраад байдаг болсон хүн юм. Төрийн нууц гүтгэлэг гэдгийг л хэлээд аль.

-Тийм юм байхгүй.

-Байхгүй болоод Баатар генерал гээчээр шорон шүншиглэв үү.

-Энэ чинь шинэ юм биш. Жамбалдоржийн үед ч байсан.

-Худал гүтгэхийг хуурай гүжир гэдэгсэн. Яахаараа эсэргүү болгож эргэнд хаядаг билээ.

-Хуулийн цоорхойгоор хонзон гоожсон юм байлгүй.

-Завсраар нь заан ойчихоор хуультай байж, хулгана гүйсний төлөө хутга мэсээр ч яахсан билээ. Энэ дотоод яам чинь хуучин ногоон малгайтны газар уу?

-Хэн мэдэхэв. Цагаан малгайтай улс л харагддаг юм билээ.

-Толгой солиогүй, малгай сольсон бол “долоо наймын донжиг нэг” гэсэн үг.

-Амнаасаа болж аарцны савнаасаа салах гэсэн үг бий шүү.

-Ардчилал чинь донгосч болно гээ биз дээ.

-Ардчилал хэний гарт байгаагаас л болно.

-За за больё. Хааны нохойд ноцуулахаар хангайн чононд бариул гэдэг. Явгий бухмаад...

Шаантаг. Ардчиллын арван таван жил эзэддээ халгаатай байв. Батчулуун Энхбаатар, Байгал гурвыг “казино”-гийн гэх хохирогчгүй, нэхэмжлэлгүй хэргээр шорондов. Зоригийн егүүтгэлийн хэрэгт Бат-Үүлийн цагаан толгойг цагаан малгайд нь хомборгодон, Гүндалайд “гүрний бяр” гарган “худаглав”. Генерал Баатар, хурандаа Санжаасүрэн хоёрыг цовдлов. Бас сэтгүүлчид ч өртөв. Эл “ялтнууд” яагаад ардчиллын үнэрээр шиншлүүлсэн нь сэтгэл сэрдхийлгэхгүй байна гэж үү. “Ганц худаг” руу очих ардчилалын зам мянганых юм уу. Энэ бүх хэрэгт эрүү үүсгээчдэд “эргүү” үүсгэж мөрөөс холтгохгүй бол төрийн суганд хярсан төмөр “бугнууд” эрээ цээр алдах нээ. Тэдэнд ил далд мөрдөс, гав, шоронгийн түлхүүр бас буу бий. Сүхбаатарын талбайд цуглан газраа өмчлөх гэсэн тракторчдын жагсаалын үеэр цагдаагийн нэгэн таахай “дарга тушаавал буудна” гэж зандарсныг санаж байна. Бууны ард бурхан байдаггүй еэ.

Ард олны сэтгэлээс айдсын чихүүцэл арилахгүй байна. Улаан хувьсгалчийн сүг сүүдэр цагаан ардчилагчийн дүрээр тодорч шударгын жанч нөмрөн зүрх бус зүс хувилжээ. Тэднийг басаж болохгүй. Аюул биш гэхэд түйвээлээр амьдралын замд сүүдэгнэж буйг анзаарахгүй байж бүр ч болохгүй.

Миний хувьд гэвэл гучаад оны идүүрээс цус долоомооргүй байна. Цалин, одон, хэргэм гурвын төлөө яахаас ч буцахгүй цагдаа, тагнуул, шүүхийн зарим сэтэртнүүдийг мартсандаа бус, эрх чөлөөний дальдчин буй гэрэлд энэ хорвоогийн эмзэгхэн нэгэн үүр цайхыг үзмээр банья. Тэгэхдээ хохирогч заавал хэрэгтэй бол гарзгүйгээр нь намайг аваг.

Оросын дайзыг монголын гавалд сулласан шарх зүрхэнд буглаастай байгаа. Чөтгөр инээдэг, харин уйлдаггүй гэдэг билээ.

Нээнтэг. Гонжийн дог:

-Нөгөө Зориг хүүг хөнөөсөн хэрэг хэзээ илрэх гэж байна.

-Илрүүлэх шатандаа л гэдэг.

-Тэр шат нь тэг дундуураа хугарсан юм биш үү. Мөрөн хурандаа гээч энэ засгийн үед илрэхгүй гэж байгаад их хуралд цогнойгоо биз дээ. Зүрхэн дотроо над шиг таван хошууны хугархайтай зүдэг жаал, зүүдээ ярьсан уу, хулгайгаа ярьсан уу. Сая бас шар Энхээ ч гэнэ үү, уухилж аахилсан улингар “Энхсайханы даалгавараар, “Цагаан шонхор”-ын Энхтайван захиалж надаар нядаалгасан гээд гарын үсэг зурчихвал, хэргээс хэлтлэж хэдэн бор юм чулуудна” гэж тулгасан гэх ухааны юм бурна билээ. Энэ цагдаа, тагнуулч эзнээ алдаж эмээлээ шоохойлжээ. Нөгөө засгийн ам гарсан таван зуун саяыг тампуулах нээ. Тэрэндээ тулвал муу хөгшин чинь хүлээгээд ганц нагай хэдэн мөндөлдөө хөөе орхиод тонилоё.

-Амь ч үгүй, мөнгө ч үгүй болов доо.

-Гонжийн дог. Хотын захад хоолой хэрччихээд учир битүүлгээр үхсэн гэж чадах л вий. Яахав дээ, ямааны үнэ надад байхгүй. Навтсан дээр дугжрах, нааран дээр хөгцрөх ялгаа юу байна вэ. Явгий бухмаад...!

Шаантаг. Мөрөн хурандаагийн хий алдсан онжгонд “Ардчилалынхан Зоригийг алсан” гэх хоргос байсан гэхэд өөрийнх нь үү, өрөөлд шахуулж дүлсэн үү гэдгийг би мэдэхгүй. Харин тагнуулынхан гучаад оноос ялтантай янаглан, гэрч хээлтүүлж гэмгүйг гэсгээж асныг даяар мэднэ. Эсхүл тэртэй тэргүй золигт гарсан золиосонд дайж хавгас хаадаг арга ч бий. “Хорин таван мянгатын” гэх хүн амины болон Дарамын Төмөр-Очирыг егүүтгэсэн хэргийг ийнхүү цөлсөн шүү дээ. Алив хэрэг явдлыг ам тагласан үгээр бөглөж мартагнуулахад бид ч гайхахаа байжээ. Уг нь гайхах чадваргүй болтлоо адал балмадад аажууран дасваас аминд халтай. Өнгөрсөн зууны гамшигийг өнөөдөр бид мартахын манангаар булсаар л байна. Алуурчдыг өмөөрч “Цаг үе нь тийм байсан” хэмээн цагаатгалын цэцэг өргөх болжээ. Энэ бол амь үрэгдэгсдийн хойноос “хохь чинь” гэж тавлаж буй гутаал мөн. Нэхэл хатуу сэхэл сэрүүн байхгүй бол болохгүйнээ. Хүн дагасан боохой хүү татахаасаа өмнө дасгадаг юм гэнэлээ.

Хүчнийхэн хэмээгчид ухааныхан болоогүй цагт хүзүү толгойн заадас хүний мэсэнд байгаа шүү. Үүр шөнийн заагаар үе олоход амархан гэлцэх юм билээ. Харанхуй хүмүүс хасвуу тамга барьваас гавьяа нь зөвхөн цусан байх болно.

Нээнтэг. Гонжийн дог:

-Өвгөн миний өрөөсөн хөл гадаа өрөөсөн нь гэрт солбиж байтал өдөр хоног нисээд дөрвөн жил болчихож. Нөгөө сонгуулийн шүлхий нь савирчихлаа. Араажав (радио) зурагт хоёр магтаал хараал хоёроор үерлэж мань мэт нь маларч гүйцлээ. Танай ардчиллынхныг чинь байшин иддэг, банк уудаг, хортойгоороо могой, ховдгоороо боохой гэж байна. Манайхан ч яахав хоол иддэг хойш нь гаргадагаас бусдаар бурхан хэвээрээ. Муу хөгшин чинь толгойгоо олж малгай тавихгүй хөлөө олж гутлаа жийхгүй боллоо. Нэг нь “Таны төлөө тантай хамт” гээд овоохойд орж ирээд ор руу гулгах гээд хоймрын авдран дээр хоолны мөнгө тавиад байдаг. Нөгөө нь арван мянган төгрөгөөр амин газар дүрээд байдаг. Авахгүй гэхээр ач зээнэрийн нүд бүлтэгнээд, авгай хүртэл яншаад аргаа барж байна. Өөрийгөө хувааж өрөөл өрөөлөөр санал өгөлтэй нь биш. Урдахыг дагахаар улаантан, хойдохоо дагахаар урвагч гэж зүхнэ. Хайшаа шуу харж, хананыхаа ёроолд үлддэг юм билээ. Явгий бухмаад...

Шаантаг. 2004 оны сонгуулийн хоормог холилдов. Үндэсний гэх радио телевиз үлсэн дагасан хэдэн хэлгий суваг (UBS. TV-5. TV-9) үгсэв. Урдын цагт үүнийг коммунист суртал нэвтрүүлэг гэдэгсэн. “Тарваганы шийр шиг Янжмаа хүүхэн талд нь гараад бөнжийж байнаа хө” гэж нэг дуу байсан даа. Хэн нэгэн даргын аманд хэлээ дүрсэн сурвалжлагч бүсгүй “Уравсан хулгай П.Очирбат, Д.Бямбасүрэн, Н.Багабанди мэтийг бараг л шонд өлгүүлэх юм хэлүүлж аазгайрав. Өөрийн үнэрийг мэдэхгүй, өрөөлийн өмхийг гайхахад гахай ичдэг гэл үү.

Намдаа үнэнчий нь миний бие биширдэг Төрмөнх хэмээгч “дайсны тагнуул” барьсан тухай цаазын газраас сурвалжилж үхсэн муураар амьд бар хийх гэж аргаа барав. Эрдэмтэн судлаач хэмээгсэд элдэв цол дуудуулж зүүн талын засуул дээр дэвж шаваад “Нэг намын нэг баг бол

ардчиллын дээд хэлбэр. Тэнцвэртэй засаглал тэнгэрийн дор үгүй. Зүүн баруун хоёр зүг нийлдэггүй” хэмээн төвөгшөөтөл довогдов. Олон захиалгатай хэмээх “Сэрүүлэг”, “Хүмүүс” зэрэг эрээн сонин дөрөвдөх засаглалын дөрөөнд чиргүүлэв. Тэдний чөлөөт гэдэг титэм хүлээт болж хувирав. “Мөнгөнд аргамжуулвал мөндөлтэй нагай болно” гэдэг бил үү. Бас зусрын магтаал бол амттай хор ч гэдэг. Тийм л болсон доо. Ерөөс сэтгүүлчийн сэтэр зүүхийн өмнө хоёр нүд хорвоог бүтэн харж байгаа эсэхээ мэдүүштэй. Өрөөсөн нүдтэй сэтгүүлч өрөөл ухаантай гэвээс зөвхөн биеэ үнэлэгчийн ганцхан хувь тавилан бий. Үнэлж авснаа хүн хэрэг барагдмагц үнгээд л хаядаг шүү дээ. Хэвлэл мэдээлэл дөрөвдөх засаглал гэдэг ухааралд хэдэн сайн сэтгүүлчээс бусад нь хэнздэж байна. Элдэв нэр хочтой холбоонууд нь эрх баригчдын өмнө “доль хангайрч” дагаж салбаагүй нэгнээ адлан гадуурхаж буй нь ардчилсан сэтгүүл зүйн арга барил гэвэл алдас болно. Ядуурлаас болж янхарч байгаа гэвэл энгэр ташаа бүрэн товчтой яваа эгэл хүмүүс эвлэрэхгүй. Олон түмнээс урвахаас илүү бузар орчлонд үгүй. Үзэг баригчид шилжилтийн үе байдаг юм гэхэд үнэнд шилжилт гэж байхгүй.

Нээнтэг. Гонжийн дог:

-Сүг болохоор, сүүжээ даадаггүй юм байна. Орноосоо ховхрох гэсээр овооны наадмаас хожимдлоо. Энэ жил намуудын үүдээр навсганаж чадсангүй. Илүү зан л юм даа. Өнөөдүүл чинь өмбүүний хоёр эвэр, өмдний хоёр шуумаг болоо юу. Гонжийн дог. Хэмжсэн юм шиг хэрчиж дээ. Чи надтай хайнцлаа гэж бодоогүй биз. Үгүй шүү. Би тахимаа өгөхгүй. Манай дарга ойчоогүй гээд шороогоо гөвж байна лээ. Эр хүн. Адаг араандаа зуусан байхад “Амбаа” нь нэг л өдөр сэвсээрээ дарна гэж мэдэх үү. Танайхан чинь гурван толгой нийлээ биз дээ. Гонжийн дог. Хоёр эхнэртэй байхад холхиж болдог, гуравтай бол гуя дутдаг юм гэнэлээ. Нэг тогооны хусам, гурван хошуунд хүрэхгүй л болов уу. Ардчилсан нам чинь дотроо алх хадаас, муна гадас ч гэх шиг ам ангархай, салтаа садархай гэсэн биз дээ. Эр цээлсэн мөртөө төрийн дөрөөнд хөл нь хүрдэггүй улс явгарах л вий. Цус, гүзээ, зайдас гурав цугаараа тахилын ширээнд залрах дуртай гэл үү. Дур байвч сур богинодох гэж нэг юм бий. Ноохой зуух нас хүрвэл новширохыг нь харж л хэвтгье.

Манайхан ч өдийд орондоо шээж, ордондоо бааж байгаа биз. Албан тушаалд амь нь уяатай байдаг юм чинь арга байж уу, хөөрхий. Тэгэхдээ манайхан тэрэгнийхээ тоосноос тэнгэрийн умдаг атгахаа мэднэ. Танайхныг арьсанд нь хүрээгүй сарвалзаж байхад манайхан хоёр төмсөгий нь холбоод атгачихна, гайгүй. Харин хомрогонд мань мэт хойт энгэр түшвэл яана. Явгий бухмаад...!

Шаантаг. Хувьсгалт намыхан “хүссэнээр болоогүй, хүчингүй сонгууль” гэх маягийн үг алдав. Үнэн л дээ. Тоогоо буруу бодвол хариу нь тэгж л гарна.

Пунцагийн Бадарч, Цоодолын Хулан хоёр “Алдаагаа өөрөөсөө эр” гээд ах намыг зандарчихав. Үнэн л дээ. Ху намаас сувай лоозон, судархай шоу хальж асгарав. Ардчиллынхныг ам бүхнээр зүхсэн нь зодуулж байгааг нь өмөөрдөг монгол сэтгэл зүйг халгаав. Ядуурлаас гарах цалин тэтгэвэрийг амалснаараа нэмж чадаагүй үнэнээ учирласангүй. Засгийн газрын мөрийн хөтөлбөр бүрэн биелэсэн “гайхамшигийг” түүх онгичоод ч олдохгүйг хүмүүс мэдэлгүй дээ. Ардчиллынхны арван мянган төгрөгний урдуур орох гэж “алаагүй үнэгний арьс” хармалахад нь эх үр эмзэглэв. Өөрсдийн нь амласан мөнгө анхлаж санаагүй учир араас нь шидсэн “тэмээний засаа” болов.

Социнтэрн-д элссэн нам гэхийн оронд “дэлхийд өргөмжлөгдсөн нам” хэн нэгнээ “эх орны хүү”, “ард түмний хүү” гэж хөөрөгдсөн уянгын халилтай улс төрийн хальтрал байв. Хэнтийн хулгайчийн халааснаас олсон гэх үнгэлдсэн цаас харуулж заналхийлсэн нь гай болж 1932 онд Дадалын тусгай төлөөлөгч Данзангийн зохиомол бичгээр Лхүмбийн хэрэг үүсгэн хядсаныг санагдуулж хүмүүсийг цочоов. Энэ үеэр улс төрөөс уулын цаагуур байх ёстой үйлдвэрчин, эмэгтэйчүүдийн байгууллагын хоёр дарга нэгэн намын гүзээнд дэлүүлсэн нь “монгол мундраар” дэлхийн чихийг дэлэм сунгав. Хот хүрээгээр хоргойлсон самбар нүд эцээж нүүр буруулахад хүргэв. Хувьсгалт нам дотор нь гэрэл гэгээтэй хүмүүс байсаар агал “хуучрагсад” урдуур нь хөндөлдөж хоцрогдлын хормой чирэх нь юу вэ? Дэндүү гүехэн уриа лоозон, нүүр түлсэн магтаалын нурам, чилсэн хөгшидийн чихний сэжиг хүргэсэн ёворхил өсөглөн дуутай бэсрэгхэн хүмүүсийн өнчин зандраа өнөө цагт хүний сэтгэлд хүйтэн жавар хургаахаас хэтрэхээ байжээ. Хөндлөнгөөс хөх толгой шургуулж болдогсон бол хоцрогсодыг хоймороосоо холдуулвал хохирохгүйгээр үл барам хор нь арилахсан даа. Муужгай төрөлсдөг гэвч хэзээ ч бар болдоггүй билээ.

“Эх орон-ардчилал” эвсэл эвлэх эвдрэхийн нугачаанд таварцаглаж хүмүүсийн итгэлийг сэвтээв. ИЗ-БН намын илүү гэрийн янаглал хөнжлөө тийрсний эцэст гурван нам сэрүүвтэр энгэр зөрүүлсэн боловч тойргийн хишиг булаалдсанаас сонгогчдод бүтэхгүйн бүлх залгиулав. Хэдэн тойрог авахын сувьдалд гар нь хүрснээс бус хэн нь гарах вэ гэдэг дээр ухаан нь угнаасанд тээглэв. Нэг нь нөгөөдөө садаа болоод байхад нэрээ татах, татуулах зориг байсангүй. Ерөнхий сайд асан Амаржаргалын урдуур ерийн нэгэн гээгтэй хөндлөн хэвтээд босоогүй нь үүний жишээ. МАШС нам толгойдоо томдсон тойрог тэвэрсэн бол Ардчилсан намын зарим архагууд улс төрийн жанч халснаа эс мэдэн хэрүүлийн буг болов. Энэ бүхний хөлд Энхсайхан үйлээ үзэж үсээ цайлгаад хөтлөөд гардгаараа гарсан. Гэтэл Энхсайхан новшоос болж цөөн суудал авлаа гэж нулимуулав. Уг нь Гүндалай, Наранцацралт, Энхсайхан, Бат-үүл, Баабар мэт л дөрвөн жилийн турш дөрөөгөө сэтэртэл хараалган байж ардчиллын улааг нэхсэн шүү дээ. Гэтэл хоолоо идэж суусан нь төрийн эмээл дээр сандайлахдаа хонио хариулж явсан хэдээрээ тогоо тослох гэвэл хүний ёсонд ташаа хэлтгий бус уу. “Ардчиллынхан алиа алджээ” гэж Баабар шалжаалсан байна лээ. Биенээсээ “Би” нь өндөр тэр гайхал өлийж хардаггүй өнгийж хардаг юм шүү.

“Эх орон ардчилал” эвсэл хэдий муу ч “цугаараа нийлээд байхыг бодоход цаадуул нь л болохгүй байна” гэсэн сэтгэгдлийг олон түмний орой руу оруулсан юм шүү. Гурван тийшээ салаад давхисан бол гурмасын чөдрийн тасархайтай үлдэх ч байсан юм бил үү.

Ардчиллынхны дунд архагшиж буй албан тушаалын ангуучлал, сайрхалын сагуурал, өөрийгөө өргөмжлөх өвгөрөл, бүхнийг мэдэгчийн бүдүүн цэцэрхэл, амин хувийн атгагт авгал, эрх чөлөөний сэлгүүцэл, хагас хугас мэдээлэлийн садрал нийлээд эвийг нь сарниаж, эрчим хүчийг нь бутлаж буйг хүмүүс мөн ч их үглэсэн дээ. Гэвч нөхрийн үгэнд нөхөөс авахгүй ярдаглаад байгаа нь сайны мөр бус сармай дээлээсээ салахын ёр доо.

Хувьсгалт намын хувьд хумсаа нууж л байгаагаас бус цуггасан ган шиг цул нэгдэл нь хуучин домгийн шинэ цомог төдийгөөс хэтрэхгүй.

Хоёр намын хорыг маажив. Хөрс хатуутай болохоор ирвэгнэхгүй л болов уу. Арьсаараа мэдрэх нэг нь уцаарлавал би гомдохгүй, бас өршөөл өчихгүй ээ. Улс төрийн хоёр багана гэх хоёр нам

хойч үедээ өлзийгөө өгвөл хэн хэнд нь Монголын заяа баясана. Хэрхэгийг тэдний омог олтгой нь бус оюун ухаан мэдтүгэй.

Нээнтэг. Гонжийн дог. Орост өргүй боллоо гээд оготнын нүх рүү хашгирах шахаа биз дээ. Над шиг нэг үрчээхэй бүр намаглаж байгаа харагдсан. Ингэж асгахыг бодоход их л нулимс тээж явж дээ, хөөрхий.

Арван тэрбум “дойлорыг” хоёр зуун таван саяар хуньсан гээ биз дээ. Тэгтэл хагас хугас нь хаачив гэх боллоо. Тийм юм уу?

-Өгсөн авсан хоёр л мэдэх биз.

-Гонжийн дог. Улаан орос манайхыг хүнтэй малтай, газар устай нь хүүдийлээ биз дээ. Нөгөө хайрт ахын харамладаггүй тусламж гээд байсан чинь хар эрээн могой байгаа юу? Тэрэн дээрээ тулбал би “малгай нэхвэл, толгой нэхээд” суучих хүн. Энэ Монголын чинь амь нь ялаа, алт нь шороо юм уу. Явгий бухмаад!...

Шаантаг. Би л лав Оросын өрийг дарлаа хэмээн адар шал хоёр цөмөртөл цовхчиж дэвхцээгүй. Учир гэвээс Орос мэт аварга айл олон жилийн нүгэл буянаа дэнслээд нүдийг нь олж цайруулах биз хэмээн горьдож суусан хүмүүсийн нэг. Улс төрийн хаялага эдийн засгийн авлага юм биз. Орох савандаа холгоос нь очоод Оросын төр болгоосон бол оймс цоорхой таваргах л болж дээ. Үүнийг би үндэсний баяр гэж ташаалж эс чадьюу. Үүгээр Монгол улс Орост өр тэглэсэн бус төлөөстэй барагдуулсан гэж бодно. Тэгээд ч бид дээл биш зээл нөмөрч л яваа шүү дээ. Алгаараа харж арваараа барьж авсан тэрбум долларын өртэй бид тэрэгний мөр дээр хэвтсэн голио биш гэхэд хэцүү. Хүний юм авсан бол хүзүү дутуу. Өртэй хүн өөрийн эрхгүй өвдөг сөхрөнө. Энэ бол эзэн заяагаа боолын босгонд адсагалах лугаа агаар нэгэн. Иймээс монголчууд “өргүй бол баян, өвчингүй бол жаргал” гэж хэлдэг. Эх оронтой, эрх чөлөөтэй байвал “Өртэй жаргахаар өлөн зовьё” гэж хэзээ ч би хэдэрлэнэ. Үндэс нэгт түмэнтэйгээ хамт халах, хөрөх байтугай хөлдөх заяагаар эвг нь багтсанаа би мэднэ. Мэдэх нь чадахын хагас гэдгийг ч бас гадарлана.

Дэлхий өр дээр тогтдог гэж “дээдэс лүндэгнэх” юм. Энэ нь сайн шалтаг, саар уршиг. Авахын эхэнд өгөхийн эцсийг эс бодвоос үгүйрэл. Өнгөт хорвоо өгөө авааны дэнстэй. Боолын богочноос эзний эрсдлийг эрхэмд үздэг тэмцлийн хаттай, тэнгэрийн тамгатай ураг удмын минь ёс төр ийн бөлгөө. Үүнээс учиглан “ард түмэн бол алдаа бичдэг нооргийн цаас биш шүү” гэж алба хашаач бүхний агдаж тэвэрдэг ширээ бүхэн дээр хөх бэхээр балрахгүйгээр барлая.

Өнөөдөр бид ах дүүсээд алгаа тосоод байгаа тэр улс гүрнүүд нэг л өдөр гал дээр ус хийвэл яана? Түүнийг өнөөгийн бид үзэхгүй гэхэд үр хүүхэд минь үнсэн дээр үлдвэл яана? Хугацаа хэтэрсэн авлагатнууд хутгатай ч ирж чадна шүү дээ.

Нээнтэг. Гонжийн дог. Манайхан хоёр тойргийн хонгонд хортой соёо шаачихлаа. Махы нь барж ясы нь яйруулах вий. Сонгуулийн хороо юмуу сохрын хороо юм уу. Арван хэдэн хуршсан борц хурал хурдаг гэв үү. Ардаа нүдтэй, урдаа ухархайтай юм байлгүй. Гонжийн дог. Мань мэтийн саналыг махны машин шиг хигээд хаячихаж болдог юм бол нэр бичсэн хуудсы нь

тойргийхонд өгөөд тэглүүлчихмээр юм. Яршиг түвэг явдал суудалгүй амар. Анхны сонгуульд аминдаа зөв гоёж очсон юмдаг. Одоо ч онгорхой цоорхойгоо голохоо больсон. Ирэх сонгуулиар илүү дутуугаа харуулаад нүцгэн очих байлгүй.

Хоёр голгоносон нүд элдвийн юм үзэж гүйцээгүй бололтой. Чи худлаа гэнэ дээ. Тасганы овоог сэтлээд хаяж байгаа шорооноос авч манай гудамжны шалбаагийн хонхрыг тэгшлэх гэтэл “Намын шороо” гээд өгдөггүй. Нэр дэвшигч нь ардчиллынх байхгүй юу. Гонжийн дог. Намуудын нүх гэж гарах нь л дээ. Намайг мажийхаар аль ч нам нь нүх өгөхгүй авгай хүүхдэд авс тэврүүлээд хатаачих вий дээ. Явгий бухмаад...

Шаантаг. 2004 оны зургадугаар сарын хорин долооны оноолт өдөр “Ху нам 36 эвсэл 36 бие даагч 3 БННам 1 гэсэн сонгуулийн дүн үүрээд улиран одов. 24. 59 гэсэн хоёр тойргийн булхайг хараад эх орон, ард түмнээ бид үнэ хямдартал талцуулсанд гутрав.

Сонгуулийн хорооныхон тойрог хэсгийн толгой дээр гишгэж захиргааны шүүхийг заамдан дахин сонгуулийн ший гаргах гэж тайзан дээр гүйлдэж явахдаа өөрсдийн нь өмд шувгархай гурван гуя нь гялалзаж буйг мэдсэнгүй.

Радио, телевиз рүү дайрч орсон ардчиллынхан ялтай, дөрвөн жил амы нь барьсан нь гавьяатай хэмээн хэтэрхий мэргэд дүвчигнэв. Нэгэн намын жанжин молиго үмхүүлэх үүрэгтэй тэдэнтэй тэрсээд ч яахсан билээ.

Улирсан он цагийг уургалж болдоггүй. Гагцхүү унасан давсан алин боловч уйлах инээхийн орчинд ухаарлын сургамж л үлддэг. Тэр ч ёсоор дэлхий хоног хурааж эргэв. Болсон явдлыг түүвэрлэн бичиж үлдээхийг түүх гэдэг билээ. Түүх түүхээрээ байг. Түүнд хийсэн бидний засвар бүхнийг цаг хугацаа хасвар болгож байнам бус уу.

Нээнтэг. Гонжийн дог:

-Улсын Их Хурал хичнээн гишүүнтэй болоод байгаа юм бэ. 152 болчихвол над мэт нь тогоо баярлуулах толгой цувдайгүй болох нээ.

-Чи чинь бас ямар салхинд цохиулчихаа вэ?

-Ерөнхийлөгч нь зарлигдаад хурал хураад байдаг. Хуучцуул нь хударгадаад хууль гаргаад байгаа бололтой. Аягүй бол талийгаач дарга нар тамаас ирж тархидах нь л дээ. Хөгшин чинь сая Лениний музейн талбайд дайчилгааны цуглаанд дарьгүй хонгио шиг дайз бөглөж байгаад ирлээ. Хорооноос хөөгөөд суулгадаггүй. Тэгсэн чинь нэг дэлүү хар юм “ард түмэн саналаараа энд цугласан” гэж амаа урж байхгүй юу. Гонжийн дог. Түр цэрэг шиг татаад түймэр тавиулчих гэсэн нь болсонгүй. Танай Сүрэнжав, Урианхай хоёр хэдэн чүдэнз зурж хаяв уу даа. Унгадаж утаа гарсангүй. Урианхай чинь манай дацанд сахил хүртчихэж. Нөгөө гон бие, гозон толгойн хувьсгалыг больсон юм уу?

-Ганц хүний хөдөлгөөн шүү дээ.

-Гонжийн дог. “Сахал, хормой хоёр чинь ороолдоод салхины өөдөөс алхаж чадалгүй хувьсгалт

намын хударганд ороо юу. Оройтсон хойно нам болохоор лам болоод охидын судас барихгүй дээ” гэж хэлэх юмсан. Цаадах чинь нүдээ сорвилж байгаад нүглээ халхалж инээх вий. Будлиан дундаа булхайтай гэж та нар хэлдэг дээ. Ухаантай гайхал үнэгүй бол үг унагахгүй л болов уу. Тэр яахав. Энэ ардчилал гэдэг чинь ар өврөөрөө нийлсэн хаашаа ч хажир вэ дээ. Ногоо иддэг улсын ном, мах иддэг манайхтай нийлдэггүй юм болов уу. Ноёд шиг сагсалзаад байснаа нохой шиг хэрэлдээд л унах юм. Алтан аяга, модон тагш хоёрын альнаас нь ч гудрах ялгаагүй гэдэг дээ. Явгий бухмаад...

Шаантаг. Улс төр гэдэг угаавч хар. Эрх мэдлийн төлөө эрэгчин эмэгчнээ үзнэ гэдэг цаанаасаа цагаан гэгээний зураггүй.

2004 оны сонгуулийн ээдрээ хугацаа эцэслэсэн Их хурлын хуралдаан хүмүүсийг цочоов. Хувьсгалт нам Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг эс дагасан нь төрийн танхайрлаас хэтрээгүй нь аз. Ардчилсан нэртэй эргэлтийн зай байж болох нээ гэдгийг монголын хамгийн уйтгарт парламентын сүүлний шарваа хүмүүст сануулсан нь яамай.

Миний хувьд элдэв цуглаан хөвөрдөж эрүү эцээхээс төвөгшөөдөг. Худлаа хуцдаг нохойд нэр байдаггүй. Эзэн нь хувхай гамшиг л гэдэг шүү дээ.

Нээнтэг. Гонжийн дог:

Цаадуул чинь ууцаа таллаж үүцээ хуваах гээд мунгинаад байгаа юмаа даа. Алийн болгон араараа тангарч, өврөөрөө өшиглөх вэ дээ.

Монголын л хүүхдүүд юм бол урт мориндоо сундлахаас яахав. Ам нэгсэж зам нийлдэг дээрээ тулахаар аваа өгөө таарах амаргүй. Тэгэхдээ хариас сураглахаар хаяанаасаа эр гэдэг. Сургий нь дуулвал үг заалгах гэж уул ус хэрчиж хэдэн хүн хэрж яваа юмдаг уу. Гонжийн дог. Манай муу майжиг чавганцаас асуугаад ганц хөл мах гарт нь биш гэхэд гадаа чулуудчихгүй дээ. Манай тэр муу чинь мойног ч гэсэн монголын хугархай, хүүршсэн ч гэсэн хүний тасархай юм болохоор “Үнэн голоос үг хэлээ олоод үүд, өрхөндөө багт” гээд элбэгхэн хэлчихнэ. Гарч шээхээ хүртэл гадаадаас асуух юм байлгүй. Авгайгаа зайдлахаа асуух гэж байгаад хүүхдээ хэнздүүлчих вий дээ. Явгий бухмаад!...

Шаантаг. Ард түмэн, толгой, олгой хоёрынхоо алинаар ч өгсөн байг энэ удаагийн сонгууль “зөвшилцөл” хэмээх үгийг улс төрчдийн амнаас унагуулав. Миний хувьд үрэн таран болж байсан үндэсний эв нэгдлийг цомойлох ардын зарлигт биширнэ. Ард түмний сонголтыг Аллах, Адам Ева, Арел Шароны алинаас нь ч асууваас азанд муу.

Чингис хааны их хуралдай нь зөвшилцлийн үүсгэл байгаагүй гэж үү. Найман зууны тэртээд тулгар төрөө байгуулсан монголчууд төрийг засах эрдэмгүй, төөрсөн жин шиг болж харийн өлмийд хормой дэвсэхдээ тулсан гэж үү? Арай ч дээ. Ир, мөр нь мэдэгдэхгүй түшмэлүүдийн ичгүүрт нь бус их дээдсийн минь алдар сууг бүү бузарла гэж би л хувьд сэтгэлдээ хашгирсан шүү.

Монгол бол найман зууны чандаас төрт ёсыг тогтоосон орон. Төрөө дээдлэхдээ, төмөр нүүрийн шударгыг эрхэмлэхийн зэрэгцээ, төрийн эзэрхэлийг зөөллөж, төрийн сүлд өршөө

гэсэн энэрэхүйн залбиралтай. Бас “Төр түмэн нүдтэй” гэсэн нь нэг буюу цөөн хүний ноёрхлоос ангид олны мэлмийгээр шүүн тунгаахын учрыг номлосон нь бус уу.

Алсын түүхэнд амьсгаа хүрэхгүй гэхэд хоргоноос нь гарч чаддаггүй хорьдугаар зуундаа эрэгцэхгүй дээ. Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөрт “Хэрэв өөр суртлын нам гарч ирээд... тусламаар аваас мөнхүү тэдгээр намууд лугаа тухай бүр хэлэлцэн хүчин хавсарсугай” гэсэн мөрийг тэмтэрч болмоор доо.

Изриалийг дууриах гэвэл Палестин бас нэг эрээн алчууртай алчуургүй өвгөн, гудамжны чулуу, амьд бөмбөг аль аль нь хэрэгтэй болно биз дээ. Нүүдэлчдийн “нохой долоо” гэсэн голонгуйрлын цаана шавхруу гэсэн санаа бий.

“Их эвслийн” хэмээх засгийн газар бөөрлөв. Их нь ч юусан билээ. Ямааны дагзанд бугын эвэр зоох нь бидний зан юм даа. Гэвч нэг нь тоглоом, нөгөө нь шоглоом, гуравдах нь хуйвалдаан гэж хочлов. Хоёр жилээр ээлжлэх юм гэнэ. Бавуугийн Лхагвасүрэн хорин дөрөв, дөчин найман цагаар ээлжлэхгүй дээ гэж дамшиглав. Үндсэн хуулийг намын үгсэлээр өөрчлөөд байвал үхэр ч үгүй, тэрэг ч үгүй болохын цондон.

Хүнд суртлын ланчигийг хөнгөлөх болов уу гэтэл яам тамга нэмж, янчааны сайдын бөгсөнд сандал ивэв хэмээн хүмүүс зэвүүцэв. Толгой нь агаруудсан засгийн газарт тонгорцоглохын гэм буй.

Албан тушаалын элээнүүд амандаа зоос зуун унгалдав. Тэр ч бүү хэл дуудлага худалдаатай больё хэмээн яршиглах нь ч бас сонсдов. Сайд гээч “лайд” болоод гайд гардаг дарга гээч “тарга” болоод “гарга” болдог гэх үгийн тоглоом ч бий.

Баруун, зүүний нам нэг овоохойд багтахгүй гэж урамдаад байсан онолын боолтрогонууд таг болов. Хүний хоолойгоор орилох хэцүү. Гэвч тэднийг буруутгах юун. Олон улсын баримжаагаар сажлаж яваа бидэнд онолсоод байх юм юусан билээ. Их сайндаа л хэн нэгнийг ишлэх юм. Иш бол багаж биш бариул шүү дээ. Ноён Черчилийг бид английн цагаан гахай гээд нүд үзүүрлэдэг байсан бол одоо бурханчлаад мөргөж байна. Тэрвээр сайн улс төрч байснаас бус сартвахи байгаагүй шүү дээ. Ерөөс улс төрийн шинжлэх ухаан бол өчигдрийн дадлага, маргаашийн таамналын зангилаанд хийж буй өнөөдрийн тайлал гэж бүдүүвчилж болно. Тэгвэл бид капитализмыг алгасч чадаагүй болохоор ойчиж боссон улс ордог үүдийг олох онолын баримжааг өөрсдөө товлох ёстой. Алийн болгон харийн номлолыг хадганд боож адис авах вэ дээ.

Диваажингийн түлхүүр Будда, Христ, Аллахын хэнд нь байдгийг бүү мэд. Харин газрын диваажин буюу үндэсний хөгжлийн түлхүүрийг бид Оросоос эрээд олоогүй. Одоо Америк, Европоор эрэлд хатаж байна. Тэдний алинд ч Монголд таарах түлхүүр байхгүй. Нүүдэлчдийн соёл иргэншил өөрийн цоожтой. Түлхүүрийг нь бид л хийж чадна. Энэ бол монголчуудын оюуны тунгаамалаар цутгасан эх орны хөгжлийн үзэл баримтлал мөн.

Улс төрч гуай нар ажил үйлсээ хариас хулуусан үгээр “тоглоом” гэж нэрлэх юм. Уг нь улс орны төлөө уулгалсан тэмцэл, зүтгэл байх ёстойсон. Хэрэв тоглоом гэж байгаа бол буруу эрхлэх вий дээ. Ардчиллын амласан хүүхэд бүрт сард хүртээх арван мянга, хувьсгалт намын

төрсөн нялхаст хайрлах зуун мянга, шинэ гал голомт мялаах таван зуун мянган төгрөг тоглоом уу. Тоглоом тоогоо алдвал толгой мөлжүүрээ алднам бус уу.

Амлалт гэдэг мянга нэгэн шөнийн бус дөрвөн жилээр тооцвол мянга дөрвөн зуун жаран шөнийн үлгэр юм гэж үү? Хүмүүн олноо үлгэр ярьж жаргаадаг нь алив улсын засгийн газрын жам гэнэм. Энэ үлгэр нь “мөрийн хөтөлбөр” нэртэй.

Ромын Пап ламтны зараалаар арван гуравдугаар зуунд Монголд ирсэн туршуул гэлэн Плано Карпини “...бусад хүмүүсээс үлэмж илүү худалч бөгөөд бараг үнэн ярина гэж үгүй” хэмээн монголчуудыг дайрсан байдаг. Үүгээр бол манайхан засгийн хөтөлбөрийг тун гарамгай хийж магадгүй гэлтэй нь биш дээ.

Нээнтэг. Гонжийн дог:

-Нутгийн ханагар аянтай юу? Сонин сайхан, солиу гажуу, илүү дутуу билүү чулуу юу байна даа.

Би түүний дөрөө чангалсныг анзаараад,

-Тайван сайхан даа гэсхийв.

-Тайван нь танайд сайхан нь сайдынд байгаа биз. Надад бол наад хоёр чинь байхгүй ээ. Цагаан цорой ханчиртай тулдаа ханзраагүй, хоёр майгаараа хорвоогийн тоос хольсон шуу явна.

-Чиний амнаас олигтой үг ойчих биш дээ.

-Гонжийн дог. Ноёдтой адил би нохой гасалтал худлаа шаах хэрэг үү. Алив хө аяганы амсар зууя. Хөрөнгөтний юм байвал хөгшин чинь гол бүлээсэгмээр байна.

Би дундарсан виски гаргаж аягалаад мөс хийх гэтэл

-Найз минь больж үз. Найрка болчихно. Амьд хүн байна даа, Аагтай юмаар ам цавлая гээд хөнтөрснөө тамшааж,

-Муусайн хөрөнгөтнүүд муу идээ хийж чаддаггүй дамшигууд юм даа. Устай мөртөө тостой юм шиг гулгаж ходоодны жавар хөөж байна шүү. Манайхны архи ч дээ. Монгол усыг хятад спиртээр галзууруулхаас цаашгүй дэг. Арван долоон чингэлэг спирт уучихсан хойно ус болчихсон гэл үү. Гонжийн дог. Түүний чинь хүчинд өвгөнтийн хөндий бид хоёр ходоод гэсгээв дээ.

-Элдвийн юм битгий ууж бай. Эрэмдэг болно шүү.

-Үнэн юм гудрах гэхээр үнхэлцэг дэлбэрхээр үнэтэй. Чи ер нь мань мэтийг яаж шуу ясан дээр арьс нөмөрч яваа гэж боддог хүн бэ. Гэр хороололын бидний гэдэс дотор гэдэргээ л байгаа шүү дээ.

-Арай ч дээ.

-Арваас нэг нь аминдаа зөв байж мэднэ. Чи яваад үз л дээ.

-Надад хэлээд яахав дээ.

-Гонжийндог. Нам засагт хэл гэж үү. Бурхан шургах зайгүй буу жадны завсраар хөгшин чөтгөрт хөл тавих зай бий гэж бодоо юу.

-Сонгосон гишүүндээ хэлэхгүй юу.

-Бидний залууд “депутоодог” гэдэг байл уу. Тэр л юм даа. Сонгуулийн өмнө хорооны “хөлөөвт” бараа харсан. Ядарч зүдэрч яваагаа учирлаж оцойж байгаад хуцсан л даа.

-Юу гэж байна вэ?

-Тантай санал нэг байна. Тэр ядуурлыг чинь алаад өгнө гэх ухааны юм хэлнэ лээ. Тараад гартал нэг халамцуу хар юм “зөнөг пизда минь ална шүү” гэж хөндөлдсөн. Хамаатан нь юм уу, хамхуул юм уу бүү мэд. Өвгөн чинь өмд чийгтэй зуларсан. Үжирсэн яс үйрүүлээд хаячихвал яах юм бэ. Үүнээс хойш үг унагахаа цэглэе гэж шийдлээ. Мань мэтийг өмөөрөх хүн байх биш. Чи л гэхэд чимэг цолноосоо болоод “ахбарамын” загас болоо шив дээ.

-Загас чинь үг хэлдэггүй ч нүдтэй шүү дээ.

-Хэлгүй байснаас сохор нь дээр. Улаан тугал шиг хэдэн ач зээгээ бодоод танай намд санал өгчихсөн чинь хуурай дэлэн гувшчихаж.

-Танай нам ч мөнгө амласан шүү дээ.

-Даалимба даахгүй өвгөн залуу авгай зайдалж, хэнз хүүхэд гоожуулаад мөнгө олдог гэж хэн чамд хэлсэн юм бэ. Гуйлгачин болж гурван нялхтай гудамж дэрлэсэн хойно гурван мянган төгрөг сарвайх бололтой. Бас болоогүй, цус шинжиж, яс зорж байж алга тэнийх юм гэнэ. Хоёр нам ховсдоод хонгонд цай чаначихлаа. Сүнсээ түймэрд.

-Улс төржихөө больж үз.

-Улс төрийг биш улаан хоолойгоо бодохоор хэдэн үгээр хэхэрмээр байх юм. Хүүе ээ! Танай хэд чинь манай намын өвөрт шаачихлаа гэв үү. Хонь чоно хоёрын хоногийн жаргал байдаг байх нээ. Тийм үү?

-Тэгээд яагаав?

-Гонжийн дог. Тос гартал тэврэлдээд цус гоожиж салах вий дээ.

-Эвлэж байгаа бол эрхбиш болно биз.

-Хумхиж идэж хувааж түрийлэх ч юм билүү.

-Үрийг нь харъя.

-Үхсэн тугал л гарна биз.

Тэрвээр нилээд хөглөсөн тул би салахын түүс болж “гэгээтэйд гэрийн бараа хар” гэж аргадваас

-Оройтсон ч овоохойгоо олж шургаад ороо тэмтрээд сүүжилдэнэ. Харин чамайг өнөөдөр авч явна.

-Надаар яах гэв?

-Дээгүүрээ нийлчихсэн байхад дэр тусгаарлаад яахав, өнөөдөр чи миний өвөрт унт гэж шарлаав.

Арга барахдаа такси дуудаж үүдэнд нь зогсоход

-Чи орж бай. Би тооцоо хийнэ гэж хуураад, уургын унааны хүчинд ухасхийх агшинд Гонжийндог:

-Өвгөн чинь өврийн бузар хийхгүй. Би ямар танай Дүлзэнгүүд биш гээд тачигнатал хөхрөх нь чих шивэв. Иймэрхүү инээдийг монголчууд хүйтэн хөх гэдэг. Энэ бол ярзайсан зэвүүцэл буюу сэтгэлийн хөлдүүс. Миний хувьд уран сайхны Дүлзэнгийн дүр улс төрийн хоч болсонд жихүүцдэг. Энэ хоч нэгэнд хөөрхөн зохиж байхад нөгөөд харуусам хар толбо санагдана. Урвагчийн ийм сэтэр аяга цайны ханштай нь амьд ахуйд нэр хөөдөхөөр үл барам амарлисан хойно яс хөндөхөөр нь олон үүднээс хатавч сонгон шургаласны балаг. Ухасхийж өрсөх мэх төрийн явдалд байхыг үгүйсгэхгүй боловч ардчилал алт гэвээс албан тушаал бол авч өгч сурсан самбай билээ.

Мохол

Гонжийн дог бид хоёрын томолдсон толхилцоон мохов. Хэзээ хойно хэн нэгэн илүү загнаж улирсан бичиг сэлт ухав гэхэд элэнцэрсэн он цаг хүмүүсийн тухай уяа хүрэхгүй үзүүр олж мэднэ.

Бор гэрийнхээ хооронд бодлын хаяа нийлэх гэж бид бас оролдсон шүү.

Би-Жаран ямаанд зуун ухнаар яахав. Эрхэм гишүүдийн талыг танаж төрийн зовлонгоос салгаж гэрийн жаргал эдлүүлье. Арван хэдэн яамыг тав болгож хүнд суртлын тамыг цөөлж хүний зовлонг нимгэлье.

Гонжийндог-Тэр бүтэхгүй. Олбогоо орхиход наад зах нь оготнын зориг хэрэгтэй.

Би-Авилга бол төрийн эмгэг. Үүний үндсийг таслая.

Гонжийн дог-Хүний шуналын ходоод дүүрч хоёр гар хоорондоо зодолдохгүй.

Би-УИХ-ын гишүүнд сайдын отго салаалж хууль тогтоох, гүйцэтгэх засаглал хоёрыг хуургалахаа больё.

Гонжийн дог-Албан тушаалын эвэр арван хоёр салаа болсон ч цөөднө.

Би-Монголын хуулийн баян ядуугийн бараан цагаан хоёр нүүрийг нэг болгоё.

Гонжийн дог-Мөнгөтэй нь өнгөтэй, мөнгөгүй нь дөнгөтэй гэдэг дээ.

Би-Эрхэм гишүүд амалсандаа хүрэхгүй бол эгүүлэн татдаг больё.

Гонжийн дог-Буруу эдэлсэн хамар дөрвөн жил дөр хүргэхгүй.

Би-Нийгмийн баялагийг олон хүн бүтээгээд оорцог хүн хувааж идэхийг цэглэе.

Гонжийн дог-Сангийн хишгийг савныхаа хэмжээгээр хутгана. Сааль ч үгүй сав ч үгүй надад хүртээлгүй.

Би-Өөрсдөө бүтээх үүдэл бүхнийг дэмжиж үйлдвэрлэгч үндэстэн больё.

Гонжийн дог-Гаалийн танаас, татварын шулаас гар дээр юм унагахгүй.

Би-Тэтгэвэр тэтгэмжийг нэмье.

Гонжийн дог-Тэр чинь тэнгэрээс ойр ч газраас хол.

Би-Ерөнхийлөгчийн эвлүүлсэн эрхийг сэргээж, бүхий олноороо сонгодгоороо сонгож байя.

Гонжийн дог-Чадахгүй мөртөө дуртай нь олон. Наадам бүхний дэвжээ хэсч явахаас намын майхан нь амар гэнэ дээ.

Би-Олон намын батлахыг овоолж байгаад шатаая. Үндэсний хагарлын үүр эвдрэг.

Гонжийн дог-Намын дөрөөгүй бол намханууд нь төрийн нуруунд гарахгүй.

Би-Намын гишүүн бурхан байхгүй, чөтгөр мундахгүй. Хоёулаа намаас гарья.

Гонжийн дог-Хороо хориноос эхлээд хонь чонолоод салахгүй. Би ч дүүрснээрээ дүүрье. Чи яахаа өөрөө мэд...

Гонжийн дог бид хоёр ийнхүү амь айл, санаа саахалт явах нээ. Энэ нь зэрвэсдээ зэвэрсэн хоёр хохимдогийн лай мэт боловч үндэсний үгсэл эвдэрсний урхаг. Улсын тусад ивлэх сэтгэл салах нь хөх үндэсний хөндүүрлэл мөн. Нэгэнд мэргэн түргэнээ, нөгөөд мэдэхгүй балайгаа дуудуулдаг эгэл хүмүүсийн зүрхэнд эх орны амь оршино. Үүнийг мартваас ирээдүйд өргөсөн итгэлийн зул бүүдийнэ. Энэ хэр “болсноосоо түүхий нь, болохгүйгээсээ чадахгүй нь” чамлахааргүй тул ус балгаж эс түвдэв.

Гонжийн дог бид хоёрын үг хол явахгүй, амнаасаа болж аламд унах вий гэснээс дэмий юм санаанд сэрхийв. Тэр жил хотын золбин ноход олширсноос шөнө хуцаад унтуулахгүй байна гэсэн гадаадынхны гомдлоор муусайн гамшигуудыг нядааж билээ. Бурхан минь!

Молхи би нээнтэгтэй шаантагийн эл хэсгийг номд дайх эсэхээ тээнэгэлзсэн боловч Намбардагва мэтийн он цагийн эгэл гэрчийн үгийг ямагт газар гэж аснаа санав. Харанхуйчуул хэмээгдэх харцын үгийн сонсохуйяа чимэгтэй цэцийн чанад үнэний үзүүр байдаг. Үгийн ид шидээр улаан хөлтийг алхуулдаггүй миний буурал найз мэт нь уул ус бүхэнд байсан атал өдгөө цөөрснөөс монгол хэл маань хялуурч модон хэлийн ган гачигласанд эмзэглэх учир ч үүнд түлхээс болов. Ярианы болон бичгийн хэлэнд баяжих ядуурахын гэм байдаг нь цагийн жам боловч түүнийг халтарлагчдын халдвараас үл хамгаалан эзэнгүйдүүлвээс үндэсний үгүйдэхүйн ёр болдгийг мартваас бидний заяа заваггүй болно.

Хорьдугаар зуунаас хойчийн эринд хормой хошроож яваа бидний явдал дэндүү цаг үеийн боловч алдаж онон алхаж буй алаг мөр минь билээ. Үүнийг бодгал бүхэн өөрийн “Би”-д хичээн шүүвээс мунгиналын мухарт эрэгцэлгүй харгуйн халгааг хэтлэхсэн дээ.

Монголчууд бид арван хоёр жилийг нэгэн үе гэдэг. Ардчиллын нэгэн үе мултарч байна. Хуучцуул хулширч, шинэчүүд хиртэж буйг бид харж байна.

2005 оны хавар ардчилсан нам толгой салсан арсалдааны үеэр үндэсний телевизээр Бат-Үүлийг үг хэлүүлж болохгүй гэж хэрэг эрхлэхийн хэн нэгэн түшмэлийн захирсны дагуу Куланда хэмээх ардчилагч асан авхай боомилсон тухай сонссон золбин гөлөг хүртэл гаслах шиг болсон шүү. Ардчилагчид ам барьтлаа өтлөнө гэдэг Ринчен гуай нэгэнтээ Хаант Оросын үнэгүйдсэн мөнгөн дэвсгэртийг “Напраас” гэснийг сануулав. Иймэрхүү ардчилагчид төөрсөн төрлөөсөө тохой ханзлаж төрхөмдөө буцах л үлджээ.

Энэ бүхнийг би эрэгцүүлэхдээ ардчиллын ололтыг үгүйсгэх атгаг санаа өвөрлөөгүй. Цагийн эрхээр өвгөрсөн боловч ардчиллын галыг унтраах гэж нойтон навгас салбуулж бахирдаг нүдний булай болсон зөнөг намчийн нүглийг би хуваалцахгүй. Надад өөдрөг үзэл цагаан мөрөөдөл бий. Нүүсэн буурин дээр нүдний булай болж хоцрохгүйгээ би мэднэ. Ардчилалд тэн даахгүй ч гэсэн ачаа дагасан нохой явахаа азанд би тооцно.

Арван таван жилийн өмнөхийг өнөөдөртэй жишвэл бидний бүтээсэн бүхэн хараатайн байтугай харалганы ёлтонд өртөнө. Гагцхүү ардчиллын эрчмийг ээдрээсэн алгуурал, хоргодол, алив бусармаг явдал сэтгэл сэлтлэж байна.

Авилгалын аалз төрийг торлож, тэхий дундаасаа дээш бээрэллээ. Авилгачдыг цээрлүүлэе гэхгүй, эрхлүүлэе гэж би хэлж чадахгүй. Энд ямар ч гучин долоон он хамаагүй. Тэр үед ард түмнийг цээрлүүлсэн бол өдгөө гэмт хэрэгтнүүдийг гэсгээх нь тэнгэрийн цааз мөн. Тэд төсвийн цалингаар бус өтгөс нялхасын сүү, өвчтөний амин тарианаас тонож орд харш бариулж ондгор “ЖИП” хүлэглэж явахад бид нүдээ нуух ёстой гэж үү? Албаны түшмэлүүд авилгын үндсийг шинжлэн судлаж таслах юм гэнэ. Тэднээс үнэн, шинжлэхүй ухаан хоёрыг горьдох нь үхсэн илжигнээс амьд дудран хүлээх лүгээ агаар нэгэн. Нүгэлтнүүд нүүрээ ширлэвч түлэгдэж өөрсдөө өнөөх “худагтаа” өргөөлөхөөс айхдаа мэлзэхийн мэх гогцоолж “авсан өгсөн баримтыг нь аваад ир” гэж ам асуух боллоо. Өнөөгийн хуулиар өгөө аваа

хайнцал унаагай болохоор оодорч байгаа юм. Хуульд цоорхойгоос гадна хулгайчийн мужиг бас байх нээ. Борооны чононд нарнаар баригдах жалга бий дээ.

Олон түмний зэвүү бүрхэглэсээр нэг л өдөр оосор бүчээ тасчин шуургалж хог новшийг ховхлон хөөдөг билээ. Эцэс төгсгөлгүй эрх дарх гэж байдаггүй. Буганд алдсан гэх эврээ тэмээ хүлээдэг гэвэл, бусдад алдсан үнэ цэнтэй бүхнээ хүн ард хүлцэлгүй тэмцлээр эгүүлэн авдаг хатуурхалтай.

Миний муу найз Гонжийн дог хэмээх Намбардагва бол гоочилсон хүнд гэрийн хоймроос хэтрээгүй явар харц боловч үзэл суртлын үхээр бололгүй үхэр тэргээр үнэний мөр хөөж яваа нэгэн. Чухам л ийм дэндүү эгэлхэн агаад дээдсийн мэлмийд сүрэг төдий сүүтэгнэх хүмүүс л цагаа болохоор аминыхаа гарзаар амьдралыг гэгээлэхээс буцдаггүй. Харин албан тушаалын хүлээсэнд автагдсадын “амьдрал сайхан байна” хэмээн гоёчлон гоожуулдаг үг бол улс төрийн зомгол л байдаг. “Ийм тийм юмны жил” “аян” мэтийн хамрын шуухнаа мэт сэдрээн хадны цууриа төдий дүйвүүлэг мөн. Эздийх нь хуруу дармаас бусад нь хөсөрдөж газар нутгийн баялагаа харийн хээлэнд цутгаж, хаа сайгүй “гэрэлт хонгил”-ыг ёрлосон энэ үед өөдрөг сэтгэл, өөрийн ухаанаар улс гэрээ эзэгнэн төвхнүүлэхийн төлөө хүн бүр хүндхэн буулганд хүзүү холгон зүтгэхээс өөр гарц үгүй. Түүхэнд бүү хэл түрийвчиндээ ч үлдэхгүй “явуулаар” ачаа татуулснаас, хар нутагт хаяад нүүвээс бид хожно.

Эрх зүйт төрийн гараанаас ухарч нам шүтээнт захирангуйн ноёлол руу хальтарч буй нь гамшиг бус уу. Удирдах зөвлөл нэртэй “улс төрийн товчоод засгийн хэргийг замд гацаан, үндсэн хуулийг үгсэлээр бусниаж буй нь ардчиллын олзоо алдахын гай уднам бус уу.

Бидний тэнгэрт алив нам бус найман зууны тэртээд тогтноосон их цагаан сүлдэт төр байх ёстойг хором умартваас хохь болно. Төр төмбөгөр нам навтгар байх ёстой байрандаа байг.

Төрийн хярд гараачид намчирхлын дов тойрч ард түмнээ өрөөлдөн явгаварлах тахир татуу сэтгэлгээнээсээ салаачээ гэж олон түмэн омогдуухан хэлж буй нь түмэн зөв өө.

Хулгай, худал, авилгал үүрлэсэн тогтворшилын хуурамч гоёл хүн ардад хэрэггүй. Эрхийг эвдэх элдэв бусчирт эвлэршгүй байж.

Ардчиллыг ариусгая.

Шударгууг шулуусгая.

“Учрал” хэмээх цацлага бүлэг

Хорвоогийн гэрэл сүүдрийн сүлэлдээнд амьдралын ганзага алаглан хар цагаанаар агирах ажаам. Миний мэт алмай нь цагийн зайг багтаж ядаж бус барж цөхөж элээснээ үдээс хойши ухаанаар үүлгэртэн гэмшивч хожимдсон сэхээрлийн үнэ цэн юусан билээ.

Орчлонд би ойр холын олон хүнтэй дөрөө харшиж нөмөр нөөлгөнд тэвхэрлүүлж, тэвхдүүлж явсан бор заяаны хүн. Энэ бол миний амьдралын эз аз хоёр юм. Миний займарсан зам цайж барайсан өдөр цагийн ээлжийг ажаа нь үгүй туулахсан гэсэн цөхрөл байлаа. Бавуугийн Лхагвасүрэн нэгэнтээ “Энэ хүнд зовлон баймаар атал үргэлж инээж явах юм” гэж гайхширсныг санаж байна. Сэтгэлийн сэвийг билүүдэж, гутарч бус бадарч явах нь жаргал бус гэхэд зовлон биш. Хар санаатай хүнийг ээрсэн өвчин үл илаарших цөвгэйг ч дорнын мэргэд айлдсан нь ариуслын номлол аж.

Гонжийн дог надад “шүлгийн чинь шүд ойгоо биз дээ” гэсэн нь цочоосон үнэн байв. Яруу найрагт хиймэл шүд суулгаж болдоггүйг яалтай билээ. Шүүгч өтлөхөөрөө үүргэлсэн өмгөөлөгч, шүлэгч өтлөхөөрөө үргэлжилсэн зохиолч болдог нь огт оргүй бус бололтой. Ам булаасан мориноос бууж, аяны хөсөг хөтлөхөд газар хорохгүйн залхаалыг эдлэж явна. Цаг элээж цаасанд түүртсэн заяа минь энэ байжээ.

“Улаан гэрийн хоригдол”

Би вээр дуртгалын анхны номоо ийн нэрлэн Бээжинд эсгэж Улаанбаатарт хөвөрдсөн юм. Уг номыг Цэрэнпилийн Гомбосүрэн хэмээх “эрдэмтэй боловсон ард” шавдуулсны эрчинд автан, арай ядан хана дугуйлж “Интерпресс” хэвлэлийн газрын “Бидний монголчууд” цувралын холбоонд шургуулсан билээ. Үүнийгээ би цайруулж “үргэлжилсэн үгээр миний бичиглэснийг уншиж үхэр тэргээр наадам үз дээ” гэж уншигчидаа аргадсан удаа бий. “Улаан гэрийн хоригдлын” хувьд уншигчийн санал алаг цооглов. Нэг нь уншууртай хэмээн урмаар угжиж, нөгөө нь уравсан хулгайн улиг мэтээр хяламхийв. Үүнд хачирхал нь үгүй агаад нийгмийн сэтгэл зүйн өнгөний харшил байлаа. Энэхүү худрага намайг холгож эрэгцүүлэл, эгдүүцлээ тэн шордож “Бор гэрийн богд” хэмээх дэд дэвтрийн залгаасыг бороолуулснаа өчсү. Түрүүч номд болсон явдлыг бороглосон учир энэ удаад болж буйг болгочисноороо ялгаа салгах гэж ядан зүдэн эвцүүлвэй.

Уран Зохиолын Академи

Нийгмийн буурь сэлгэхүйд хуучин нутагт орхих гээш гэвээс өтөл суртал байв. Гэвч оюун санааны өнцөг булан бүрийд чигжээстэй байсан новшноосоо салах хэцүү байлаа. Үхэж хатаж байгаа хөрөнгөтнийг үнсэн товрог болгох гэж болжморын цээжээ богтсоороо нүдэж байсан бидэнд социализмын дутагдлыг сөхөх “жижиг хөрөнгөтний салан задгай байдалд” тасч жинхэнэ гуйвж дайвсан сэхээтэн болох гэтэл дагаар орох сүжиг хомс давж заалдах хүчин мөхөсдөө тулсныг нуугаад яахав.

Уран бүтээлийн ардчиллын шинэ орчныг эрэлхийлж 1992 онд Г.Аким, Ж.Барамсай, П.Бадарч, Л.Дагвадорж, С.Дашдооров, Ж.Лхагва, Б.Лхагвасүрэн, Л.Пүрэвдорж, С.Эрдэнэ бид

арвуул үгсэн Монголын уран зохиолын академи байгуулах төсөл боловсруулж улмаар зохиолчдын их хуралд өргөн толилуулсан боловч хагалан бутаргахын хардал, сэрдлээр өөдөөс шидчихэв. Ургалч үзэл салаалж уралдах бус уран бүтээлчдийн чин бат нэгдлийн тухай манайхан үлгэр ярьцгаасан юм. Гэвч явахгүй гэсэн замаар орсон хойно давахгүй гэсэн даваагаар дайрахаас өөр гарц олдсонгүй.

2000 онд бид уран зохиолын академи байгуулав. Манай нэрт зохиолчид С.Эрдэнэ, С.Дашдооров, Д.Гармаа, Д.Нямаа, Д.Цоодол, С.Пүрэв, С.Лочин, П.Бадарч, Т.Галсан, Д.Төрбат нар болон академич Д.Цэрэнсодном, Х.Сампилдэндэв, доктор профессор Билигсайхан нарын дөчөөд хүн эвлэлдсэн нь утга зохиолын цөм гэж болно. Унаагүй, цалингүй, урцгүй, уут үүрсэн ерөнхийлөгчийн тоог би нэмэв. Монголын Уран Зохиолын Академийн нэрийн хураангуй нь МУЗА. Энэ нь тохиолдлоор эртний Грекийн шинжлэх ухаан урлагийн бурхан, дам утгаар онгод гэсэнтэй дүйцнэ.

Бидний эхний төлөвлөсөн ажил “XXI зууны судар” хэмээх уран зохиол-түүхийн таван боть цувралын төсөл байв. Лувсангийн Пүрэвдорж бид хоёр Ерөнхий сайд Ринчиннямын Амаржаргалд бараалхан тэр эрдэмт хүүгийн буянаар “Цагаан морин жил”, “Буруу номтнууд”, “Сүүдэр, шүүдэр”, “Сүжиг сэжиг”, “Хөх туурга” таван боть хэвлэгдсэн учиртай.

Миний бие “Ник” компанийн Энэрэлт, Сүхбаатар, “Говь”-ийн Ёндонжамц, “Монголросцветмет”-ын Бадамсүрэн, “МИАТ”-ын Нямдаваа “Эрдэнэт”-ийн Дорлигжав, ХХБанкны Мөнхтөр, Саран нарт учир гаргаж уруул унжуулан эдгээр сайхан хүмүүс эх бэлтгэлийн тоног төхөөрөмж хайрлаж өгүүлсэн компаниуд сайхь судрыг үндэслэгчид болсон ачийг номын титэмд дуурсгасан болно. Уг цувралын дээжийг төв болон аймгийн номын сангуудад түгээж, Соросын сан болон улсын номын сантай хамтран орон нутагт хүртээж буй. Уг цувралыг хойшид үргэлжлүүлэх төсөл боловсруулж засгийн ээлж бүхэнд өргөн барьж алсалваас “зууны номын зам”-ыг тавих учиртай юм.

“Монголын нууц товчоо”

Уран зохиолын академийн оюуны суурь дээр “Монголын нууц товчоо” уран зохиолын дээд сургууль байгуулахаар зохиолчдын эвлэлийн гүйцэтгэх захирал асан Дамбын Төрбаттай зөвшин хөөцөлдөв. Уг нь Зохиолчдын хорооноос Нацагдоржийн нэрэмжит сургууль байгуулах тухай тогтоол, хэсэг зохиолчдын гарын үсэг бүхий бичиг хоёрыг Гэгээрлийн яаманд өргөсөн юм билээ. Гэтэл сургууль байгуулахын тулд “Сундуй”, “Жадамба”-ын дайтай судар цомголдог юмсанж. Бичиг цаасны хөөө арай ядан хураавал Гэгээрлийн сайд бөлгөө Баттөр өлзийгөө өгч эрх олгов. Гэтэл Зохиолчдын хороонд сохор зоос байсангүй. Төрбат бид хоёр халаасаа тэмтрэв. Би гэдэг бинчингүйн эрхэнд дөрвөн буудалд байсан хашаа байшингаа зарж дов шарлууллаа.

“Монголын нууц товчоо” бол түүх утга зохиолын түгээмжит үндэс тавьсан тулгуур бүтээл учир эрхэм сайхан нэрийг нь бэлэгшээсэн билээ. “Нууц товчоонд” яруу найраг, хүүрнэлт зохиол, тэр бүү хэл тайз дэлгэцийн бүтээлийн үндэс бий. Ийнхүү чиглэлийн академийн дэвсгэртэй анхны сургууль 2000 онд үүд сөхөж билээ.

Зохиолчдын их хурал болж Удирдах Зөвлөлийн даргаар Цэндийн Энхбат, гүйцэтгэх захирлаар

Чилаажав, тэргүүлэгчээр Дарамын Батбаяр, Үржингийн Хүрэлбаатар, Загдын Түмэнжаргал нарын есөн удирдагч тодров. Тэдний анхны цааз нь сургуультай хамтран ажиллахаас татгалзан зохиолчдын оромжноос үлдэн хөөх тухай байв. Монголын үр сад утга зохиолын үүдээр орох гэхэд өөдөөс нь шороо цацсан цаасан дээр нэрээ мутарлахдаа тэдгээр хүмүүс гар нь чичрээгүйд би гайхав.

Утга зохиол, уншигч хоёрыг холбох аман хүзүүг хуга мушигваас надтай хамт тонилгохыг би Энхбат, Чилаажав нарт эгдүүцэн учирлав. Ц.Энхбат Москвагийн утга зохиолын дээд сургууль төгссөн хүний хувьд хатуурхаж чадсангүй.

“Монголын нууц товчоо” сургууль 2004 онд анхны төгсөгчдийнхөө халуун чихийг атгав.

“Зохиолчдын ордон” хэмээх халил бүхий нэртэй энэ байшинг үе үеэр уламжлан зохиолчид эзэгнэж босгыг нь элээх хувь зохиолын хуультай. Түүний үүдэнд залуусын зам зангалсан хөлдүү цагдааг бүү ойртуулья. Авьяастныг авьяасгүй нь ялж чаддаггүй ч хүлж дөнгөнө.

Утга зохиол хэмээх ерөнхий нэрийн дотор “уран сайхны утга зохиол” гэх ангилал бий. Манай сургууль хоёрдох буюу уран бүтээлийн зэрэглэлээрээ утга зохиолын багшийн сургуулиас ялгаатай.

Одоо хэр олон дээд сургуультай болжээ. Үүнээс уламлаад “энэ олон дээд боловсролтноор яах гэсэн юм бэ?” гэж өдөр бүр аашлах боловч, “олон харанхуй хүнээр” яах гэсэн юм бол? Хуулийн боловсролтнууд, хулгайчийн тооноос даваагүй, үндсэн хуулиас эхлээд бүх хуулиа дээр доргүй зөрчиж байхад хуульчид хэрэггүй гэж үү? Тэд заавал улсын төсөв рүү чихэлдэх албагүй. Өөрийгөө зөв авч явдаг өрхийн тэргүүлэгч дутаад байна. Тэгээд ч боловсрол, мэргэжил хоёр тэнгийн хоёр тал гэдгийг саная.

Хорин нэгдүгээр зууны духан дээр “оюуны” гэсэн бичээс байгааг харж байгаа л юм бол хормой чирсэн барлагуудыг “нөхөн үржүүлэх” гэж зүтгээд баймгүй. Боловсролыг бодлогоор тэтгээгүй улс орон балар ширэнг л болно. Энэ ялдамд өчихөд их дээд сургуулийн элсэлтийг нэг босгоор давуулдаг болох аваас авьяас ард нь үлдэнэ. Норовбанзадаас орос хэл, Явуухулангаас марксистын шалгалт авч байсан нь балайрал л байсан шүү дээ. Хүний байгалийн заяалыг огоорвоос “бөөний худалдаа” бодгалийн нөөцийг илрүүлж чадахгүй. Оросын олон олмоор чангалах, америкийн амыг нь сул тавих хоёрын аль алинд авах гээх юм бий. Халыг дуулж, мулт мушгихаа больё. Туршлагын туулай эрдэм шинжилгээний золиос л болдог бус уу.

“Хар хорум”

Эрхэм сайхан анд хөгжмийн зохиолч Дагвын Лувсаншарав бид хоёр ийм нэгэн дуурь хамжихаар арваад жил мөнгөний гачаалд эрэгцсэн юм. Гэтэл “Хан Бройн” захирал Санжмятавын Отгонбаатар хэмээх буянт хүү дөч гаруй сая төгрөгөөр уг дуурийг тайзанд залж магнай тэнийлгэв.

Отгонбаатарын эцэг Санжмятав театрын морин хуурчаас удирдаач болсон, миний дүү Санжмятавын амидаа найз нь байсан юм. Ухаантай хүү эцэгтээ ийнхүү “дуурин хөшөө”

босгосон билээ. Сайхан буян шүү. Харин уран бүтээлийг сэтгэл гарган тэтгэж засаг төрийн соёлын ачааг үүрдэг ийм хүмүүсийг татвар гувчуураас нь танаж урамшуулдаг байгаасай.

“Хар Хорум” дуурийг бүтээлцсэн ардын жүжигчин Уртнасан, ардын зураач Гунгаасүх, удирдаач урлагийн гавьяат зүтгэлтэн Туулайхүү гол дүрийг бүтээсэн ардын жүжигчин Долгор, Жавзандулам гавьяатнууд Мөнхшүр, Түвшинтөгс, Эрдэнэбат, Дашпэлжээ нарын зэрэг Улсын Дуурь бүжгийн академик театрын бүх уран бүтээлчдэд бишрэн сөгдье.

Эл дуурьт Чингай болон Булгай Чансан, Итали хувраг Плано Карпини, Франц дархан Гийом Бушье, орос дархан Козьма нарын түүхэн хүмүүсээс гадна уран сайхны дүрүүд буй. Хэрэг явдал алдарт мөнгөн модыг бүтээх явцаас үүднэ. Монгол дархан Хүрэлдэй, Бэрхэ, Салжи нар сайхь модны оройд нар, сар, галын бэлэгдлийг тахих гэнэ. Гэтэл Бушье Козьма нарын харийн урчуул Ангел тэнгэрийг залах гэснээс зөрчил үүснэ. Үйл явдлын эгзэгтэй энэ үед Хүрэлдэй нь эзэн хааны татвар эм, үзэсгэлэн гоо перс бүсгүй Жамийлаад сэтгэл алдарснаас нөхдийн хамт алс дайны газар хөөгдөнө. Энэхэн зайг эзгүйчилж эсрэг этгээд нь алтан бишгүүр үлээсэн Ангел тэнгэр босгоно.

Харийн дайнд хань нөхдөө алдаж, өөрөө сохорсон Хүрэлдэй тэмтчин ирж

-Асар мөнгөн модон дээр

Алтан нар сар байна уу?

хэмээн асуухуйд далдаас давалгаалсан олны шивнээ

-Алтан бүрээ үлээсэн

Ангел тэнгэр байна... гэхэд

Хүрэлдэй –Хар Хорумын тэнгэрт

Харийн шүтээн залрахыг

Хараагүй минь болжээ...

Түүний санааг газар дэлхий өргөн

Монгол туургатны голомт

Энд байх ёстой

Монгол угсаатны ураг

Энд байх ёстой

Монгол улсын өргөө

Энд байх ёстой

Монгол төрийн сүлд

Энд залрах ёстой

Энэ бол эзэн Чингисийн зарлиг

Энэ бол эцэг тэнгэрийн зарлиг гэсэн найрал, тэнгэрийн түрлэгтэй нийцэн өндөрлөнө.

Энд би эх орны голомтыг мөнхлөх санаа, басхүү харийн халдаараас асадхийлгүй сахихын нэгэн үзүүрт санааг мөнөөхөн “Би” үгүйдвээс эзэнгүйдлийн хоосон орон зайд улар уршгийн гэм үүсдэгийг холбон тайлсан юм.

Энэ дашрамд өгүүлэхэд буянт дүү Отгонбаатар маань Баянзүрх хайрханыг хормойлсон хатан Туулын хөвөөнд нэгэн сайхан орд харшийн цогцолбор зочид буудлыг барьж, түүний гол талбайд Мөнгөн модыг сүлдлэн залсанд ихэд бэлэгшээж билээ. Үүнд би хошуу нэмж “Монгол шилтгээн” хэмээх нэр оноон, дөрвөн үүдийг Тэнгэр, Газар, Нар сарны, гол асрыг “Хамаг Монгол” хөлгөн асар, мөн зургаан асрыг Хэрэйд, Найман, Тайчууд, Мэргэд, Хонгирад, Жадран, хоёр талын арван зургаан өргөөг өрлөгүүд, хатадын нэрээр товлосон юм. Тус гэхэд томдох тул дусал сэтгэл гэхүү дээ.

Монгол шилтгээнд Хархорумыг углуургаласан боловч төрийн бус шашны бэлэгдлээр чимэж сүм хийдийн төрх оруулсан нь агуулгад зохицолгүй хэлбэр ойрчилсон буюу чимэх чимэглэх урлагийн дүйцлийн мөчигдөл болсон юм. Үүнд бас төр шашныг шавааралдуулан хутгуушлаж намгүй юм байхгүй аснаа ламгүй юмгүй болсон цагийн цалгиас ч бас нөлөөлсөн байхаа. Ерөөс бүх юм тэр дундаа урлагийн бүтээл харилцан шүтэлцээтэй байх нь тухайн бүтээлийг цогц болгодог билээ. Үүнийг өлгөцлөж буй маань Хархорумыг жишиг хот болгохоор хаашаа жишиглэх нь бүдэгхэн байгаатай ухаан хүрэхгүй ч гэсэн сэтгэлийн сэжүүр шүргүүлж байгаа юм. Молхи түшмэл, толхи бүтээлчийн хамсаалд автаж хам хум хийлгүй, эрдэмтэн мэргэдийн олон сэдэл санаанаас ончтойг сонгож чадваас үндэсний бахархалын үлгэр загварыг бүтээж чадахсан даа.

Аргамж ба сургамж

Буриад гарвалийн “салхич хөвүүн” Базарын Цэдэндамба вээр “Тэгж ярьвал би чинь Шингис хаантай нэг сум, нэг бяргаад” гэж хөөрсөн гэдэг. Бахархал нь багтаж ядаж л дээ. Ус нутаг удам сурвалж холын би хүртэл өөрийн овгийг “хиад боржигин” гэж хэлэн алдаад алтан ургийн сүрэнд балтасхийж амаа хамхисан удаа бий. Тэгэвч тэр аугаа их эзний сүлдэн дорхи сүүдэр хэмээн зовлон жаргалын хударганд зовхи өргөж яваа минь аз.

Чингис хааны дүрийг төсөөлөх гэж мунхаглавч миний тачир ухааны тагжир хөрсөнд ургадаггүй юм билээ.

Хайсиг авгай “Монголын түүх ба соёл” номондоо “...Хорезмд болсон аян дайнд түүний биеийг нүдээр үзсэн хүний үгээр бол: Өндөр нуруутай, өргөн мөртэй, шингэн боровтор

сахалтай, муурын нүдтэй хүн байлаа” гэжээ. Мууран нүд хэмээсэн нь өрнийн суурин хүний ойрчилсон зүйрцэл биз. Малтай буянтай манайхаар бол хонин бор нүд гэхэд ташаагүй болов уу.

“Мэн да бай лу” хэмээх монгол татарын тэмдэглэлд “Тэмүүжин бол өндөр чацархаг, өргөн духтай, урт сахалтай, дайчин хүчирхэгээрээ бусдаас ялгарна” гэжээ. Эдгээрийн аль нь ч дам үгний дамжигтай боловч хоймор дүүрэн монгол эрийн шинжийг илтгэнэ.

Монгол туурганы цаана наана тэнгэр эзний тухай кино бүтээсэн нь нэг бус чиг, сэтгэлд хоргодсон нь үгүй. Америкийн жүжигчин Стивен Сигал гээч зар болж, яах гэж, яасан гэж өгч буй нь “таахад таахай дутав” гэгчээр холливудын шагнал гэж хэдэн хөөрхөн тоглоом тараагаад сураггүй. Монгол японы хамтарсан киноны зар тарсаар... Алин боловч эзнээ голдоггүй дур, эмээлээ голдоггүй морь гэгчээр бус сор сонгодог нь гараасай гэж залбирнам.

Зүйд нийцүүлэн бодвоос их хааны дүрийг Бурхан Халдуныг тахиж, гурван голын уснаас амсаж, морин дэл дээр, Монголын талын цэцэг анхилсан үнэрийг мэдэрч яс цусандаа яргаасан үзэл, бишрэл, өөриймслөөр бид л бүтээх оноолтойсон билээ. Хожимдсон хойно санахад, Ринчен гуай, алтан үеийнхэн бүтэн байсан үед кино жүжиг бүтээсэн бол... гэж халагламаар л байдаг. Гэвч тэр үед кино, жүжиг бүтээх бүү хэл хөшөөгий нь буулгах гэж хөглөж байв даа.

1980 оны 7-р сарын 14-ний Улс төрийн товчооны хурал дээр Ю.Цэдэнбал “...Чингисийн хөшөөг арилгах хэрэгтэй... Арилгах юмыг арилгаж л байя. Намар намайг ирэхэд энэ тогтоолыг үзэл суртлын хэлтэс бэлдсэн байх ёстой” гэж даалгасан байдаг. Гэвч Монголоо гэсэн сэтгэлтэй хүмүүс мартагнуулсан юм билээ.

Миний бие гутрахдаа нохойтож Цэдэнбалын нэр дээр далаад оны эцсээр том захидал бичсэнээ санаж байна. Надад хувь үлдсэнгүй. Түүндээ “Чингис хааны хөшөөг нураах, “Нууц товчоог” хаах санал тавьсан юм. Надад хариу өгөөгүй. Яаж ч өгөх вэ дээ. Янзы нь үзэж байна муу нохой гээ биз. Төв Хорооны нарийн бичгийн дарга асан Сандагийн Сосорбарам гуай “Чиний захидал энд байж л байна” гэсхийгээд өнгөрч билээ. Намын архивт орсон, үрэгдсэн алин болохыг мэдэхгүй. Хэрэв хэрэгжүүлвэл дээдэс шившгээ хутгах байсан юм. Даанч тэгээгүй. Намын Төв Хороонд болон бусад газар эх оронч сэтгэлтэй хүмүүс байсан болохоор тэд л садаа болсон юм билээ.

Чингис хаан бол монголчуудын шүтээн. 1962 онд миний бичсэн “Чингис” хэмээх өчүүхэн шүлэг их эзний сүр хүчний сүүдэрт бараадаагүй агаад хүн ардын сэтгэлийн шүүдэр төдий юм.

Академич Ш.Нацагдорж МАХН-ын Төв Хороонд бичсэн илтгэх хуудсандаа:

“...Д.Пүрэвдоржийн “Чингис хаан” гэдэг шүлгийг нэвтрүүлэх эсэх гэж баахан ярилцав. Б.Ширэндэв, Ч.Чимид нар тэр шүлгийг үзэл суртлын талаар тохиромжгүй тул ерөөс нэвтрүүлсний хэрэггүй гэж татгалзав. Би хувьдаа Пүрэвдоржийн шүлэгт хэдэн сайн бадаг буй боловч огт ойлгогдохгүй буюу ёгт утгатай зүйл байсан тул хэвээр нь хэвлэхэд хаашаа бол гэж хэлж байсан. Д.Төмөр-Очир Пүрэвдоржийн шүлэг үнэхээрийн яруу сайн утга уянгын шүлэг

байна. Үүнийг эрхбиш хэвлэх нь зүйтэй. Та нар засах хасах зүйл байвал үзээд “Утга зохиол” сонинд нийтэл, мөн радиогоор нэвтрүүл гэв” гэжээ. Гэвч уг шүлэг тэр үеэс хорин найман жилийн хорионд орж элдэв хуулбараар олны дунд ихэд тарсан билээ. Гэтэл 2002 онд монгол телевизийн дэлгэцээр зохиолчдын хорооны зарим ноёд шүлэг биш хэмээн зарлаж дөчин насанд нь дөнгөлөх гэв. Хэцүү хатуу цагт хүмүүсийн ой тойнд нэгэнт орогносон энэ шүлгийг үгүйтгэх гэж үсээ үгтээгээд өөрсдөө өл халзан болох вий дээ. Шүүмжийг шүлсээр хэрж болох чиг, шүлгийг шүлгээр л дийлнэ. Өөрөөс минь илүү хэнд ч болов би өчиггүй тахимаа өгнө.

Далай ламтан нэгэнтээ айлдахдаа намайг нэр заан миний “Чингис” шүлгээс иш татаад “...Чингис хаан болвоос... оюуны соёл ахуй байдал, зан суртахуун зэрэг амьдралын хэвшлээрээ өөр өөр овог аймгуудыг нэгтгэснээрээ монгол соёл бүрэлдэж улмаар монгол нутаг, монгол хүн хэмээсэн ухагдахуун буй болж үндэсний бахархал, үндэсний үзэл өнөөг хүртэл бидний дотор үеэс үед хадгалагдан үлдсэн...” гэж болгоосон байна лээ.

Миний муу шүлэг ийнхүү бурхны таалалд нийцэн аравнайлсан болохоор хилэнцийн хор эс халдьюу.

Өнгөрсөн түүх онгичих нь өнөөгийн явдалд хамаагүй гэх хахь үг хааяа сонсдоно. Үгүй шүү. Бид чинь хувхай ёдор биш, үндэстэй, мөчиртэй, үртэй жимстэй үлэмж наст хөх зандан. Түүх бол аргамж бас сургамж. Түүнд зоригжил, гэмшлийн аль аль нь бий. Их түүхээ инээж, уйлж ухаарч гэмээн үндэсний хэлхээнд өөрийн “Би” хэмээхийг таньж нээж басхүү тээж явахын тэнгэр оршьюу.

Долоон зууны тэртээ “Александр дайныг хөтлөх мэргэн бодлого дайсныг мэдэх хувилгаан эрдэмтэй чиг энэ цагт давхацсан бол Чингис хаанд шавь орох байсан юм” хэмээн Персийн түүхч Жувейний бичсэнээс улбаалан “Чингисийн дэргэд Македоны Александр болон Цезарь юусан билээ” гэж хойчийн мэргэд өгүүлсэн юмсанж. Америкт “Чингис бол мянганы их хүн” гэж зарласан нь “Чи бол мянганы өчүүхэн хүн” гэж намайг үнэнээр хэлсэн мэт санагдсан шүү.

Чингис бол улсаа зовж байгуулаад өөрөө жаргаж чадаагүй хаан. Түүнд гөлмөн алтаар хээлсэн ордонд эмс, дарсанд талимааран тансаглах зав байгаагүй. Энэлж, эзэгнэж, элэгдэж мөнхөрсөн аугаа их амьдралаа энэ хорвоотой хамт эмээлийн хоёр бүүрэгний хооронд багтаасан билээ. Бид түүний дайтай аж төрж чадахгүйгээ он цагийн сэлгээгээр цагаатгаж одоочилъёо гэхэд хүний өмнөөс амь зуух өртөөнд хөөгдсөн мэт янгуучлалгүй ядруухан яваа улсынхаа тусад ясныхаа хөлсийг нэвчээх юмсан.

...Бүтэн бие минь зоввоос зовтугай

Бүрэн улс минь бүү сандартугай...!

Энэ үг нар сарны ээлжинд надад, танд буулгасан зарлиг! Аугаа их байх нь алба биш гэхэд аминдаа зөв явъя.

Эцэг дээдсийнхээ түүхийг эс мэдвээс эргэх цагийн салхинд хамхуул больюу. Түүхийн мөрөөр хэгжиж түүсэн санаагаа би “Их цагаан сүлдэнд мөргөх айлтгал” шүлэгтээ цомойлсон юм.

Энэ шүлэг Монгол улсын анхны ерөнхийлөгч П.Очирбатын “Тэнгэрийн цаг” номын үүдийг өлзийлсэн билээ.

Их цагаан сүлдэнд мөргөх айлтгал

Мөнх тэнгэрийн хүчин дор

Монгол Улсын суу залийн эрхэн дор

Найман зовхисыг хүрээлэн

Нарны тэнхлэгт хүрдлэн

Ертөнцийн тулах цэгээс тэнгэрлэсэн

Есөн цагаан хүсэл

Есөн цагаан цацал

Есөн цагаан сүлдэндээ мөргөн айлтгая!

Эвлэрсэн улсыг тань ээдрээж

Эвшээсэн нумыг тань эрхээж

Эрсэлсэн ханыг тань эмтэлж

Элгэн зуур эвдрэлцсэнийг өршөө!

Эзэн Чингисийн зарлигийг огоорч

Эх орныхоо заяаг огшоож

Эрхт төрийнхөө жолоог ончроож

Эмээлээс буугаад эндсэнийг өршөө!

Хатуу, зөөлөн өглөгт өрсөж

Харийн өлмийд өвдөг өлтөрч

Хархорумын өрхийг бүтээж

Халдах дайсанд өөөдсөнийг өршөө!

Хатан зоригоо зуланд жаргааж

Хан илдээ хадганд зэврээж

Хасвуу тамгаа түүхэнд хагсааж

Харанхуй билгүүн мунхарсныг өршөө!

Алдар сүрийн омогшилд эрдэж

Алмай залхайн орхилд автаж

Алд биеийн оторт гортож

Алжаалаас эмээн амирласныг өршөө!

Айлсан хадамсан өчиггүй сүжирч

Амин нутгаа өмлөн зуйрч

Алаг дэлхийгээс хаяа ханзлаж

Алтан аргамж атираасныг өршөө!

Уурагтайгаа амласан хэлээ хэлтлэж

Улстайгаа мэндэлсэн бичгээ адлаж

Уламж соёлдоо харалган тэрслэж

Ура бахиран бүрэлгэснийг өршөө!

Ургуул үндсийг тань хилсээр сэндэж

Уугуул үрсийн тань цусаар мандаж

Улаантнууд егүүтгэхэд нүглийг хүлцэж

Улсын цаазаар яллаагүйг өршөө!

Туулсан алдас харууслыг эс мартъя

Тусгаар тонтнолоо амиараа халхалая

Тулсан голомтоо удмаараа мөнхлөө

Туг сүлдэндээ үүний тулд андгайल्या

Эрх чөлөө, ардчиллын хүчин дор

Эх орны сэргэн мандлын эрхэн дээр

Найман зуун товчоог

Наран дор тогтоож

Ертөнцийн чих нүднээ сүндэрлэсэн

Есөн цагаан хүсэл

Есөн цагаан цацал

Есөн цагаан сүлд минь

Эл андгайг хэн эс дагаваас

Эцэг тэнгэр хүнд гэсгээтүгэй!

1996 он

“Хөх үндэсний гал”

Тарчигхан шүлгээ танагчилж түүвэр болгосны нэр нь энэ. Уг номыг Монгол улсын анхны ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат ивээн баримтаглаж өлзийгөө өгөв. Буян нь дэлгэрэг. “Интерпресс” хэвлэлийн газрын “Бидний монголчууд цувралд холбоосон энэ номыг “Улаан гэрийн хоригдол” дурсамжийг минь хөтлөсөн Цэрэнпилийн Гомбосүрэн мөнхүү цэгцлэв. Тэрвээр сайхь дурсамжийн жаргаах гадарт “Oderunt poetas” буюу шүлэгч ад болдог хэмээх латин үг зоосны тайлал “Хөх үндэсний гал”-д буй.

Найргийн хуримаа ч би ийн нэрлэв. Хуриманд очихдоо хэдхэн хоногийн өмнө ардчилсан намын дарга М.Энхсайхан “Чингис”, “Тусгаар тогтнол” шүлэг бичсэний төлөө мялаасан Чингисийн одонгоор гоёв. Эрдэнэсийн дундаас алтаар товойсон эзэн хааны гэгээн дүрээс илүү гоёл юусан билээ.

Найрагч нь дулим чиг найз нөхөд нутаг усаараа би баярхсан шүү. Жанцанноров минь хөтөлбөрийг өрж өгөв.

Өвөрхангай аймгийн засаг дарга Батмөнх элч илгээж, жүжигчдийн шан харамжийг “Монгол ньюсийн” Балдорж дүү маань соёлын өргөөний төлөөсийг даав. Хотын захиргааны Болдбаатар, соёлын төв өргөөний Байгалмаа нарч баруун гар сунгав.

Өвөрхангай нутгийн буянт дүү нэр Батхүү, Батбаяр, Бадамдамдин, Чулуунбат, Дамдинбазар, Зоригт Бүрд сумын засаг дарга Гачмаа, нутгийн зөвлөлийн дарга Бүргэдээ нар уран бүтээлийн байр, шүншиглэж хотод зайдлах хөнгөн хүлэг сойв. Баярлахаас гадна сэтгэл зовсон доо. Оюуны бүтээлийг хорьдугаар зуунд ийнхүү урамшуулсан нь үгүй бөгөөд XXI зууны анхны цагаан эсгийг Өвөрхангайнхан ийнхүү дэвссэнд бахархаж бас гайхуулснаа ил хэлье. Энэ омогшилоороо би Хэнтий аймгийн нэгэн гавьяатад “Танай аймаг 80 жилийн ойгоороо их Лувсаншаравыг хүндэт иргэн болгожээ. Тэр чинь танай унаган иргэн, Монгол улсын хүндэт иргэн шүү. Та нар манай аймаг шиг даналзахаа байг гэхэд цаад аугаа өвгөндөө унадаг дугуй

аваад өгчих” гэж шаралхсан хун даа.

Найргийн хуримыг Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, анхны ерөнхийлөгч П.Очирбат нар хойморлосонд машинд бэлэгшээв.

Болор цомын эзэд, Б.Лхагвасүрэн, П.Бадарч, Д.Цоодол, Т.Галсан, Ц.Чимиддорж, Ц.Хулан, Б.Ичинхорлоо нар ээлжлэн хөтөлж үзэгчдийг яруу найргийн цэнгэлд умбуулсан юм. Ардын жүжигчин Уртнасан, Зангад, гавьяат жүжигчин Дашпэлжээ, Цэцэгээ нар ая өргөж ардын жүжигчин Батчулуун морин хуурын чуулгатайгаа, урлагийн гавьяат зүтгэлтэн Туулайхүү найрал хөгжимтэйгээ тайз эзэгнэхэд дов жижигдэж байлаа.

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Төмөр хэмээх авгын инженер гялалзсан залуу байсан юм. Олон жилийн архаг согогтой орос тэрэг, тоосыг нь арчихаас өөр шидгүй, тосгүй жолооч бид хоёр хотын замд хоюулаа унтрах тоолон Төмөрийгөө би “ахыгаа бодоорой” гэж түргэн тусламж дууддагсан. Гэтэл түүний охин нь дуучин Ариунаа юмсанж. Дуутайгаа авалцан ноцдог, ер бусын дотоод эрчим хүчээр тэсэрдэг цог жавхлант дуучин охин минь ирж нутгийн ахдаа “Дөрвөн цагийн тал”, “Хаврын шөнийн бодол”-оор тэнгэрлэг ая өргөсөнд би баярласнаа өчье.

“Хөх үндэсний гал”! Энэ нэрэнд би ертөнцийг бус гэхэд Монголоо гэх үзлээ тарни мэт шившсэн нь учиртай.

Сайн саарыг эс ялган салхи бүхнийг даган савлах буюу өдрийн нигуур, шөнийн явуур төдийгөөс дайжих бодол надад бий. Энэ нь миний сүрхий ухаантайнх бус харийн алдааг хаяагаа ханзлаж ханаа дөлөртөл давгаж халирсных биз.

Алаг дэлхий алган дээр мэт энэ цагт авах юм олон боловч алдаж болохгүй ганц эрдэнэ Монгол минь билээ.

Энэхүү язгуур санааг хойч үеийн хүн бүхний оюун ухаанд аргамжих гэсэн дээдсийн таалалыг ойшоосондоо олзуурхан “Хөх үндэсний гал” хэмээх гуравхан үгийг хэлхсэн юм. Энэ санааг доктор Л.Хүрэлбаатар хэмээх номч эрдэмтэн задлан шинжсэнийг уншаад уран бүтээлийг ийнхүү үндэс, иш, түрүү гурвын зангилаанд ухаарахуйн үлгэрийг үзүүлсэнд бишрэн судлалын мөр хөөх залууст сургамжтайд олзуурхав.

Эрээн уулынхаа хормойд төрсөн хондоо дэвсэн нэгэнтаа нойр хулжаахдаа үүр шөнө ханзрах торгон агшинд үй олон үндэс бүүр түүрхэн шивнэхийг чимээлсэн юм. Тэрхэн зуур тэдгээр үндэс хөх агаад бүгэтхэн галтайг мэдэрч билээ. Бидний биес сайхь үндэснээс ургаж, бас түүний илчийг зүрхэндээ тээж яваа болохоор хөх үндэсний гал ажээ. Учир иймээс бид үндсээ, үндэстнээ хайрлах, хамгаалах “гавьяаны амралтгүй” үйлсийг үүрч яваа билээ. Үүнийг олон хэлийн ном сударт эх оронч үзэл гэж нэрлэдэг юм гэнэлээ. Энэ үзлийг эзэгнэн амьд явах байтугай үхэх хүртэл тэнгэрийн таалалд багтана.

Эрдэнийн эцсийн зүүд

Сэнгийн Эрдэнэ бол сэтгэлдээ уянгын эгшиглэнтэй зохиолч. Харин түүний тэлмэсэн яруусал

нулимстай байсан юм шүү. Эрх танхи насандаа эсэргүү хилсээр эцгээ буудуулж Сэрүүн Галттайн хөвчөөс үргэсэн янзганы нүд насан турш будантай явсан юм. Тэрвээр гучаад оны улаан яргалалыг үзэн ядаж байсан нь ард түмнээ өмөөрсөн том зохиолчийн хилэгнэл байв. Тэрхүү хилэн бадарсаар бусчир аюулыг үүрд үлдэн хөөхийг бурханд даатган өөрөө зул болсон билээ.

Эрдэнэ маань лагшин чилээрхүү байхдаа буриадын зохиолч Батжавын Дашравдангийн “Төөрөлдсөн хувь заяа” романаар кино зохиол тэрлэхээр алжаалыг үл огоорон эрэлхийлсээр байв. Уран бүтээлийн тамд унасан жинхэнэ зохиолчийн зовлонд хөвсөн жаргал гэдэг энэ.

Миний тэмдэглэлд Эрдэнийн дүрийг зураглах гэсэн хэдэн мөрөнд “...Украинд папаах духдуулах нь Батца Махно мэт, Ховдын голын хөвөөнд бурхны дой мэт, Казах оронд залрах нь султаан мэт, долгиорсон буурал үс сортуулж, тас хар костюмтай хойморлох нь лорд мэт, Шилийн Богдын хормойд сэгсүүргэн дээл эсгий гуталд түүртэх нь шилийн сайн эр мэт, Бээжингийн зоогийн газар ардын зоос шидэж шар айраг шимэх нь шинэ баян мэт, Ганга мөрний хөвөөнд залбиран рашаан хүртэх нь бурхны шавь мэт. Гал тогооны өрөөнд хоёр хутга солбиулж буузны мах татах нь буриад тогооч мэт, асгартал уйлж тайтгарах нь хүүхэд мэт Эрдэнэ бол Эрдэнэ л байлаа” гэсэн байх юм. Сайхан дүрийн муухан таталбар байгаа биз. Яая гэхэв дээ, өөрийнхөө жингээс илүү ачаа би өргөж чадах биш дээ.

Намайг очих бүр уран бүтээлийн яриа дэлгэх зуур улс төр рүү ч хожуулаа хальтардаг байлаа. Ардчиллыг анхны өдрөөс нь алга тосч авсан хирнээ, төрийн нуруу түвшрээгүй залуусын овилго алдаж буйд Эрдэнэ харуусан чамлана. Тэдний өөр зуураа тэрсэж, өмнөх замаа бартаглаж хүмүүсийн сэтгэл рүү жавар цацах тоолон найз минь халаглахаас ч яахсан билээ. Алсхан харж чаддаг Эрдэнэ мэт хүнд ардчилсан хүчнийхний үдийн хугархай ухаан шидмэсний тасархай шиг байсан биз ээ.

Хоёрдугаар нэгдсэн эмнэлэгт түүнийг эргэж очиход тэр маань бие эцэж, гагцхүү сэтгэлийнхээ дөрөөн дээр тогтож байх шиг санагдсан. Бат-Үүл аавыгаа асарч тойлж байлаа. Надтай харцаараа мэнд солиод Эрдэнэ минь:

-Би жаахан өндийж суумаар байна гэлээ. Би цээжийг нь өргөн өндийлгөөд түшиж хэдхэн агшин суулгав. Тэгэхэд Эрдэнэ тамирдангуй инээвхийлж,

-Хачин юм зүүдэллээ гэж мушилзсанаа –Цэрэндэжид минь цэл залуухан, бид хоёр Бразилийн ерөнхийлөгчийн гоёмсог ордонд хүлээн авалтанд цэнгэж байх юм гэхэд нь би,

-Бразил байдаг нь ч юу билээ. Ядахдаа Чилид Пиночетийн ордон байсан бол чи бид хоёр сураг дуулсан баймаар юм гэхэд,

-Харин тиймээ... гээд эргэн хажуулав.

Тэр маань хар багаас ижилссэн ханиа өрөвдөж дотоод ертөнцийнхөө илч гэрэлд эрхлүүлэн зүүдэлжээ. Би эмнэлгээс ирээд гэр рүү нь утасдаж Цэрэндэжидэд энэ тухай хэлбэл,

-Та хоёр чинь бүр зүүдээ ярихтайгаа байгаа юу гээд инээсэн юм. Энэ инээд Эрдэнийн

зүүдний цагаан тайлал байв.

Сэнгийн Эрдэнийн эцсийн зүүд энэ. Аугаа их бичгийн мэргэн, энэрэнгүй үзэлтэн, энэ хүн зүрх сэтгэлд төдийгүй, зүүдэндээ ийнхүү цагаан гэгээ цацан буцсан билээ.

Эрдэнийн маань гэргий Цэрэндэжид нөхрийнхөө сан хөмрөг бичиг сэлтийг хадгалааны горимоор цэгцлүүлж бурхан баярлахаар сайн үйл бүтээсэн дээ. Тэрвээр бас хөшөө чулуун дээр нь товгор баримал суулгахыг сэдэж, би вээр Дондогийн Цэвэгмид гуайн хүү төрийн шагналт барималч Амгалантай үг хэлээ ололцон байрлуулсан. Миний хийсэн цорын ганц буян л энэ.

Монгол туургатны оюуны огторгуйн нэгэн шүтээн Сэнгийн Эрдэнэ мөнхрөлийн хувьтан бөлгөө.

Дооровын орхисон инээд

Цагаан хэрмийн чанадаас ирээд Эрдэнэтэй төвөггүйхэн уулзсан бол Дашдооровтойгоо золгоо хожуудсан нь миний загалгаа муу дээр тэр маань зуслан сувилгааны эрхээр хотын гэртээ байсангүй. Түүний хүрээлсэн сургаар Дамбын Төрбат бид очив.

Их газрын чулуутай хамт ургасан гэмээр хүдэр чийрэг, ёстой л сүхээр цохиход ирий нь эмтэлж оч бутрахаар эр тулдаа л өвчин даажээ. Түүний хүчирхэг цогцос, сэтгэл зоригийн хатыг би биширсэн шүү.

Гуравдугаар давхарт Дооровын инээхэд гудамжинд явсан хүн эргэж хардаг гэж манайхан хэлдэг. Үнэхээр түүний бүдүүн хоолойгоор чихэлдэн гарах инээдэнд ширээ доргиж, шил харших шиг болдогсон. Гайхалтай сайхан инээд. Энэ инээдийн үзүүрт ирвэгнэсэн хошигнол нийтгээстэй байдаг бөгөөд амьдрал уран бүтээлийн хос сүвэгчээр хүнийг гэгээлдэг гэж болно. Түүнтэй хамт байхад сүүдэр үргэж, ер бусын цэлмэлд бид умбаж, утга зохиолын улааг уйтгаргүйхэн нэхэж явсан даа. Энэ удаагийн уулзалт ч тийм байв.

Итгэл ахайтны цай зоог дээр дэвэрсэн бидний хууч наргианы хачиртай байсан юм. Зохиолчдын тухай чинжүүтэй шог халуухан байсныг яана. Тэгээд ч тэр бүхэн голцуу Дооровын туурвил байсны дээр миний чимх давс орсон болохоор бидний яриа амттай байсан буй за.

Дооров маань хиртсэнээс хойш тэгж инээгээгүй юм билээ. Тэгээд ч түүний хошигнолын хүчит цэнэг зовиурыг нь нэвглэж, бидний сэтгэл рүү инээдээр урсан шингэсэн авай.

Энэ уулзалтаас хойшхи учралыг хорвоо биднээс булаан авсан юм. Дооровын маань элдэв учралын тухай номын гар бичмэл үлдсэнийг Итгэлтэй ярилцан “Интерпресс”-ээр хэвлүүлэх санаа сэдэн сайхь Ц.Гомбосүрэнд учирлаваас уриалгахан тоссон юм. Гэтэл хэвлэлийн зардлыг даах буянтныг хайж нилээд алгуурласны хойно Гомбосүрэн маань Уртнасангийн Уламбаяртай үгссэнээр уг ном хэвлэгдсэн юм. Буян үйлдэгч маань манай нэрт зураглаач Уртнасангийн хүү дэд бүтцийн дэд сайд бөлгөө Уламбаяр шүү дээ. Бидний өхөөрдлөөр Умбаа маань унаган сэхээтэн, утга зохиол урлагийн тэнгэрт дээж өргөдөг хүү болохыг

ялдамд хөхүүлсү.

Дооровын хөргийг төсөөлөхөд морин дэл дээр дарцагласан адуучин эр санаанд буудаг юм. Бүрх малгай шилэнд хаяж задгай заамны цаанаас хүрэл цээжийг гайхуулан, уян дээр гэлдэрч буугаад тогоо авсны хойно тоос гозойлгон буцахад дээлий нь ар салхи хөөрөглөж хормой нь морины хондлойд шүхэрлэн буй мэт зураг харагддаг юм. Тэрвээр бидний дотроос монгол эр хүний төрхтэй нь асан болоод тэр болов уу. Бас тэгээд хоёр азрага адуутай хориод зэгсэн морьтой айлын хүү. Таван настай унааны нуруунд гарсан гэхээр адуунд элэг бариулахгүй элдүүр хангах эртэй байхсан биз.

Дооровыг харчин гэгцгээдэг байсны учрыг би мэдэхгүй. Харчин бол Дарлигин монголын урианхай овогтны нэг мөчир гэвээс цэрвэх ч юу байхав. Гэвч харчингууд өөрсдийгөө Боржигин гэж хэлэх дуртай юм билээ. Аль нь ч байсан Дооровт таарна. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Сормууниршийн голомтны хүү. Сормуунирш гуайг нярай ахуйд XIII-р Далай лам тэр нутгаар залрахад аав ээж нь мөргөөд хүүд минь нэр хайрла гэж л дээ. Далай лам хүүгий нь шинжээд “Энэ хүү чинь миний багшийн сүнс байна” гэж дуу алдаад Сормуунирш нэр хайрлажээ. Сормуунирш гэдэг нь “хорин дөрвөн хуруут” гэсэн үг юмсанж. Сормуунирш гуай дөрвөн мөчиндөө нижгээд илүү хуруутай байсан нь ламтны багштай адил байсан юм байлгүй. Тэгээд ч эндүүрэхээргүй сондгой нэр өгч л дээ.

Дооров 1935 бус 1936 оны хулгана жил Шорвогийн овоо гэдэг газар төрсөн гэдэг. Хулганатай өчүүхэн ч төсгүй болохоор жил нь төөрөв гэхэд хондоо гарцаагүй олсон болохоор шорвогдсон биз ээ. Тэр шорвогийг бид гашуу оргитол амталсан бол, уран бүтээлээр нь уншигч авхай та ч амхарсан даа. Хүний өчүүхэн төдий өө сэвийг олж хорсгодог сайхь шорвог буюу хошигнол нь том зохиолчийн хачир байсан юм шүү. Энгийн цагт энэ нь түүний инээдээр илэрдэг байсан бөгөөд, тэрхүү цавцалзсан цагаан инээдээ бидэнд рашааны дусал болгон орхисон билээ. Инээж амьдраад хүний сэтгэлд сүүдэр үлдээлгүй буцах гэдэг ухаан сэтгэлийн тэгшрэл ажаам.

Б.Явуухулан, С.Эрдэнэ, С.Дашдооров, Д.Мягмар нараар ийнхүү миний тэнгийнхний эрхиний хэлхээс тасарч хадгалж буцах халагласан дуртгал үлдсэн авай. Үхэлтэй эвлэрэх атал, амьдралтай тэрсэх хүмүүний бэлчээр юутай богинохон юм бэ.

“Бэрс гарсан хүү”

Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабандид “XXI зууны судар”-аа өргөн барихын ялдамд надад бас айлтгах үг байсан юм. Албархал, ёсорхол, цагийн шавдуулалгүй авч хад хайрцаг мэт төрийн тэргүүний хувьд миний өчил бутархай садархай байсныг үл өгүүлэн сэрмүүчлэе.

Нэг. Монгол улсын төр хойморлох газраас олны саналыг ойшоон бурхан болоочдыг сэлгэн ёс горимоор хөдөөлүүлбэ. Ерөөс ийнхүү голомтдоо буххлах нь манай өтгөсийн ёсонд хазгай бөгөөд бэлэгшээлгүй.

Хоёр. Тулгар төрийн ойн янар Их эзэн хааны хөшөөг дээдлэж төв талбайд залж, одоогийн бунхныг ордны хэв маягт нийцүүлэн сүлдийн өргөө болгоё. Энд төрийн түшээд тангараг

өргөж хуримын хос сүслэж, баяр ёслолоор болон хүндэт зочид цэцэг өргөдөг болговол сайхан аа.

Гурав. “Монголын нууц товчоо”, “Үндсэн хууль”-аа алт мөнгө эрдэнээр чимэн их цагаан сүлдийн дэргэд залъя. Энэ нь төрийг болон номыг дээдлэх эрхэм ёсонд нийцнэ. Тэнд залсан “Үндсэн хууль”-ийг зөвхөн нэмэлт өөрчлөлт оруулах, ерөнхийлөгч тангараг өргөхөд хүндэтгэлтэйгээр залдаг байваас төр, түмэнд нийцэлтэй билээ.

Дөрөв. Монголчууд сайн сэтгэлт айлчны өөдөөс буу дуугаргадаггүй тул аман зохиолд олонтаа гарах төрийн “Их хэнгэрэг” байвал зүгээр мэт. Бас гоёмсог хоёр бортгонд шатдаг хий дөллүүлсэн гал үүсгэж түүний хооронд цагаан эсгий дэвсэн өлмий түших аваас монгол хүндлэл болно.

Тав. Утга зохиол урлаг, биеийн тамир спортыг ивээгч үндэсний бэлтэй хүмүүс буй болжээ. Төрийн ачааг ийнхүү түмний тусад үүрэлцэж яваа хүмүүсийг татварын бодлогоор хөхүүлж байвал тустайяа.

Зургаа. Ардын уран зохиолч цол хүртэгсэдээс Ц.Дамдинсүрэн, С.Эрдэнэ, С.Дашдооров нар таалал төгсөв. Иймд уран бүтээлийн дорвитой шинэчлэл хийсэн Бавуугийн Лхагвасүрэнд энэ цолыг хүртээж ажаамуу хэмээн эдгээр саналд олон хүний санааг зангидсан нь бүтэн цаг миний задгайрсан үглээний бүдүүн гол байсан юм.

2003 он буюу “Болор цом”-ын хорин жилийн наадамд ерөнхийлөгч Багабанди морилов. Түүнээс улбаалан цагаан сарын өмнөхөн намайг дуудаж “Бид сар шинээр урлаг соёл, шинжлэх ухааны зүтгэлтнүүдийг урьдаг юм. Энэ жил Оюунбилэг бид хоёр “Болор цом”-ынхныг урихаар ярилцлаа. Танд ямар санал байна вэ” гэж асуухад нь “Төрийн хүндэтгэл хэмээн хүлээн авлаа” гэж товчхон хариулж билээ.

Ерөнхийлөгчийнд цагаан сараар саатах зуураа ажваас илүү буюу дутуу нь үгүй, бүх юм цэгцтэй тахил шиг байсан шүү.

Манайхан “мордохынх молор” шүлэг уншицгаасан. Төрбатыг шүлэг уншихад нь “энэ морийг их наадамд сойх санаатай” гэдгээ би хэлээд амжсан даа.

Мичин жилийн сар шинээр Л.Түдэв, Ш.Сүрэнжав, Д.Цоодол бид мөн золгоор бараалхав. Тэгэхэд Л.Түдэв,

-УИХ-ын дарга С.Төмөр-Очир төмөр замын нэгэн өртөөн дээр хэлсэн үгэндээ Раашийг баатар болгохоор ярьж байсан. Түүнээс хойш хоёр жил өнгөрлөө. Мартсан юм болов уу даа. Би өнөөдөр түүнийг Ерөнхийлөгчид сануулах гэсэн юм гэлээ. Би түүнийг дэмжиж,

-Рааш минь баатар болохоосоо өмнө “Монголын нууц товчоог” төрийн хойморт залахад хүчин зүтгээрэй гэж ташуур өгөв.

Биднийг ийнхүү наргианы завсар үг хавчуулж байхад Рааш маань хөөрөг няслан мушилзаж суув. Тэндээс Сүрэнжав, Рааш, морин хуурын Батчулуун бид дөрөв Ерөнхий сайд

Н.Энхбаярын хожимдосхийн очсоноо цайруулж:

-Бид ажилтай явлаа. Раашийг баатар болгохоор шийдчихээд ирлээ гэж наргиан болгосноо санаж байна.

Энэ бүхнээс хойш “Монголын нууц товчооны” тухай зарлиг буулгаж Лхагвасүрэн ардын зохиолч, Рааш хөдөлмөрийн баатар, Төрбатад төрийн шагнал хүртээсэн нь бидний үг дэм бус гэхэд гэм болоогүйнх биз. Тахиа жилийн цагаан сараар золгохдоо танай уяан дээр урт хар морь байгаа шүү гэж Д.Цоодолыг гилээд авсан. Тэр ч ёсоор болов. Энэ бүхэнд олон хүний санаа оноо сав дүүргэсэн ч хянуур, товхгор Ерөнхийлөгч маань зохиолчдын үгийг болгоож, олны оноотой нийцүүлсэн нь таатай санагдсаныг талархан өчсү.

Нацагийн Багабанди бол миний мэт давжаахан эр. Ерөнхийлөгч ямар бөх биш арал чацаар ч яахав дээ. Ухааны бяра түүнд бий. Өөрийн “Би”-г таньдаггүй хүн өрөөлийг өнгөнөөс нь хардаг болохоор хэвлэлийнхэн түүнийг “сахалт” гэж хочилдог. Түүний жирвээ нь цолшихооргүй ч гэсэн гурван хар зураасны нэг нүд дассан бидэнд үгүйлэгдэх биз. Тэрвээр биеийг хичээн цэгцэлж намбалаг хянуур алхдаг. Алхаагаа тоолдоггүй гэхэд шавхайд гишигчих хүн биш. Тачигнатал хөхөрдөггүй ч бүлээн инээмсэглэлээр өөрийгөө гэгээлдэг. Түүнд хурган даргын ширээ дэлдэх агсрал үгүй ч ширдгэнд бохирох дургүй монгол ноёны ихэмсэл бий. Утга зохиол, урлагийн бүтээл үзэх дуртай. Энэ нь хөлдүү түшмэл бус гэгээрлийн мөртэй гэсэн үг. Тэрвээр малчны утаа үнэрлэсэн хүний жудгаар ардын ухаан, соёл, ёс заншилыг дээдлэнэ. Төр засгийн хоймроос монголоороо ухаалж, унаган хэлээрээ ярьж чаддаг хүн энэ хэр түүнээс давуу нь үгүй. Өгүүлбэрт нь олонхи эрхмүүдийнх шиг орчуулгын хийц байхгүй. Санаа нь оновчтой тод, илбэх ба чимхэхийн илүү тунгүй дүйцэлтэй монгол аман болон бичгийн утга зохиолын амсуургатай, өрнө дорнын гүн ухааны углуургатай байдаг юм. Энэ нь морь үргэхээр модон хэлтэй мохсын ухаанд үл хүрэх нь бий. Үүнийг хачирлахын учир гэвээс төрийг түшээч үндэсний утга соёлын үр байхаас өргөмөл жаал байж болохгүйг хэгжүүхэн хэлж байгаа нь болой.

Ерөнхийлөгч бол аль нэгэн намаас нэр дэвшдэг учир тэр тал руугаа мөр мөлтөрхий байх юм. Харин 2001 оны сонгуулиар манай ерөнхийлөгчийн зүүн мөрний хэвгий тэгширсэн шүү. Түүний “шинэ сонголт” гэдэг үгэнд өөнтөглөөчдөд “дахин сунгалт” гэж хэлэх ёстой юм уу гэж дардаймаар байв. Нам нь намаг, гишүүн нь мэлхий байх албагүй. Тэгээд ч бүх ард түмний сонгосон ерөнхийлөгчийг бүлгийн өмч болж өргөө улсаа өрөөлдөхийг шаардах эрх хэн бугайд ч байхгүй. Энэ өгүүлбэрийг би аядуухан хэлхэж байна. Цэгмидийн Гайтав маань өнөөдөр байсан бол “улс төрийн жалгархал, улаантай цагаантайгаа сөнөтүгэй” гэж аянгалах байсан биз ээ.

Ерөнхийлөгч Багабанди бол “бэрс гарсан хүү” гэж нүүрэн дээр нь хэлчихсэн удаа бий. Харцын хүү хааны зэрэгт хүрэв гэсэн санаа сарвайж байгаа минь тэр.

Завхан нутгийн зохиолч Ишдоржийн Цэрэнжамц “Засагт хааныхан засагт үнэтэй. Завхан аймаг арваад хутагт, анхны аман хүзүүний хоёр ерөнхийлөгчтэй” гэж нутаг нугаараа хөөрлөж байхыг би сонссон. Энэ үгээ хэлээд нутагтаа очиход аяга цайгаар дутахгүйгээ тэр мэднэ. Тэгэхээр ганц түүний үг лав биш болов уу.

Ардчиллын үед бид хоёр ерөнхийлөгч сонголоо. Аль алинд нь алдсангүй. Гуравдах нь Намбарын Энхбаяр болов. Гараан дээр нь ерөөл хэлж, бариан дээр нь үгээ үлдээе.

2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн шөнө Мэндсайханы Энхсайхан Энхбаярт утсаар баяр хүргэхэд улс төрийн соёлтойд нь өрсөлдөгч нь ч, өргөн түмэн ч таашаасан билээ. Харин Энхсайханы хувьд ар өврөөрөө харсан ардчилсан намынхан онх босов. “Өөрийн нам руу буюу намын нэр дэвшигч рүү хандсан дайралтыг зохион байгуулагч шууд илэрхийлэгч нар нь намаа төлөөлж төрийн өндөрлөгт очигсод байсан. Ардчилсан нам нэр дэвшигчдээ ганц ч төгрөг өгөөгүй гээд бод доо. Намын бүх шатны нэгжид хандсан “Намаа задалсан Энхсайханыг сонгох хэрэг байгаа юм уу” гэсэн философлог асуулт-мессеж чухам засгийн газрын гэсэн хаягаар шуурхай тарж байсан ба гардагч нь намын удирдлага байв” гэж Баабар бичжээ. (Өдрийн сонин, 2005 оны 6-р сарын 3) Хэрэв энэ үнэн бол түүний хэлснээр “ардчилсан нам өөд болжээ)

Монголын түүхэнд гарамгай гавьяа байгуулсан намын морийг нь алж, модыг нь бариулсан хүмүүс намтрын бузраа сэгсэрч өөр намын өврөөс гарах болтугай. Элдэв муу үйлтний нэр цолоос хамгийн жигшилтэй нь урвагч. Үүнийг Бавуугийн Лхагвасүрэн “үр могой” гэж нүдий нь олж, нүглийг нь ялласан билээ. Үр могой гэдэг нь хүн могойн тухай хүүрнэл. Энэ могойн эрээн нь дотроо агаад үнэнч хань, үр хүүхдээ байтугай үндэстнээ залгих ёртой. Түүний аманд үхлийн хор балгаастай байдгийг машидын туйлд адлан, ард түмний аминаас хол байлгая. Гэрт орсон могойд бэлэгшээл байдаг гэхэд төрд орсон хүн могойд хорлолоос өөр нь үгүй. Хол байгтүн.

“Эрдэнийн чуулбар”

Норовбанзадын далан насны ой монгол дууны их тахилга болсон юм. Соёлын төв өргөөний тайзнаа алтарсан сэнтийд их дуучин заларсан нь агуугийн бэлэгдэл хэмээсэн найруулагч Жанцанноровын санаа. Ухаанд ургасан шүү. Монголын алдартай дуучид түүнд эгшгийн цацал өргөсөн нь урлагийн гайхуулал бахархал байв.

Норовбанзадыг урлагийнхан Норовоо гэдэг бол би “Норов хатан” гэж өхөөрдөн өргөмжилдөг. Тэрвээр үнэхээр монгол ардын уртын дууны тэнгэрлэг хатан юм чинь дээ. Түүний дуулахад тэнгэр цэлсхийн, тал алслаж, хөх хөвч шуугин, ус таргилтан, уулын цагаан салхи үүлнээ дэгдэн ер бусын амгалан цэнгэлд өөрийн эрхгүй жаргадаг. Юутай гайхамшиг.

Цэнгэл өндөрлөхөд бидний хэсэг нөхөд хэдэн хором идээ ундаа тойрон саатахуйд Норовбанзад,

-Манай Банзрагч чинь танай Өвөрхангайх шүү дээ гэв. Би гайхшран,

-Завханы Алдархаан гэдэг шүү дээ гэвэл Банзрагч маань,

-Өвөрхангайн Нарийнтээлээс өртөөнд хөөгдсөн айл юм билээ гэж тайлав. Донровын Намдаг гуай шиг юмсанж.

Норов хатныхаа цэнгэл дээр хэдэн мөр хэлхэн хэлснээ сийрүүлье.

Намжилын Норовбанзад танаа

Монгол ардын уртын дуу-

Найрын хойроос алсарсан аялгуу

Наадмын морьдын асгарсан гараа

Найраг хөглөсөн хуурын цацал

Уул уулсын цангинасан цуурай

Ус усны шагширсан шуурай

Униарт говийн дуртсан бүүвэй

Норовбанзадын дуулахад-

Тайгын цэцэг шүүдрээр мэлмэрнэ

Таанын залаанд салхи хоргодно

Талын хаяа тэнгэрт эрхлэнэ

Хаярсан зэлэнд гүү ивлэнэ

Хагссан хөхүүрт саам иснэ

Хайрын нулимс учиралд инээнэ

Норовбанзад алдартай хүн-

Урлагийн тайзны эртийн солонго

Улсын шагналын энгэрийн цомог

Уртын дууны амьд домог

Норовбанзад азтай хүн-

Дэргэд нь сайн хань Банзрагч байна

Дэнсмаа, Дэдэрмаа, Дэлгэрмаа нь байна

Дэгж дэрвэж өссөн үрийн үрс нь байна

Ардын дуунд-

Төрсөн он гэж байхгүй

Төгсөх он бүр байхгүй

Мөрийн цагаан түүнд бий

Мөнхийн рашаан дуунд бий

Буяны ерөөлөөр дуундаа жаргатугай

Бурхны авралаар дуу шигээ насалтугай.

2000.12.22

“Улаанбаатар” зоогийн газар болсон цайллага ч бас дуугаар үерлэв. Дундговийнхон дуучирхаж, Хайдав, Дашпэлжээ, Нэргүй нар ёстой л хадаав. Найрын даамал сайхь Жанцанноров нэгэн ээлжинд намайг урив. Би наргиан болгож,

-Дундговийнхон дуучидтай нь үнээн. Яагаад гэвэл Онгийн гол Жанцанноров бид хоёроос эх авч Дундговь руу дуугаар урсдаг юм гэхэд хүмүүс хөгжилдөв. Уран бүтээлчдийн наргиан балтай бас охьтой байдаг хойно доо.

Банзрагчийн Дэлгэрмаа нэгэн ярилцлагадаа “Хэнтийн ууланд Норов банзад нэртэй мод байдгийг дурссан байна лээ. 2004 оны зун бядан явахдаа Хархорумын чанд Орхон голын нэгэн сайхан тохой “Бага хүрээ” хэмээх газар өвгөн буурал аварга улиас байх агаад нэг нь унахдаа нөгөөгөө түшиж асарлан ургажээ. Түүнийг “Норовбанзад” хэмээн нутгийнхан нэрлэн тахиж дархалжээ. Норовбанзад хэмээх нэрийг “Эрдэнэсийн сан чуулбар” хэмээн тайлах аваас Норовоо маань тийн ахуйд ихэд бэлэгшээн Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат, элчин сайд Ц.Гомбосүрэн, “Sky плаза” компанийн захирал Баасандорж бид гэр бүлээрээ хадаг өргөж адис авсан билээ.

Норовбанзад минь үнэхээр ховор, Сонинбаяр ламтны утгачлан айлдсанаар “Тэнгэрийн мод” авай.

“Ялгуусан эрдэнэ”

Утас дуугарав.

-Би Жанцанноров гэдэг хүн байна

-Чи хүн юм уу?

-Биш юм уу?

-Би чамайг бурхан гэж боддог шүү...

Тиймээ. Жанцанноров шиг авьяастан бол бурхан. Урд нь би олны жишгээр даргыг бурхан гэж боддог байлаа. Гэтэл тэднийг чөтгөрийн садан гэлцээд миний сүжиг сэжигэрсэн юм. Дарга болохын тулд дээд ноёндоо дэлэгнэх ёстой гэнэ. Ингэж л мах цусанд төрсөн хүний үр бузардан өөрийгөө тойрсон худал хуурмаг зусар зуурмагийн хаяавчтай болж, бурхан дүрэвсэн зайнд чөтгөр шулам шүглэдэг гээд байгаа юм. Энд бүх юм байх боловч гагцхүү “Үнэн” орогнолгүй нь ортой л болов уу. Иймээс авьяасаараа алтарсан хүмүүсийг бурханчилъя.

Хорьдугаар зууны соёл урлаг, утга зохиол, шинжлэхүй ухааны бүх бурхадын гэгээн дурсгалын өмнө сөгдмүү би.

Нацагийн Жанцанноров бид хоёр хаяа хатгасан нутагтан. Тэдний Сангийн далай хэмээх нүдэн нууранд намрын түмэн хун чуулж цавцалзан давалж байх нь бишрэм сайхан. Тэр өнгө, эгшиг хоёр Жанцанноровын сэтгэлийг сүлж яруусгасан буй за. “Мандухай”, “Чингис” киноны хөгжим, морин хуурын чуулгад зориулсан бүтээл, аялгуугаар аван хайлсан дуунуудад автахгүй байхын аргагүй.

Жанцанноровын бүтээлийг ойшоож төрийн шагнал хоёронтоо хүртээсэн. Анхных нь “Мандухай” кино бүтээгчдэд олгосон болохоор дундын найрны дугараа болсон. Хоёрдох шагналынхаа талыг морин хуурынхандаа хишиглэсэн. Чанга атгалаа гэхэд чамламаар байгаа биз. Бас мялаалганд дөрвөн саяар түлэгддэг юм гэнэлээ. Хэцүү сайхан гэх үү дээ. Төрийн хайр нь алдраас гадна амин зуулгын алсхан хаялгатай байгаасай. Найраа, дайраа хоёрын алинаар ч начин болсон хэн нэгэнд унах тэрэг, суух байраар гар цайлгадаг болж шүү дээ. Тэгэхэд сайдын жип-ний тал үнээр сайхан авьяасыг тэтгэхэд эх орон хотойхгүй. Гагцхүү оюуны бүтээлийг үнэлэхэд ордны дээвэр намхан юм биш байгаа?

Төрийн одон сэлтийг төмөр л гэх болж. Төмөр байтугай мод ч байсан их эзэн хааны удам төрийн хишигийг дордолвоос өөрийн өлмий өлтрөнө.

Хэн нэгэн Лучано Фавороти, Майкл Жексон гавьяат биш л гэнэ. Яадаг юм бэ. Адриатикийн тэнгисд уйлан унаж, Арлингтонд унтахгүйгээс хойш аль бүхнийг дууриаж алцан тэх болох юм бэ. Орон нутгийн болжмор оцон шувуу дууриавал туйлд хүрэлгүй дусал мөс болно шүү дээ.

Улсынхаа иргэнийг хөхиүлэх, цээрлүүлэх нь төрийн эрхэн дор буй. Гагцхүү цээр нь цэхийгүй, хайр нь хагасгүй болвоос төрийн сүлдэнд сүслэх сэтгэл бадрана.

Энэ бүх санааг Жанцанноров надад хэлсэн юм бишээ, би түүний нэрийг дөрөөлж нэхэл хатуурхсан нь болой.

Би Жанцанноровт “Чиний бүх эрхийг хэвээр үлдээж, гагцхүү өвдөх эрхийг хаслаа” гэж хэлдэг юм. Ховрын нэгэн учраас тэр. Эрдэнэ гээч элбэггүйдээ л үнэтэй.

Жанцанноров хэмээх нэрийг монголоор тайлваас ялгуусан эрдэнэ гэсэнтэй утга учрах аж. Харин тонгоруулваас Норовжанцан болно. Бээлийн хүрээнд ийм нэртэй ширээт ламтан байгаад ширвэгдсэн юм гэнэлээ. “Говийн Лха” бурханы хүлэгтэй зүс нийлүүлсэн зээрд халзан морь унадаг байж. Сүүлдээ халимаг тавьж “Опел” дугуйтай дарцаглаж явсан ч гэдэг. Нутгийн хөгшчүүлийн шивнээгээр Жанцанноров бол тэрхүү ламтны сүнс буюу хойт дүр гэлцэхийг би сонссон. Тэгээд л сайхь ламтны нэрийг сангийн лам Балбар гэлэн хайрласан бололтой юм билээ. Ямар ч атугай их ламтны сахиусыг тэрвээр шүтээлэн зүүж явааг би мэднэ.

Мөхөс би авьяасыг атаархах бус, шүтэн бишрэгч. Нацагийн Жанцанноров бол “ялгуусан эрдэнэ”.

Түүнийг бурхан гэснийхээ төлөө би түм байтугай нэгээхэн ч бурууг эс хүлээюү.

Тамгатай хутагт

-Содном чи битгий ярь ядарчихна. Пүрэвдоржийн ярихыг чагна!

Энэ бол ерөнхий сайд бөлгөө Пэлжидийн Гэндэнгийн охин цуутай их эмч Цэрэндулам гуайн зарлиг. Нэгдсэн хоёрдугаар эмнэлэгт өөдөөс харсан хоёр өрөөнд академич Намсрайн Содном гуай чилээрхэж, би ялархаж хорвоогийн хэд хоногийг хороосон юм.

Би хэдийвээр нутагсаж Цэрэндулам гуайг хүндэтгэх боловч Содном гуайд сонсгохоор юмгүй тул эгчийн үгийг эс дагасан буруугаа хүлээнэ.

Содном гуай бол мэргэжлийн явцуугүй, мэдлэгийн цараа ихтэй том эрдэмтэн гэдэгт биширсэн зөвөө ч бас хүлээнэ. Тэрвээр эцэг нь багш асан агаад Ц.Дамдинсүрэн гуайг түшиж номын мөр хөөсөн нь түүнд гэгээрлийн машинд өлзий болсон юм билээ. Уснаас ус, галаас гал эх авдаг билээ.

Би хүндэт бууралд дурсгасан ном дээрээ “Монгол улсын шинжлэхүй ухааны тамгатай хутагт Н.Содном, энэ хэр зарлиг саатсан эрүүлийг хамгаалахын гавьяат Г.Цэрэндулам гуай нарт” гэж бичсэн. Энэ бол миний сүжиг санааны хураангуй.

Бидний нэгэн удаагийн ярианы сэжүүрээс өлгөж Н.Содном гуайн таталсан нэгэн хуудсыг би гар эхээр нь хадгалж байдгаа уншигч авгай танд толилуулъя.

Өлгөц

Манай эрин, хүний эрин...

Христос мэндэлсэн оныг он тооллын эх болгон Христос мэндэлсний (ХМ), христос мэндлэхээс өмнө (ХМӨ) гэж ялган тоолдог заншлыг дэлхий даяар хүлээн авчээ. Жишээ нь ХМ 1914 онд дэлхийн дайн эхэлсэн, ХМӨ... онд Пифагор мэндэлсэн гэх мэт. Гэтэл 1917 онд Орост октябрийн хувьсгал гарахаар большевекууд шашингүй улс тул христосын мэндэлснээс хойш, урагш гэж хэлэхэд зохимжгүй гээд манай эриний (МЭ) буюу манай эринээс өмнө

(МЭӨ) гэж хачин нэрлэсэн юм. Оросуудыг манайхан (түүхчид л) дууриагаад бас манай эриний өмнө, хойно гэх болоод дасжээ. Гэрэл Чингис хаан аз болж манай эринд төржээ. Харин бурхан багш МЭӨ буюу хүний эринд төржээ.

Энэ бас хачин. Иймд бид Христосхынхон дагаж ХМ онууд (англиар AD буюу христосын жилүүд), ХМӨ онууд (англиар BC буюу Христосоос өмнө) гэж бичмээр байгаа юм. Эсвэл Христос бидэнд хамаагүй гэвэл бас нэг аргацааж нийтийн тоолол (НТ) гэдэг нэр оруулж, ХМ оныг жишээ нь НТ-ын 1911 он гэх юм уу, НТӨ төдөн он гэж бичвэл боломжтой мэт.

Уул нь бурхан багшийн мэндэлсэн оноос ч юм уу, Аллахын мэндэлсэн оноос эхлэж болно. Харамсалтай нь даяарчлалын үед дэлхий нийтээр хэрэглэж буй он тооллыг хэрэглэхээс өөр яахав гэсэн энэ саналыг НТ 2001 оны 12-р сард бичив.

Н.Түүбиш

Гарын үсгээ “Н.Түүхчбиш” гэж бисэнээ товчилж “Н.Түүбиш” болгосон юм.

Эл бичил таталбар бол их эрдэмтний гар бичмэлийн эцсийнх ч байх юуны магад тул номоо чимэглээд үр хүүхдэд нь үлдээх болно.

Цасан дээрх нь арилавч цаасан дээрх хүний мөрийг хадгалах учиртай. Түүнийг мөшгөн он цагийн алгасалд түүвэрлэснийг намтар гэдэг. Хаяхыгаа түвдэхгүй атал, хадгалахыгаа тээршээсэн бидний мөчиглөл даанчиг тачирхан аа!

Шувууныхан

Шувуу бол газрын эрхшээл тэнгэрийн эзэгнэлтэй. Гайхамшигт хос жигүүрээр элин халих түүний байгалийн заяа л хүмүүн төрөлхтөнд нисэх сэдэл ургуулан эрх чөлөөний гэгээн мөрөөдлийг буйлуулсан гэж санана. Миний багад нутгийн буурлууд “Бэртсэн хун шувууг намар ижлээсээ хоцроход нэгэн айл додомдон хавар нь нисгэжээ. Хойтон жилийн хавар нь тэр айлын тоонон дээгүүр хун шувуу эргэлдэж байгаад тогоотой сүүнд нь хэлхээтэй сувд унагажээ. Түүнээс хойш ховор хоосон явар ядуу тэр айл өөдөлсөн...” гэж домог хүүрнэдэгсэн. Ачийг хариулж ачлахын ухаарлыг энэ домог надад өгсөн юм. Энэ ч бас хэлхээ цагаан сувд.

Хиад Боржигин овгийн сүлд нь цагаан Шонхор. Энэ нь манайхны “урт дурын хүмүүс” гээд байгаа “Зоргоор хүмүүсийн” зориг санааны бэлэгдэл байж мэднэ.

Тэрхүү аархсан чөлөөт хүмүүс амьдрах тэмцэх хүчтэй, алсыг харах ухаантай байсан нь гарцаагүй. Эс тэгвээс бүүр хүмүүсийн бүрлэг, аймаг ханлигийн адаг байхсан биз ээ. Энэ ухаарал бол эрх чөлөөний эрдэнийн хэлхээ.

Манайхан хаяа дэрлэхийг айлсах, аяны ганзага нийлэхийг гал гэдэг. Одоо цагт орон хотын чулуун оромжноос хүмүүс үе үесхэн хэсэг бусгаар дайжиж байгал эхийн өвөр дээр тарвалзахыг хичээх болжээ. Ийм гал тоо алдсан нь мөнөөх “Зоргоор хүмүүсийн” улбааны ойр зоргын шижим гэж болно. Бидний хувьд бичил галаа “Шувууны баяр” хэмээхээс өдлөж

“Шувууныхан” гэж нэрлэсэн юм. Суурьшлаас хүн их юм олж, бас бага ч үгүй юмаа алддаг. Уурын дулаанд хэврэгшиж, утаа униарт мэнгэршиж, ажлын аргамжаа тойрч сульданд, айлдаа ч шагайхгүй явцууран, хэрэгтэй хэрэггүй мэдээлэлийн хэл аманд ороолгуулж суух гэдэг жаргалд умбасан зовлон. “Би” хэмээх бодгалаа олж авсан тэнгэр, газар, усны гурмаслалд бие сэтгэлийн таавыг эдлэхээр “шувуучлах” нь ангижрал. Онгон дагшин байгалд оюуны утаагаа гөвөхөд орчлон өөрийнхөө өнгөөр харагддаг билээ.

“Шувууныхны” бүлд анхны ерөнхийлөгч П.Очирбат, гэргий Ш.Цэвэлмаа, элчин сайд Ц.Гомбосүрэн, гэргий Д.Сүрэнхорлоо, Д.Цахилгаан, гэргий М.Гапилмаа, “Скай плаза” компанийн захирал Д.Баасандорж, гэргий Б.Жаргал дээр нь Н.Чанцал бид хоёр холбоосоод таван айл. Бидний аян зам алслагүй ч унасан газар угаасан усаа амьсаж дээдсийн хайрласан эх нутгаа сүжрэх сэтгэлийн шимийг хүртдэг юм.

Хан Хэнтийн номин татуурга гурван Баянд Зуугийн булгийг дуугаар уяраан даргиаж явлаа. Эрэг дээр нь эхийн тухай дуу аялахад бүүвэйд тайтгарсан шиг мишилзэн ундардаг юм билээ. Энэ бол Шаравын Цэвэлмаагийн төрсөн нутаг. Сайхан нутагт төрсөн хүн санаагаа тэндээс цайлгасан биз ээ.

Анхны Ерөнхийлөгчийн маань нутагд дүүжимхэн учир энэ хэр бидний шувуудын бичил жигүүр хүрээгүй. Хол ойрын алинд ч түшиг болдог, хоймор хатавч хоёрын хаана нь ч сууж чаддаг, энгүүн эвсэг, газарлаг мөртөө тэнгэрлэг, азтай бас хүчтэй хүн бол гарцаагүй Очирбат мөн.

Монгол төр түүнд Чингис хааны одонгийн дээжийг хүртээсэн нь төрийн мэлмий хүнээ таньсан хүндэтгэл бахархал байв.

Миний бие одон мялаасан олны найран дээр, “Чингис” шүлгээсээ хэдэн шад уншаад хойноос нь угсарч

Очирбат-Цэнхэр тэнгэрээс Отгонтэнгэрт унаагүй

Очирбат-Цэцгэн дундаас Цэвэлмаатай ургаагүй

Очирбат-Алтан ургийн хойморт

Амтаг суварган бялуугаар тансаглаагүй

Очирбат-Алаг адууны хаяанд

Төмөр нүүргүй, дөчин таван гуталгүй төрсөн юм

Ямар ч байсан энэ хээгүй монгол хар хүн

анхны ерөнхийлөгчийн сэнтийд заларч

Явцгаая таминь ээ бар больё гэж

ард түмэндээ хэлсэн юм

Эрх чөлөө тусгаар тогтнолын

үндсэн хуулийг баринтаглаж

Эх орныхоо түүхэн дээр

ардчилал гэж бичсэн юм... гэвээ.

Энэ хэдэн мөрөнд би эрхбиш өөрийн санааг инээмсэглэн нийтгэсэн гэж бодно.

Монгол орон минь үлэмжийн сайхны суу юм даа. Өглөөний нар аяганд эрхэлсэн хээрийн цай, үдшийн сар хундаганд бишүүрхсэн сархадын дугарааг гүйцэх амттан юусан билээ. Бид аян замд ижилсэж аандаа ч гэх үү гарсан хуваартай болсон юм. Өглөө эрт тогоо шанага хангинуулж хэл аманд Цэвэлмаа бид хоёр өртөнө. Айргийг Гомбосүрэн шинжинэ. Ууж боломгүй бол ус голсон тэмээ шиг уруулаа сэгсрээд буцаад явчихна. Аяны дугараа ирвэл Гапилмаагаар нүүр тахлана. “Хөөрхөн борлог” гээд дуулахыг нь сонссон хөдөөнийхөн цагаан идээгээ зөөнө. Өрөм тараг авгай хүүхдийн өмнө, өөх бол Цахилгаан, Баасандорж хоёр цааш харуулна. Ерөнхий тогооч нь би. Хомоолтой, холтостой нь холиод хуураад, хайраад ганц нь ч нэр өгч чадахгүй гал дээр тонгочсон, гахай хүн хоёрын хэн нь ч идчихээр нэг юм хийчихнэ. Миний туслах Жаргал. Хүүхнүүдийн цуглуулсан “юухан хээхэн” гэх амны зугаа ходоод хохироож ширээ баясгана. Энэ бүх эмхгүйн дунд бид хүн агаархахгүй гэхэд өөрсдөө чамлахааргүй жаргадаг юм.

Монгол нутаг минь. Хаана нь ч очоод хэвтсэн хажууд дэндүү их зай гардаг. Энэ нутагт, эргэх буцахын ээлжинд төрсөн маань эцэг тэнгэрийн таалал буй за.

Өвөрхангай нутгийн хүү Гаваагийн Батхүүгийн яармагт босгосон хурдан морины чимэгт самбарт

“Тэмүүжиний удам мориндоо жигүүртэй

Тэнгэрийн дор Монголдоо жаргалтай”

гэж би бичиж өгснөө санаж байна. Өөр хаана жаргах гэж? Надад бол нартын дор ганцхан миний Монгол.

“Шувууныхан” газар дөтлөж миний төрсөн нутаг Өвөрхангай аймгийн Бүрд суманд очиж билээ.

Харлин, Жаргалант голын бэлчирт саатаж Их Монгол уулын энгэрт Өндөр гэгээний ширээлсэн газар, Улаанбаатар хотын голомтонд мөргөж Эрээн уулын Хажуу худгийн буурал хондонд дээж өргөж явлаа. Энэ бол миний унаган нутаг. Усны нь ундаргыг шимсэн ч уулынхаа сүрийг би авч чадаагүй юмсанжээ.

Хархорумын чанадхан Орхон голын “Бага хүрээ” хэмээх тохойд уулын голын урсгалд уяран

Цэвэлдорж (нутгийнхан нь Гэээгт гэнэ) хэмээх... “хүнд гарын” эрийн хөхүүртээ дуулах шахсан айрагнаас шимж суух маань эр хүний эзэнтэй хээрийн жаргал байлаа.

Зуны шөнө Хархорумын тэнгэр ширтэн бодолшихуйд хоёр загал морь газраас хөөрөн алтан гадас одны аргамжаанд ижил хоёр од болох шиг. Сэрвэн хадтай уулын хэцээс Чингис хаан хөх чулуу атган Орхоны хөндийд шавлахдаа “энд их балгадыг үүдтүгэй” гэх нь сонсдох шиг... Одод гэнэт дэгдэн чуулж огторгуйд соёмболон гялбалзах шиг... Ерөөс соёмбо бичгийг “өөрөө гарсан” “огторгуйд харагдсан” гэдэг санааг дагасан ч юм уу? Гал, нар, сар мөнхийн дөрвөлжин хэлбэр нь бат бөхийн, хүрдэн дугуй дахь хоёр загас арга бэлгийн бэлэгдэл шиг... Харин уруу харсан хоёр гурвалжин нь Жагарын номонд заадагаар ус гэвээс амьдралын орчин иж бүрдэх шиг... Өндөр гэгээн Түвд, Жагарын судар шүүрдэн энэ бүхнийг цогцлоож буй нь харагдах шиг... сэтгэл уужлан ухаанд ургах юм билээ. Энэ нутаг Цэрэнпилийн Гомбосүрэнгийн “эдлэн”. Тэрвээр ном дор мөргөхийн үүдийг эндээс сөхсөн буй за.

Энэ хорвоогийн гайхамшиг нь шүтэн барилдлага мөн. Утга зохиол урлагийн суут бүтээл нь хүний бодол санааны эрхэнд үл автах түмэн гэхээр холбоосон нууцлалын учгаас ургуулсан өвөрмөц дуурьсал мөн. Уран бүтээлч хүн ертөнцийн тогтолцооны ид шидийг танин мэдэхүйн эрэлд өөрийгөө олж бас алддаг. Аяны алжаал тоос хоёроос урлахуйн ухаарал уургалаваас алтан шар замын өлзий болой.

Шувуу бол эрх чөлөөний үггүй дуун. Шувууныхан шувуу биш чиг хүсэл мөрөөдлөөр галын захаас тэнгэрлэдэг юм. Энэ бол эх оронтой азтай хүмүүсийн орон зайн алслал. Хойч үе маань хол ойрын аянд хормой сэнслэж сайхан эх орноо санаандаа багтааж аваасай. Үндэсний бахархал үүн дээр ургана.

Хуримын ерөөл

Нугас жаргахад нуур инээдэг гэнэм. Харь газар нутгийн хүү сайн явахад халуун агаад хар элэгний талцаа арилах юм. Улсын заан Долгорсүрэнгийн хүү Дагвадорж арлын Япон оронд “Асашёрую” хэмээгдэн сумо буюу манайхны хошигнодогоор “мантуун бөх”-ийн аварга болоход бүхний сэтгэл бэлчих нь таатай байв. Үндэстний санаа ийнхүү нэгэн үзүүрт нийтгэгдэх нь үйлс тэгшрэх нигууртай.

Улсын заан Долгорсүрэн хэмээх бүсгүй нэртэй бүтэн эр хүнтэй би вээр ус нутгийн залгаагаар урагсаж танилцсан юм. Дөрвөн туурайтын нуруунаас тэрвээр дөрвөн дугуйтын бүхээгт сандайлсан тээврийн жолооч. Долгорсүрэн Хархорин ороод ирэхэд арван тав хоногтой гэдэг байв. Арчаагүйдээ юм уу ачаа бараа саатсанаас бус айрганд аргамжуулдаг хүн. Хуруудаад уухад хулны зөрөөнд шаагдах эр бишээ.

Долгорсүрэн өөрөө бөх удамтай Донров зааны хүү бол 1934 онд улсад түрүүлсэн Архангай аймгийн “Өөлдийн улаан хүзүү” хэмээх Дэлэг арслангийн ураг Пүрэвбадамтай дэр нэгтгэн дөрвөн хүүгийн зулай үнэрлэсэн нь Сумъяабазар, Сэржбүдээ, Дагвадорж нар аж. Учиг тасарвал залгаасгүй, ураг барилдвал залгамжтай нь үнэн ажаам.

Дагвадоржийн хурим Их тэнгэрийн амыг бүчсэн магнай найр бас найрсал байв. Хоёр хос, морьтой ирж тулганд гал үүсгэн, нум эвшээлгэж, морин хуураар жавар үргээх нь сонин

сайхан байсан юм. Аваргын аав ээж, хадмууд, ах дүүс, анд нөхдөөс гадна улс төр, урлаг соёл, спортын алдартнууд цөм бүрдсэн юм. Би өөрийн хавийн чандмань гурван ширээг санаж байна. Манай ширээнд ардын жүжигчин Гомбосүрэн, Лувсаншарав, Гантөмөр, Очирбат, ардын зохиолч Сүрэнжав, Баруун ширээнд ардын жүжигчин Цогзолмаа, Хайдав, Жаргалсайхан, Жамсранжав, Цэрэндагва, хойт ширээнд аварга Мөнхбат, Цэрэнтогтох, Балжинням нар байлаа. Ховор л учрал.

Дуу хуур, наргиан, доргион дундраагүй. Би УИХ-ы гишүүн Очирхүүг өдөсхийж,

-Өвөрхангайнхан мундаг байгаа биз гэхэд тэрвээр,

-Тийм байна. Аз жаргалаа Говь-алтайгаас олдог юм байна гэж ам таглав. Шинэ бэр Тамирын аав Гомбоцэрэн алтайн унага юмсанж. Үүнээс үүдэн:

-Арвайхээрийнхэн, адуу малыг

Аймаг бүхнээс авдаг

Авгай хүүхнийг хааяа

Алтайгаас олдог... хэмээсэн бадаг үүсэв.

“Эрэл”-ийн хэмээх Эрдэнэбат, хатагтай Сэргэлэн хоёртой хундага золгуулахдаа

Эрлийн үзүүрт эрдэнэ

Эрдэнийн үзүүрт Эрдэнэбат

Эрдэнэбатын үзүүрт сэтгэл

Сэтгэлийн үзүүрт Сэргэлэн... хэмээсэн миний наргиан илүүдсэнгүй.

Манай аймгийн жавхлант хоёр охин, найрагч Ичинхорлоо, дуучин Ариунаа, хоёрын нөхөр Товуудорж, Буяндорж хоёрыг “Адтай хоёр охиныг минь аятайхан авч явах ашгүй сайн нөхөр заяажээ, азаар та хоёр минь таараагүй бол аль зүгт алдах байснаа мэдэхгүй” гэж хөхүүлэн хадамсав. Уран бүтээлээ асаж амилж хийдэг нүд сэтгэл гялбаасан охидын минь онгодын тэнгэр цэлмэг байг аа!

Эх орноо эзэгнэсэн тэнгэрлэг дээдсийн сүнс сүлд биднийг өршөөг.

Өвтэгш сайхан хуримын өлзий бэлэгдэж аминдаа зөв хичээн айлтгасан ерөөл минь бат оршиг.

Гомбоцэрэнгийн тамир нарт

Зэ, найман зууны тэнгэрт

Нар сартай мандсан

Эзэн Чингис хааныхаа

Эрднийн цагаан сүлдэн дор мөргөөө!

Өдөр судар нь заллагатай

Өгөөж буяны даллагатай

Өнөр хуримын үүсгээнд

Өвөрхангайн учралаар

Өвгөн шүлэгч намайг

Өлзий түвшилж ерөө гэсэн юм биз ээ

Зэ, энэ найрыг хойморлосон

Эзэн Дагвадорж гэвээс

Харайгаад гарах нь арслан шиг

Харваад дайрах нь хангарьд шиг

Харахад сүртэй нь луу шиг

Ханьсхад номхон нь заан шиг

Ивээл дөрвөн хүчтэний

Ид хав тэгшэрсэн

Их аврага Екузоно

Асашерюу юм байна.

Энэ л манлайн дээд

Эгнэшгүй их аваргын

Эцэг удам гэвээс

Улсын манлай заан Долгорсүрэн

Эх Пүрэвбадамын ураг гэвээс

Улаан хүзүү Дэлэг арслан

Төө зайгүй

Төрсөн ах нар нь гэвээс

Төмөр гарьд Сумъяабазар

Идэр начин Сэржбүдээ гээд

Хүрээ хөдөөгүй

Хүй залгасан

Хүчтэн овгийхон юм байна.

Энэ хуримын

Эзэгтэй гэвээс

Эцэг Гомбоцэрэн

Эх Эрдэнэчимэг хоёрын

Энгэрээс олдсон

Эрднийн цагаан сувд

Эрх хатагтай Тамир юм байна

Зэ, энд морилсон

Эрхэм зочид нь гэвээс

Улс төрийн өрлөгүүд

Улаан шар хуврагууд

Ухаан гийсэн мэргэд

Урлаг соёлын бурхад

Алсын Япон андууд

Аралтай бяргай бөхчууд

Аргатай бэлтэй боссууд

Айл гэрийн миссүүд

Уянгалаад хаддаг дуучид

Урсгаад дагадаг хуурчид

Угалзлаад нисдэг бүжигчид

Уралдсан нь түрүүлдэг уяачид

Аймаг сүмын элчүүд

Анги танхимын найзууд

Ахан дүүс хотлоор

Адбиш сайхан тэгширсэн юм байна.

Зэ, газар дэлхийд илчтэй

Гал голомтоо бадрааж

Гандах нь үгүй итгэлээр

Гар гараасаа барилцаж

Эх орондоо өрх татаж

Элгэн түмэндээ үүд сөхөж

Эзэн эзэгтэйн дэр нийлсэн

Эрхэм хоёр дүү минь ээ!

Аз жаргал чинь хайрандаа

Амны хишиг чинь ханиндаа

Алаг үр чинь хамтдаа

Аав ээж чинь хажуудаа

Азын тэнгэрт тулсан

Айлын багана тэгшхэн

Алдрын манлайг олсон

Алсын зам саруулхан

Банзүкээг титэмлэж

Бат итгэл тэнгэрлэж

Башё бүхнийг тэргүүлэж

Баярын магнай тэнийлгэж

Орхон түшээ гүн шигээ

Олны хайраар урсаж

Онгон дагшин уулс шигээ

Омог бардам оршиж

Улам улмаар ундрахын

Удам удмаар ургахын

Учрал бүхнийг бэлэгшээн

Хамаг олны сэтгэлийн

Хайрын цацалтай ерөөлийг

Хадаган дээр хурайлан

Эцэг тэнгэр

Эх газрын

Эрхэм дээд соёрхлоор

Дэлхийн сонорыг мялааж

Дээш дээш нь

Дэлгэрүүлэн дэвшүүльеэ!

2004 оны 8-р сар

“Уцаарлал бичээс” хэмээх хаялага бүлэг

Намбардагва бол миний хувьд Нажиддагва юм. Түүнд би нэгэнтээ:

-Чи муу хөшнийгөө ээрхээ больж үз гэвэл.

-Гонжийн дог. Миний үгээр чих чийглэх хүн чамаас өөр байхгүй Одоогийн овгорууд чинь өвөөлж толгойлчихоод харийн хүний амаар гүүглэдэг юм биш үү. Хүн хорхойрхуу юм уу даа.

-Ямар хорхой гэнээ.

-Үзсэн биш. Шилбүүр далайхаар өвс бариуд өөдөөс цогнойдог амьтан байдаг гэж дуулсан.

-Эсэргүүцэж байгаа нь тэр үү.

-Үгүй ээ, дууриаж байгаа ухантай юм гэнэ лээ.

-Хүн хар гөрөөс л гэж дуулсан юм байна.

-Тэр алмас шулмас чинь амьтны бараа хардаггүй юм гэх чинь билээ. Би хүн хорхой яриад байна.

-Би ямар шавьж судлаач биш.

-Гонжийн дог. Хар ялаа шиг хааяагүй язганаж байгааг харахгүй байна уу.

-Тэгвэл би бас хүн хорхой юу?

-Хомоол барьвал хоргол шүүрэх байлгүй.

-Чи өөрөө?

-Би бол сохор хар хорхой.

-Уур нь хүрэхээр хоншоороо газар шааж, бөгсөө дэндийлдэг үү.

-Тийм ээ. Тэгээд л хүн хорхой гээч санаанд ороод уурандаа сохор хар би бөгс цондоглож байгаа хун даа.

-Би чиний уурыг яаж гаргах гэж?

-Чи энэ бух ч юм уу бяруу ч юм уу дарга нарын хамрыг сөргөөгөөд өгөөч.

-Тэднийг чи мөгөөрсөн хамартай гэж бодоо юу.

-Хамар ч гэж хад л даа. Гэхдээ гортон гаргавал гол нь ирвэгнэж магадгүй гэж горьдож байгаа чух даа.

-Амьдралын ахар сүүлэн дээр чи намайг аяга цайнаас салгах гээ юу.

-Гонжийн дог. Дарга харахаараа далбин шанага шиг дотроосоо асгачихдаг чам шиг хүн айх нь аргагүй.

-Чи яахаараа тэднийг нүд үзүүрлээд байгаа юм бэ.

-Тэд чинь мань мэтийг насаар нь хуйлруулж элдээд эвэр зоож сүүл наах л үлдлээ.

-Тэгээд яах гэж?

-Бидний багад номонд бузгай жаалыг “толгойтой хүүхэд” гэдэг байв даа. Тэд нь хаачдаг байна.

-Эрдэмтэй нь номоо хөөж тэнэг нь дарга болдог гэх гээ юү.

-Тэр бүр биш гэхэд тэнэгдүү нь голлодог юм биш үү.

-Төрийн төлөө төгцөг боож үхээд яахав дээ.

-Боож үхэх гээгүй боолгуулж үхэх гээд байна.

-Гарз нь гавахгүй юм шив дээ.

-Ортой үг гэснээ Гонжийн дог таг дуугай болж гөлөрөн енгэнэтэл санаа алдаж билээ.

Би түүнийг тайтгаруулах санаа өвөрлөж явсаар “Бичмүүн”, “Манай даргын зөв” гэсэн хоёр холгоос бичсэн учир ийм. Гэвч түний санаанд хүрээгүй тул “Мал барагдахад зэмс, маани барагдахад шүлс” л юм даа гэж чамласан. Ер түүний өдөж сөдсөн санаа олон боловч миний уран бүтээлч загалгаа дутсанаас элсэнд асгасандаа гэмшил өчье. Уран бүтээлч загалгаа! Энэ бол хэрэгшээх ёстой үг. Амьдралын алтан агшин, уран санаа үсрэх оч, сэтгэлийн сэвэлийг сэтгэхүйн гүнд тунгаах авхаалжийг бүтээлч загалгаа гэж бүдүүхэн тоймлож болно. Үүнийг алдаж болохгүй гэдгийг үргээж хулжаасан нь тоо алдсан бүтэл бүрхэг би вээр залуу зандан нөхдөд захья.

Миний муу бэлэн зэлэн балан цалан найз Намбардагва төрд төө хүрэхгүй чиг эх оронч сэтгэл эмзэглэж эрэгцүүлж түүнийгээ монгол хэлийг яргуйчлан өгүүлдэгт нь би биширч ясны монгол “Би” хэмээн хайрладаг юм шүү.

Одоогийн хэл хэлтлээчид түүний дэргэд ёстой шушмаанууд. Урдын цагт цагаач хятадууд монгол хэлэнд молхийн учир хүний хэлснийг эс ухааран “Шүо шамаа” буюу “Юу гэнээ?” гэж эргүүлэн шалгаадаг аснаас манайхан хазгай хэлтнийг ийнхүү хочлох болсон юм гэнэлээ.

Өнөөдөр иймэрхүү шушмаанууд нь бид өөрсдөө болж буй нь улс гэр ураг удам алс хойчоо хэмээх унаган монгол “Би”-гийн зүрх шимшрээж буйг дөрлөн ялгуун хүлэгт Намбардагватайгаа явгачуулыг жишиж “тулгын чулууг хөдөлгөж болохгүй” гэсэн цэхвэлзэл хэвлүүлсэн. Үүнээс үдэн бага үндэстэн “шушмаар ч” унаган хэлээ эвдэх нь уруудахуйн урсгал

гэдгийг олон хүн омогдуухан зэмлэсээр байна. Энэхүү зэмийн тухай Цицероноос иш авьюу гэтэл дэндүү холдоод мунгинаж суутал нэг зохиолч нөхөр маань “Мэдэх нь мэдээд мэдэхгүй нь мэрэгжилтний үг гэж бодог. Манайхан чинь гадаадынхны өөдөөс ганхийдэггүй” гэж явгарсан зоригий минь ямаан омоглов.

Эрт балрын Римийн мэргэн цэцэн Цицерон манай он тоололоос өмнө “эхний зэмийг эрхээж болох чиг хоёрдох нь холгож, гуравдах нь шархлуулж дөрөвдөх нь хөнөөнө” гэсэн үгийг олны зэмийг ойшоолгох санаатай оосорлож авчрав.

Эл бүхнийг эрэгцэн бичиглэж буй маань номын “утгал” бүлгийн “Би”-тэй хүй хэлхээтэй агаад үндэсний үзэл, ухаан, сэтгэл мэдрэмж бүхий “Монгол Би”-г түүхийн үрчлээний түйвээлээс хамгаалах гэсэн халаглал авай.

Миний бие шог зохиолын дүйгүй, хүүрнэлт зохиолын хүйгүй боловч уншварыг хөтлөхийн улмаас хошигнолын шижмээр эрхэмсэг уншигч таны тэнгэрлэг бодгалийн тунгаалд холбон чимээлж чих дэвсэе.

Олон түмний оюун санааны цор ганц цутгал нь монгол эх оронч үзэл мөн. Энэ бол “Би” бүхний тулах цаг. Үүнд багад суурилан үндэсний уламжлалын хөрсөнд ургахуйц шинэчлэлийг ухаан, зориг, хүчийг гурмаслан урагшлахыг шавдуулан мохолхон бичээч би өөрийгөө толхисон юм.

Улирсан лай, нүүрлэсэн гайн аль бүрт түүртэн, балар тавилан, үйлийн үрд сөхрөх нь хэн нэгэн хүний цөхрөл байж болох чиг, улс олны хувьд хатуу цээртэй. “Болдог юм болдгоороо боллоо” гэж хэнэггүйтхээсээ “ёстой юм ёсоороо байг” гэсэн нэгэн мөрийн хичээлд дэм, зэмийг бодоосой.

Оюуны залхууд автан бусдыг өвчин дууриах, утга соёлоо ухааралгүй харьд харалган дэлүүрэх, эрх тушаалын үүлэн чөлөөнд эргүүтэх, бас тавилан хэмээхэд барлагсаж, төөрөг зураг гээчид төөрөн өөрийн “Би”-г өчиггүй золбилохын аль аль нь харуусам хайран. Учир гэвээс ийм хүмүүсийн дотоод ертөнцөд гайхал хар эрчим хүч орогнодог нь түшгийн мөр мөлтөрхий, харгуйн ханьсал хальтархай. Үүнд л би эмзэглэн ганц боловч бодгалийг гаргуунд гарздахгүйсэн гээд байгаа юм. Хүн бүхнийг сэтгэлийн сэвтэлгүй болгох хүсэл минь хясалтай чиг, үндэстний сүүдэр язгуур биеэсээ том байж хэрхэвч болохгүй. Энэ санаагаа сайхь бүлэгт өөчлөл гоочлолоор хөвөрдөн таны таалалтай ташаа нийлүүлэх гэж мэрийснээ өчье.

Бичмүүн

Би өөрийгөө сармагчингийн удам судар гэдэгт нэг л итгэж чаддаггүй агаад эрэгчин, эмэгчин бичийг эмээ, өвөө гэж дуудаж заншаагүй юм. Учир юу гэвээс миний элэнц хуланц, эцэг эх аль нь ч сармагчин байгаагүй, би ч өөрийгөө хүн мөн эсэхийг алдрай залуу насандаа ажаагүй явлаа. Гэтэл насны хярд элдвийг нэхэн санах нэгэн агшнаа эрт балар цагт бус энэ зуунд мань мэт нь сармагчин хэвээр үлдсэн юм биш байгаа гэж сэрдхийх нь тэр. Балчир ахуйд мэргэн өтгөс маань аливааг дууриаж дүрсгүйтэгчийг “сармагчин” шиг гэж зэвүүцдэг байснаас улбаалан бодохул бачиг миний тээнэгэлзээ учигтай бололтой.

Сармагчин хэмээх амьтан хүний аяг араншинг төсөөхөн элэглэдэг бол бид бусдын санаа сэдлийг барлан хуулах чадвараараа яах аргагүй төрөлсөөд байх шиг. Үүнийг тайлахын тулд өнгөрсөн зуунд эрээчсэн түүхийн хуудсыг сөхөж санав. Гэтэл хуудас бүрт хувьсгал, нам, эвлэл, пионер, феодалын хөрөнгө хураах, хамтрал-хомун, нугалаа завхрал, шинэ эргэлтийн бодлого, ангийн дайсан, эсэргүү тагнуул, баруунтан зүүнтэн, баривчлага хядлага, цөллөг, нэгдэлжих хөдөлгөөн, намын эсрэг бүлэг, соц болон төлөө бригад, таван жилийн төлөвлөгөө, материал техникийн бааз, соёлын довтолгоон, зорилгот программ, социалист аж төрөх ёс гэх мэт үй түмэн үгс цоохортоно. Эдгээрийн алийг нь ч бид ухаалж олоогүй бөгөөд умард хөршөөсөө улаан цайм хуулчилжээ. Энэ бүгдийг гардан барлаачдыг би “Бичмүүн” (Бич-хүмүүн) гэж нэрлэх гээд байгаа юм. Үлгэрээр зүйрлэвэл бичин цээжтэй, хүмүүн бөгстэй гэсэн шиг ёгтлол.

“Бичмүүн” энэ нэр өхөөрдөл шиг хэрнээ бас эгдүүтэй. Тоймловол хүн, сармагчин хоёрын хүй тасрах хором буюу бичийн төгсгөл, хүний үүслийн торгон хормойд төрсөн байгалийн бус нийгмийн амьтан гэсэн төсөөлөл бууна. Бичмүүнийг гаднаас нь харахад хүнээс төдий л ялгарахгүй бөгөөтөл сэтгэхүйн хувьд бусдыг дууриах цор ганц оюуны чадавхитай өнчин эст гэмээр амьтан.

Бичмүүний дүрийг бүдүүвчилбээс тэд ихэмсэг яравгар, усны тэмээ шиг уулын толгой харамхай, алхаа нь таахалзуур Сибирийн галуутай төстэй. Ярихдаа янцаглаж дүлж, хоолой засч, “одоо”, “болбол”, “но”, “дааг дааг (так)” гэх зэрэг сул үгээр чигжсэн ишлэлийг тотъчилж давтана. Дуу нь намрын хөндий яндан мэт дүнгэнэвч ухаан санаанд унахаар оновчтой үг хэлэхгүй. “Түүнээс гадна”, “давтан хэлэхэд”, “онцлон тэмдэглэхэд”, “зарчмын дүгнэлт”, “зорилт зогсож байна” зэрэг орчуулгын хуурай үгсийн хэлхээ хөврүүлнэ. Хүний нэрийг олж ядан “нөгөө хэн” гэж ээрэн дээрэлхэх бөгөөд тулж яривал “танай хүн” гэж ёврох жишээтэй. Харин харааж загнахдаа гаргууд. “Үндсэрхэг үзэл”, “ёс суртахууны доголдол”, “хөрөнгөтний нөлөөнд автсан”, “зарчимгүй”, “нуруугүй”, “далдын хорон муу санаа өвөрлөсөн”, “гэр бүлийн талаар ялзарсан”, “марксист, ленинист онолын мэдлэгээр дулимаг” гэх зэргээр есөн шидээр дуудна.

Бичмүүнүүд молхи толхи атлаа маш нэрэлхүү, бүхнийг мэдэгч царайлах дадалтай. Мона Лизаг зөвлөлтийн элчингийн эхнэртэй, Пушкиныг ишгэй тамхитай, Аристотелийг феодалтай, найрал дууг улаан эсэргэнэтэй, Канад улсыг төмөр аргамжтай, компьютерийг жимсний чанамалтай эндүүрэх нь энүүхэнд. Тэр ч бүү хэл ойртон нягтрахыг орос эхнэр авахтай хутгаж будилсан гэлцдэг. Бичмүүнүүд илтгэл тавих, тавих ч юу байхав, бусдаар бичүүлж унзадлан унших дадалтай. Илтгэл нь “МАХН-ын удирдлагаар, ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламжаар” гэж эхлээд ололт, дутагдал, хойшид тавих зорилт гэсэн жаазанд багтана. Тогтоол нь илтгэлийн товчлол байх агаад арай бага тушаалын бичмүүн түүнийг уншиж санал нэгтэй батлуулна. Тэгэхдээ энэ бүхэн нь хойд газар болсон аль нэг хурлын бичиг хэргийн орчуулга төдийгөөс үл хэтэрнэ. Ямар сайндаа Кремльд Сталин тамхи асаахад Чой-гийн хамраар утаа олгойдож, Брежнев найтаахад Бал ханиад хүрдэг гэж шивнэлдэж байхав дээ.

Хорьдугаар зууны Монгол бол Бичмүүний алтан үе, торгон сүрэг шигшрэн толгойд ассан орон. Тэд нийгмийн бүх шовгорыг эзэгнэж, умрын ухархайд углуургадсан ганц улаан

нүдэндээ үзэгдсэн бүхнийг оюун ахуйд бартаглан барлахыг шаардана. Тэд зөвлөлтийн туршлагаас суралцахыг өдөр шөнөгүй довогдож, элдэв шалдав хурлын илтгэл, тогтоол товчлуулж, хуулуулж, шалгаж, баалж шар махтай хатаана. Бичмүүн барлан хуулах ажлаа туршлага судлах гэж гоёчлон нэрлэж, улсын төсөв цацаж халыг харснаа нэвтрүүлнэ гэж тулгана. Тэр нь юу ч байж болно. Охид хөвүүдийн арван жилийн сургуулийг тусгаарлах ч юм уу, албан даалгавар, радио хурал, аттестатчилал энэ тэр гэж сүр бадруулна. Нэг нь БАМ-ыг үзээд Тасганы овоог сэтлүүлж байхад нөгөө нь метро дууриаж “хорьдугаар” дэлгүүрийн үүдэнд хонгил ухуулж л байдаг. Тэдний нэвтрүүлэх “туршлагын” хэмжээ зэрэг дэвээсээ бас хамаарна. Том бичмүүн нь Улаан талбай дахь Лениний бунхныг хараад ордны өмнө гантиг чулуун хатиг нааж байхад бага нь “Хоёр их хурал-нэг зорилт” гэсэн ямаан самбар босгоно. Бичмүүнүүд улсынхаа түүх, соёлд сохор номин гэлтэй. Чингис гэж нэг муу зандалчин байсан гэхээс цаашгүй. Монгол гэж 1921 оноос өмнө улс байгаагүй гэж хатуу итгэчихсэн учраас бүх юм ХХ зуунд бий болсноор ойн найраа хийнэ. Наадам болоход оёос нь татсан олсон торгон дээлтэй уран сайханч шиг бөхийн засуулууд “улс хувьсгалын... ой” гэж гүрээнийхээ судсыг зэлэртэл бахирна. “Амлан авч барилдаж мэдье гэвээ” гэж нэг тал нь өргөн айлтгахад нөгөө тал нь “баярлалаа” гэж гонгиноно. Уг нь нэг бичмүүн “спасибо” гэж хэлүүлэх гээд цаадуулын нь хэл ороолдоод чадаагүй юм гэдэг. Хөөрхий засуулуудад буруу юу байхав. Ер нь тэгээд амлан авч ааглан хаях гэж байхад юунд нь баярлахсан билээ. Ядахдаа “ёсоор болгоёо” гэхэд болохгүй нь юусан билээ. Энэ нь хэдий жижиг зүйл мэт боловч улам цаашилсаар үндэсний бичиг соёл, түүх, ёс заншлыг түйвээхэд Бичмүүнүүдийн байгуулсан “гарамгай гавьяаны” ганзагын үзүүр төдий юм.

Бичмүүнүүд хэн сайн хуулан барласныг туг бариулж, тушаал хөхүүлж сармагчлах өрсөлдөөнийг дэвэргэсэн билээ. Тэд өөрийн бодолтой хүмүүсийг хар дансанд үдэж, үзэл суртлын үхэр чулуугаар дарсаар өөрсдийн явцуу хүрээ буюу балар орчныг буй болгож, оюун санааг чөдөрлөсөн юм. Тэгээд ч бичмүүнүүд амьгүй албатууд учир хойд мөрийн бичигт нь “төлөв даруу” гэсэн тодотгол хавчуулдаг байсан нь гарын дор хүлцэнгүй барлаг байв гэсэнтэй адил сонсогдоно. Муу дархны үнс их гэгчээр Бичмүүнүүдийн өрөө Маркс, Лениний ботиор чигжээстэй байх боловч ширхэг хуудасны шилний цавуу нь салаагүй байдаг болохоор таргийн таван ямаа шиг тарнийн хураангуйтай зөнөхөөс яахав. Ийм “шавь нартай” хүн төрөлхтний соёлын гайхамшгийн тухай үг сольсноос үхэр туусан нь хавьгүй дээр.

Бичмүүнүүд монголчуудыг аажмаар модон цэрэг болгож, эх оронч үзэл, үндэсний бахархал, өөртөө итгэх итгэл, сэтгэхүйн алслал, сэтгэлийн гал, амьдрах чадварыг бөхөөж байв. Хүний гар харах, чин сэтгэлээс худал ярих, хоосон амлах, нүд хуурах, хэт сүржигнэх, өс өвөрлөх, өнгөтэй өөдтэйгөө хянгардах, бурханчлан магтах, бугчлан адлах, хавчлан зусардах, хаяагаа манах, мугуйдлан зүтгэх, муйхарлан шаардах нь бичмүүнүүдийн ёс жаяг юм. Асуудлыг олон талаас нь харж үл чадна. “Цаг нь болоогүй”, “манай нөхцөлд тохирохгүй” гэхчлэн аяглах нь хойш хэлж, доош малтах шалгарсан зуршил. Ус агаар шиг шүүмжлээд аль гэж уриалчихаад зүрхний эм шиг дусаахад л зүүдэндээ ч үл мартана. Өстэй толгой өнхөрлөө гэхэд авгай хүүхдийн нь амаар шороо үмхүүлж бахаа хангана. Энэ зууны бүтсэн боссон бүхэн миний гавьяа гэж цээж дэлдэх атлаа бүрэлгэсэн сүйтгэснийг болохоор бусад руу түлхэх муур багшийн үлгэр ярих нь улс төрийн явган нохойтол юм.

Бичмүүнүүдийн хувьд бухан ч юм уу, шүдлэн дарга болно гэдэг ёстой “юун наадам, юун

боодог”. Амьд явсны аз таарч алтан аяганаас рашаан хүртэх нь тэр. Үүнийгээ алдахгүйн тулд үрээ залгих цурхай болно. Элгэндээ тамга тэврэн зөнөж, эрлэгийн элчид юм уу, эсвэл улс төрийн шуурганд үрэгдэх л үлдэнэ. Гучин жил, дөчин жил удирдах ажил хийлээ гэж саймшрах нь хорвоогийн доог. Хүний эрчимд хязгаар бий гэвэл аль хэдийнэ цэнэггүй болсон буу үүрч тулаанд орсноос юуны ялгаа. Тэгээд ч дарангуйллаар гайхуулах нь ядарсан амьтны ямаан омог.

Ардчилсан хувьсгал чулуужсан дархлалыг нь эвдсэн боловч өнөө гайхал бичмүүнүүд сармагчлах авьяасаараа хойд дүрдээ хувилж, социализмаа солгойдож хаяад менежмент, маркетинг, макро, микро гэхчлэн үг урсгаж, хэзээ язааны хэнхэг капиталистаар тодорсон нь үнсэнд хөрвөөгөөд үнэг болов гэсэн үлгэр санагдуулна. Тэр ч байтугай хэн нэг нь орхимж нөмөрч, олбогт завилж, нөгөө хэсэг нь “мөлжигч этгээд”, гуравдахь нь үхсэн буурын толгойгоор үр хүүхдээ айлгах гэж үхлээ хатлаа, үйрлээ цайрлаа гэж яхирлаж суугааг нь энэ хорвоогийн эрээн тавилан л гэлтэй.

Тэнгэр минь, тэгтэл түүхийн гай ч юм уу, бидний лай ч юм уу, шинэ маягийн Бичмүүнүүд гараад ирэх нь тэр. Тэдэнд хуучнаас удамшсан хэд хэдэн шинж бийг ажиглаж болох мэт. Энэ нь юуны урьд албан тушаалын дон юм. Тэд хэрээ мэдэхгүй дээдсийн сэнтий рүү ил далд шүлэнгэтэх, улаан цайм тушаал нэхэх, ууц таллахад хажуу олдоогүй бол жагсаж зогсож, сууж хэвтэж орилолдох нь энүүхэнд. Энэ ёозоор бол Монгол Улс зуун Ерөнхийлөгч, мянган Ерөнхий сайд, сая сайдтай болсон ч дутах бололтой. Тэгэхдээ санаа байхад сачий, хүсэл байхад хясал, мөрөөдөл байхад мөхөл, мөнгө байхад хувхайрал гэж сайнд садаа, мууд мундар бий. Өөр хоорондын самуунаас өндөр Алтайн догшин бүргэд болжмор болсныг мартаж эрх бидэнд байхгүй. Арван нас хүрээгүй, амны салиа арилаагүй Монголын ардчилал эмээлийн дөрөө өлмийдөж эрийн цээнд хүрэхээр морилж явна. Оронгийн сахиусууд олбог түшлэгээ булаацалдвал овоодой ч үгүй, шовгор ч үгүй үлддэгийг сануулахад илүүдэх юун. Тэгээд ч түмний итгэлийг нэг л удаа эвдэж түүхий хүүгээр цодолбоос хутагтын тамгаа хураалгаж, хуурай жалганд хуц хариулах л үлдэнэ шүү дээ. Энэ тухай эс нэмэн өгүүлэхэд сармагчлах өвчний саа дайрч тархсаар л байна. Эрх чөлөөний буянаар гадаад далайг гаталж гандирсын балгасанд шургасан хэд нь юм үзэж, нүд тайлаагүйн балгаар харагдсан бүхнээ хамж шимж дууриана. Эсэн бусын энтертэймент, холдинг, шоу, поп, имиж, фен гэх хагас дутуу үг зууж ирээд хана туурга, хаяа хатавч, хаа дайралдсан газраа нааж нялж орхино. Үүнийгээ тэд дэлхийгээс суралцаж байна гэж дэгслэх биз.

Бичмүүнүүд эх орон, тусгаар тогтнол гэж улиглавч эр зоригийн цагт галын шугаманд очих хат байхгүй. Монголын тулд тэдний тусыг хүлээснээс модон гүүнээс унага горьдож, хөхүүрээ хагсаасан нь дээр буй за. Бурхны авралаар манайд зүс солих мэс засал хөгжөөгүй нь яамай. Хэрэв хүний өнгө төрхийг хувилгадаг бол өдийд ямар гээчийн нүд, хамартай амьтад үйлээ үзэх байсан бол. Нэр нь ч дүүрсэн хэрэг. Орос нэр орхигдож, одоо удахгүй Билл Ёндон, Ричард Баяр, Ритаро Ганаа, Ян Амараа гээд л төрөх биз. Ерөнхийлөгч нь бишгүүр үлээж, Ерөнхий сайд нь зангиагүй уулзалтад “Говь”-ийн хүрэм бэлэглэж, УИХ-ын гишүүн улаан, хөх жанч нөмөрч, “усан цэргийн адмирал” тэмээн жин хөтөлж, Улаанбаатарын цэнгэлдэхэд улангассан бух тамлах ч юм бил үү.

Бичмүүнүүд элдэв хүний нэр барьж ишлэл авч, энд ийм, тэнд тийм байдаг гэж мэдэмхийрнэ.

Үүнд нь итгэх хэрэггүй. Хүний санааг өөрийн амаар гулигаач бол тохомгүй янгиа, толгойгүй малгай л гэж мэд. Нэгэн ёжтой эр “Холдинг, концерн, корпорац гэдэг чинь улсын эдийн засаг уруудаж өгсөхийн луужин болохоос бус яндантай морь зайдалж, явуулын утас чирсэн өмбөө цөмбөө хувиараа эрхлэх аж ахуйн эздийн толгойд тавьдаг тоорцог биш” гэж омогдсон нь хорсолтой боловч үнэн үг.

Хорьдугаар зууны турш хоёр гарыг хөсөр орхиж, амандаа алтан эвэр ургатал ярьцгаалаа. Үг олдож, үхэр холдов. Үнээгээ ойртуулахгүй бол хар цайтай хатна. Өтгөс өөдөж, нялхас харангадваас үндэс угсаа хөөрхий болно. Эрхбиш шинэ аж байдал хэвшиж, эдийн засаг сэхэл авч буй эгзэгтэй үед гал алдах бус гар санаа нийлвээс хэрэг зориг дөтөлж, хэтийн зам шулууудахсан билээ. Хэвлэл сонин хэл эвдлээ л гэнэ. Далайн захаас үлийн оготно юу хороох билээ. Шар хэвлэл, сонин л гэнэ. Бас л будааны үг. Мэдээлэлгүй амьтан мэдэхгүй байг овоо хараагүй буугаар онохгүй байлгүй яахав. Нэр төр сэргээнэ гэх юм. Оргүй юмыг сэргээж болдоггүй шүү дээ. Тэгээд ч өөртөө морины бус үхрийн үнэ хаях юм. Арга ч үгүй биз. Нэртэй төртэй нэгэн нь явган зарга хийж мунхгийг алдаршуулахгүйгээ мэднэ шүү дээ.

Энэ эриний эрдэмтэн мэргэдийн од тэнгэрт нэгэнтээ гэрэлтсэн байхад юун олон од гараад ирэх нь энэ вэ гэж хэн нэгний уцаарлах сонсогдоно. Үүнд гайхах юун. Худгийн мэлхийд огторгуй тохмын төдий, овоохойд өлгөсөн лаа орчлонг таниагүй балчирт од эрхсийн дайтай харагдах нь түмэн зөв. Үүний учрыг үсээ бус ухаанаа ургуулсан цагт л ухаарна. Тэр цагт тарианы эсэнгэд эзэн хааныхаа нэрийг зүүж, тарваганы дошийг Химлайтай андуурахаа болино. Марз ууланд онгоцтой “сүйрсэн” үзмэрчид шиг бус манай гарагийн соёл иргэншилд дээвэр өргөх тэнхээ суух цаг ирнэ. Эрээний ганзагаар энэ зуунд өл залгахаас ирэх зуунд хөл залгахгүйг ухаарч, биеийг элээж, ухааныг чилээж Бичмүүний бус хүмүүний ёсоор сэдэж бүтээхийн амтанд орж таарна. Үүний тулд дээлтэй лонх юм уу, хөлтэй ходоод байхаас ичиж, дэлхийн тоосноос сугарах л үлджээ.

Хорьдугаар зуун жаргаж байна. Үхрийн сүүлэн дээр хутга тавьснаас он цагийн хөлгийн омголон зоонд тогтож, өөрсдөө хүн шиг аж төрж, улсаа улс шиг авч явах нь бидний тэнгэрлэг хувь заяа мөн билээ. Эрхэм сайн үйлсийг ёсчлон бүтээх замд улирч буй Бичмүүнүүд хааш нь ч хамаагүй чангааж уршиг тарьж, яршиг удав чиг эгэл буянт түмэн, эрдэм, ажил, соёлын дархчуул, үйлдвэр, худалдааны бүтээлч хүмүүс эвлэлдэн Монгол хэмээх их гэр тэрэгний түмэн буулганд орж хүчин зүтгэвээс хойчийн зуунд хүрд их дугуйг нь эргүүлэх хүч, буян зузаарч мөнх тэнгэрийн таалалд нийцэхсэн билээ.

Манай даргын зөв

/мушилзал/

Дарга! Юутай эрхэмсэг, эрэлхэг эзэрхэг сонсоно вэ. Энэ үг газарт сүхийх байцын ихэмсэл, тэнгэр цуулах аяндын цахилаар сэтгэлийн уулга алдуулна. Би даргадаа хайртай. Хорвоод миний хамгийн хайртан бол манай дарга. Миний энэ хайрын дэргэд амраг хайр, ачлал хайр аль нь ч зоосны золиос. Энэ үзэл миний эс, цус, сүнсэнд хүртэл шүглэсэн гэж болно.

Манай даргын өмнө толгойтон тонгойж, гээгтэн хэвтэж байсан үед би “Хүмүүн төрөлхтний

дотроос хүмүүжихийн замыг олсон” юм.

Даргынхаа өмнө би сээр нурууны үеэ сэнсэртэл бөхийж, алгаа нялгартал ташиж, нүүрээ турсгалтал марсайж сурсан долдой хулчаахай. Манай даргыг эвийлсэн өхөөрдөл олон бий. Түүний нэгэнд “Хөл нь хөх дэрс шиг туяхан, бор ходоо нь борив мэт цодгор, хүзүүгээрээ бус биеэрээ эргэж хардаг, хүнтэй газраас бус тэнгэрээс ярьдаг, хондлой нь ховилтсон байдаг, хоёр хацар нь хойноосоо харагддаг” гэдэг байв даа. Байг хөөрхийг! Манай даргын хоолой шахаж янцаглах, үгээ зөөж дүлэгнэх, усны тэмээчлэн хямсалзах, улайны бухчлан хэрэх үлгэр дүрийг дууриах гэж мөн ч олон тожгорууд тарчилсан даа.

Манай дарга тэргүүний онолоор зэвсэглэж, нийгэм журмын замаар биднийг хоршооны хонь шиг тууж явсан билээ. Сүргээс зожигорвол тогоо тослохгүй гэхэд толгой хярваслана. Харин сүүлийн арван хэдэн жил манай дарга манийгаа капитализмын хонгилоор мөлхүүлж яваа. Үзүүрт нь гэрэл байна уу, эсхүл мухар мужиг байна уу надад хамаагүй. Гагцхүү манай даргын бойвог миний гавал дээр титэмлэж байх нь жаргалын умбаан.

Дарга гэсэн нэр бол төр, хууль цагдаа тэр бүү хэл цаазчин гэсэн утгын шавай. Тайлбар толинд “дарга бол монгол улсын хүн амын үнэмлэхүй олонхи” гэх буюу “эцгийгээ алчихвал дарга болгоно гэвээс цаадахь чинь цустай хутга түрийлж ирнэ” гэсэн золбин яриа байлаа. Дарга бол олон хүний амьдралын зорилго, дундрашгүй мөрөөдөл, няцашгүй улангасал байсан юм чинь арга байж уу. Одоо ч гэсэн дарга болох гэж нам бүлгээрээ талцан бүүрэлхэж, нам дотроо үнэ хямдарсан үгээр хэрүүл өдөн мунхаг цэцэрхэлд мунгинан, мөөрөлдөж, тойргийн сонгуульд толгой, сайдын сэнтийд бөгс шургуулах гэж үүлгэртэж буй нь мөнөөх уламжлалт даргын төлөө дажин.

Тэдний дунд тэнгэр сандайлах нь байхад, өрөөлийн өмсөх малгайгүйг шооловч, өөрөө ичих өмдгүй нь бий. Хүмүүст үл үгүйлэгдэх атал улс төрийн лангуунд тоосонд даруулж хэвтэх нь чааваасын чанад булай гэлтэй. Төр хоймороосоо цэвэршмүү гэтэл бид хойгуураа бишгүй нэг даахгүй булуу хураачихаад өнөөдөр л “ромбу” гаригаас ирсэн мэт гайхран гаслалдах нь юу вэ. Үдээс хойш ирж буй ухаан гэвээс юутай гуниг. Элдэв гувчуурын мөлжүүрээрээ улс төрч хэмээх албан тушаалын үл таних ангаахай тэжээх “хар буянд” цагаан үзүүр хэрхэвч үгүй еэ. Үүнийг өгүүлсэн нь манай даргадаа саамшсан хайрын ивэлгээг дундалсан нь огт бус гэдгийг өчихийг хичээе.

Манай даргын сургаар шоргоолжны үймээн дэгдэж, мань мэт малгай гутал хоёроо солих энүүхэнд. Ямар сайндаа манай даргыг малчин айлд морилуулах гэж алдаа дутагдал бурж мэдэх аманцар эхнэрийг нь аймгийн эмнэлэгт цөлөөд аядуу сэхээтэнд амжилтын үг заагаад түр сольчихсон чинь нөгөө хоёр дамшваа нь дүрдээ уусаж үүлэн борооны үерт нэг мөсөн урсчихаад зарга заальхай болоход даргын даалгавараар суусан гээд гэдийчихэв дээ. Далимдуулан шамшигдуулагчид!

Манай даргын араас бэсрэгүүд доль сунтаглаж үзүүр түрүүний бөхийн засуул шиг ханаран унаж байхыг мөн ч олон харсан даа, сахиус минь!

Миний өрөөсөн “даргын доодох” нэгэн вээр эхнэрийнхээ өвөрт даргыгаа гардчихаад “манай даргын зөв” гэж маасайж байсан гээд л бодчих. Тэр бүү хэл цагаач хятад “Манай дарга

Дулмаа дээгүүр байсан шүү. Манай дарга цусутай хүн. Дулмаа ч Дулмаа” гээд нарийн хоол савхдуулж, нанчидын дугараа барьсан гэдэг. Гайхамшиг!

Бурханаа шатаачихаад даргынхаа зургийг тахьсан шулдан хувьсгалч дэлхийд надаас өөр үгүй л болов уу. Харин сандлаас хальсан даргынхаа шарил дээр индэр босгоод амьдыг нь арвалзуулахыг би ахаасаа сурсан “молодец”!

Харь оронд даргыг ирэхэд алба амины нэхэл дагалаар жагсдаг бол, би ирэг шулгалж, хурдан хүлгээ зүслэн, хундага тавихгүй найрлана шүү.

Миний бие хэзээ ч анги, намаар алаглалгүй даргадаа сэтгэл дэвсдэг тул, миний хайр төвөөс тэнцүү хэлбэлзэлтэйг хэлсү.

Манай даргын осол бүхэн ололт, алдаа бүр нь амжилт хэмээсэн нь миний газарлаг төдийгүй тэнгэрлэг цайлгал. Энэ нээлтээрээ би Гиннесийн номонд шургахыг горьдон буй.

Манай дарга руу гэвч зүсэн зүйл хор цацан сэвтээх нь тэвчишгүй болсонд багачуулын хэлдэгээр би “иргэний үнэмлэхээ уралцаж Эрээний хүрмээ хүүлэлцье” гэж шийдэв. Эгзэгтэй, эмгэгтэй энэ мөчид түүнийг өмөөрөх эрх олсноор би өмгөөлөгчийн индэрт цоройж байна. Миний үг даргын айлдвар агаар нэгэн буюу. Үүний түл өгүүлэх ину:

-Манай даргыг бурхан тахил, сүм дуган ном судар галдсан л гэнэ. Цустай хутгасан, нулимстай хатаасан амь гэвэл зуун мянгаар тогтохгүй л гэнэ. Тэр байтугай жирэмсэн эхчүүдийг яргалсан жигшүүрт гэмт хэрэгтэн л гэнэ.

-Мөхөл бол мөнх бусын мөнхийн сүүдэр. Ганц манайд бус газар сайгүй хөглөрсөн булш балгас хоёр үүнийг нотлоно. Эсэргүүнүүд том дайсан гэвэл эмсийн гэдсэнд жижиг дайсан байсан тул өршөөлгүй. Баатар цагаан хаан хөл хүндтэй эмийг хэлтрүүлж байсан бол манай дарга тэгж тэнэглээгүй. “Амрагийн тэвэр тос ангийн тэмцэл цус” гэсэн нийгмийн хуулийн хүрээнд болсон ялимгүй явдлыг улс төржүүлэх нь өдөөн хатгалгаа гэсэн шүү. Манай даргын зөв!

Манай даргыг үндэсний уламжлал бахархал, бичиг соёлыг бүрэлгэсэн, харийн оюуны баялагийг хулгайлсан л гэнэ. Үзэл суртлаар гинжилж сэхээтнийг бүхэл бүтэн үеэр нь тамын тогоонд чанасан л гэнэ.

-Үндэсний гэж гайхуулаад байгаа үхмэл өвийн новшийг үүрч явахыг шинэ үе хүсээгүй. Замд төөрсөн түүхий сэхээтнүүдийг буцалгаа л биз. Орос эхнэрт захидал бичиж болохгүй хоцрогдсон бичгийг хог дээр хаяа л биз. Нийгэм шилгээдэг бас шилж сонгодог юм. Орчин үед монгол бичиг хэмээгчийг бус цоо шинэ латин уу, ханз уу гэдэг асуудлыг олон өнцгөөс нь судалж байгаа. Манай даргын зөв!

-Манай даргыг хамтрал хомуун хэмээн хадуурч, малчдын сүргийн сэг сэвсэн дээр найрласан гэнэ. “Монголын малыг хоёр зуун саяд” хүргэнэ гэж үнэнд байтугай үлгэрт байхгүй “үхэр буу” алдсан л гэнэ. Үхсэн малаас амьдын гувчуур татаж малчдыг ял ясанд хахаасан л гэнэ. Буянт малыг нь булааж авчихаад 1921 оны хувьсгалтай тэнцлээ гэж хонгиорсон л гэнэ.

-Хүн төрөлхтний замд шинэ зам нээснийг бүү март. Хэрэв империалистууд хөндлөн хэвтчихээгүй бол өдийд бид өлгийдөө хоцорсон дэлхийг эв хамтын уулан дээрээс даажигнаж, төгрөгийн зээлээр Америкийг боох ч байсан юм билүү. Үгүй гэх нотолгоо байхгүй гэдэг юм. Манай даргын зөв!

-Манай даргыг Монголын хөх туурга өмлөж уул ус хэрчиж харьд зуурьсан урвагч л гэнэ.

-Алгын чинээ газраас ах дүүгийн найрамдал үнэтэй. Эзгүйрч цөлжсөн нутаг одоо ч хөсрий хэвтсээр байна. Барын арьсан дээр муур тарвалзах нь хэрээс хэтэрсэн цамаархал. Хөлдөө таарсан хөнжилтэй байх ёстой гэж үзсэн юм. Манай даргын зөв!

Манай даргыг цагийн ханшаар хөрвөдөг улс төрийн зоос л гэнэ. Өчигдөр чөтгөрт, өнөөдөр бурханд мөргөж чадах хамелеон л гэнэ. Улаан дэглэмийн удамшлын өвчтөн л гэнэ.

-Амьдралд зохьцох нь оюуны чадавхийн төгсрөл мөн. Тэгж ярьвал большевик эмээ, улаан жаал, дөчин мянгатын хулигаан цөм л монголын үй түмэн коммунистуудын өвөр дээр шээж өссөн юм чинь судсанд нь суртлын шавхруу байгаа. Шилжилтийн үед хоёр нүд хойш, урагш солжрох нь сарвалзах, санагалзахыг хослуулах давуу тал гэж ойлгож байгаа. Манай даргын зөв!

Манай даргыг алт дийлер, Аибекс-Молам, банкны дампуурал, зээлийн хулжил, Марубены баталгаа, төсвийн төөрөл, төслийн зувчил гэж ороогоод л байгаа.

Мянган бурхан түмэн чөтгөр ангаалж эрээд ч үүний үзүүрийг олдохооргүй үхсэн үлийд булсан л гэнэ.

-Сүүдэр хоорондоо хэрэлддэггүй, сүнс нэгийгээ гэрчилдэггүй. Дарга ангийн ертөнцөд дардагч юм байхад дарах юм бас бий. Үүнийг эрх ашгийн огтолцол гэх бөгөөд эвлэрлийн ганц амь “Ахиллесын тавхай” нь тэнд яргасан байдаг юм. Ханилж чадахгүй ч хагацаж болохгүй хатуу хорвоогийн жамд салаа зам нэг гүүрэнд уулзана гэж битүүлэгхэн хэлдэг. Манай даргын зөв!

Манай даргыг өмч хувьчлалаар үндэсний баялагийг залгиж цулайсан л гэнэ. Төсвийн цалинтан тураалдаа хүрч байхад танай дарга яагаад арьсандаа багтахаа байв л гэнэ.

-Амтай бүхэн үмхэж, араатай бүхэн зажлаж байхад манай дарга ганцаараа монголын хөрсөн дээр элс тэвэрч элгээрээ харуулах ёстой юм уу. Тэгэхдээ манай даргын нэр дээр банк, компани байтугай нөгөө тоглоомын машин ч байхгүй. Авгай хүүхдийн бизнес надад хамаагүй, намд чимээгүй гэсэн шүү. Манай даргын зөв!

Манай даргыг худал амалж хулхидсан л гэнэ. Тэтгэвэр цалинг тэврээр нэмж, үнэ төлбөр, татвар гувчуурын дарамтгүй амар сайхан жаргаана гэсэн чинь яалаа л гэнэ.

-Аль ч улсад амлалтгүй сонгууль гэж байдаггүй. Улс төрийн дуудлага худалдаанд хөөрч ухаанд чинь ухуулга үхсэн бол тэвэг толгойдоо гомд. Тэнгэрээс цасны оронд гурил унаж, газраас шарилжны оронд шарын гуя ургана гэж бодоо юу. Тэгээд ч олон жилийн ган зуд гар

гавлаад, Валютын сан банк тавлаад байхад яах юм бэ гээд байгаа. Манай даргын зөв.

Манай даргыг сонгууль бүхний дараа ард түмнээ ангилан хадаж үндэсний эвдрэлд турхирч дээдсийн их голомтыг хазайлгаж байна л гэнэ.

-Эзэн хаанаас хойш монголчууд эвийн туурганд багтсан юм уу. Харцууд нь ханаа эрслэх гэхээр ноёд нь нохой амаар нийлүүлсээр өнөөг хүрээ биздээ. Албан ёсны луйварчдаас азтай нь атгаж, засагтай нь залгидаг бус уу. Сонгууль гэдэг чинь мөрийтэй тоглоом. Хожсон нь ширээн дээр хожигдсон нь шороон дээр тусдаг юм. Ард түмэн гэж бүтэн хэлээд хагасыг нь хаяхыг ардчилал гээд байгаа юм биш үү гэж нохойтсон гэдэг юм. Манай даргын зөв.

Манай даргыг хандиваар сайд салаалж, гишүүн мануухайлдаг л гэнэ. Тэднэр нь нүдний нь харцаар нүхнээс цухуйж оноосон дошин дээр оцойж хошгороод орчихдог л гэнэ.

-Улс төрийн бизнес гэж байдаг юм. Улаан мөнгөгүй гуйлгачинд бол төрийн халдага дараа. Хаялагатайг нь хамагчилж толгойг нь бус товчлуур дардаг, мөнгө тоолдог эрхий, долоовор хоёрыг нь аргамжихыг сайн засаглалын шилдэг менежемент гэнэ билээ. Манай даргын зөв!

Манай даргыг авилгалын аврага загас л гэнэ. Гааль, татвар, газар, тендер гээд суваг бүхнээр сул асгасан сувд шиг урсаж байхад хахаж үхдэггүй юм уу л гэнэ. Хуучин шинэгүй унгасан толгойтой мангасан ходоодтой юм уу л гэнэ.

-”Авдгий нь эрснээс авдаггүйг эр” гэсэн ардын үг алтан ураг, манжийн хаад, социализм, ардчилсан засагтай хав дөрвөлжин л байгаа. Олзонд дургүй оготно ч байхгүй. Харин авсан өгснийг адилхан ялаар цоровдсон аятайхан амьдралд ойрхон хууль гаргасан шүү. Хуулиар торгож болдог бас тоглож болдгийг тойруулсан юм. Манай даргын зөв!

Манай даргыг УИХ дээр сөрөг хүчнээ ам ангайлгадаггүй л гэнэ. Хуулийн хулуугаар томголсон л гэнэ.

-Амтай нь ангайж хамартай нь хагарахыг анархизм гэдэг юм. Анархистууд цагаан нунтаг цацах юм уу, гар хийцийн бөмбөг дэлбэлэхийг байг гэхгүй. Бин Ладен Хөвсгөлийн тайгад ч байгаа юм билүү. Анархистуудыг авантюрист гэж авслахгүй гэхэд алхуулахгүй байх ёстой гэдэг. Манай даргын зөв!

Манай даргыг радио, телевизийг азаргалж хэвлэл мэдээлэлийн эрх чөлөөг боймлосон л гэнэ.

-Радио, телевиз чинь үхэх нохой л биш юм бол төрийн идүүрээс эзэндээ хуцаагүй, хуцахгүй. Эрээн бараан сонин, телевиз гэвэл эрх хэнд байваас тэнд дэлүүрдэг юм. Хуучин матаач, хуурай гүжирч хоёрыг сэтгүүлчийн сэтрээр холбохоор магтаал хараалын хоёрхон өнгөөр дуулдаг юм. Нүүргүй зарцыг нүгэлд зар гэсэн үг бий. Зарцуудаа л зараа биз гээд тоодоггүй. Манай даргын зөв!

Манай даргыг өрийн долоон мэнгэтэй л гэнэ. Их өр, урсгал өр, зээл, хүү, түрээс, ашиглалт, алдагдал гэхчлэн өрдөхийн хорхой гозогнож байдаг л гэнэ. Тэр бүү хэл таньдаг айлдаа ороод ахиухан өр нэхээч гэж гуйдаг л гэнэ.

-Нарны дор өр, өрийн дор улс гүрэн оршино. Их өр гэвэл тэртэй тэргүй гарзандаа гарч, үрэгдсэн амь үгүйрсэн баялаг төлбөр тооцооны хэрэгсэл биш. Өгсөн өгөөгүй нэхнэ, нэхсэн нэхээгүй өгнө гэдэг дээр хоёр этгээд санал нийлснийг мэдэгдсэн. Манай даргын зөв!

Манай даргыг Гүндалайг цөөврүүд мэтээр хэмхүүлээд мэдэхгүй гэж мэлзсэн л гэнэ. Английн молхи Шекспир адууны жүчээндээ зүүдлээгүй жүжгийг найруулж байгаа л гэнэ.

- Гүндалайг хярамцаглахыг мэдээгүй л гээ биз. Мэдсэн бүхнээ тургих алба уу. Жүжиг гэвэл УИХ дээр улин хуцаж цогин жороолоод байгаа бэлтрэгийг спиртээр зуурч сор зална. Энхбатаар гэрчлүүлж Энхтайван, Энхсайхан хоёрыг Зоригийн амины хэргээр газар шүншиглэнэ гэж сонинууд төлөгдөөд байгаа. Сайхан буйлуулсан санаа байгаа биз. Сонгодог жүжгийн зохиол. Түүх давтагдах нь хүмүүсийн санаа зоригоос үл шалтгаална гэдгийг үгүйсгээгүй. Манай даргын зөв.

Манай даргыг “төрийн нууц гүтгэлэг” гээч нэр томъёо зохиосон л гэнэ. 37 оны “До” яаманд урдаа Жамбалтай Дорж байсан нь аз л гэнэ. Танай сайд гэмгүй юм бол яагаад хор идсэн боохой шиг хоолой бүхэн рүү үсрээд байгаа юм бэ л гэнэ.

-Засгийн зараалаар гадаадад томилсон онцгой даалгаварын тайланг олон нийтэд тавьдаггүй. Эд мөрийн баримт маш нууцын зэрэглэлтэй болохыг тогтоосон. Цагдаа тагнуул хоёр цусны үнэр авчихаад байгаа гэвэл дотоод хэрэгт нь оролцохгүй. Сайдаас савраа тат гэсэн шүүдээ. Манай даргын зөв!

-Манай даргыг цагдаа тагнуулыг буруу эрхлүүлж буугаар тоглуулаад яалаа л гэнэ. Тэдэн дунд Баатар генералаас илүү “зохиолч” бий шүү л гэнэ. Байн байн сүрдүүлээд байхыг бодоход хуучин хар хуудсаа шинэ түүхэнд хавчуулах гээд байгаа юм биш биз л гэнэ.

-Өнгөрсөн цаг ирэхгүй ч ирээдүй юу авчрахыг мэдэхгүй. Төр нүдтэй, чихтэй байсан, байх ч болно. Улс төрийн дайсныг бутцохьсон цусан гавьяа тэнд бий. Хэрэгтэй цагт хэргийг хэрхэн бүрдүүлж, хэнд яаж өмсгөхөө тэд мэднэ. Дотоод хэрэгт нь оролцохгүй. Манай даргын зөв.

Манай даргыг ерөнхийлөгчийн өөдөөс шороо цацсан л гэнэ. Ард түмний сонгуультайгаа аймаг довных нь аашилдаг боллоо, удахгүй зодох байх л гэнэ.

-Анхны ерөнхийлөгч нь хүргэнийхээ үүдэнд манаач хийгээд сууж байхаа яасан юм бэ. Одоогийн ерөнхийлөгч нь аашаа эвдэж ардчилалыг амьсаж хэл гээгүй үгээр хэдэрлэхийг хэрхэвч тэвчээгүй. Ламбугайд чөтгөр сануулснаар “Зүгээр байхад зүгээр л байгаарай” гээ биз дээ. Манай даргын зөв!

Манай даргыг хаашаа явах, хаана хүрэхээ мэддэггүй хорвоогийн дүйвээнд хоног төөрсөн л гэнэ. Үзэл баримтлал гэвээс айлын будаа буудахаас бус өөрийн гурилтай шөл байхгүй л гэнэ.

-Бид байтугай хорвоо хаана хүрэхийг хонхорт нь байгаа хэн ч хэлээгүй. Онол, үзэл баримтлал гэвэл баруун, зүүн, төв гэсэн орчуулгын амны уншалагаас өөр “онол” аль ч хүчинд элэнцэг нь байхав дээ. Хар үгээр хэлвэл социализмаас баруугаар, капитализмаас зүүгээр хүмүүн төрөлхтнийг дууриагаад л гэлдэрч явтал учир нь олдоно гээд байгаа шүү дээ. Манай даргын

ЗӨВ.

Манай даргыг элдвээр зулгааж зумлахдаа цаагуураа намайг давхар дайраад байгаа юм. “Бурхан, нохой хоёр төрийн гадаа хэвтдэг бол танай дарга, мал хоёр төрийн хамгаалтанд байдаг. Гэхдээ мал шиг зудад үхдэггүй таргалдаг. Танай дарга усан дотроос улаан, цусан дотроос цагаан гарч чадна. Танай даргад мэдэх юм бараг чиг мэдэхгүй юм байхгүй. танай дарга өрөөлийн хийснийг өөрийн нэрэмжит болгодог. Танай дарга өгөөгүйг байтугай өгснийг өөрийн гараар авдаггүй. Танай дарга далан худалч биш ч улсын дунджаар жартай. Танай дарга Андерсен биш ч үлгэр зохиож үнэн юм шиг ярьдаг. Танай дарга Дон Жуан биш, тэгэхдээ тайган бүр биш. Танай дарга эмгэнтийн жалгыг мэдэхээс, өвгөнтийн хөндийгээр шагайдаггүй. Танай дарга найз нөхдөө наад, нарийн бичгээ цаад өрөөндөө хүлээж авдаг. Танай дарга чоно биш ч нэг зуувал тас хивнэ. Танай дарга Нострадамус байтугай Дашцэрэн биш, гэхдээ намрын дараа өвөл болохыг яс хэлдэг. Танай дарга Өнөрмаа биш, өрсөлдөгчөө шатаахаас өөрийгөө ноцоохгүй. Танай дарга “Шилэн Дамдин” шиг мөнгөний авдар эвдэхгүй яагаад гэвэл түлхүүртэй. Танай даргын “Үндсээр нь шинэчлэнэ гэж үглэх нь роман, ядуурлыг бууруулна гэж янших нь хүртэл симфони...” гэж чи дуулж л байгаа биз дээ. Танай дарга шүүмжлэлд ясны дургүй, тарвагатай хүртэл өөрийгөө андуурч л байсан шүү дээ. Одоо ч энэ шалжаалыг сонсоод олон хүн өөртэйгээ андуурч “хамаг нүүрээ хамар дээрээ овоолно доо” гэж дамшиглаад байгаа. Үүний хариуд хэлэх муу үг олдохгүй байна. Үнэний сорив байгаа гэхэд тухайн нийгмийн буруу. Манай даргын зөв!

Нэг муу шог зохиолчийн сүг манай даргыг арван хоёр жилийн шинжтэй гэжээ. “Танай дарга хулгана шиг мэрнэ, үхэр шиг зүтгэнэ, бар шиг базна, туулай шиг хярна, луу шиг хүрхрэнэ, могой шиг хатгана, морь шиг булгина, хонь шиг эргүүтнэ, мич шиг дууриана, тахиа шиг амжина, нохой шиг хуцна, гахай шиг хадрана” гэсэн байна. Би тэр муутай заргалдаж даргынхаа нэр төрийг сэргээнэ. Тэрбум төгрөг авч даргадаа өгнө. Би даргадаа хайртай.

Манай дарга улсын сэтгэлд мөнх оршихгүй ч дарга болохсон гэж зүүдээ манаж зүрхээ чагнаж яваа албан тушаалын ангуучдын мянганы урсгалаар үргэлжлэнэ. Манай дарга улаан, цагаан, ногоон эсхүл байдаг л нэг Өлзийхүү атугай ч удаан жилийн зузаан хайр түүнд юүлэхийн тулд эх орон, ардчилал, хүний эрх мэтийн эрээвэр хурааварыг огоорхоос өөр аргагүй. Бидний дээр тэнгэр, түүний дээр манай дарга бий. Манайх дарга шүтээнтэй улс. Улаанбаатарт манай даргын хөшөө дурсгал л гэхээс бус Монгол улсыг байгуулсан Чингис хааных байхгүй. Түүнд хотын хойроос зүг буруу зүүн урд хатавчинд газар заасан. Энэ бол манай даргыг шүтсэн миний үзлийн ялалт мөн. Гэтэл гай дайрч буянт шүтээнээ бургасдах болвол яанаа? Бид нүгэл хилэнцдээ хэмлэгдэн зовох болов уу? Арай жаргах юм биш байгаа? Үүнд ухаан дутаж үл мэдэг мушилзав.

Тулгын чулууг хөдөлгөж болохгүй

Монголчууд үгийн эрдэнэс хэлхэж үлгэр туульсаа хуур цоортой шүлэглэн хайлдаг цэцэн цэлмэг үндэстэн. Өтгөс буурлуудын яриаг сонсохуйд үгийн цэц онч, цэвэр тунгаамал сэтгэлд утга эгшгээр найрсуу нь нэн гайхамшигтай. Нэгэн цагт Ринчен доктор гурваад сая үгийн сангай хэмээсэн хэлнээсээ өдгөө бид гурваад зууг номгочлон дагиж их сүргээ эмнэгшүүлэн, тэр бүү хэл, хол ойроос уургын улаагаар хөл дүүжлэж буурлын буяныг буртаглаж буйд үрийн зулайтай, үндэсний цочоотой бүхэн халаглах болов.

Монгол хэл минь бидний хувьд амин хүйтэй тусгаар тогтнолын алтан гэрэгэ, хүн төрөлхтний соёлыг чинээлсэн өв залгах өмч билээ. Эрт баларын үүх түүхээс, эргэх цагийн соёл иргэншил, шинжлэхүй ухааны оньсыг тайлах, улс төрийн ончроог хариулах алин дор боловч хэний ч өмнө гартаж үг бадарлахааргүй бэл бидэнд бий.

Хэлний бэхжил, хэврэгшил нь үндэстний оршихуй, огшихуйг илтгэх ахул, удам хэлээ огоорох нь уусах уруудахын ёр авай. Үүнийг мөчиг ухааран бусдыг ойврон дагаж сэвсэр дэлсэх нь сэтгэлгээний явцуурал, боолын бохирол мөн. Өгүүлэгч вээр ярианы болон бичгийн хэлний ялгааг арилгах, нийгмийн хувьсал дэвшилд хэлнийхээ хилийг хаах бодол өвөрлөсөн нь бус монгол хэлээ хамгаалан хөгжүүлэх тухайд тойнтрог чулуугаар товирыг доргиох горьд хөтлөгдөн өлгөн хэлэлцэхийн өөш төдийг өмнөтгөн өчсу.

Өнгөрсөн зууны оросжих дарвианд хэлний хээл хаясан жишээ олон. Хэн нэгэн дарга “зуд” гэдэг үг орос толь бичгээс шүүрдэн гагцхүү “бескормица” /тэжээвэр малтай газар тэжээл дугах, манайхаар өл алдах/ гэх үгтэй халз тулгарахдаа “зуд” гэдэг орос хэлэнд байхгүй тул ерөөс байдаггүйг нотлон “Байгаль цаг агаарын түр зуурын бэрхшээл” гэж гуравхан үсгээр бүтсэн үгийг гучин дөрөв болгон зудалсан билээ. Оросын “переменный” гэдгийг солигдмол “покрыв, покрытие” гэдгийг нь бүрхүүл гэж оноосноос монгол орныг солигдмол үүлтэй, цасан бүрхүүлтэй болгов. Үүлийг нүүх, суух, борооны, цасны, аадрын, хурган, сэмжин гэх буюу цасыг битүү, тарлан, бод богийн хар туурай, малын амны, шувууны мөр гэхчлэн ялгадаг малчид “манай нутаг солигдмол үүлтэй цасан бүрхүүлтэй байна” гэж хэлэх гээд хэл нь эвлэсэнгүй. Гэвч гурилтай хоолоо лапшаадаж бараг дадаад цагаан идээгээ сүү, сүүн бүтээгдэхүүн болгох “төсөл” хэрэгжиж л байна.

Хүнд сурталтнууд бол хэлэнд өт цацдаг батгана мөн. Тэд дээдсийн ихэмсэлд сүүл сээрдэн гаж үг, молхи орчуулгаар хэл новшилдог. Мойног даргын модон хэл гэсэн шалжаа үүнээс үүдэлтэй. Нэг үе “үзэж байна” гэдэг асан нь нам, тушаал хоёрын л лаахай байсан бол өдгөө “энэ утгаар нь ойлгож байна” гэх болов. Энэ нь ацан шалаанаас зулрах бусгаа юу, илэрхийлж эс чадахын зовлон уу гэдгийг таахад бэрх. Тэгээд ч энэ утгын цаана тэр утга, нөгөө утга нуугдах нь барьц холбиороотой, эргэж бухаад элс тэврүүлж мэдэх тул итгэхүйеэ бэрх. Дэл сул үг гол санааны тусгалыг хазайлган хүний сэтгэл ээдүүлдгийн жишээ энэ.

Урдын “хэлний их өрийн” шавхруу асуудал, арга хэмжээ гэдгийг өдгөө “хүрээлэх” болж. Асуудлыг хүрээлээд түүнийгээ олон өнцөгтөд хувааж аль өнцгөөс нь харахаа шагайж зүдэрсний эцэст хөндөж /шарх буглаа бололтой/ түүнд тохирсон механизм /оньс хөдөлгүүр/ олж эцэст баталгаажуулдаг бололтой. Хуучны асуудлаас “үзэл суртал, гэр бүлийн талаар ялзрах асуудал” дуулдахаа больсон нь унтарсан буюу бүгд ялзарсан алин болохыг чөтгөр мэдэх биз. Асуудал нь зарчмын, зарчимгүй, ноцтой, бүрхэг эмзэг, ээдрээтэй, заримдаа “проблем” болдог олон хувилбараар сөхөгдөж, сэдэгдэж, орхигдож, тулгамдаж, шаардагдаж, тавигдаж байдгийн дотроос энэ хэр жендерийн /хүйс/ нөхөн үржихүйн мэтийн хурц үе юм байх. Хүүхэн даргатай болох нь хэцүү гэхэд хүүхэд бүтээх зэрэгт, гадаадын мэргэжилтэн урьж сургалт явуулалгүй /хичээл заалгахгүй/ өөрсдөө оролдвол дөнгөхгүй юм сан уу. Оросоор “мероприятия” гэдгийг арга хэмжээ хэмээн буулгаж ажил, ёслол, цээрлэлийг “бөөндсөн” хэвээр. Ой тэмдэглэх, хувийн зоосоор татвар төлөх, түүгээр албаныхан найрлах цөм арга хэмжээ агаад бас “хүрээтэй”. Харин “баталгаажуулах” нь шинэ гэмээр. Гэтэл бүх юмыг, тэр

байтугай газар хөдлөхгүй, үхэхгүй гэхийн баталгаа байхгүй гэх юм. Яаж байх вэ. Тэнгэрийг засаглаж, мөнхийн усыг “Наран туул” дээр зартал зай бий.

Улс төрчид хэмээгсдийн дунд санаагаа цэгцтэй илэрхийлддэг нэгэн байхад нөгөө нь ус гоожихоос тос тусахгүй. Зарим нь үгээ зөөж, дүлэгнэж төмөр хоолойгоор “товчоодон” сүрдүүлэх, эсхүл үгийн түүдэг хийж өнхрүүлэх нь хөх инээд хөхүлнэ. Эмэгтэй хүн ийн аяглах нь бүсгүйн хүүхэмсэл хэмээх нүд булааж, сэтгэл бүлээсгэх аалийг товроглож хувхай мод санагдуулах нь хайран. Умард хөршид саяхан дарга нарт үг хөгжлийн хичээл заах яриа гарсан байна билээ. Манайд ч гэсэн ийм хичээл зааваас дээдэс байтугай, зохиолч сэтэртэй мань мэтийн ярих гэж зовлого зулгаагсдад хэрэгтэй сэн.

Хүмүүс зарим гишүүдийг хэлд орохгүй, танигдахгүй өнгөрөх нь гэж гоочилдог. Хэрэгшээхээр хэлэх юмгүй бол заасан товхонд нь хуруу зоогоод сууг л даа. Явуулын хүнд иргэний гэхээс төрийн зүс байх албагүй. Тойргоос сонгогддог атлаа сонгогчиддоо бус “ард түмэндээ хандаж” зарим нь томроно. Сонгоогүй, сонгох ч үгүй хүмүүс түүний өмчийн ард түмэн мөн юм болов уу. Ишгэн дарга нар эврийн ёзоор цухуйлгаж “баяр хүрэгхийг хүсч байна, хүргэмээр байна” гэж хямсалгах нь хөөрхөн л дөө. Уг нь хүргэе гэдгээ хэлвэл хэлээд байвал байна л биз. Гарз нь гайгүй хэвтэнэ.

Хүндрэл гэдэг үг амны уншлага болов. “Үгээ чи минь хэлэхгүй үнэхээр намайг хүндрүүлж байна” гэж дуулах л дутаад байна. Тэгвэл хөнгөрөл нь юу болох вэ? Өлссөн жаал өөдсөн чинээ алга тосох хүндрэл бол цадсан босс “суугаад” босох хөнгөрөл үү? Энэ мэтээс болоод “танхи төрсөн миний амраг, тавхан үгэндээ танигдаад байна” гэдэг бол “зуурдаар учирсан миний ноён зуун үгэндээ ч танигдахгүй” болов оо.

Модон хэл хэмээгчийн жишээг шүүх эмнэлэгийн дүгнэлт хэмээх гайхамшигт загвараар төсөөлж “хүүхэд төрсний нотолгоо” гаргуулья гэж бодъё л доо. Тэгвэл “Холбогдогсод дурлалтын процессд болзолтонд уулзалт зохион байгуулахдаа, нүүрний доод хэсгийн зөөлөн эдийн шүргэлт даамжралтанд хүрснээс хавьталт явагдаж мохоо үзүүртэй зүйлийн үйчлэлээр үр тогтолт үүсгэгдэн тээлт, төрөлт зохиогдсон нь тогтоогдов” гэх нь л дээ.

Өнөөгийн хэлний хялуугаар яриваас дорхи мэт. “Би интэрнешнл импекс холдинг-д боос. Аудиторыг аудитлахаар аудитлуулна. Эхнэр салонтой, лицензтэй. Хүү кино студид продюсэр, доктрант мобикомтой. Бэр топ модель, кино пробонд. Охин магистр коллежид. Скайтельтай. Хүргэн компантай, компьютер интернет факстай, сембирнартай, кабелийн телевизтэй. “Капитрон” банканд карттай. Бенцгүй, жиптэй, бензин, маслаа Ник, Петровис, Синчи Ойлоос авдаг. Би костюм, сорочка, галстук, ботинк, зажигалка, сигарет гэнэ. Хөгшин, шуба, сапог туфль, браслет, зонтик, духи, шампунь, кофе, сыр, шоколад гэнэ. Хүүхдүүд Хамелеон, Драгон, Хард-рок, хип хоп, Эмошн, Камертон мисс, стриптиз гэнэ. Эстрадын фенүүд. Манайх палкан дачтай, котельтой, каминтай, саунтай. Хобби марк, конверт, медальон. Гэртээ ёлкдоно. Торт, виски, сода, жүүс, оранж бүх деликатестай. Ну проблем. Санта Клаус, салют, шампанск. О`кей Хаппи ньу иар! ...” Үүн дээр их хурлаа парламент гээд гишүүдээ сенатор, конгресмен гэх биз. Ус ховор тул флот, адмирал нь юу л бол. Харин тэмээгээ хуурай далайн хөлөг онгоц гээд тэмээчнээ “Камелрал” гэж болох юм. Доктрант магистрантын араас баклавант, дамжаарант гарах биз. Хэм гэж хэвшээд байтал хэмжлийн тогтоолоор шавхуурдаж “гяраатусдуулсан” дуулдсан. УИХ угсраа мэхээр “аудитын өргөс” хэлэнд шаалаа.

Хянан шалгах гэхэд агуулга нь багтахгүй байна гэнээ. Урд тоо бүртгэл гэхэд цараа нь багадаад статистик болгож, зурагт гэхэд бас л давчуудсан билээ. Монгол гэдэг нэр хэзээ явцуудхыг мэдэхгүй. Хуучин шинэ ах нараас хулуусан үг хонь хурга шиг нийлэв. Ийнхүү бид нойл настай хүүхэдтэй палкан /саваа/ байшинтай дрожь /чичрэл, жихүүцэл/ дэвсдэг, өөрөө явагчтай, тэргээр бус хэрэгсэлээр зорчдог, өндрөөр хэмждэг багтаамжтай өргөн баригдсан хуультай, үхсэн бус амьд хөгжим сонсдог, гудамж бүхэн центр, хаустай, хонгил нь ресторан баартай, мухлаг нь маркет, оромж нь отел, хэвтээ босоо замтай, крилл латин бичигтэй, христ, буддын шашинтай азийн бар болоод архирч болдог бол сайхан аа. Ер алив хэлийг сайтар сурсан нь хярамцагладаггүй гагцхүү оготнын хөөө зуусан нь омойтдог. Хэдэн малаа суурьшилд хөөгөөд, хэл соёлоо даяаршилд үйгээд азгүй нэгэн өглөө айлын хатавчинд сэрэхгүй юмсан. Яанам билээ. Хэдхэн жишээгээр хэлний хутгуушийг хэсэглэн хэлхвэл хорсгохгүй гэхэд холгох юуны магад.

Санхүү банкны сэсчээмтэй

Сантехникийн сэлээсэртэй

Барьцааны ломбаардтай

Баталгааны нотираадтай

Удирдагч нь куульттэй

Удирдаач нь пуульттэй

Хувийн коодтой

Хувцасны моодтой

Галын командтай

Газрын кадаастартай

Орцондоо ноймортой

Ордондоо каамэртай

Архины бокаалтай

Ажлын бахиалтай

Зайгуулын тараншээтэй

Зайлуулгын тараактартай

Клиникийн үзлэгтэй

Клирингийн тооцоотой

Хоол нь поорцтой

Холио нь пээрцтэй

Яам нь мээнэжэртэй

Ямаа нь кашмиртай

Өрөөлдөө портээзтэй

Өвөртөө пороомсогтой

Чихэндээ апараадтай

Чивэндээ гондоомтой

Эцэг нь таавчигтай

Эх нь лээвчигтэй

Хүүхэд нь паампэрстэй

Ууцандаа масажтай

Утсандаа мэйсэжтэй

Унадаг бөх моосттой

Уулзвар бүхэн поосттой

Тээстээр шалгадаг

Тээндэрээр уралддаг

Шооконд ордог

Сейфэнд нуудаг

Пэлтаа наадаг

Пэлээтэг залгадаг

Рээзэвт бичдэг

Истоор нээдэг

Инчрээстэй тоглодог

Стрээс тайлдаг

Ханаа дараанкталдаг

Хадлангаа пэрээсэлдэг

Хийсэн бүтээл дисэртаац

Хичээлийн давтлага консолтаац

Өргүүр шат лийпт

Өнждөг араа лүүпт

Цаасан хүүдий пакээт

Царсан шал паркээт

Томхон танхим заал

Тойрон бүжвэл баал

Хурлын дарга спикэр

Хувийн дугаар эргистэр

Аливааг чадвал маасчар

Адрын гэрэл лүүстэр

Түүчээ тэрэг бүүпэр

Түгжээт нууцлал шийпэр

Цусны чагт хэрээст

Усны цорго караант

Цайны идээ заваарк

Цаасны хэмжээ формат

Энгийн дэр падуушаг

Ээрүүлт хүрд кадуушаг

Яриан жүжиг дараам

Янзны хүрээ араам

Нэрийн чансаа эрээтэнг

Нэхэл өлгөц эрээплэг

Албан суудал мээст

Алдар хүнд чээст

Санаандгүй явдал сүрпэрийз

Салбан өмд тарпээз

Нүхэн гарц түнээл

Нүнжигтэй эд оргинаал

Ахлаж яваа нь лийдэр

Ард үлдсэн нь лоодор

Мулгуу нь паакт

Муу нь аакт

Амьсгал хордвол угаар

Аюулд өртвөл аваар

Ханын шүүгээ шкаав

Хомон хадаас скоов

Тэвэг талх батоон

Тэцэн хувин битаан

Оноол ажил ноором

Онцлох хувцас фоором

Огтор банзал мийний

Ороолдсон хормой макси

Цэргийн дуулга каасаг

Цээрийн баг маасаг

Албаны өрөө оофис

Амрагийн хурьцал сээкс

Гэрийн тавилга мээбэл

Гэрлийн утас каабэл

Халуун уур паар

Хальсан бөмбөлөг шаар

Өвөөлжин шовоохой бүүтэг

Өвчүүн завь лоотог

Сахлын хутга бэрийтэг

Саравчтай малгай кээпэг

Ханцуйн товч заапанг

Хавчах хавгас паапаг

Эдийн солгой бараак

Эргүү толгой дураак

Данс баригч нариадчаг

Даган баясагч балиалшэг

Хурууд эм таблээтаг

Хулгар сандал табурээтаг

Алаг хөзөр каарт

Агтан гуявч шоорт

Тааран шалбуур жийнс

Тарчиг тэтгэвэр пээнс

Хоригдлын хэвтээш наар

Хоногийн нэвчиш баар

Эрээвэр зууш салаат

Эмчийн нөмрөг халаат

Элдэв шүхэр зоонтиг

Эрвээхэй зангиа баантик

Өвсний хадуур касилк

Өвчитний дамнуур носилк

Үнэ хямдрал сээл

Үнгэг шохой мээл

Хайнцал нь ничээ

Хийрхэл нь шизо

Үзэх зүс имийж

Үлэг жаал дэбийл

Чимэгт зар рэклаам

Чихэвч мөр рэглаан

Илүү зан хооби

Ихсийн булагнал лооби

Сайн дуу хийт

Сагсны бай шийт

Нүдний шил ооптиг

Нүүрний гоёл космээтэг

Тунгийн тариур шипрээц

Турсган цавуу скооч

Аюулын нөөц фоонд

Арилжааны өөш боонд

Яншаа дуу хийп хоп

Янагийн гоёл шууб наап

Үзэгслэнт бүсгүй оны мийс

Үдшийн мэдээ сийтий нүүс...

Энэ бүхэн уншваас инээд, ухаарваас ханиад. Эх хэлээ түйвээх нь амиа егүүтгэхтэй агаар нэгэн буюу.

Унаган хэлээ сайтар эзэгнэвээс харь хэлийг сурах дэвсгэр болдгийг бодолцон хүүхдийг хар багаас нь ярих бичихэд зүгшрүүлэхсэн. Тэгэхдээ “Эзгүй хээрийн мангас эр эмгүй сахалтай” /ямаа/ “Өөхөн бөмбүүлэй, өвдөл цөвдөл” /хонь/ гэж буянт мал бузарласан сурах бус урах бичиг /гуравдугаар анги/ зохиодог хүмүүсийг хуучны номын багш нарт хэлвээс хулсан үзэг хуйханд нь зоох байсан биз.

Хэвлэл мэдээлэлийхэн маань юу л гээч “хэлгий даадай” болоод байна даа. Төрийн өндөрлөгүүд гэнэ. Тэгвэл намлаг нь хэн бэ? Хэцлэг, ухаалаг, толгодлог, тошлог, довлог байх нээ. Мань мэт нь хонхорлог байхад гомдохгүй. Харин өндөрлөгийн хань ижил биеийн байцаалдаа нөхөр буюу эхнэр гэснийг “өндөрлөг” гэж бөглөх үү. Төртэй улсын овогтой эцгийн хашсан албатай хүнийг ёсоор нь хэлж болмоор. Ерөнхийлөгч, ерөнхий сайд нараа “эксдэлгүй” дэс дараагаар /Богд, Далай лам мэт/ оноон хэлж болох мэт. Үүнээс үүдээд, хөгжил, ажил, сурлага, цалин, тэтгэвэр бүх юм өндрийн хэмжээтэй болов. Өндөр ашиг шимтэй мал гэдэг нь өндөр сүү, мах ноолууртай, өндөр боловсролтныг бэлтгэдэг нь өндөр сургууль, өндөржүүлсэн бэлэн байдал нь ерийн үед намжуулсан байх юм уу. Төрийн хар хайрцаг /чёрный ящик/ нь ядахдаа төмөр авдар биз.

Улирсан онд Чингис хаантан монгол туурганд заяасны ой тохиох үед улс, хувьсгалын 81 жилийн ой хэмээн дүрэмдэв. Улс нь наян нэгтэй хаан нь найман зуун дөчтэй байхнээ. Ерөнхий сайд эрднийн чулуу өвдөглөн /хөшөө дурсгалын суурь тавихдаа сөгдөж сөхөрсөн бололтой/ Ерөнхийлөгчийн зарлигаар усанд живсэн хүмүүсийг аварсан /усанд живснийг аварсаны нь зарлигаар шагнасан/ Зориг таалал төгсөөд ... жил болов /Таалал төгсөөгүй хөнөөлөгсөн/ гэх мэтээ больж үзээч ээ. Багачуул балчирдаад байвал найруулга зүйн дөртөй хэлээ мэддэг олныг түшээч ээ. Тэгвэл ядахдаа “хүсээгүй жирмэслэлтээс олдсон хүүхэд” гэхгүй “хоноцын хүүхэд” гэдэг ч юм уу бэлгийн замын халдварт өвчин гэдгий нь хурьцалын, “дархлалын олдмол хомсдлын хам шинж” гэдгийг дархлалын тахал гэхэд ядахдаа цаас цаг хоёрын гарз багаснаа даа. Эртхэндээ сангийн лам байснаас бус элэнцгийн “Загалмайлсан эцэг” байх юм бэ. Эздийн сэнтийд бөгс хувааж “ элбэж идэж эвхэж түрийлэв” гэх гээд байгаа юм бол бялуу хуваах бус ялсан нам ууцаа таллах юм биш үү. Олон юмыг зүйрлэхдээ “борооны дараах мөөг” гэнэ. Манайд мөөгний манан гэж бий. Түүнээс бус бороо бүхний дараа мөөг

ургах нь бүү хэл жил өнжинө. Хүндэтгэл үзүүлэх, тусламж үзүүлэх гэдэг нь харуулсан төдий биш бол хүндэтгэв, туслав гэнэ биз дээ. Айлын хаяа ухахаар авдраа уудлая. Болсон сэвс хивэхээр борог ч атугай өөрсдөө зулгааж бодлын бэлчээр холтгоё. Үүнд гомдоод “барилдахгүй” гэдэг шиг бичихгүй гэвэл гэхээс дээ. Үнэрхээд хэн бугайч үнэ хүрэхгүй. Монгол биднээр бага дутав гэхэд бид монголоор мөн ч их дутна даа. Сурвалжлагч, тайлбарлагчдыг ёстой нөгөө дамжаагаар талхиж, сургалтаар сунгаж элдүүрийг нь хангахгүй бол горьгүй нээ. Монголынхоо аман болон бичгийн утга зохиолоос үгийн эрдэнэсийг шүүрч тэд маань үндэснийхээ хэлний дархан харуул болоосой.

Хөлбөмбөгийн дэлхийн аврага шалгаруулах тэмцээний үеэр “хөврөлдүүлэн үзүүлж” “орой болж нүдэнд нар орохоо болив” гэх буюу “боксчид гэдсэнд нь ажиллах” “бөмбөг давуулалтаар тоглолтонд орох, тэмцээн явагдах тэмцээний ажиллагаа” мэт нь сайварлах гээд салгалахын үлгэр. Үндэсний гэж гайхуулдаг бөхөө үзүүр түрүү гэдэг үг байсаар атал “тэргүүн байр булаалцалдахаар гарч ирлээ” /мөн албархаваа/ гэнэ. Цол дуудаж амлахад нөгөө жигүүр нь “баярлалаа” гэж элээчлэн унгалдана. Түүний оронд “за, ёсоор болгоёо, болгоолоо” гэвээс нийцтэй мэт. Уг нь оросоор спасибо гэж хэлүүлэх гэтэл молхи засуулчид нь “эс башийв” гэж гутаатаад “баярлалаа” болгосон гэж шоглодог. Одоо унасан бөхдөө давсан нь “сори” гэх нь л дээ. “Люблю, лав-ю” – гийн хооронд хавчуулсан халиуны зулзагануудын яриаг сонсоход аймаар дурлаж, аягүй баярлахаас цаашгүй, хэлий нь зангидсан мэт ээрэх буюу, өгүүлбэр бүхнээ “за” гаар залгиж, үг бүрийн хооронд “одоо” шаантаглаж, “тиймээ” гэж тулгах “тэгдэг л байхгүй юу” гэж мэдэмхийрэх эмгэгийг илиаршуулахад нэвтрүүлэг эрхлээчид нүүрэнд нь будаг нялахаас илүү хичээгээсэй. Хэлээ мэдэхгүй ярьж чадахгүй над мэтийг олны өмнө “нохой ногоо идүүлж” байх нь ямар хэрэгтэй юм бэ.

Мэдээлэлийн зуун гэдэг нь мэдлэггүйн зуун гэсэн үг биш. Өрнөдийн соёл иргэншилд аванхайлсан сэхээтнүүд бид дорно дахины болон өөрийн түүх соёлыг эс өнгийвөөс өрөөсөн нүдтэйгээс ялгаа нь үгүй. Сэтгэх тэнхээтэй, илэрхийлэх чадвартай байж гэмээн сэтгэлийг хураана. “Би хэмээн биеэ таньж билэг оюунаа хурцалтугай” гэж Чингис хаан айлдсаныг бүү мартагъя.

Эл бүхнийг үглэхдээ улигт боолын сэтгэлгээний урхаг арилаагүй, дотоод ертөнцийн хүлээс алдраагүй, мэлмийн хиртэл цэлмээгүйтэй холбох нэгэн учрыг тодлоё. Ойрмогхоны баримт хэлье.

Эрхэм гишүүн Гүндалай хэмээгч “цадиггүй эр” нам засгийн удирдагчдын улаан нүүрэн дээр, гадаадын элчүүдийн нүдэн дээр шаардах хуудас өргөсөн нь “үхэр цам харайлган” юм үзээгүй миний мэтийн нүдийг бүлтлэх шахав. Гэтэл хэдэн хуудас цаас барьсан, урсан аль нь ч гайхаад байх юм биш гэнэ. Хэд хоногийн дараа Италийн парламентад мөн явдал болсон нь Гүндалай уруу татсаных бус, италичууд уг бусармагийг дэлхийд цацсан нь ичих нүүрээ илгэдсэнийх бас биш гэнэ. Харин их хурлын танхимд цууриатсан “шар хад” гэсэн үгийг эрэгцүүлье. Энэ нь цаазын газар, галзуугийн больниц гэсэн эрт, эдүгээн хоёр тайлалтай. Дарангуйлалын үед тэрслүү үзэлтнээ солиотой хэмээн хатаах буюу хороодог байсныг өгүүлэгч бодоогүй гэхэд үг бүхэн утга үүрдэг ухаан санааны засаглал сум агаад эм гэдгийг ухаарсангүй л дээ, хөөрхий. Тэгтэл бас Сүхбаатрын талбайд хэдэн “салга амбан” зогсож үнхэлцэг хагалан алдав. Эзэд нь амин зулгын газраа үнэгүй хувьчилж авна гэж буй бололтой.

Харин зурагтаар миний өрөөсөн “хуучин хааны луучин гуталнууд” “өлгийтэй өтгөс” цасан бүрхүүл, алаг чулуун зам, зүлэгний хайс хэмээн аашлах нь тэр. Тэмцлийг тэнгэрт хийж, тааламжтай тавдах улирал нэмэлттэй биш. Гэтэл нөгөө хэргийн эзэн газрын хуулийн тухай таг. Энэ нь мөнөөх элдэв ял хүүдийлж мушгин хилсдүүлдэг сэтгэлгээнээс салаагүй, гол гогцоог барих дотоод ертөнцийн эрх чөлөөг эдлэж чадаагүйн харгай. Дэндүү энгийн өөр нэгэн жишээ татья. Эдийн савангийн чимэг заранд адуучнаа хатсан улаан дээлт мулгуу унаж яваа мориноосоо гулжийн годройтход эхнэр нь орны даавуу угаадаг. Үүгээр бол нөгөө гайхал мориноос төдийгүй орноос ойчдог бололтой. Халширсан бүсгүйн царайг харвал “энэ маань намайг найдлахаас цаашгүй” хэмээн өгүүлэх мэт. Учир зүйн холбоо тасарваас ийн буюу. Үүнээс үүдэхэд бизнесийн хэмээдэх “шушмаа”-нуудыг яая даа байз. Хаа явсан газраасаа хагас үг зууж ирээд хаалгаа цоохорлосноор дэлхийн дэвжээнд гарах нь юу л бол. Тэдний эмнэлэг, цай хоолны газрын үүдэнд дөрвөн далай гатлаж дөрөө мултлан шавааралдах нь үл харагдана. Нүд тайлсан хүн нүх бүхэнд шургаа гэж үү. Харин монгол хаягтай бол халтар ураг нь халаасаа тэмтрэх биз. Тун сая л гэхэд “ассоциазаас номинацаар брээнд” олгоно гэж сүржигнэв. Англи хэлээр ам нь дүүрээд, алд бие нь монголд томдоод байгаа юм бол хоормог холилгүй сонгосон хэлээрээ ус цас шиг урсгаач ээ. Чадахгүй юм бол өмдгүй байж малгайгаар яанам билээ.

Улаанбаатар монгол туургатны голомт атал харь хэлээр бичсэн хаягнаас болоод үндэстэн дотроо үүд олоход бэрх болов. Тусгаар улс өөрийн хэлийг дагалдуулан бусад хэлээр бичдэгийг эзэд нь мэддэггүй юм болов уу. Тэдэнд хандаж Чингис хааны зовж байгуулсан улсын минь туурганд өчүүхэн бидэнд зориулж өөрийнхөө яруу алдрын дуулалыг монголоор бичиж хайрла гэж гуйхаас даа. Энэ тухайд нийслэлийн захиргааны үүсгэл нэхэл хатуу байгаасай.

Монгол улсын хэлний хуулийг эрдэмтэн мэргэд, эзэн түмний саналыг цомойлон нягтлаасай. Улсын хэмжээнд нэр томъёог эрхлэх эзэнтэй болгож, харь хэлнээс авах гээхийг нэгэн мөр болгон цэгцлээсэй.

Үндэсний хэл нь далай лугаа элдэв хог буртгийг хаялагаар хөөж ариусдаг жамтай боловч эздийн ивээлд оршихуйн учир хэл зөрчигсөдтэй “зоосоор” хэлэлцэж оюуны нь тагжрааг зэтгэх үндэсний дэгийн дарангуйлал, оюуны ноёрхол хэрэгтэй. Учир гэвээс эх хэл эвдрэх нь сэтгэхүйг ээдрээж, сэтгэлийг хиртээж, үзлийг үргээж эх оронч элэг эгшээдэг билээ. Монгол улсынхаа өрхний оосрыг монголоо алдаачдад өгвөөс хошуулдан хошуулдсаар бүтээчихэж чадна. Сэрэмжлэгтүн.

Монгол хэл минь тусгаар тогтнолын тулгын нэгэн чулуу. Хөдөлгөж үл болно. Элэнц дээдсийн засагласан хэл, эзэн хааны зарлигийн бичиг бидэнд бий. Эвдвээс, эцэг тэнгэр гэсгээн түүх биднээс ял асуух өдөр буйг ухаартугай.

Даалууны гуншин буюу тоглоомын шоглоом

Даалуу буюу “Жаран хар” хэмээх нэгэн зүйл тоглоом монгол газар хүрээ хөдөөгүй элэнц хуланцаар улбаалан өнөөг хүрчээ. Уг нь өмнөд хөршийн үүсэлтэй гэх энэ тоглоомд ургуул гарал, монголжсон шинжийн ул мөр аль аль нь бий. Даалуу гэдэг нь хятадаар “их зургаа”, үүлүү нь “тав зургаа”, Сийлүү нь “дөрөв зургаа” эрлүү нь “хоёр зургаа” гэсэн тоон нэрийдэл

ахул, бажгар, шанага, сарлаг, нохой, бөхөөн гэх мэт манай өтгөсийн оноосон нэрийг анзаарч болно. Харин “тавнаг” гэсэн нь “тав, нэг” гэж манайхны оноол бололтой. Өмнөд хөршийн үүслийн шивнээ даалууны гуншин буюу мод цоллоход ажиглагдана. Жишээ нь “чанс” хэмээх зургааг “Янгиа зургаа ясчин хятад”, бөхөөн дөрвийг “Бөхөөн нуман дөрөв, Бөөдий хотын данжаад” гэх буюу мод зүлгэж сонгож хаяхдаа “данжаадын хүү далиу нүхлээгүй бол...” гэж хэлдэг аж. Үүнийг хэлхэгч вээр уг тоглоомын тухайд судалгаа хийх нь бус, даалууны гуншинг аман зохиолын хувьд нь шохоорхсоноос үл хэтрэнэ. Одоо үед орон сууцны хороололын дунд хаа сайгүй дэвжээ засч тэтгэвэрийн голцуу хөгшид “жаа” хэмээгчийг тоглон цаг хулжаан зугаа гаргах нь хавтгайрчээ. Тийм тоглоомчдын дэргэд нэгэнтээ би саатахул нас хэвийсэн дорсгой хөх эрийн мод цоллох нь чих чимэв. Түүний тогтож ядсан харц, ойж буусан хөдөлгөөн, гүрээний судас нь гүрвэлзэн, атираат магнай нь агшиж тэлэх тоолон хоёр чих хулмалзах нь залуу зандандаа нохой шуугиулж явсан эрийн шинжийг илтгэнэ. Харин түүний шүд унаж, тарваганых мэт үүдэн хоёр дорсгой санжганан үлдсэн тул шүлс үсчих нь надад тийм ч таатай санагдаагүй.

Тоглоомын эрэмбээр мань эр майхан алдаж, сүүдрэвчний сандалд хөл ачин дугуй хайрцагтай улаан тамхи гарган сонинд орооход нь би янжуур сарвайвал,

-Наадах чинь ханиалгаад байдаг юм. Нар, нарс хоёрт насаар салаагүй болохоор надад энэ нь дээр гээд авсангүй. Түүний ийн хэлэхийг сонсоод яагаад ч юм бэ, ам цуурсан хэргээр аавынд элэгдсэн “гулиа” Лувсанбалдан хэмээгчийн тухай чих дэлссэнээ санаад өрөөсөн бойтог нь болов уу гэх бодол зурсхийсэн боловч зүрхлэн асууж чадалгүй,

-Алдар хэнсэн билээ гэвэл,

-Муу хөгшин чинь төрд төмөр данстай амьтан. Уг нь нэг нэр чаргуулж явсан ч одоо бараг мартагдаж, мэдэх нэг нь “дорсгой” л гэдэг юм. Энэ хоёр ногооныг ойчихоор “онгорхой” гэнэ биз.

-Та даалуунд даналзах бололтой юмаа.

-Буруу хойшоо. Хот хүрээний луглагаруудын дэргэд хүүхэд нохойн доог явсан. Тэгэхдээ ам, даалуу хоёрынхоо ачаар аавын будаатай хярамцагийг бурхны хишиг гэж хүртсэн, хөөрхий.

-Мөрийтэй тоглоомын хэрэг гэсэн үг үү?

-Тоглоом шоглоом аль аль нь гэх үү дээ.

-Бас улс төрийн хэрэгт холбогдсон байх нээ?

-Тийм шүү юм. Даалуу даравгар хоёр л доо.

-Юу гэсэн үг вэ?

-Сая чи намайг донгосч байхыг чагнаа биз дээ. Авсан өгсөн, ам цуурсан гээд хоёр зүйл анги харагдахгүй байна уу?

-Ямар гуншин хэлж ял зэмэндээ хүрсэн юм бэ?

-Мартаж орхиж. Мартнаа гэдэг чинь маниас байтугай Марксаас өмнийх гэдэг биз дээ. Хэл хальгарсан байхад хэлээгүйг бас тулгана. Ухаандаа энэ муу даалууг хаяхдаа “Улаан халзан пай жалсан, улсын мангаа Чойбалсан” гэсэн гээд л “маршалыг мангас” гэсэн ч бил үү ноцоод л байсан. Одоо бол одон өгөхөөр шахуу юм байж хэмээн мушилзав.

-Таних танихгүй хүнтэй тоглох гэмтэй байжээ?

-Ялгаагүй. Цаадул чинь архи даалуу хоёр байтугай, авгайн ичээнд шургана гээч. “Тулиа” бандгайн хэлснээр цоож үмхүүлээд “Нүд гэж нүх, шүд гэж шүлс” болсон хойно л хог дээр гаргана шүү дээ. “Тулиа” Лувсанбалдан хэмээгчийн тухай санаад орсон нь оножээ хэмээн яриа өдөхийг хэдий хорхойсовч дэмий хадуурахаас эмээв. Харин сайхь эрийн тэлмэн асгарах бэлэн үг, бичгийн утга зохиолын эрхэнд автаагүй задгай цэц, хочлон хоросгох аяс, цаг үедээ тэрсэх гоочлоонд мөнөөх домогт “тулиа”гийн ч юм уу “ташийшогойн” хэмээх Түдэвийн Гочоотой ижилсэх өвөрмөц онцлог байгааг хэрэгшээж билээ. Даалуунд гуншин гэж байх атал, төрөлсөж болох “хөзөр” хэмээх тоглоомд ийнхүү цоллох жишиг байдаггүйн учрыг бодовч эс олов. Боолыг хатан, хатныг ноёноор дарж буй нь нийгмийн ойлго атал, яагаад “янтгар хатан зарга шүүдэггүй” “эрийн муу эмийн дор” гэх мэтээр хэлний хялуу гаргадаггүй нь хачин юм шүү.

Дорсгойд ая тал засч ам халахын тулд би “залуу зандандаа тоглоом сураагүй болохоор өдөр өнгөрч өгөхгүй зовдгоо учирлаж хэдэн модны гуншин хэлж өгөхийг царайчлав. Дорсгой мөнөөх тарваган шүдээ ёрдойлгон инээж.

-Даалуу чинь гурван зиндаатай. Их гарын жаачид цоллодоггүй. Даалууг “пай” үүлүүг “үүл”, сарлагийг “мал”, нохойг “гөлөг”, чүүг “чүлтэм” гэхчлэн хаяна. Дунд гарыхан буюу “шалдан жаачид” л хуцаж өгнө дөө. Бага гарыхан гэх авгай хүүхнүүд “зургаан хүний тавил”, “таван хүний үүпээ”. Хөгшид нь нүх шахаж өөрийгөө зугаацуулдаг юм. Гуншин гэвэл нутаг нугын вандан ондоо. Дээр үед Амгалангийн “Саранпай” Цэнд гэж ёстой нэг хуцдаг халтрыг үзсэн. Би бол түүний дэргэд уулгамч чавганц. Уг нь би цолны жаачин биш. Алба хашиж явсан амралтын газрын “тэмээн” жаачдад тааруулж байгаа юм гэснээ над руу бөхийн аминчилж “Эд нар чинь майхны зуун янчаанаар үздэг. Эхлээд хэд хожигдож өгөөд хохирсон хүн болж хоёр гурван мянгаар боож хамчихаад л зайлдаг. Наддаа талхны мөнгө. Мань мэтийн тэтгэвэр юу билээ. Өлөн гэдсний өнгөр төдий...”

-Боолтод хожигдвол яахав.

-Тэр номонд хазгай. Хоёр гарын арван мод чинь хонь хурга шиг нийлнэ. Холих гээч нь тэр. Даалууны илбэ л юм. Эдний нүд гүйцэхгүй...

Ийнхүү үг сольсны бөгсөнд тэрвээр надад хэдэн гуншин хэлж өгсөн юм. Түүний хэлэх бүр нь ялгаатай, бас заримдаа амны цээр алдаж байв.

Даалууны гуншин нь аман зохиолын зүйлд урагсах учир цаг үеийн нялзвартай аж. Жишээ нь даалууг “ эзэн хааны эрээн иштэй хутга”, үүлүүг “үүцэг түгжийн бороохой толгойт”, сийлүүг

“Сэмбэн сийлүү, сэтгэлтээ Донгоо”, бажгарыг “Дурдан бажгар дурсхийж, Дугарын сүм гозосхийж” худийг “Хунчил Цавчил ягаан яатуу, хуучин цагийн Түмэн эх” тавнагийг “Таахай булуу тамжидсан, тарганы ажаа гожинсон”, бөхөөнийг “бөхийж бай бэрээднэ, тонгойж бай торлогдоно” Вандыг “ванлаг вангийн хүрээ, байшин сүмийн нуруу”, чүү тавыг “хүүхдийн эцэг хүрэн бор гэлэн” сарлагийг “мал малын зах манай ноёны сүрэг”, тавнагийг “тайжийн жинс”, ёозыг “Ёозон хуазын цэцэг Ёзон хамбын гар хөл” гэдэг асан нь үүнийг гэрчлэнэ.

Давхрын жаа буюу гурван хожлоор (майхан авал) тоглоомд хамгийн адтай нь нэг нь нөгөөгийнхөө өгсөж уруудсан хожлын модыг тосгуулж цохих (духдах) хожил аж. Духдаж буй нь:

“Амбан явдаггүй замаар

Амаа мэдэхгүй азрагатай” хаа хүрэх нь вэ гэдэг байснаа

“Чи байтугай

Чингис яваагүй”

“Анжгай байтугай

Америк яваагүй”

Захын ямбий машинтай

Заазан сарампай онгоцтой

Хаа хүрэх нь вэ

Хай гэдий!...гээд

“Дураа цааш нь

Духаа нааш нь ...

“Татвараа нааш нь

Тархиа цааш нь...

“Торгуулаа нааш нь

Толгойгоо цааш нь”...

“Гаалиа нааш нь

Гавлаа цааш нь”... гэх буюу

“Намаар явалгүй

Замаар яв”

“Засгаар цадахгүй

Зусагаар цадна”...

“Миний замаар

Мисс-д очно

Таны замаар

Траншейд орно” гэх зэргээр хорыг нь малтдаг болжээ.

Хожигдлын шившигт духдуулахаас гадна тархинд үхэх, тавьж өгөх хоёр орно. Ийм үед

Хормойн ганцаас хэтрээгүй

Хоногийн борыг тэврээгүй

Хонго нь нойтон нусгай

Хотын сайчуутай тоглодоггүй...гэх буюу

Авсан өгснөө мэдэхгүй

Авааль яваалаа ялгахгүй

Аргал усны ангаахай

Аймгийн сайчуудтай тоглодоггүй...

Ам цуурсны

Арван жил...

Тавьж өгсний

Таван жил... гэж ял асуухын цаана мөнгөний тоог нууцаар хэлдэг аж.

Духдах нь бахтай хожил бол, харин суусан мод ижил хирнээ досгуул таарахгүй бол хожилд үл тооцно. Үүнийг хүйтэн бөгс тэврэх гэдэг байна. Ийм тохиолд,

“Нүүсэн айлын бууринд

Нүцгэн битгий мөлх”

“Айлын авгай самардаж

Аарцгаа зад тийрүүлэв ээ”

“Өгдөгөө өг

Өмдөө тат”

“Тэвэрдэгээ тэвэр

Тэлээгээ тат” гэхчлэн шалжаалах гэнэ.

Дорсгойн хэлснээр, гуншин нь найзан дунд наргиан бөгөөд бас сэрэмж алдуулж гарын болон газрын мод сэм холих, айлд тогловол авгай хүүхнүүд уяраан аяга цай, аягүй бол гожин юм гаргуулж гол төмөр халаадаг гэнэ. Тэrvээр гэнэт сэхээ авсан мэт

-Би чинь хаанахын хэн гээчтэй буу халж сумаа барж орхив доо гэхэд, би нэр усаа, бас цаас эрээчдэгээ хэлбэл,

-Яамных л биш бол яахав. Би чамайг мэдэхгүй юм байна. Муу хөгшин чинь номонд ногоон нохойд бараан амьтан. Эргэж уулзах онь хөтөл таарвал тэр биз. Шувуу бид хоёр ч нутаггүй дээ гэсэн юм. Үнэхээр би энд тэнд даалууны буланд юу магад хэмээн сэм горьдовч тусыг эс олсон тул түүний нэг л хувилбарыг элбэн дэлбэн эвлүүлж эрээчсэнээ, гаргацтай болговоос дараахи мэт болой.

Даалуу. /арван хоёр/

Албанд уясан

Амины сейф

Араар шуусан

Алаг жип

Өртөй босс

Өттэй зоос

Өчигдрийн лай

Өнөөдрийн гай

Хамбан нөмрөг

Хаш хөөрөг

Жанжин малгай

Манжин толгой

Үүлүү. /арван нэг/

Үүлээр уйлсан бороо

Үерээр урссан шороо

Үхрийн үнэтэй ууц

Үгүйрч үлдсэн бууц

Данжаадын наадгай

Даргын нуудгай

Гэртэй гэсээнз

Гэээгтэй лиценз

Сийлүү. /арав/

Арав дөрвийн хээл

Аваад өгдөггүй зээл

Анаж ольдог цүүц

Алаг хогны ТҮЦ

Бажгар. /арав/

Хурган даргын нүд цоохор

Хужаа панзын шүд цоохор

Хувийн тэрэгний гадар цоохор

Хуурамч эмийн дотор цоохор

Дэгээ ес.

Хуучин хааны зүтгүүр

Хулгар харын зүлгүүр

Хугас иштэй сэлүүр

Хулсан голтой бүлүүр

Дээд найман тахил

Дэгээ есөн цацал

Улаан ес

Эрэлхэг чонын хөх гавал

Эрээн лууны хар гавал

Эргүү баавгайн улаан гавал

Энэ бидний эрээн гавал

Хунди. /найм/

Тендерийн шантгануур

Жендрийн жандгануур

Эрийн там

Эмийн гэм

Торгонд боосон эмээ

Тосон будагтай ямаа.

Дөнгө. /найм/

Дотор газрын дөнгө

До яамны занга

Доогуур харцтай шиншүүр

Долоон голтой доншуур

Муруй найм

Ангийн дайсны сэнтий

Ардын цэргийн сэлээдий

Адуунд тавивал азрага

Айлд дэвсвэл адсага

Шор./долоо/

Эцэг өвгийн шор

Эрээний захын хор

Эр хүний шөвөг

Эм хүний түвэг

Шанага долоо.

Засаг дамжсан

Заарьтай гуя

Зах зээлийн

Саарьтай хөл

Тугалаас булаасан

Тулмын шанага

Туулаар сүлсэн

Тунгийн халбага

Сарлаг долоо.

Хангай ханы савдаг

Хаданд ургасан саваг

Халуу хаагсан сарлаг

Хадуурч хатгалын хайнаг

Чанс. /зургаа/

Шөрөг ханын ташуу зургаа

Сөрөг хүчний зөрүү зургаа

Худалч намын хулхи зургаа

Хууль номын цоорхой зургаа

Нохой. /зургаа/

Айлын хотонд банхар

Албаны үүдэнд жингэр

Авилгаа хөөвөл албин

Алдуурч тэнэвэл золбин

Тавнаг. /зургаа/

Тартаг эрийн

Тавхайн матаас

Тагнуулын газрын

Тавгай хадаас

Мунаг эрийн

Зүрхний чулуу

Зөнөг нохойн

Зүүдний булуу

Чүү. /тав/

Авхайн божго

Амин судас

Амрагийн можго

Алтан гадас

Ямбаны жижүүр

Янагийн тариур

Янхны гэтэвч

Ялтны хөтөвч

Бөхөөн. /дөрөв/

Адуучны мойног хуруу

Аргалчны бөгтгөр нуруу

Ахайтны торгон оймс

Аянчны тоостой бойтог

Ванд. /дөрөв/

Албаны уулганд

Алтан дөрөө

Амин зуулганд

Аяганы ширээ

Азын шоогоор

Цалинтай вандан

Алдахын тоогоор

Цаазтай тавцан

Ёоз. /хоёр/

Социализмын сохор зоос

Капитализмын халтар цаас

Хонгилд гарсан гэрэл

Хорвоод харсан нүгэл...

Дорсгойн хувилбар яавч нэгээхэн бус. Тэрвээр үүнийг чинь би олон вандангийн булангаас түүсэн юм. Ер нь гуншин бол золбин эд. Амтай нь ангайж хэлтэй нь хэлхэнэ. Халхын хавтгайд халуурдаг хүүхэд алийг тэр гэх вэ. Муу хөгшнөө битгий чонын хүзүүнээс зүүгээд тавьчихаарай гэж үнэнээсээ гуйсан юм. Би түүнд цаг өөр болсныг итгүүлэх гэсэн боловч,

-Наашир гэхгүй шуу л байна. Наар нь зайгүй юм болов уу даа гэж уйтгартайхан өгүүлж билээ.

Дорсгой хаанаа явааг үл мэднэ. Магадгүй алдарсан итгэлээ эрж яваа ч юм билүү. Ямар ч атугай түүний хувилбарт утга, авцалдаа оновч алдсан, гүехэн цэцэлсэн зүйл байвч өөрийн нь хэлснээр ам дамжсан эл чуулбарт эзэн оноож утга зохиолын шүүлтүүрт тунгаах нь гэнэхэн буй за.

Хархорум судар хот

1346 онд монгол, хятад хэлээр сийлсэн чулууны бичээс нь “Чингис хаан их ор-аа сагугсан арвантавдугаар он Гин-луу-жил дүр Хорум-аа сагугу балгасун орши гулугсан ажгуу” хэмээжээ. Энэ бол эзэн хааны зарлигаар тогтоосон улсын голомт хэмээн хойчийн бидэнд илгээсэн дээдсийн захиас авай. Тийм ахул энэхүү дархан голомтыг бөхөөх харийн ноёрхлын хар санаатай бидний үеийнхэн эвлэрэн суух аваас эх орны заяа гомдоно.

2004 оны намар миний журмын нөхөр Бирагийн Чимидийн тоомсорлон захирснаар “Хархорум-жишиг хот” чуулганд оролцох хувь надад тохиож билээ. Тус хурал дээр УИХ-ын дарга Н.Энхбаяр, Ерөнхий сайд Ц.Элбэгдорж нар эртний хотоо эзэгнэж сэргээх санаа нийлэмжид нь олзуурхан “Улс төрийн хүчнүүд өөдөөсөө харж суугаа үед энэхүү нэгэн их үйлийг эрчимтэй үүсгэхийг” хичээнгүйлэн гуйснаа санаж хэсэг бусаг санаа хэлхэж буй минь энэ.

Эрт цагаас Монголын уугуул болон нүүгүүл аймгууд Орхон голын цэнхэр хөндий рүү тэмүүлж, орд өргөө барьж асан нь нүүдэлчдийн зоргоор сэлгүүцэл бус чухамхүү энд их хотын буурь нутаг үзэж сонгосон үнэнхүү мэргэн ухаан ажээ. Энэ нутаг бол эсгий туургатан, самбар үүдтэн алинд ч идээшилтэй уул ус хөрс жигдэрсэн байгаль эхийн ээлтэй өлгий агаад улсын хүйсэнд оршиж буй нь чин бишрэлтэй.

Молхи миний бие ирээдүйн Хархорумын тухай сэтгэлдээ зурьюу хэмээн цагаан мөрөөдөл буйлуулснаа уншигч авгай танд өчсү. Нэгэн цагт орчлонгийн олон орон гүрнийг холбон дээвэр дороо дэлхийн хэрэг хэлэлцэж асан хотыг шинэчлэн бүтээхдээ юуны өмнө “судар хот” гэсэн санааг тулгуур болгоосой гэж би хэлэх гэсэн юм.

Миний зэрвэс харсан нэгэн зураг сайжруулсан сибирийн тосгон гэмээр санагдсаныг үл өгүүлэн өгүүлэх ину:

Хархорум хот өрнө дорнын уран барилгын өвөрмөц цогцолбор, хот байгуулалтын монгол нээлт, алхам бүр нь түүх өгүүлсэн хот байгаасай гэсэндээ “судар хот” хэмээх санаагаа ивээд байгаа юм.

Хархорумын зураг төслийг бүтээхдээ зуур хоногийн бус зуун дамнах ухаан бэлчээж урлаасай. Аялал жуулчлалын бааз төдийд бус алсдаа Монгол улсын нийслэл байх санааг анхны чулуутай нь хамт тулах юмсан. Нэг удаа “Улаанбаатарыг Хархорум руу нүүлгэх үү” гэсэн асуулт гудамжаар зорчигчдод тулгаж “үгүй чийш” хэмээн цовхчуулсан нэвтрүүлэг харснаа санаж байна. Хүмүүсийг хүчирхэн төөрүүлэх ийм суртал би нэвтрүүлэх гээгүй. Өнөөгийн Улаанбаатар минь дөрвөн уулын дундаа дархан ханхайж бас нэгэн сайхан хот бахархал болон сүндэрлээсэй гэж залбирна. Дэлхийн жишгийг харахад шинэ нийслэл гэдэг хуучин хотоо буулгаж ачаалаад нүүх бус төр засаг, яам тамга буурь сэлгэхийг хэлдэг юм билээ.

Хархорум хотын төв болон бусад талбай тэргэл дугуй хэлбэртэй байвал нар, сар, гэрийн гэгээн гурван тойрог буюу эвийн хүрээ хэмээх монгол язгуурын бэлэгдэлд нийцэлтэйеэ.

Хотын төвийн их тойруулган талбайд есөн цагаан сүлдний хүрээлэнд монгол улсыг дэлхийн чихнээ сонордуулан тунхаглаж буй Чингис хааны дүр ургаад байгаа юм. Төв талбайн хоймор УИХ, баруун этгээдэд Ерөнхийлөгчийн, зүүн этгээдэд Засгийн газрын ордон, өлзийт үүднээ алтан аргамжийн гадаад хэргийн яам байхаар мөрөөдье.

Франц гэлэн Гийом Рубрукийн тэмдэглэлд “...Хаантны өөдөөс харж ар нуруугаа “мөнгөн мод” руу харуулаад зогсож байсан...” гэж бий. Энэ нь сайхь мөнгөн мод их ордны дотор байсныг нуталсан гэрчийн үг. Харин одоо шинэчлэн байгуулахад мөнгөн модны талбайг тусад нь буйрлаад “Монголын нууц товчоо” морин хуур, шинжлэх ухаан, соёлын дурсгал бүхий театр, номын сан, музей цогцлоож болох мэт.

Хархорумд өргөөлж асан их хаадын нэрэмжит талбай байхаар бодъё. Тэгвэл Өгөөдэй хааны талбайд зам тээвэр, холбоо, нийгмийн хамгааллын, Гүюүгийн талбайд сангийн болон эрүүл мэндийн яамд, Мөнх хааны талбайд хотын захиргаа гэх мэт багцаалвал мэдэхгүй миний үг мэргэн түргэнд тус болох ч юм бил үү.

Хотын гудамж, хорооллыг өдгөөгийн Улаанбаатар мэт, хорьдугаар зууны хормой дор эргэлдэн хэдэн дарга нарын нэр оноох, эсхүл дугаар хороолол хэмээн бүдүүн тоймоор багцаалалгүй түүхэн дээдсийн болон овог аймгуудын нэрийг мөнхжүүлэх буюу хамаг монгол, тайчууд, мэргэд, хэрэйд, найман юм уу өрлөгүүд, баатадын нэрэмжит байж болох мэт. Үүнээс гадна түүхэн сурвалжийг түшиглэн Саррицыны, /араб-персийн гэж болно/ нангиадын болон монголын хороолол байваас олон үндэстний эеийн тооно байсныг эрхбиш сануулах буй за. Саррицыны дүүрэгт лалын сүм Ил хаадын дурсгал, Жувейний буусан газрын тэмдэг, нангиадын дүүрэгт Хубилай, Тогоонтөмөрийн дурсгал, зах дэлгүүр, монголын хороололд Буддын сүм, түүний дотор Хэрэйдийн хэсэгт христийн сүм, Рубрукийн орхисон гэх зургаан загалмай, мөн тэр орчимд франц дархан Бушье, орос дархан Козьма нарын орон гэрийн шав дурсгал байж болно.

Хархорумын түүхтэй түрүү их хаадаас гадна Отчигон ноён, Аюушридар, Аригбөх, Чингай чансан улмаар Батмөнх даян хаан, Авгай сайн хаан, Түшээт хан Гомбодорж гээд олон хүний үйлс холбоотой. Тэдний нэр бүхий гудамж, дурсгалын самбар байж таарна. Хотын захиргаа гэхэд Төмөр ноёны дурсгалын бичээс байх биз. Би энэ бүхэнд хувьсгалын үеийн хуучин шинэ дарга нарыг алагчилсандаа бус, эртний хотын түүхэнд эрхмүүдийн нэр чимэг зохихгүй. Хотын гудамж гэхэд тэрэг хөсөг тээглэхгүйг бодолцох юмсан. Албан газар, аялал жуулчлалын бааз бүхэн зогсоолтой, айлын сууц, зочид буудлын гараажтай байх мэтийг аар саарт бодон анзааралгүй орхиж болохгүй биз дээ.

Манай археологчдын ухаж түүсэн хэдэн чингэлэг олдвор музейн сайхан үзмэр болно. Түүнийг зэвгэр хадан хайрцганд бус чамин тансаг, уламжлалаас хийсвэрлэсэн уран барилгад дэлгэн тавих сан. Энэ мэт эртний түүхэн хэлхээ Эрдэнэ Зууд бөөрлөн наашлах учиртайяа.

Аялал жуулчлалын зам баруунаа Орхон голыг хөвөөлж, Бага хүрээ, Их хүрээ хүрч болно. Алсдаа Төвхөн хийд ч ойртоно. Хархорумын чулуун мэлхийнүүдийн нэгэн буюу гүйцээж эс чадсан чулуун мэлхийг үзээд, Бага хүрээнд Норовбанзад модны дэргэд морин хуур, уртын дууны эгшиг сонсож, Их хүрээнд морин поло, монгол бөх, морь, сур, бас айлаар орж айраг шимж, идээ цагаа боловсруулах монгол аргыг үзвэл харийн аянчдын сониучлалын таалалд нийцнэ. Умар зүгт Уйгарын хар балгас, дорно этгээдэд Хөшөө цайдам дахь Түрэгийн дурсгал ч аялалын замд холбогдохыг дэд бүтцээр нийцүүлэх буй за.

Саянаас онгоцны буудал барих газрыг мэргэн онож товлосон тухай мэдээлнэ билээ. Тэгвэл алсдаа төмөр зам тавих тухай бас үүн шигээ эртээс нүдийг нь олвоос аятай юу даа.

Пакистаны шинэ нийслэл Исламабадад очихдоо анзаарсан нэгэн зүйл маань алив орон байшин барих бүрдээ эхлээд зам тавьсан тухай тэдний өгүүлсэн нь санаанд хоногшжээ. Энэ нь байгаль орчныг хамгаалахтай авцалдана. Эс тэгвээс барилгын элдэв ачаа тээсэн их даацын машины мөр газрын хөрсийг урна гэсэн үг. Тэгээд ч манайхны дуртай газраа дугуйгаар хэрчин талхалдаг муу зуршил давтагдаас гангийн тойром болдог гамшиг нүүрлэнэ. Энд бас Орхон голын тухай нэхлийг Туулын эмгэнэл сануулнам бус уу. Хангайн нуруунаас ивэлсэн эх газрын эл мэлмэрсэн дээжинд бузар бургтгийг үл хүргэе. Энэ бүхнийг үглэхийн учир гэвээс байгалийн унаган төрхийг сэвтээхгүйн тулд болой. Үүнээс учиглаваас Хархорумыг жишиг хот болгох ажлыг замаас эхлэх юм биш байгаа даа. Эс тэгвээс халцалсан газрын үлд дээр голынхоо зүлгийг хуулан нааж үхшрүүлээд хангайн цагаан салхиар хавтгай улаан тоос хурайлна. Модыг ч гэсэн уулнаас зулгаан авчирч борцлоод ёдорлохоос зайлсхийх юмсан. Улсын бүх аймаг хот нэрэмжит цэцэрлэг байгуулж, алсдаа хуримын хос, төрсөн хүүхдийн сэтэртэй мод тарьж болно. Нэр заасан мод гэхэд бэлэгшээх хүнтэй додомдох эзэнтэй байна гэсэн үг. Бас оросууд мөнгөн гачуур, япончууд сакура, хятадууд хуайс суулгах мэтээр эвийн цэцэрлэг байгуулах үүдийг сөхөх юмсан.

Шинэ хот хаяалахдаа өргөө гэрээ хажиглаваас монгол хотын төрхийг эс ольюу. Тийм ахул гэрийн хорооллыг барихдаа ус, дулаан цахилгаанаар сүлжиж хашаа хүрээ нь цэвэр цэмцгэр байж таарна. Одоогийн байгаа тэмээ туйлсан мэт хөглөрөл, нүдэнд өргөс торсон хашаа байшинг цэгцлэх тухай зураг төсөлд дэглэн заавал эхнээсээ эмхэрнэ.

Хархорум дахь Түмэн амгалант орд гөлмөн алт цоолборлосон угалз хээтэй, мөнгөн модны

навч жимс нь цалин цагаан мөнгө байсныг эхлээд сүрдүүлэн дурсч, сангийн сайдыг цус харвуулчихгүйг би хичээсэндээ цухалзуулаад орхиё. Энэ үйлсэд эртний нийслэлтэй түүхэн холбоо бүхий Орос, Хятад, Франц, Иран, Ирак, Ватикан, Дундад Азийн орнуудыг тойлж, хүчин хавсрах арга сүйхээлвээс дэм тусыг олох юуны магад. Түүний зэрэгцээ монголчууд бид эрвийх дэрвийхээрээ хөдлөх учиртай.

Персийн түүхч Жувейни “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” номдоо Хархорумыг байгуулахад гаднын учруудыг хүчин зүтгүүлснээс гадна “...хааны өршөөл адбиш уудам учир ард иргэд дөрвөн зүг найман зовхисоос ирцгээж барилга байгуулалтад оролцон, энэхүү оронд охорхон хугацаанаа нэгэн хот байгуулав” хэмээн дурдсан үгийг эргэн санахад сургамжтай агаад үлгэртэйн цаана хүмүүсийн ажиллах, амьдрах орчныг бүрдүүлэхийн учир бас бий.

Хархорумын сууринд гурван хангай, гучин гурван говийн газрын дээжийг өлгийдвээс ашдын бэлэг оршино. Бүх аймаг, том хотууд нижгээд барилга байгууламжийг үүсгэлцвэл өлзийгөө өгнө. Түүнчлэн гадаадын болон үндэсний том компаниуд хувь хишиг хүртээх буй за. Энэ бүхнийг зангидваас, эрт цагийн улс үндэстний уулзвар хот энэ үед даяаршлын дээвэр дэлгэх нигууртай яа.

Хот балгадыг хоногийн дотор барьдаггүй учир гэрэл, сүүдрийн талыг хянан байцааж машид хичээнгүйлвээс эх орны сэргэн мандлын эрчим нийтгэсэн мянганы төдийгүй түмний бүтээн байгуулалт цогцлох сон билээ.

Хархорум зөвхөн бидний бус монгол туургатны шүтээн хот болтугай. Анхнаасаа алхам тэгш байхын тулд эрдэмтэн мэргэд, уран барилгачид, олон түмний оломгүй санаа бодлыг цомойлж гэмээнэ оновчтой шийдвэр олж чадна. Өөрийн хэрээр эрэгцүүлсэн өчүүхэн өлгөцөөр уншигч авгай нарын мэргэн оюуныг хөгжөөхийн ялдамд дээдсийн амнаас унах алтыг тосон чих дэвсэж ийнхүү бичиглэвэй.

“Учирлал” хэмээх дайвар бүлэг

Яруу найргийн шинэчлэгчид миний довон дээр ирж шээхийн тулд асар их ухрах хэрэгтэй

-Монголчууд “Болор цом”-оо тойроод л шүлэг уншаад, наадаад байдаг, Монголын яруу найраг дэлхийн уран зохиолд орсон юм алга гэж шүүмжлээд байгаа шүү дээ, өнөөгийнхөн?

-”Дэлхий” гэж яриад байгаа тэр улсууд яаж хэмжиж байгааг би мэдэхгүй юм. Дэлхийн энгээр ярьдаг тэр хүмүүсийн хэмжээнд хүрч ярьж би чадахгүй. Дэлхийн энгээр ярья гэхэд Шекспирийн г биг англи хэл дээр нь уншаагүй. Англичууд нь өөрсдөө толь харж уншдаг. Тэгээд тийм нэвтэрчихсэн улс манайд байгаа юм байлгүй. Дорно дахины утга зохиол гэж бий. Эртний Хятад, Энэтхэгийн хэдэн мянган жилийн соёл. Би тэрэн лүү өнгийж хараагүй. Тэрийг хараагүй байж “дэлхий” гэж ярих арга ерөөсөө надад байхгүй. Тэгэхээр би бол дэлхийн хүн биш. Дэлхийн яруу найргийн хэмжүүр гэж ямар хэмжүүр байдгийг тэр дэлхийн өмнөөс ярьж байгаа улстай л ярихаас өөр арга байхгүй. Дэлхий дахиныг төлөөлж ярьдаг “яруу найргийн НҮБ”-ын ч юмуу улсууд манайд байх шиг байгаа юм. Тэр улсууд л мэдэх байлгүй. Сая манай зохиолч Дарамын Батбаяр ярилцлага өгснийг би уншсан л даа. “Тэнгэр тэмтэрсэн яруу найрагч” гэж хүмүүст нэр оноосон байна лээ.

-Аюурзанын “Цаг хугацаа амсхийх зуур” номны тухай байх аа?

-Би гайхаж л байсан. “Тэнгэрийг Явуухулан ч тэмтрээгүй, Пушкин, Лермонтов ч тэмтрээгүй” гэж ярьсан байна лаа. Тэнгэр тэмтрэх онол гэдгийг би мэдэхгүй юм. Тэр шүлгэнд нь тэнгэрт гараа хүргэсэн чинь хуруу нь даарсан ч бил үү, тулсан ч бил үү нэг үг байдаг юм. Хязгааргүй энэ галактикт чинь тоо томшгүй олон эрхэс байгаа шүү дээ. Ямрыг нь тэмтэрснийг би мэдэхгүй юм. Зүгээр яруу найргийн ихэсгэл, хийсвэрлэл гэж ярих юм бол Явуухулан ухаандаа “Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би” гэж бичсэн. Тэр тэнгэр тэмтэрсэн хүн биш юм уу. Эзэн богд Чингис хаан чинь бүсээ хүзүүндээ өлгөж байгаад эцэг тэнгэртэй ярьдаг байсан. Монголчууд эртнээсээ тэнгэрт шүтэж, өөрсдийгөө тэнгэрийн үр гэж үздэг ард түмэн. Гэнэтхэн яагаад энэ үндэстэн байхгүй болчихоод сая XXI зууны эхээр баахан тэнгэр тэмтэрдэг улс, түүнийг нь баталдаг онол гарч ирээд байгаад миний ухаан хүрэхгүй байгаа юм. Пушкин, Лермонтовын тухайд би бас нэг их сайн мэдэхгүй юм. Тэдний шүлгийг Монголд мэдэж, ойлгож байсан улсууд гэвэл Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ч.Чимид гэж ийм л улсыг би мэднэ. Унаган орос хэл дээр, ардын орос хэлээр уншаад, сэтгэлийн таашаал аваад, юу нь байна юу нь байхгүй байна гэж шүүмжлэх хэмжээнд хүрсэн хүн тэднээс өөр байгаагүй. Оросын ард түмний энэ гайхамшигтай яруу найрагчид тэнгэр тэмтэрснэ үү, газар самардана уу бидэнд ер нь ямар хамаатай юм. Бид тэрийг дүгнэж байдаг улс нь ч биш. Оросын ард түмэн л өөрсдөө хэлэг. Ер нь аливаа ард түмний соёл руу дайрч, чамлаж, голж хандах бол соёлтой гэж хэлэгддэг хүний хийдэг ажил ч биш.

-Яруу найраг бол элит хүрээнийхний соёл, хэрэглээ. Яруу найргийг массын сэтгэхүйд зориулж бичдэггүй гэж их ярих болж дээ?

-Тэрийг чинь ХХ зууны туршид ярьсан. Нийтийн соёл, явцуу хүрээний соёл гэж. Тэндээс л нэг будаа зууж ирээд “май, энийг ид” гэж хүмүүст тулгах албагүй шүү дээ. Халтар зохиолч, харанхуй уншигчид нь “Болор цом”-оо хийгээд л явж байгаа. Тэр их гэгээн, яруу тансаг зохиолчид нь тэр дээр ирээдүйн зууныхандаа зориулж бичээд байж байна биз. Би шинэчлэлийг битгий хий гэж байгаа юм биш. Шинэчлэлийг амаар хийдэггүй юм. Уран зохиолын шинэчлэлийг бүтээлээр хийдэг. Аяндаа цаг хугацаа, уншигчид өөрийнхөө үнэлэлтийг өгөөд л явна.

-Өнгөрсөн зун болсон Зохиолчдын их хурал дээр хэний ч танил биш нэг согтуу нөхөр таныг “Монголын уран зохиолд гай болсон нөхөр, зайгаа тавьж өгвөл таарна” гэж загнаж байсан. Гэхдээ энэ их олон хүний үг биш байх л даа?

-Намайг ухаандаа “хоцрогдсон, задарсан муухай амьтан. Хуучны үлдэгдэл” гэгцгээж байгаа л даа. Би бол хорьдугаар зууны хүн. Бид чинь хорьдугаар зуундаа босгочихсон өөр өөрийн довтой улс. Хорин нэгдүгээр зуунаас өмнө амьдарч байсан бүх хүний довон дээр очиж шээнэ гэвэл чадахгүй. Тэр дов руу очиж шээхийн тулд өөрсдөө асар их ухрах хэрэгтэй бөгөөд ухарсныхаа дараа бас авирах хэрэгтэй болно. Үнэнийг харах нүдгүй байж болно, үхлийг хүлээх тэвчээртэй бай. Булшин дээр минь та нар ялалтын марш эгшиглүүлж болно оо, бурхан тэрнийг чинь сонсохгүй гэж би тэдэнд хэлмээр байгаа юм. Би ерөөсөө энэ залуучуудыг харааж байгаагүй. Юугаараа би тэдний өмнө буруудаж байгаа юм гэвэл цаг үеийнхээ хэдээс ганцаараа амьд үлдчихсэн, одоохондоо амьд байгаа минь л буруу байх. Миний амьд байгаа минь утга зохиолын шинэчлэлд ямар ч саад болохгүй шүү дээ. Тэд нар надаас “Яаж бичих вэ” гэж асуухгүй, би ч тэдэнд “тэгж бич” гэж заахгүй. Хэлэх ч үгүй, би. Яагаад саад болоод байгаагаа би ойлгодоггүй юм. Цагаа болохоор л би явна шүү дээ. Цагаас нь наана явуулмаар байвал, бас тийм арга зам байдаг бол түүнийгээ хэрэглэж болно шүү дээ. Зовлон жаргалыг би социализмтай, капитализмтай, бүх юмтай нь үзлээ. Одоо бол надад тийм их хоргодоод байх юм байхгүй. Ямар нэг аргаар зайлуулах барих тухай ярьдаг юм гэнэ лээ. Ямар нэгэн аргаа хэрэглэвэл хэрэглэнэ биз.

-Шинэчлэгчид, 90-ээд оныхон гэж ярьдаг. Төрийн шагналт Б.Лхагвасүрэн 90-ээд оныхны тухай “Монголын яруу найрагт орж ирсэн босоо цагаан давалгаа” гэж хэлсэн. Дашибалбар агсан тэдний тухай “Яруу найраг дахь нялхсын өвчин” гэж том шүүмж бичсэн. 90-ээд оныхны тухай ганц ч үг хэлээгүй хүн бол та. Яагаад?

-90-ээд оныхон гэж ямар улсуудыг хэлээд байгааг нь би сайн мэдэхгүй байгаа юм. Ичинхорлоо, Хулан эд нар нь л лав ордоггүй юм шиг байна лээ. Мөнцэцэг эд нарыгаа болохоор “тоодгорууд” гэж хэлээд байх шиг байгаа юм.

-Яагаад?

-Утга зохиолын салбадайнүүд гэсэн маягаар хэлж байгаа юм байна л даа. Хэн нэгнийг “тоодгор” гэж хэлж байвал заавал хариу сонсоно шүү дээ. Тэгж хэлснийх нь хариуд ядаж “Можгорууд” гэнэ биз дээ. Тэгээд “тоодгорууд”, “можгорууд” хоёр чинь хоорондоо зодолдоно биз дээ. Тэгж байх ямар хэрэгтэй юм бэ. Тэглээ гээд Монголын утга зохиолд юу ч авчирч чадахгүй. Хүнийг яаж үзэх вэ гэдэг хувь хүний үзэл байдаг л даа. Тэрийгээ үндэсний утга

зохиолын хэмжээний ойлголт болгоод зарлаад байх хэрэггүй шүү дээ. Хамгийн гол нь “Би сайн, би мундаг” гэдгийгээ хүнээр хэлүүлэх ёстой юм, өөрөө хэлэх биш. Жаахан тэсвэртэй байгаад сайн юм хийгээд байвал аяндаа хажуунаас чинь хүн хэлээд өгдөг юм. “Хөөе наана чинь ёстой мундаг хүн байна” гээд. Залуу улсууд байна жаахан хүлээгээд юмаа хийгээд бай л даа. Нэг л өдөр гараад ирнэ, юунд ч дарагдахгүй. Юм хийж чадахгүй, тэгээд “би мундаг” гээд зарлаад байвал нэг л өдөр мартагдсан байна. Хэнд ч танигдалгүйгээр мартагдсан байна. Энэ бол зохиолчийн хамгийн эмгэнэл. “Элит хүрээний цөөхөн уншигчид зориулж бичнэ” гэж байгаа юм, бичиг л дээ. Тэрийгээ “массд хамрагддаг муусайн уншигчид уншлаа, та нар юу юм бэ” гэж тэднийг загнаж байх хэрэг байхгүй шүү дээ. Урлагийн бүтээл гэдэг юмыг тэр баячууд нь цадталаа идэж байхад ядуучууд, борчууд нь бас ам хүрч болно биз дээ. Тэднийг харанхуй бүдүүлгээр нь дуудах хэрэггүй.

-Таныг “төрийн шагналт Б.Лхагвасүрэн гуайг яруу найрагч гэж тоодог өөр хэнийг ч тоодоггүй” гэж залуучууд тань ярих юм билээ? Яагаад?

-Лхагвасүрэнгийн нэг сайхан санагддаг юм нь “Ганцхан сайхан шүлэг бичээд үхэх юмсан” гэж ярьдаг юм. Тэр сайхан шүлгээ бичээгүй байна гэдэг чинь цаана нь өөрт нь хийх гэж амь нь тэмцэж байгаа юм байна гэсэн үг. “Би болчихлоо. Төрийн шагнал авчихлаа. Ерөнхийлөгч намайг хүлээж авлаа” гээд ороо засаад хэвтээд өгөхгүй байна шүү дээ, тэр хүн чинь. Нөгөөх л мөнхийн түгшүүр, шаналгаандаа байж яруу найраг, ер нь аливаа уран бүтээл гардаг. ХХ зуунд яруу найрагт гурван шинэчлэл гарсан юм. ХХ зууны эхээр монголын яруу найргт магтаалын цагаан шүлэг л байсан. Энэнийг 50-иад оны эхээр Д.Сэнгээ гэдэг хүн үнэн рүү ойртуулсан юм. Явуухулан сэтгэл рүү ойртуулсан. Б.Лхагвасүрэн ухаарал руу ойртуулсан юм.

-Өнгөрсөн жилийн “Болор цом”-ыг Лхагвасүрэн гуай дундаас нь хаяад гарсан. Тэр үед та юу бодсон бэ?

-Юуг ч хаяж болно шүү дээ. “Болор цом”-ыг байтгуай амьдралыг орхиод явдаг шүү дээ. Яруу найрагч хүн хаяж чаддаг байх ёстой. Яагаад бид үүнийг тэгтлээ их гайхаад байдаг гэхээр бүгдээрээ стандарт сэтгэлгээтэй болчихсон. Тэр стандарт сэтгэлгээнд нь багтаагүй хүнийг их гайхаад шуугиан дуулиан болгоод байдаг. Энэ бол гайхалтай юм биш шүү дээ.

-90-ээд оны үед мөн л зохиолчдын их хурал дээр Дашбалбар агсан “Явуухуланг Пүрэвдорж алсан” гэж хэлж та хариуд нь “Би үзэл суртлын үед их буугаар буудуулж байсан хүн. Чавхаар харвах юу ч биш” гэж хэлж байсан гэдэг. Та Дашбалбар агсныг бас л тоодоггүй байсан учраас тэр үү?

-Тэр үе чинь нийгмийн тэсрэлтийн үе байлаа. Хүмүүс санаа бодлоо янз бүрээр илэрхийлдэг байсан үе. Нэгнийгээ хэлэх хэлэхгүйгээр хэлдэг, харь гаригаас хүн ирдэг, алтан цөгц олдог, цээжээ самардаж од гаригтай ярьдаг үе байлаа шүү дээ. Одоо бол тим юманд хүмүүс гайхахаа больсон. Хаа очиж бидний үед уран бүтээлийн атаа жөтөө, хагарал тэмцэл байгаагүй. Бие биенийхээрээ орж гараад, ууж идээд л явдаг байсан. Намын хурал дээр л намын үүрийн даргаа /Б.Явуухуланг. сурв/ нэг гишүүн нь шүүмжилсэн хэрэг шүү дээ. Үүнээс л үүдсэн үг л дээ. Хэрвээ би түрүүлээд үхчихсэн бол “Явуу Пүрэвдоржийг алчихлаа” гэх байсан биз. Дашбалбар нас барахынхаа өмнө “Залуугийн болчимгүй зангаас болж ахмад үе

рүүгээ буруу үг хэлж байж” гэж надаас уучлал гуйсан. Ер нь сүүлийн үед хараад байхад эгэл жирийн хүн л мөрөөрөө үхдэг, олны танил гайгүй шиг улс нь бүгд л учир битүүлгээр үхдэг юм шиг байна. Ийм л юм ярьдаг болчихож. О.Дашбалбар, М.Чимэдцэрэн, Ш.Отгонбилэг. Маргааш намайг үхчихвэл “Өчигдөр зүгээр байсан хүн үхчихлээ. Шинэчлэгчид нь алчихсан юм биш биз” гэх гээд. Үхэл чинь заавал заяагүй хүнийг сонгодог ч юм биш л дээ. Бүгдийг нь тэгш сонгодог юм. Явуухулан, Эрдэнэ, Дашдооров бүгдээрээ өнгөрсөн. Би л үлдэж байх шиг байна. Нэг хэсэг биднийг “алтан үеийн шавхруу” гэдэг байлаа. Одоо бол “Өнгөрсөн нийгмийн хоцрогдол, аягүй бол “Цагаан давааныхан” гэх гээд байгаа юм. Цаг хугацаа хаан юм чинь хэнийг ч, хаана ч хаяж болно. Заавал бурхантай зэрэгцэх гээд байх хэрэггүй, “там руу яв аа” гэвэл “явахгүй” гэж болдоггүй л юм гэнэ лээ. Одоо бол хэн хаана очихыг газар дээр хуваарилаад байх шиг байгаа юм. Гэтэл нөгөө эрлэг номун хаантайгаа уулзана, төслөө барина гэдэг хэцүү еэ дээ.

Ц.Булган

“Сэрүүлэг” 2001 №38

Товчлов.

Утга зохиолыг хэн нэгэн миний л голдрилоорурсах ёстой гэж тулгах эрхгүй

-Уран бүтэлийн олз омог ихтэй юү. Ойрын үед юү хийж байна вэ?

-Уран бүтээлийн олз гэвэл миний ургацын талбай жижигхэн. Тэр талбайгаас хураах юмаа хураачихсан юм шиг байна. Яруу найраг бол уран бүтээлчтэй учирдаг, бас тэднийг орхидог юм. Одоо миний нас яруу найргийн хурдыг гүйцэхгүй болжээ. Гэхдээ Монголын үндэсний их яруу найргийн тоосыг магнайдаа дээдэлж явдаг. Өнгөрсөн жил “Улаан гэрийн хоригдол” дурсамжийн номоо хэвлүүлсэн. Одоо ардын жүжигчин Д.Лувсаншаравтай хамтарч “Хар хорум” гэдэг дуурь тэрлэж байна. Цомнол бол зөвхөн овоо. Энэ овоон дээр хичнээн өнгийн, ямар шувуу суулгахыг хөгжмийн зохиолч мэддэг. Тийм ч учраас дуурийг хөгжмийн зохиолчийн бүтээл гэж үздэг.

-Өчүүхэн жиижиг талбай ч гэсэн үржил шимтэй байдаг даа?

-Миний өчүүхэн гэж хэлээд буй ургацын талбай бол хөрс нь мянган жилийн идээшилтэй, Монголын утга соёлын үржилтэй талбар юм. Ийм хөрснөөс ямар ургац хураахыг яруу найрагчийн авьяасын сав мэднэ.

-Таныг Зохиолчдын эвлэлийн байранд хувийн сургууль хичээллүүлж зохиолчдын эвлэлийн хөрөнгөнөөс “идэж” байна гэж зөндөө ярьж бичлээ. Энэ талаар?

-Сургуулийн талаар гэвэл уг нь Зохиолчдын эвлэлтэйгээ хамтарч “Монголын нууц товчоо” дээд сургууль байгуулсан. Зохиолчдын эвлэлийн удирдлага сургуультай хамтран ажиллахаас татгалзсан учраас өөрөө голлоод залуучуудтай сэтгэл хувааж, тэдний хөлийг Монголын утга зохиолын дөрөөнд хүрээсэй гэж сүү өргөж сууна. Уг нь энэ байшинд утга зохиолын залгамж үеийн дуу тасрах ёсгүй гэж үздэг. Энэ санааг минь олон зохиолч хуваалцана.

-Танай сургуулийн оюутнууд бүгдээрээ яруу найрагч, зохиолч болох хэрэг үү?

-Манай сургуулийн нэг онцлог нь оюуны бааз нь Монголын уран зохиолын академи. Энэ академид манай гол зохиолчид эрдэмтэд нэгддэг. Сургуулийн багш нарын ихэнх нь академийн гишүүн. Утга зохиолын сургууль гэдэг утгаараа залууст уран бүтээлийн орчин бий болгодог. Тийм орчинд л уран бүтээлчийн авьяас хөгждөг. Бүгд зохиолч болохгүй ч гэсэн Монголын утга зохиолын их танхимын хамгийн урд эгнээнд суудал эзлэх хүмүүс болно. Энэ бол нөгөө олон тонн хүдрээс эрдэнэ тунгаах гэдэг мэргэдийн сургаалд нийцэж байгаа юм.

-Тэгэхээр авьяастай залуус олон байна уу?

-Авьяас бол маш эмзэгхэн байдаг учраас түүнийг хайрлаж хамгаалах, дэлбээгээ нээхэд нь эрдэмтэд, уран бүтээлчдийн оюуны хур, нар аль аль нь хэрэгтэй болдог. Нэг авьяастныг алдана гэдэг үндэсний хохирол байдаг. Ер нь бид авьяасыг үнэлэх чадвар дутсан гашуун туршлага бий. Авьяасыг үзэл суртал руу түлхэж хөнөөсөн эмгэнэл бидэнд бий. Жишээлбэл, уран бүтээлч хүн авьяасаас айдаггүй. Толгой дээр нь цахиур хагарч байхад дороос нь өөрөө гал өрдөж өргөмжилдөг. Энэ бол уламжлал шинэчлэлийн гэгээн хууль.

-Өнөөгийн Монголын яруу найргийн төвшин, өнгө төрхийг тодорхойлохгүй юу?

-XX зууны Монголын яруу найраг хэв загварт хавчигдсан ч юм бий, эвдэж гарсан ч юм бий. Бид XXI зуунд Монголын үндэсний их яруу найргийн өвийг өргөж орлоо. Сүүлийн үед нийгмийн харилцаа өөрчлөгдөхийн хэрээр утга зохиол шинэ тогтолцоонд өөрийнхөө өнгийг олох эрлийн үе байлаа. Тэгэхдээ эрэл бол олз биш. Эрснээ олохоос өмнө “Эврика” гэж дуу алдаж болдоггүй юм.

-Дэлхийн яруу найргийн төвшинтэй харьцуулбал?

-Дэлхийн яруу найрагтай харьцуулах гэж их ярьдаг болж. Энэ дэлхийн яруу найраг чинь улс үндэстнүүдийн яруу найргаас бүрдэнэ. Хэрвээ дэлхийн утга зохиолыг оюуны далай гэж төсөөлөх юм бол түүнд Монголын гол цутгах ёстой. Түүнээс бус улс үндэстнийг их, багаар ялгаварлах ч юм уу, эсвэл нэг малгай дор багтаах гэсэн ойлголт байж болдоггүй. Бид Монгол газар дээр унаж, монгол агаараар амьсгалж, монгол эхийн сүү амталж яруу найргийн хэлд орсноо мартаж учиргүй.

-Хэн дуртай нь өөрийгөө яруу найрагч гэж цоллодог болсон. Тэгэхээр жинхэнэ яруу найрагч гэж хэн юм бэ?

-Яруу найраг гэдэг хүнд зориулсан уран бүтээлийн дээж. Тийм учраас малын тэжээлээс ялгаатай. Яруу найрагчийн өргөмжлөлийг өөрөө бус чухамхүү зориулсан уншигчдаас өгдөг их хүндтэй титэм. Товчоор хэлэхэд үндэстэн хүлээн зөвшөөрсөн цагт яруу найрагчийн тэргүүнд тэр титэм өөрөө асдаг юм. Нэгэнт үндэстэн тэр титэмийг асаасан бол түүнийг булаах хүч хаана ч байдаггүй.

-Утга зохиолын байгууллага яг ямар байх ёстой гэж бодож байна?

-Монголын зохиолчдын эвлэлийг 1943 онд Хувьсгалт уран зохиолчдын эвлэл нэртэй байгуулсан. Энэ бол үзэл суртлын байгууллага байсан. Одоо ч бид энэ ойлголтоос салж чадахгүй л байна. Бид нийгмийн шинэ тогтолцоонд утга зохиолын байгууллага ямар байх хэлбэрийг олж чадаагүй байна. Утга зохиолыг удирдах бодлого зохицуулах тухай яриа цагтайгаа хамт улирчээ. Өнөөгийн зохиолчид уран бүтээлийн эрх чөлөөгөө дахин алдахыг хүсэхгүй. Аль нэг байгууллагын заавар захирамж хэрэггүй. Бид дөнгө зүүж хаширсан. Хэрвээ зохиолчдын байгууллага байвал зохиолчдын эрхийг хамгаалахад туслах, утга зохиолын шинэ залуу үеийг дэмжих байгууллага байх ёстой. Одоогийн хэрүүл маргаан юунаас болж гарч байна вэ гэвэл янз бүрийн үзэл бодолтой хүмүүс нэг гэрт чихэлдсэнээс л болж байгаа юм. Ийм учраас уран бүтээлийн чиг баримтлалаараа нэгдэх ёстой.

-Зохиолчдын эвлэлийн удирдлага өөрчлөгдөж залуужсан. Та одоогийн энэ байгууллагатай аль хэр холбоотой ажилладаг вэ?

-Зохиолчдын хорооны ажилд оролцдоггүй. Ямар нэг сонгууль байхгүй. Сонгогдох ч хүсэл алга. Эдний явуулж буй ажил үндэсний уран зохиолын хөгжилд ус биш, тус болоосой л гэж харж сууна. Хэрвээ намайг зохиолчдын эвлэлийн гишүүн нэрээр буруутгах хүсэлтэй хүн байгаа бол би гишүүн байх нь алба бус. Надад өөрийн сонгосон зам, зорилго бий. Тэр зам жим болоод тасартал түүндээ би үнэнч байх болно.

-Зохиолчдын хоёр хороо толхилцох бус эвлэрэх нэгдэх цаг болсон гэж ярих юм. Энэ талаар та юу боддог вэ?

-Үндэсний чөлөөт зохиолчдын холбоо байгуулагдсан нь буруу юм биш. Дахиад ч тийм холбоо байгуулагдаж болно. Ер нь олон клуб, танхим, нэгдэл, олон хэлбэр байж болно. Харин үйл ажиллагаагаа уран зохиолын нэгэн үзүүрт чиглүүлэх ёстой гэж боддог. Нэг хайрцганд бүх зохиолчийг багтаагаад цоожлоход маш хэцүү. Хэрвээ бид олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрч л байгаа юм бол утга зохиолын урсгал чиглэлийг ч хүлээн зөвшөөрөх ёстой. Харин хэн нэгэн өөрийнхөө санааны зоргоор Монголын утга зохиол миний голдрилоор л урсах ёстой гэж тулгах эрх байхгүй.

-Найрагчид өөрсдийгөө тэнгэрээс төрсөн гэх нь байдаг. Таны хувьд?

-Нэг удаа “Ийгл” телевизийн нөхдөд ярьж байсан юм. “Та нар “Оддын амьдрал” гэж нэвтрүүлэг явуулах юм. Хэрвээ танай нэвтрүүлэгт зохиолчид оролцох юм бол “Моддын амьдрал” гэж нэрлээрэй. Зохиолчид гэдэг чинь газар дээр ургаж, тэнгэрт тэмүүлээд эргэж газартаа унадаг юм” гэж.

Ш.Лхамноржмаа

“Зууны мэдээ” №17(903) 2002.1.9

Товчлов.

-Та Чингис хаантай хэдийд танилцсан юм бэ?

-”Монголын нууц товчоо”-ноос уншсан. Манай нутгийнхан домог мэт шивнэж ярьдаг байлаа, энэ хүний тухай. Чингис хаан гэдэг нэрийг миний багад хэлэх цээртэй байсан. Гэхдээ хүмүүсийн сэтгэлд тэр их хааны дүр шүтээн хадгалагдаж байсан юм. Монголын түүхэнд Чингис хааны нэр зандалчин, яргачин, үл бүтэх этгээд нэрээр сургуулийн сурах бичигт дурсагдаад өнгөрдөг байсан. Гэвч монголчууд зөвхөн сэтгэлээс гадна газар тэнгэртээ хүртэл их хааны дурсгалыг мөнхжүүлсэн хэвээр байсан юм. Чингисийн морины уяа, суусан, саатсан газар, Чингисийн гүүн зэл, төрсөн газар гээд Монгол даяар домгийн шинжтэй их олон газар бий.

-Тэнгэрт ч бас Чингисийн нэртэй зүйл байна уу?

-Тэгэлгүй яахав, тэнгэрт л гэхэд Чингисийн хоёр загал гээд од байна.

-Та Чингис хааныг сэтгэл зүрхэндээ хэдийнэ залчихсан явсан байх нь ээ?

-Монголчууд эзэн хаанаа уул, ус, тэнгэртээ 800 гаруй жилийн турш харж яваа юм. Чингис хааны өөрийнх нь хэлсэн үг байдаг. “Сэтгэлийг хурааваас бие хаа одох” гэж. Тэгэхээр Монголын сэтгэлийг хураасан, Монгол улсын түүхэнд газар, тэнгэр эвлэж, ганц удаа заяасан ийм агуу жолоодогч юм даа, Чингис хаан.

-Та Чингисийн тухай олон бүтээл хийсэн. Нэрийг нь хүртэл шивнэж байсан тэр үед яагаад нууж чадахгүйд хүрсэн юм бэ. Ингэж тэсрэхэд юу нөлөөлөв?

-1962 онд “Чингис” шүлгээ бичсэн. 1992 онд “Чингисийн тахилга” гэж найраглал бичсэн. Чингис хааны тухай ном судар, эрдэмтэн мэргэдийн бичсэн зүйлийг сонирхож, өөрийнхөө хэмжээнд үзэж харсан жаал зугаа юм бий. Чингис хаан тусгаар тогтносон улсад юу байх ёстой юм, тэр бүхнийг бүрдүүлж чадсан хүн гэж би боддог. Төртэй, хуультай, засаг захиргааны зохион байгууллалттай, хил хязгаартай, сан хөмрөгтэй, төрийн сүлд, төрийн дуу, зэвсэгт хүчинтэй, тэр бүү хэл өнчдийг тэтгэх сан хүртэл байгуулсан байсан. “Чингис” шүлгийг бичих болсны тухайд бол 1962 онд их эзний 800 жилийн ойг тэмдэглэхээр намын төв хорооноос тогтоол гаргасан. Ингэж Хэнтийн Гурван нуурт Чингис хааны хөшөө босгосон. Улаанбаатарт хурал болсон. Хугас хурал л даа. Яагаад гэвэл том хурал төлөвлөсөн байсан ч ШУА-ийн ерөнхийлөгч нээж, зарим эрдэмтэн үг хэлээд л өнгөрсөн юм. Энэ үеэр л би “Чингис” шүлгээ бичсэн.

-Энэ ойн үр дүн юу байв?

-Сүүлд нь ой тэмдэглэсэн бүхэн, түүнд оролцсон хүн бүхэн буруутсан. Тэр үеийн ЗХУ-ын Коммунист намаас манай намын дарга нарын хонгоноос нь чимхсэн юм шиг байгаа юм. Харин манай дарга нар байя, байя гэж дуу алдан, гэм буруутныг нь харин ч нэг хурдан, сайн гэсгээсэн. Хамгийн эхлээд хэлмэгдсэн хүн бол намын төв хорооны суртал эрхэлсэн нарийн бичгийн дарга Д.Төмөр-Очир байсан юм. Түүнийг золиосонд гаргаж, Баянхонгор, Хөвсгөлийн Ханх зэрэг газар руу хөөж, бүх насаар нь, амьдаар нь тамласан гэж болно.

-Таныг яасан бэ?

-”Чингис” шүлгийг нэг удаа л “Утга зохиол, урлаг” сонинд хэвлэсэн юм. Тэгээд хаачихсан. Намайг үзэл суртлын улсын зөвлөлгөөний илтгэлд үндсэрхэг үзэл гаргаж, Чингисийг шагшин магтсан шүлэг бичсэн гэж зэмлэж, буруушаасан. Тэгээд би их олон жил суртлын тэнсэнтэй, найдваргүй этгээд гэсэн данстай явсан.

-Харин ч гайгүй өнгөрчээ?

-Харин л дээ. Тэр олон жил намын итгэлтэй ажлыг хийж болохгүй, бас миний ном болгон, шүлэг бүхэн тусгай хяналтад байсан. Төрийн шагналаас зургаан удаа хасуулж байлаа. Энэ үед дээрээс хялайхаас гадна дэргэдээс хадардаг улс бас гарч ирсэн.

-Зохиолчдоос уу?

-Тийм ээ, тийм.

-Матах уу?

-Тэр үед намайг матаж явсан хүмүүсийн зарим нь байж л байна.

-Тэднийг хэн гэдгийг нь Та мэддэг юм уу?

-Тэд намайг юу ч мэдээгүй гэж боддог бололтой юм билээ. Би тэдэнд өс санаж, нэхэл болж явдаггүй. Яагаад гэвэл тэр хүмүүс амьдралд байр суурь олж, нийгэмд өөрийн зайтай болох гэж бор ходоодоо борлуулж, чаддаг юмаа л хийсэн нь тэр. Энд би хүний нэр дурдахгүй. Үүнийг уншаад намайг хэлж байна гэж хамгийн түрүүнд цочих ганц, хоёр хүн бий.

-Энэ үг чинь их аймаар сонсогдож байна?

-Тухайн нийгмийн тогтолцоо нь хүн нэгийгээ барьж идэж байж, өөрөө дээдсийн хишиг хүртдэг тийм бузар ёс суртахууны хаанчлалын үе байлаа.

-Таны “Чингис” шүлгийг одоо хүртэл хүмүүс мартаагүй, олон хүн мэддэг. Ганц удаа сонинд хэвлэгдээд дарагдчихсан шүлэг яаж олонд түгсэн юм бол?

-28 жил хориотой байсан. Энэ хооронд амьтны гар дамжаад тарчихсан юм билээ. Ер нь хүн гэдэг нуусан юмны хойноос учрыг нь олох гэж зүтгэдэг амьтан. Энэ шүлгийг хаасан нь улам дэлгэрэх боломж гаргачихсан юм шиг. Энэ шүлэг цэргийн өврийн дэвтрээс, хоригдлуудын халааснаас хүртэл гардаг байсан юм гэнэ лээ. Тийм сайн шүлэг байсандаа ч биш, тэр хөлдүү нийгэмд монгол хүн, Чингис хаан гэж дуугарсан нь л сонин байсан. Энэ шүлэг бол хүмүүсийн сэтгэлд хадгалагдаж байсан тэр шүтээнд дээж өргөсөн өргөл учраас олны сонирхол шохоорхлыг татаж чадсан.

-1962 онд Гурван нуурт босгосон хөшөөг аваад хаячихаагүй юм уу?

-Гурван нуурт боссон хөшөөг буулгах тухай хоёр ч удаа Ю.Цэдэнбал дарга үүрэг өгсөн. Түүнийг нь их эзэн хаанаа гэсэн сэтгэлтэй монгол сэхээтнүүд нураагаагүй, тушаалын дагуу хөдөлж өгөөгүй юм билээ. Гурван нуурт хааны хөшөөний оронд Монгол, Зөвлөлтийн найрамдлын өндөрлөг байгуулах тухай ч ярьж л байсан.

-Чингисийн тухай бичихэд юу таныг ирлэж өгсөн бэ?

-Би “Нууц товчоо”-г уншаад, үндэсний бахархалтай болсон. Мөн Оросын зохиолч Яны бичсэн “Чингис хаан” гэдэг номыг уншаад бүхэл бүтэн улс үндэстнийг коммунист суртлын үүднээс доромжилж, үгүйсгэж, харааж зүхсэнийг үзээд зэвүү хүрсэн. Нууц товчооноос олсон үндэсний бахархал, Яны номоос олсон зэвүүцэл хоёр миний ухаарахад түлхээс болсон гэж хэлж болох юм.

-Аливаа улсад үндэстний бахархал гэж байдаг?

-Үндэстэн бүрийн бахархал янз, янз. Монголын үндэсний бахархал нь яах ч аргагүй Чингис хаан юм даа. 900-гаад жил дэлхий мартаггүй байхад, өнөөдөр өөрийгөө агуу их гэж тооцдог зарим хүний дэргэдэх нь ч санахгүй байгаа шүү дээ. Чингис хаан бол улс төрийн зүтгэлтэн, цэргийн жанжнаас гадна оюуны хүчийг үнэлж чаддаг, орчлонг тэгшхэн харж чаддаг төрийн зүтгэлтэн байсан юм гэж хэлмээр байна. Тэрвээр “Эрдэм билэгт хүнийг эрхбиш илүү хүндэтгэж яв” гэж айлдсан байдаг. Бид өнөөдөр оюуны бүтээлийг үнэлж чадахгүй байна гэж үглэсээр л байна. Чингис хаан оюун билгийн тухай “Авьяас билэгтэн цөөн бол амьтан, хүн олон ч тусгүй” гэсэн байдаг.

-Бид Чингис хааны сургаалийг амьдралдаа хэр мөрддөг ард түмэн бэ?

-Бид түүхэндээ эзэн хааныхаа сургаалийг дэндүү олон зөрчсөн. Тэр бүхний тоогоор түүхийн өмнө ял хүлээсэн. Түүнээс болж Монгол үндэстэн доройтож, сарнин бутарч, харийн хөлд гутамшигтайгаар сөгдөж байсан. Одоо ч гэсэн бид бусдын соёлыг бурхны зарлигт тооцож, өөрийнхөө өвийг өнгөрсөн үеийн хоцрогдол мэтээр эндүүрдэг хэвээрээ л байна.

-Чингис хааныг сурталчилгаанд их ашиглах болсон. Үүнийг юу гэж боддог вэ?

-Бид Чингисийг ёс төдий, чимэгтэй зар төдийгөөр алдар нэрийг нь ашиглах хэрэггүй юм л даа. Монголчууд Чингис хаанаа хүрээлж, өргөмжилж, нэгдэж улсаа авч явах ёстой. Одоо би ингэж боддог юм. Хэрвээ Сүхбаатарын талбайд Чингис хаан ирвэл Сүхбаатар жанжин мориноосоо бууж золгоод, та дээшээ морил гэж хэлэх байсан байх аа. Ямар ч гэсэн монгол цустай тэр залуухан дайчин эр би төв талбай дээр байж байя. Та тэрүүхэн зүүн урд талд байвал байна биз гэж хэлэхгүй байсан. Гэхдээ яая гэхэв, бидний сэтгэхүйн хэмжээ ХХ зууны ертөнцийг үзэх үзэл гэж зээлдэж авсан тэр сургаалынхаа хашаан дотор байна шүү дээ.

-Та Сүхбаатарын хөшөөний оронд Чингис хааны хөшөөг байрлуулах нь зүйтэй гэж үзэж байгаа юм уу?

-Би биш ээ. Сүхбаатар л тэгээд байгаа юм. Миний төсөөлсөн Сүхбаатарын дүрээр бол Чингис хааны хөшөө төв голомтод л байх ёстой. Гадна, дотнын зочноос эхлээд гавьяа шагнал авсан

хүмүүс, сургууль номоо төгссөн, гэр бүл болсон залуус очиж мөргөдөг байвал дээр. Таны зовж байгуулсан улсыг бид авч явна, тэр улсын чинь голомтыг бадрааж явна гэж сэтгэлдээ андгайлдаг байвал сайхан юм даа. Гэвч Сүхбаатар үүнийг шийдэхгүй, арай жижигхэн “баатрууд” шийдэх байх.

-Чингис хааныг ганц өгүүлбэрээр тодорхойлооч гэвэл?

-Маш товчхоноор хэлэхэд монгол хүний сэтгэл, итгэл, мөрөөдлийн цутгамал дүр гэж болно.

Ш.Лхамноржмаа

“Зууны мэдээ” 2003-5-12 №11

Товчлов.

Сармагчин болж жаргахаас хүн байж зовсон нь дээр...

-Чингис хааны 840 жилийн ойд зориулсан уран бүтээлийн уралдаан зарлажээ. Та хуучин “Чингис” шүлгээрээ оролцох уу. Эсвэл...

-Уралдаанд уяашдаг нас намаршиж битүү морьгүй болжээ. Харин миний дөчин настай хүлгийг тоосоороо булаад байранд ирээчийн торгон жолоог өргөлгүй яахав.

-Тэр шүлгээ бичсэн үеийг өнөөдөртэй зэрэгцүүлээд бодоход юу хэлмээр санагдах юм бэ?

-“Чингис” шүлгийг бичсэн 1962 он бол дарангуйллын далайсан газар бид далд орсон үе. Даллаагүй байхад ил гарснаараа энэ шүлэг гучаад жил үзэл суртлын “Ганц хутагт” хоригдож ерэн онд суллагдсан. Гэтэл саяхан “Энэ бол шүлэг биш” гэж хэн нэгэн зандарсан гэнэ билээ. “Яамны” цэс харж ялны яс мэрсэн юм болов уу даа. Ямар ч болсон үзэл суртлын үхэр чулуун дороос эзэн хаандаа сэтгэлийн дээж өргөж чадсан юм чинь одоо дэгээдсэн бүхэнд ойчиж, дэвсэн бүхэнд дэвсүүлэхгүй. Харин өчигдөрхөн “Чингис бол яргачин” гэж индэр нударгалаачингууд өнөөдөр торгон дээлийг мөнгөн агсрагаар бэлхэмжилж Чингисийн өмнө сөхөрч буйг хараад цаг өөр болсныг мэдэрч сууна. Гэтэл “баатарлаг түүхээрээ бид амьдрахгүй” гэж бас цээж дэлдэх нь чих шорлоно. Тийм хүмүүст дэрэн дээр дэргэдэх нь танихгүй чамаар бус, дэлхийд биднийг Чингис хаанаар мэднэ шүү гэж хэлэх юмсан. Үе үеийнхний цогцлоосон үндэсний бахархалд дөрөөлж он цагийн хүлгийн зоонд гарах ёстой гэж би боддог шүү.

-Үндсэрхэх үзлийн тухайд олон янзаар л ярьдаг. Энэ талаархи таны бодол...

-Миний хувьд морио машинаар сольж болдог юм гэхэд Монголоо гэсэн үзлээ даяаршлын тогоонд хутгамгүй байна. Эс, цус, газар усаар бүрддэг эх орноо гэсэн сэтгэлээс ургасан үндсэрхэх үзлээр ялангуяа хойч үе минь эдгэршгүй өвчлөөсэй гэж бид хэлдэг. Баавгай луу ч юмуу, бар арслан болох юм гэж боддоггүй. Модоо барьсан ч Монголоо алдахгүй юмсан.

Сармагчин болж жаргах нь хялбар ч, хүн байж зовох нь дээр. Харьд тайж байснаас хатавчиндаа хамжлага байхыг би сонгоно. Энэ нь хүн төрөлхтнөөс хүй тасрах гэсэн үг биш. Дэлхийн дэвшлээс аягатай нь аягандаа, аягагүй нь амандаа балгасан монгол хүн байя л гэсэн үг шүү. Ингэж хэллээ гээд эргэж мөргөх гэвэл ишигний эвэр тэдэнд байхгүй.

-Та хэдэн жилийн өмнө “төрийн жолоо, яруу найргийн жолоо хоёрыг залуучуудад атгуулах болсон” гэж ярьсан. Өнөөдөр уран зохиолын хувьд залуучууд жолоо атгалаа гэж болох уу?

-Жолооны хувьд хүссэн хүсээгүй хойт үе өшиглөж бус өргөж авдаг жамтай. Үндэсний яруу найргийн жолоог атгах нь атгаж, алдах нь алдаж явдаг. Ерээд оныхноос Ц.Хулан, Б.Ичинхорлоо, Г.Мөнхцэцэг, А.Эрдэнэ-Очир, Ц.Бавуудорж нарын залуус цагийн давалгаа сэрвээлж байна. Ер нь гучин насан дотор тоосноос сугарахгүй бол хойдох нь түрж, урдах нь гүйцэгдэхгүй болдог шиг байна. Энэ бол уран бүтээлийн эрэлд хатаж өөрийгөө олох хугацаа чинь хязгааргүй юм биш шүү гэдгийг л хэлээд байгаа юм.

-Залуучууд хоорондоо нэг сайнгүй харьцаатай байх шиг. Тухайлбал Г.Аюурзана, Ц.Хулан нарын хоорондын маргаан...

-Аюурзаныг нь би мэдэхгүй. Өөрийгөө үнэлэх их чадвартай юм шиг дуулддаг. Энэ нь үнэнхүү хүчиндээ эрдэж байгаа бол сайн хэрэг. Харин өөрөөсөө бусдыг харахгүй байгаа бол их утга зохиолын илүү гэрт үлдэх гэм. Хулангийн хувьд бол цагтайгаа цалгиж, цахилсан найрагч бүсгүй. Эдний хоорондын маргаан нь яруу найргийн шинэчлэлийн талаар уран бүтээлчийн үзэл бодлын илэрхийлэл. Энэ ялдамд хэлэхэд, яруу найргийн шинэчлэл бол гадаадын зээл биш. Өрнөдийн яруу найргийн урсгалаас хадмал орчуулга төдий оочих, өөрийнхөөрөө нээх хоёрт ялгаа бий. Яруу найргаас сэтгэл, цаг хугацаа хоёрыг таягдаж, гагцхүү “философдох” тухай зарим нь “онолдож” байна. Аугаа их орон зайг эзэгнэх гэсэн энэхүү мөрөөдөл, амьд хүмүүсийн хэмжээт эрхт орчлонд аль хэр газар авах бол. Тэгээд ч гүн ухааны суутнуудын нээлтийг дарж гарахад тэнгэр холдож мэднэ. Харин сэрэл мэдрэмжийн тухайд бол сэрүүн яваа яруу найрагчид байдаг ерийн агаад ер бусын чанар юм. Утга зохиолын шинэчлэлийг уухилж, бус урлаж хийе. Алив урсгал мөхөж их утга зохиол тэдгээрийн төрх шарх хоёрын аль нэгийг авч үлддэг. Үүний хариуг нөгөө “хүчингүй” болгоё гээд байгаа цаг хугацаа хэлдэг. Эргэцүүлэл хэдийвээр найрагчийн сэтгэхүйг тунгаадаг боловч бодлын булингар гүн ухаан биш. Энэ бүхнээс үүдэн хэлэхэд маргааны үр нь үнэнийг олох, худлыг дэвэргэх хоёр үзүүртэйг санахад илүүдэхгүй.

-Таны залууд ийм явдал байсан уу. Явуу найрагч та хоёрыг хоорондоо таарамжгүй байсан гэж ярьж бичих хүмүүс байж л байна?

-Эрдэнэ, Явуухулан, Дашдооров бид бол нэг галын аянчид. Бид дор бүртгээ өрх үүдтэй байсан болохоор юугаа булаалцалдах билээ. Харин Явуухуланд маань намын үүрийн дарга гэдэг дэмий сонгууль тохож, бидний өөдөөс бамбайлж байсан хүмүүс бий. Үүнийг “завхай” сонины зарим нэгэн хөвсөрч дайснууд байсан мэтээр зар тарааж “бор юм” олдог шиг байгаа юм. Хараалаар олсон зоос хавирга сөрлөх гай бий. Тэгээд ч тийм хүмүүс “социализмын үлдэгдэлтэй” тэмцэнэ гэж сүр бадруулдаг боловч ардчилалд “чатга” тургиж аль дийлсэн талд зусрын зулаг элээж яваа нь олны нүдэнд ил байгаа. Харин миний нөхөд амь унтартлаа

ардчиллыг түшиж явсныг би бардамхан хэлье.

-Ахмад болоод алдарт хүний хувьд уран зохиолын өнгө аяс, урсгал чиглэлийн талаар бодлоо хэлнэ үү?

-Утга зохиолын ертөнцөд гэхээсээ уншигчдын танхимд үүний хариуг эрмээр байгаа юм. Энэ талаар социологийн судалгаа хийх биз дээ. Урсгал чиглэлийн тухайд “бодлого зохицуулах” сталинч загвар нэгэнт хэмхэрчээ. Залуус өөрийн шохоорхсон чиглэлээр хүчээ сорьж азаа үзэгл дээ. Үндэсний утга соёлын сан хэрэгтэйгээ л авна. Өнөөхөндөө өнгөрсний шавраас өрөөсөн хөлөө сугалж чадаагүй байгаа болохоор албадан хэв тогтоох гэж аргай мөргүүлэх санаа цухалзаж буй нь суртлын сувайрал. Утга зохиолд авьяастай нь алхаж ороод, амнаас цаашгүй нь атаархал зууж гадаа нь хоцордог. Уран бүтээлийн эрх чөлөөг урлахуйн ухаанаар эзэгнэж чадсан нь өнгөлөөд л гарна. Түүний замд хэнбугайч хөндлөн хэвтээд нэмэргүй. Ёстой нөгөө хөл нь чилэхгүй бол хөшөөний чинь суурь бэлэн гээч л болно.

-Та Ардчилсан намыг илүүтэй дэмждэг. Бусад уран бүтээлчид улс төр бидэнд хамаагүй, шүлгээ л бичвэл барав гэсэн шиг байх юм?

-Монгол Улсаа дэлхийн жишигт яваг гэсэн бүхэн ардчиллыг дэмжиж байгаа юм биш үү. Ардчиллаас авсан юм бидэнд их бий. Гагцхүү бид санахаасаа мартаж эрхээ илүү эдэлдэг юм биш байгаа. Би бол залуучуудыг дэмждэг. Хуучцуул цагийн хүрдийг түшиж өгөхөөс түлхэх хүч юусан билээ. Амьдралаа дурсамж болгон элээсэн над мэт нь улирсан буурин дээр уллахаас бус урагшаа давхиад уул давахгүй. Харин газрын бартаа гадарлаж гайгүй шиг зам хэлж мэдэх вий. Бидний үр хүүхэд цагийг эзэгнэх ёстой. Уран бүтээлчид ташаа нийлдгийг үгүйсгэх аргагүй. Тэгээд л би ширгэсэн худаг дээр хатаж үхэхээр шинэ үеийн булагнаас ам цавлаад гэлдэрч явна. Ардчилалд би дөнгөж хөл тавьж байгаа болохоор урьд нь байгуулж үзсэн юм шиг “жинхэнэ ардчилал тийм байдаг” гэж хэлний хялуу гаргадаг хүмүүсийн оюуны ончроог тайлж чаддаггүй. Одоо хэр оносон гэх загварт нь ухаажихаас гадна томоожихыг илүүд үзнэ. Хаширлаачид ташуур, хадуурагчид хазаар хэрэгтэй.

-Нийгмийн амьдралыг идэвхтэй мэдрэмжтэй ажигладаг хүний хувьд “амьдрал ямар байна даа” гэсэн асуултад хариулна уу?

-Ухуулганд ухархай ширгэсэн болохоор амьдрал сайхан байна гэдэг үлгэрт хууртахаа байжээ. Өтгэй ямаа шиг өртэй баячуулыг ч жаргаж байна гэж боддоггүй. Ядуурлаас гаргана гэж орой бүхэн хэн нэгэн хөхөө зурагтын дэлгэцнээс донгодох юм. Гайгүй ч хэвтэнэ. Ам ширээн дээр амьдрал адсаган дээр байна шүү дээ. Монгол хүний буян хишиг арилаагүй болохоор ядуурлаас гарна. Гартлаа удна. Хоосон үгээр хоол хийлгүй хоёр гараа тархиндаа угсарсан оюун, хүчийн нэгдлээр бид өөрсдийгөө эрчлэх ёстой. Тэнгэрээс гурил буухгүй. Тэнэгийн цэцэрхлээс, ухаантны мунхаглал дээр шүү.

-Чимидийн Энхээ, Лхагвасүрэнгийн Хасар, Цоодолын Хулан, Явуухулангийн Энхээ гэх мэт удам дамжсан найрагч бүтээлчид байх юм. Таны хүүхдээс уран зохиолын авьяастан бий юу. Ер нь Пүрэвдоржийнхны талаар яриа дэлгэнэ үү?

-Зохиолчдын хүүхдүүд туурай хатааж яваад олзуурхдаг. Надад зохиолчийн удам байхгүй. Би

тэгээд “чагтгат” удмын генийн гажиг юм байлгүй. Ар гэр гэвэл айлын утаатай явна. Ор дэрээ онгичуулж гэрэлтдэг “од” биш болохоор олзгүй үгний олныг тэвчье.

-Та Хятадад байхдаа “Харимаар байна” гэж нутгаа санаж бэтгэрсэн хүний зүрх сэтгэлээр шүлэг уншиж зурагтаар гарч байсныг санаж байна. Хүний нутагт амьдрахад уран бүтээлч хүнд ямар байдаг юм бол?

-Холдож харахад нүдний өөх сийрдэг. Эх орноо хариас санах, эргэж ирээд элгээ дэвтгээх нь цаасанд мөртөд хэрэгтэй. Харь газар гутах, ноцохын аль аль нь тохиодог. Санахын зовлонд өөрийгөө ширгээвэл, учрахын жаргалыг илүү ухаарна. Хүний нутагт саатаж болохоос бус уусч чадахгүй хүн би. Сайн сайхан юмыг нь нүдлэж авна гэдэг бага олз биш. Энэ нь хуулаад бай гэсэн үг биш. Хуулсанд орвол хулгайлсан нь дээр. Муу боловч өөрийн ухаан эрхбиш орж байгаа юм. Бид чинь алийн болгон харийн хуулга байх юм бэ. Ядахдаа өөрийнхөөрөө тэнэглэе л дээ.

-Таны өнөөдрийн бүтээл халуун залуу насныхаас өөрчлөгдөж хувирсан, хэрсүүжиж гүнзгийрсэн л болов уу гэж бодогдоод байх юм?

-Ёроолынхоо чулуунд тулчихаад байхад гүнзгийрэх нь юу л бол. Ардын жүжигчин Лувсаншаравтай “Хархорум” дуурь тэрлэснийг дуурийн театрынхан тайзанд буурилж байна. Тэгэхдээ дуу, дуурь мэтийг би хөгжмийн зохиолчтой булаацалддаггүй. Энэ бол Лувсаншаравын маань бүтээл. Уулзсан хүмүүс “Уран бүтээл өндөр...” гэж ёс шиг асуух юм. Юу гэсэн үг юм бол. “Ажил өндөр”, “сурлага өндөр” гэх мэтийг бодоход өндрийн хэмжээс байдаг гэвэл би “намхан” гэж хэлэхээс яахав. Харин юу бичиж байна гэвэл “сачийгаа гүйцэхгүй санаа, саваа дүүргэхгүй сааль” төдийгөөс хэтэрсэн нь үгүй. Энэ ялдамд “Хархорум” дуурийг манай нэрт хөгжимчин, удирдаач асан Маамын Санжмятавын маань хүүхдүүд Отгонбаатар нар өмч тасалж өрх тусгаарлаж өгсөнд магнайн үрчлээ машид тэнийлээ.

-Чингис хааны 840 жилийн гэсэн хаягтай олон ажил зохиогдож тэр бүхэнд Дэндэвийн Пүрэвдорж оролцож завгүй байгааг би ярицлага авах хугацаанда мэдэрлээ. Энэ тухайд юу хэлэх вэ?

-”Би холдоогүй Бин Ладен олдоогүй” гэсэн үг гарсан байна билээ. Түүн лугаа их эзний ойд би сүсэг сэтгэлээс өөр юугаар гийгүүлэх билээ. Нөхдийн эс чамласанд омойрч “Цагаан сүргийн тахилга”-тай холбоотой хэд гурван мөр хэлхсэн. Мэргэд болгоох эсэхийг мэдэхгүй.

-Улсын наадам ойртож байна. Таны “Сумын наадам” шүлэг монгол ахуй төрхийг үнэртүүлсэн наадмын тухай ганц бүтээл гэхэд хэтрүүлсэн болохгүй. Монгол наадам ямар ая зантай, аялгуу хэмтэй байх ёстой вэ?

-Улсын наадамд дараа болохоор сумын наадамд бараа болох нь дээр байдаг. Эрийн гурван наадмын хувьд уламжлалаа устгахгүй шинэчлэлийг ширвэхгүй хосолмол хувилбар бодох, хийх юм байх шиг санагддаг. Бөх л гэхэд цаг нь болсон шинэчлэл дээр хамраа сөргөлцөөд яана даа. ХХI зуун зууны хурд, үзэгчдийн танхим хоёрыг тооцохгүй аль болгон алмайдах вэ. Санаа

зоргоос гадна эрин үеийн хууль гэж бий. Гэтэл бид чинь нэг бол овоохойдоо хэвтээд байдаг. Эсхүл оромжоо хаячихаад давхидаг хаашаа ч улс юм бэ дээ.

Т.Баянсан

“Өдрийн сонин” 2002.6.20 №151

Товчлов.

Чи Дүндгэрийн тухай л уул шугамандаа надаас асуух гээд байна аа даа

Радиогийн сурвалжлагч хөдөөгийн айлд очоод,

-Танай охиноос орой интервью авна шүү гээд давхиад өгч. Орой нь эмгэн, өвгөн хоёр охиноо усанд оруулчихаад хүлээж байсан юм гэнэ лээ. Танаас “интервью” авна аа?

Ярилцлага гэнэ ээ. Чи бас ингэж ядраа юу.

-Юу гэсэн үг вэ.

-Өөртөө онгичих юмгүй сэтгүүлч өрөөлийн аманд хуруугаа хийж бөөлжүүлдэг гэж та нар шоолдог биз дээ.

-Эмээлтэй хазаартай хандгай байх... гэдэг биз дээ.

-Тэгээд буудуулдаг морь нь би болох уу.

-Нэг сурвалжлагч чоно гэж асуусан санагдах юм.

-Яахав яахав. Яруу найргийн ишиг гэрийн бүрээс ураад байхаа болиг.

-Хошин шогийн талаар хэдэн үг сольё. Та чинь “Тоншуул”-ын нарийн бичгийн дарга байсан шүү дээ?

-Тоншуул аа? Мартсанаас тэр чинь хаачсан бэ?

-Байдыгийнд

-Гэрийн шувуу болоо юу?

-Чихмэл хийчихсэн.

-Та нар маань өөрсдөө чихмэл болчихоогүй нь яамай.

-Та ч гэсэн дээ

-Тэр үед “Тоншуул” нь торонд, бид чихмэл нь байсан юм.

-Бидний тавилан юм байлгүй дээ.

-Эзэн хаанд өргөмжлөлийн дуулал бичиж чаддаггүй этгээд авьяаснаасаа болж шогчид дээдсийн нүдний үзүүр шүдний шазуурт өртсөн үйлтнүүд “Тоншуул”-ын хувьд шогчдод заасан нутаг байсан. Би тэнд бүлээцсэний хүчинд хөлдүүс болчихоогүй юм.

-Хошин шогийн мэдрэмж зохиолчид заавал байх хэрэгтэй юу?

-Хошигнол бол зохиолчийг чулуужихаас авардаг рашааны дусал. Хүн бүхэнд байдаг согогийн цэгээс үүсгэх дүрийн ихэсгэл буюу багасгал нь хошигнол. Тэгэхдээ төстэй цэг байж болно. Жишээ нь Байды гэхэд Ц.Доржготовын нөхөрсөг шогийг зуран, миний нэрийг тавьчихаад хэдэнтээ шагнал авсан гэх буюу Ц.Доржготовыг Дашбалбар “чи яагаад Пүрэвдоржтой адилхан байгаа юм бэ” гэж зодох гэсэн гэдэг. Энэ нь мөнөөх цэгийн төсөө уран бүтээлчийн нүдэнд өртөж байгаа нь тэр.

-”Тоншуул” торноос гарах үе байсан уу?

-Торноос гарах тоолон толгойд нь булдруу ургана. Тэр үеийн дарга нар өөрийгөө дэндүү олон юмтай андуурдаг байсан юм. Модны хожуул, зөнөг банхар, хашир тарвага, чалчаа шаазгайн тухай уншаад “Хэнийг хэлээд байна вэ?” гээд шалгаана.

-Тэгвэл одоогийн хэвлэлийн эрх чөлөөнд атаархаж байгаа биз.

-Үгүй дээ. Хэвлэл мэдээлэл дөрөвдэх засаглал гэж хормойгий нь огшоохоор хонгоо гялалзуулаад гүйдэг цаг өнгөрч.

-Хошин шогийг хоймртоо залдаг төр ер нь байсан юм уу?

-Хонгонд нь ассан түймэрт толгой нь шатна гэдгийг мэдэлгүй дээ. Харин унтраах гэж мунгинаад түймэр тавьчих нь бий. Эрхийг хязгаарлаваас эсрэгт ташуур өгнө.

-Бүх юм ил тод болчихоор сэдэв олоход хэцүү байдаг юм биш байгаа?

-Бидний нүд хөлхөрч л дээ. Орон нутгийн сонгуулиар чи бид хоёрын хотын даргаа иргэдийн хуралд сонгож байхад танай байрны Хөхөө мэт манайхны хүүхдийн тоглоомын талбайд төмөр гарааш овоолж (алгын чинээ зүлгий минь сүйтэгчихжээ. Тэр “дүндгэр” дал гаруй айлын толгой дээр шүлсээ хаяж байна. Юутай гутармаар аминчлал, хүнийрхэл, цэвдэгшил вэ. Гэтэл зохиогчийн сэтэр зүүсэн бид хоёр “дүндгэрүүд”-ийг өхөөрдөөд л сууж байна.

-Дүндгэр гэдэг чинь юу гэсэн үг вэ?

-”Эргүү жаал” гэж байгаа юм. Дүндгэрүүд монголын түүхийн хар хуудас бүхнийг бичсэн юм. Тэд чинь толгойн тарга, оюуны тураалтай байдаг юм.

-Толгойн тарга гэж нэг их дуулаагүй юм байна.

-Махан толгой л гэсэн үг. Гахайн толгой хамгийн их махтай атлаа ухаан нь зовлого шүү дээ.

-Тэгвэл хорын ёзоорыг толгойд эрэх ёстой гэсэн үг үү?

-Уг нь тийм. Тэгэхдээ толгой нь таргалчихсан хүний ходоодонд нь эрсэн нь дээр. Сэтгэх чадварыг хивэх дадал залгих нь бий.

-Х.Билэгжаргал “Та шүүмжлээд нийгэм яасан ч гүй” гэлээ. Би хариуд нь “Чи магтаад бас яасан ч гүй” гэлээ. Аль нь зөв вэ?

-Аргаль мөргөлдөхөд ялаа үхдэг юм гэнэлээ. Хоёр том хүний хооронд орохоо больё. Харин та хоёр хорвоог өөрчлөх гэж байгаа бол ядахдаа авгай хүүхдээ хань татсан нь дээр болов уу.

-Хуулиар зохицуулсан нь дээр юм биш байгаа.

-Хууль гэдэг алив төрөөс тогтоодог хэмжээ, гэсгээл хоёрын солбицол. Гэвч хуулийн жаазанд амьдрал багтдаггүй учраас алхаж гарсанд нь овоохой барьж өгөөд суулгадаг. Үүнийг шорон гэнэ. Тэгэхээр орчлонг овоохойгоор нойрсуулж чадахгүй. Харин хүн бүхэнд жолоогоо тавих, татах ёс суртахууны дархлаа тогтоох нь илүү болов уу. Үүний төлөө зохиолч амьд явах төдийгүй үхэж болно. Тэр тусмаа шог зохиолч улсын улхаг засгийн залхагийг сэндийлэхгүй юм бол шогч байснаас шонгийн мод болсон нь дээр.

-Үүнд чинь манай дээдэс дуртай байх болов уу даа.

-Дургүйцвэл бүр сайн. Тэр чинь эмгэгтэй газар нь хөндүүрлэж байгаа нь тэр. Түүнийг нь онож хатгаад буглаагий нь гэртэй нь авч чадвал ядахдаа хоёр нүглийн нэгийг хэрьж чадна. Энэ бол бага юм биш.

-Инээдмийн өдрийг та нар анх санаачилсан байх аа.

-Зохиолчдын хороо сэдсэн юм. Нийгэм бүгчимдээд байгааг мэдээд арга сүвэгчилж хаяа сөхсөн хэрэг. Инээдээр цалгисан үзэгчид биеийн тамирын ордон, улсын циркийн хаалга эвдэж байлаа. Гэвч өөрсдийнхөө эвдрэхийг эвлүүлэх гэж оролдсон нь олз. Урлагийн газрууд үүнээс үлгэр авч улмаар хошин урлаг, шоуны чинь оч харвасан гэж болно.

-Одоогийн хошин шог ямар хэмжээнд байна вэ?

-Уур хүрэх хэмжээнд гэвэл урлагийн заяа гомдох байх даа. Шоу гэдэг гаднын үгийг “дүндгэрүүд” зууж ирсэн бололтой. Хар ухаанаар бодоход наргиа цэнгээн, үзвэр гэсэн санаа биз. Ямар ч байсан хошин урлагийг сайн дурын савчаанаас мэргэжлийн урлагийн түвшинд хүргэх юмсан.

-Үүний тулд?

-Та нар час хийсэн зохиол бичээч. Зохиолгүй жүжигчдийг арзаганалаа, маргазаналаа гээд яах юм бэ. Шог гараанаас эхлээд жүжиг, кино хүртэл мөн ч олон төрөл бий дээ. Урлагийн санд эрдэнэ болох юм хийгээд орлогын сандаа зоос цутгахад яадаг юм бэ?

-Шог зохиолын шинэ үеийн баатрууд хэн байж болох вэ?

-Хорьдугаар зууны турш бид муусайн хар шар феодал, данжаад, панзчинг үнсийг нь байтугай сүнсийг нь хийстэл нооллоо. Одоо энэ үеэ харах болсон биш үү. Хүмүүсийн гайхамшигт хувьсал болж байна шүү дээ. Намын дарга маань лам, дамын наймаачин эзэн болчихлоо. Хүмүүсийн нэг хэсэг нь амь зуух аргаа олж, нөгөө нь амьдралын ёроолд живжээ. Өмчтэй болсон нь ардчиллын буян хүртэж, үнсэнд хаягдсан “хохь тайжууд”, “хишигтнүүдийг” зүхэж сууна. Эрдэмтэй нь толгойгоо, эргүү нь бөгсөө үнэлж, хулгайч цөлмөж, худалч залилаж, архичид гудамжинд тарвалзаж амьдралын алаг цоохор өнгөөр дүрийн яармаг дэлгээд борлуулагчаа хүлээж байна.

-Хамгийн сонирхолтой дүр гэвэл?

-Дүндгэр. Эрх зэрэг, эд мөнгө, итгэм үг, андуурам аяг ер бүх юмтай авч гагцхүү тэрвээр эх оронч л байж чаддаггүй. Түүний хүн чанарын далд цөмд Монгол улсын төлөө үхэх бүү хэл, өвдөж чадахгүй амьсгал шүглэсэн байдаг. Дүндгэр үүнийхээ төлөө айлын ёс, улсын тусыг огоорч чадна. Үүнээс л учиглахад дүр нь амилна.

-Та хаашаа явж байна вэ?

-Буцаж явна. Нөгөө харайгаад гарчихсан капитализм руугаа эргээд л салгалж явна. “Энэ утгаараа” гэдгээр бол урагшаа явж байна.

-Уншаад болдог утга зохиолыг дунд сургуульд заагаад яах юм бэ гэж хэн нэгэн хэлсэн гэж дуулсан уу.

-Тэр яахав. Нэг дүндгэрийн л үг биз. Бүх шинжлэх ухааныг унших болдог. Харин уншаад олдог буюу дүндгэр бус болгохын тулд заадаг юм.

-Дүндгэр, уран сайхны соёлыг ухаардаг уу.

-Тэр чинь ийм халдвар авахгүй дархлалтай. “Миний үзэсгэлэн намайг аврана” гээд замын голоор алхаж явахдаа, согтуу жолооч ирж дайрахыг санадаггүй гэнэн бүсгүйтэй ярьсан дээр.

-Зам гэснээс хотын гудамжаар явахад хэцүү байна уу?

-Явган нь баян монголын хонь ямаа шиг бэлчиж явах юм. Харин дүндгэрүүд нэг гартаа гар утастай, жолоогоо өрөөснөөрөө залж чагнаалдаж шахаад давхичихна. Намайг айгаад зогсохоор цагдаа торгочихно. Тэгэхээр би замын хөдөлгөөнд ордоггүй, намайг оруулдаг юм.

-Сарын аян боллоо гэдэг биз дээ.

-Архи, тэрэг хоёрын аян сарын настай юм уу даа.

Нуруу бөөрний өвчин шиг үе үе хөдөлдөг ажлын сарын тэмдэг төдий л юм даа. Амьдралын хөдөлгөөн ч бас л ийм байгаа юм биш үү.

-Амьдрал олон өнгөтэй. Аль талаас нь бичвэл дээр юм дээ.

-Шогчид гэрлий нь эхэлж хараад эргүүлж сүүдрийг нь бичдэг юм гэнэ лээ. Эс тэгвэл нөгөө эвэр амтай дүндгэрүүд шиг хөршийнхөө гэрийг шатаж байхад өрийнхөө гэр рүү ус цацаад “баларлаа, сүйрлээ” гээд л бахираад байдгийн үлгэр болно.

-Зохиолчийн байр суурийн талаар таны бодол?

-Эх орон гэсэн нэг л цэг дээр тогтож хайрла. Түүнээс бус идүүрэнд угаадас хийсэн бүхний төлөө хүзүүгээ холгон тэлүүлэх нь зохиолчийн ёс зүйд үл нийцнэ. Та нарын дээдэлдэг туркийн гайхамшигт шог зохиолч Азиз Несины далан насны нь ойд зориулсан Анкара хотын даргын дайллага дээр “Би засгийн газрын эсрэг ард түмнийхээ талд л байх болно шүү” гэж хэлэхийг Ц.Балдорж бид хоёр чихээрээ сонссон. Зарим хүн өчигдөрхөн ардчиллыг магтан донгодож байсан бол өнөөдөр “ардчилсан хувьсгал гэгч” “ардчилсан хүчнийхэн гэгдэх” гээд л гаагалж байна. Гэхдээ энэ бол шинэ юм биш. Хааны гишигсэн шороонд мөргөж, хатны хөл үнсэгчид хаа сайгүй байгаа. Эд чинь ертөнцийн шог зохиолчдыг тэжээж байдаг “буянтнууд”.

-Эх хэлний хувь заяанд эмзэглэх үе байдаг уу?

-Сонин гарчиглаж суухад заримдаа яс хянгардах шиг болох юм. “Эр хөвгүүд”, “Хонины ноолуур”, “Чонын хүүхэд” гэж унших чинь жаргал юм уу. Чи энэ хотын хаягийг хар. Улирсан колонийн баларсан туурь юм уу. Би чинь “ю ви” ситид сууж, “супер маркетаас” кетчуп авч, “синчи ойлд” шатахуун шахуулж, “алимны жүүс” ууж юу ч гэнэв “хотелд” ямар ч гэнэв хоол идэж, шоуны фэн гээч болж “вааран дотор бээр” шимэх ёстой болж байх шив. Энэ чинь нөгөө “Совет гүрний делегацыг ирэхэд полный зеритль байсан, народ халуун привет хүргэдэгийн” үлгэр болох нээ. Тэр “дүндгэрүүд” харь хэл нэвтэртэл сурах улс биш. Агуу их болох гэж амбарынхаа нүүрэн дээр англи хаяг гуйж бичүүлдэг юм. Тэд чинь А үсгэн дээр мордоод В үсгэнд гар нь хүрээгүйгээ нуухчаа болж байгаа царай нь тэр. Намайг хоцрогдсон новш гэх дүндгэр гарч магадгүй. Хэн ч биш боол байснаас, хэрэггүй ч гэсэн монголынхоо байсан нь надад омгорхол. Хэл эвдэрэхэд сэтгэхүй хүнийсч ёс харшиж үндэстэн мөхдөг. Монголчуудын амь оршсон тусгаар тогтнолыг “дүндгэрүүд” л түйвээж байсан шүү дээ. Тэд чинь хэргэм, мөнгө хоёроос бүхнийг худалдаж чадна. Бурхан минь! Далан уулын дээгүүр дархан хилийн цаагуур...

-Та уран зохиолын эрдмийн дээд сургууль нээлээ. Шог зохиолчид төрөх болов уу?

-Манай утга зохиолын цөмд багтдаг зохиолчид эрдэмтэд Монголын уран зохиолын академи байгуулсан. Түүн дээрээ суурилож “Монголын нууц товчоо” дээд сургууль нээлээ. Уран сайхны академийн сургалттай уран бүтээлийн анхны дээд сургууль. Ямар ч гэсэн үндэсний болон дэлхийн соёлын бэлтэй, орос, англи хэлээр сонгодог зохиол уншчихдаг хүмүүс гарна. Зохиолчийг сургуулиар бэлтгэдэггүй гэж “дүндгэрүүд” цэцэрхдэг боловч авьяасыг нээж, хөгжүүлж болдог. Шог зохиолчийн хувьд ганц ч болов гараасай билээ. Бидэнд туршлага бий. Хамтран ажиллая. Таг мартсан юм дахин сэргэхдээ шинэ ч байх юм бил үү. Манай сургуульд Монгол улсын анхны ерөнхийлөгч П.Очирбат морилж, багш оюутнуудад ухаарлын сайхан үг хэлж сэтгэл мялаалаа. Бид машинд бэлэгшээж буй. Сайхан өнгөөр яриагаа өндөрлөө. Элдэв илүү юм шалгаах хэрэггүй. Хөгшин амьтан мөлжүүрээ бүрэн өгдөггүйг чи мэднэ. Харин нэг

шүлэг хавсаргая.

Ринчен гуайн бичих л байсан шүлэг

Оюуны минь огторгуйд од мэт гурваад сая үг ину түгсэн
Орчлонд хосгүй хэл мину чи харь харалганд аанай л өртсөөр үү
Урьдын цагт улаан дэлэн үлгэж хар буян үйлдээчдээс
Удмын хэлээ өмөөрч хараалгасан минь тун саяхан бус уу
Үүний өшөөр үсэн буурал намайг насан заяа үзүүлэхгүй
Үзэл суртлын асман бухандайнууд сэжсэн нь тоогүй олон.
Өв соёлоо архаизм, феодалын хэл гэдэг нүдэн балай чихэн дүлий тэд
Өчигдөрхөн өвөг дээдсээ алуурчин зэрлэгүүд гэдгээ таг мартаад
Өдгөө эзэн Чингисийн сүлдэнд мөргөж ичих нүүрэндээ илэг наачихаад
Өрөөсөн эвэр солжирлон мөөрч байх нь мэл гайхаж, цэл хөхөрмөөрөө
Ойдоо хүрээгүй нярайг “нойл” настай хэмээн нойлтдог нь
Одоогийн орчуулгын оромцогоор нь зүйрлэвээс
Оюуны “олдмол дуглын хам шинж л” байж дээ
Үүл нүүхийг солигдох гэж махчлан “солигдмол үүлдэж”
Үзэгчийг “зритель” танхимыг “зал” гэж залдагдсан.
Өвчнийг “истордож” сүүг “молокдож” тосыг “масалдаж”
Өмдөө “брюкдэж” цамцаа “сороочигдож”, гутлаа “бажийнкалдагсан”
Төмөр тэргийг хүн жолооддог атал өөрөө явдаг гэж буудан
Төрсөн эхээ бүү хэл, төөрсөн эхнэрийг хүртэл “маамддагсан”
Албаны мөнгөөр нанчид хүртэхээ “арга хэмжээ” гэж дүрэмдэн
Авгай хүүхэн ноолохоо “мероприятие” гэж албархах дутдагсан
Намайг урвагч цагаантан гэж гөрддөг нөгөө урвадаггүй улаантнууд

Напраас болчихоод капитализм байгуулах гэж үйлээ үзэх нь

элэг хөшмөөрөө

Арван хар нүглийн алдсыг тоочиж эс барьюу гэхэд

Ардын минь хэлийг ад үзсэнийг санахад эх орон гомдмоороо

Ухна ишгийг “байворцоодох” гэж хуухнагийг нь хумслан бахируулж

Уулгамч чавганцаас орос хэл шалгах гэж шанагы нь хуга цохиулдагсан

Хулгайн муу орчуулгын будаа сахалдаа наачихсныг нь хэлэхээр

Хуулийн хэл, албаны хэл гэж мойног түшмэл модон сэлэм далайдагсан

Хөрсөн дор хүйтэрдэг юм шиг хөрсөн дээр цочир хүйтрүүлж

Хөхөвчийг “лээвчигдэж” хөтөвчийг “горшоокдож” аашаа эвддэгсэн

“Тэхлээр”-дэж “одоо”-дож тэр энэ утгаардвал монгол хэл

Телевизийн программын редакци гэвэл олон улсын хэл

болдог юм биш үү

Тэнгэр эзнийхээ хайрласан буянаар ходоодоо баясуулаад үрчихвэл

Тээрмийн хөлд орсон буудайн үлгэр л болно шүү

Өв соёлдоо сүв битүү, сав цоорхойн гайгаар

Өрнөдийн өмнө өмдгүй гүйж яваагаа үл ухаараачин

Өмхий батгана мэт хана туурганд өт цацаж

Өтгөсийн минь хэлийг бузарлах нь ой гутмаараа

Мэргэдийн малгайг мэдэхгүйн толгойд “глобалчлах” гэж

Менежердэж, бирждэж, фермердэж, лоббидож

Миссдэж, боссдож, шоудаж, фэндэх нь

Мэл гайхсан дэлхийн өмнө нүүр хийх газаргүй еэ

Морио алдаад мод зайдлан эцэнхий гуя алгадаачаас

Монголоо арилжаад элэнхий сүүл харьд шарваач хавнуудаас

“Мохоо үзүүртэй зүйлийн үйлчлэлээр” моншин болоочдоос

Монгол хэл бичиг соёлоо өмөөрөн босьюу би Ёншөбү Ринчен.

Сартуул овогтой И.Цэрэнжамц

“Өнөөдөр” 2000.10.23

Эрээн уулын донсоорой

Хавар намраа цасан сархиат

Харлаг тахь шиг Эрээн уул минь...

*Таны нутагт ийм нэг сайхан уул байдаг юм байжээ гэж шүлгээс тань мэдэхээс цаашгүй.
Яруу найрагч болоход нутаг ус, хүн ардынх нь амьдрал, зан заншил нөлөөлж таардаг.*

-Манай Бүрд Архангайгаас Өвөрхангайд орсон сум. Эрээн уулын ноёлох өндрийг Чагтгатын Цагаан овоо гэдэг. Цагаан овооны хөлөөс улбаалан урсах жаалхан горхины бас нэг жаалхан хондыг Хажуу худаг гэдэг. Тэнд миний хүйг дарсан чулуу бий. Эрээн уулын хэцээс харахад Дулаан Хайрхан, Батхаан, Хөгнөхаан ийм дөрвөн уул, тэртээ зүүн хаяанд Монголын элс хонгортоод... Нас ахихаар нутаг их бодогдох юм аа. Сумын төвөөс минь урагш охор өртөө газар Монгол Улсын төв цэг, хойшоо хугас үдийн газар эртний Хархорум байгаа. Ингэхээр би чинь яаж ч бодсон улсынхаа голомтыг түшиж унасан байна уу.

Бүрдийнхэн адуу мал, айраг цагаа сайтай, адуу дагаад айраг, айраг дагаад найр, найр наадам дагаад ерөөл магтаал, адаглаад нэг нэгэндээ шүлэглэж өгсөн нэр хоч нь хүртэл гүйцэгдэхгүй.

Зээхий мэргэний зээ билээ бүүвэй

Зэгсэн гуагийн хүү билээ бүүвэй... та нарыг ингэж бүүвэйлж өгсөн гэж ээж минь, миний ээж Довдмаа гэдэг байсан юм шүү дээ, ярьдагсан.

...Эрээн уулын Донсоорой

Эвхрээ тайхайн Думаарай

Арын булгийн Донсоорой

Арзгар Ламхүүн Думаарай

Худаг усны Донсоорой

Худалч Дамбын Думаарай...

Ламхүүгийн Дамба гэж нээрээн байсан юм гэнэ лээ. Бас тэр Думаарай Донсоорой юу гэснийг бүү мэд. Хүүхэд гэдэг хүүхэд. Хэнийг нь мэдэхгүй байж би Донсоорой шиг хүн болно. Түүн шиг дуунд гарах юмсан, ерөөл магтаал хэлдэг хүн болох юмсан гэж саваагүйрхэн боддог байсан юм даг.

Бүрдийнхэн архи уухдаа ч дуугүй уухгүй ээ.

...Амьтны нууцыг задруулдаг

Алаг шилтэй монопоол

Хүний нууцыг задруулдаг

Хүрэн шилтэй монопоол

гэж солгой зөв хоолойгоор бархирч нэг мэдэхнээ ойчицгооно. Ойчоогүй нь,

Тарнын яргайд татуулах уу

Тарган хониор шөл уух уу

Хөгнийн яргайд татуулах уу

Хөгшин хониор шөл уух уу...

гэж баярхах. Нэр хочгүй амьтан байхгүй байсан байх аа. Ать Балдан, Ангад Раднаа, Саларцаг, Мэдэржав, Сахалт Чогсом гээд л цөм тодотголтой. Бүрдийнхний энэ бүх зан надад байсан авьяасын жаахан үрийг сэрээсэн байлгүй дээ.

-Бүрднийхний зан авир авьяас билэг ч гэх үү надад байсан авьяасын үрийг сэрээсэн гэж түрүү та хэлэв дээ. Равжаа долоотойдоо. Пушкин дөрөвтэйдээ ч гэх шиг авьяас нь танигдсан, шүлэг бичсэн гэгцээдэг. Анхны багын шүлгүүдээ санадаг уу?

-Уухай, хөгшин хүнийг хөөргөж үг алдуулаад, сүүлд нь дооглоцгоох нь уу. Хэн мэддэг юм, цаашаа! Дээр үед хүүхдүүд арав гарч сургуульд ордог байсан болохоор нэлээд биерхүү Хажидсүрэн, Должинжав гэдэг хоёр хөөрхөн охин манай ангид байсан юм. Ухаандаа би тэдэнд сээтгэнэж байгаа юм биз дээ.

...Алаг морийг унаюу, байюу

Аюурын Хажидсүрэнд очъюу байюу

Бага хээрийг унаюу байюу

Батаагийн Должинжавт очъюу байюу

гэж цодойж, эгчмэд охидод “газрын бэтгээ” дуудуулж хожимхон нь айлд гэрийн ерөөл тавьж,

сургуулийн концертод шүлэг уншиж явлаа. Долоо төгсөөд багшилж, сумын клубт нэг их бүдүүн “Нансалмаатай” Юндэн болж өнөөхөө тэврээд дуулах гэсэн нь гар богинодоод улс шоолоод л. Дараа нь аймгийн гэгээрлийн хэлтсийн байцаагчирхуу юм болж, удалгүй “өсөх ирээдүй” нь тодрон Намын дээд сургуульд хуваарилагдаж, тэндээс “сахилга алдан” хасагдаж хамаг юм нурлаа.

-”Улаан эрдэмтэн” ингээд ойчлоо одоо яахав?

-Гэвч надад түшиж авах юм байгаа, яруу найраг байгаа санагдсан. Хорвоогийн олон замын тэхийд хүн боддог. Өөрийгөө эрдэг. Эрээд, бодоод ерөөсөө “Эрээн уулын Донсоорой” больё. Яруу найрагт сэвээд үзье, Цэцдийн их зам дээр голио болж хэвтэж азаа үзье гэж шийдсэн. Түүнээ ээжид, нагацдаа хэллээ. Нэг их дургүйлхээгүй. Тэгээд манайх 1952 оны намар хэдэн бодоо үгүй хийж хэдэн хонь болгоод, долоон тэмээ хөлсөлж, хот руу нүүлээ. Би хонь тууж, ачаа гүйцэхгүй нэг муу хөгшин нохойгоо ачаан дээр ачаад гарч өглөө. Намрын нарны халуун, замын урт гэдэг тамтаггүй. Тэгж ядарч үхэх гэж яваа мөртлөө муу нагац ах, ээж тэр хэдийгээ шоолж,

...Ааш муутай ах ламтай

Амандаа цайхгүй хүргэн ахтай

Ачаа гүйцэхгүй хар нохойтой

Авдар даахгүй Пүүжээ хонь тууж явна ч бил үү

завхарсан юм уншиж нойроо сэргээж явсаар арай гэж хотын бараа харлаа. Нутгийн айлын хашаанд бууж өвөлжсөн юмсан. Гэр гэж сархинаг, мод нь ч хэргээ барсан байж. Нарийн төмөр зам гэж байсны тэнд, бараан захын дэргэд, Сэлбийн гүүрний урд, одоогийн Сангийн яамны зүүхэнтэй аавын хашаанд... манайх гэдэг айл бууриа, айлын том хүү би амь зуух аргаа эрж явсан хэрэг байжээ.

-За тэгээд яаж амь зуув?

-Манай аавын дүү Ц.Намжил гэдэг хүн тэр үед Гэгээрлийн яамны орлогч байсан юм. Намайг шүлэг зохиол оролддог гэж дуулаад театрын дарга Нямын Цэгмидтэй ярьж ажилд авах өгөх юм болжээ. Мань “Богд” хэдэн юм асуусан болоод уран сайхны удирдагч Вангантай уулз гэлээ. Ванган намхан, хэрдээ нүд хөмсөг болсон хөөрхөн эр тайзны хойд арын бүүдгэр өрөөнд тал шиг том шар ширээний ард шатрын хүү шиг цодгорхон сууж, “Уг нь манайд шүлэг бичдэг хүн л хэрэгтэй юмсан” гэсэн боловч цааргалж тээглүүлэлгүй утга зохиолын эрхлэгч гээч албанд авсан юм. Үг хэлээ ч амархан ололцсон доо.

-Ванган гуай гэхлээр “Алтан үеийнхэн” санагдаад байна. Бидний хувьд тэр ихсийн хувьд баруун зүүнгүй андалж яваагүй юм гэхэд бараагий нь хараад алдчих хувь бас тохиосон л доо. Явуу, одоо ч байгаа манай нэг зохиолчийг нэрлэж “Ванган бол зуунтай тэнцэнэ гэж” магтдаг байлаа. С.Эрдэнэ, С.Гэндэн, Ч.Чимид наратй хаа л бол хамт нийлж “савдаг” нэг их том шар цүнх барьчихсан яваа нь шар нохой хөтөлчихсөн ч юм шиг л харагддагсан

даа?

-Түүнийг театрт зориулж бурхнаас бүтээсэн юм шиг байгаа юм. Жүжиг найруулж байхыг нь харахад энэ чинь яасан харгис, дарангуй хүн бэ гэмээр. Үзэгчдийн танхимаас тайз руу гялалзан хүрч, “дахиад” гэж ганцхан хашгирахдаа их бага бүх жүжигчдийг балтасхийлгэж Цагааны Цэгмид, Лигдэн Бат-Очир, цоохор Мижиддорж гээд аваргуудыг ч хурууныхаа үзүүрт бөндөгнүүлнэ. Ерөөс тийм хүн үү гэвэл үгүй. Найруулагчдыг дайрдаг Гэндэн, нухдаг Цэгмид, боддог Ванган гэдэг байсан. Тэгэхлээр Ванган “боддог” байж. Театраа мэддэг, бусдын мэддэгийг өөрснөө мэддэг болох гэж Улстөрийн товчоо золигтдог байхад Бал даргыг нь ч тоодоггүй, дарга нарыг аятайхан мөгдорлоод буцаачихдаг. Өөрийнхөө томыг, жижиг амьтдын зовлонг ч мэддэг, ажлын бус цагт хэнтэй л бол хэнтэй нөхөрлөдөг. Наргиж даргиж ч чаддаг тийм л хүн байсан даа.

-Театрт ороход тань алтан үеийнхэн яг тоогоороо ярайж байсан гэхэд болох биз?

-Би бол театр руу үзэгчдийн хаалгаар бус театрын амьдрал жинхэнэ өрнөж байдаг тэр талаас нь орчихсон хүн л дээ. Эхлээд сүрдэж балмагдсан минь ч ойлгомжтой. Хаана л бол дуулсан, хуурдсан, будсан шунхадсан, дуурь, жүжиг сургуулилсан улс. Тэнд халхын цоохор Цогт, энд Арслан тайж, Хулан хатан, наана нь Гүен баатар, цаана нь Улаан малгайт... дүрээрээ. Сүрдэхээс яах юм бэ. Хийлч Цэрэндолгор, урлагийнхан “Эно” гэдэг Эрэнцэнноров ч байж л байсан. Нансалмаа ч болдог Хоролмаа ч болдог Пүрэвсүрэн ид гаарч байсан үе. Загдсүрэн, Цэвэлсүрэн хоёр гоцлож эхэлж, ардын жүжигчин Гантөмөр гэдэг шовх улаан хархүү театрын үүд дөнгөж татаад байлаа. Ичинхорлоо гуай, Хандсүрэн гуай бөөн намба, цул авьяас байхын нэр хүнд заларч харагдсан даа. Л.Намхайцэрэн, Л.Гаваа, Б.Дамдинсүрэн, С.Гончигсумлаа цэл залуухан, театрын хаалгыг онголзуулдаг банди нар нь гэхэд хойно сурч байсан Л.Мөрдорж, Ц.Намсрайжав, Д.Лувсаншарав...

-Төвдийн гүнж Дулмаа (Л.Цогзолмаа гуай) байсан л байлгүй?

-Хаачсан ч юм эхний өдөр байгаагүй санагддаг юм. Тэгэхнээ нэг өдөр шатны тэнд баахан хүний дунд юм, ярилцаад зогсож байсан юм даг. Цогзолмаа үүдний манаач Өндөр наймаагаас аваад бүх хүнтэй эн чацуу мэндэлж инээд баяр бэлэглээд л. Хүний хайр татдаг нь байдаг гэхэд бүх хүний хайр хүлээдэг Цогзолмаа шиг нь ховор байсан даа. Театрт ирж байгаа улсын хагас нь жүжиг үзэх гэж үлдсэн нь Цооцоог харах гэж ирдэг гэлцдэг байсан юм шүү. Яваандаа танилцаад миний хэд хэдэн дууг дуулсаан. Миний “Хаврын дууг” дуулахаар нь Ванган уг шүлгийн хэлбэрээр,

Пүрэвдоржийн паргиа дуу

Пүрэвсүрэнгийн царгиа дуу

Бүлтүүн хүүхний нялуун дуу

Бүгд нийлээд театрын дуу

гэж гаргасан билээ.

-Саяын таны олон “хаан”, “хатдыг” хүмүүс зүгээр л “Алтан” гэж үнэлээгүй дээ. Үнэхээр алтан байж уу?

-Дашдэлэг гуай ёочингоосоо салахгүй зүгээр л нэг эмээ, хуурч Жамъян жийхайж хүн шоолсон зүгээр л нэг хархүү. Алдарт Цэвээнжав гуай ердөө л говийн нэг тэмээчин бор хүүхэн. Гэтэл тайзан дээр гараад ирэхээрээ төрөл арилжицгаачих нь тэр. Цагаан Цэгмид “Цогийн идэр нас” жүжигт гурван дүрд хувилж тоглоход нь хамт ажилладаг би ялгаж таниагүй юм чинь. Долоон худгийн нутагт түүнийг айлд очиж оройноос маргааш өдөр нь болтол хятад болж жүжиглэхэд гэрийн эзэд үгүй ээ бас их айраг уудаг хужаа яа гээд хоцорч байх нь ч аргагүй юмаа даа.

-Зохиолчдын хороогоо яаж бараадав. Тэр үеийн хорооны тухай?

-Би “Цогийн” нарийн бичгийн даргаар очсон юм. Ц.Хасбаатар эрхлэгч нь байлаа. Зохиолчдын хороо Засгийн газрын ордны зүүн жигүүрт гурван өрөөтэй. Дарга нь дипломатч Б.Жаргалсайхан гуай, Д.Сэнгээ нарийн бичгийн дарга нь. Ч.Ойдов, С.Дашдэндэв, Б.Бааст, Ч.Лхамсүрэн гэсхийгээд дуусна. Залуусаас их сургуулийн оюутан алтан шүдтэй ганган Д.Мягмар, М.Ширчинсүрэн гэж шарваар өмссөн шулга цагаан залуу, театрын найрал дуунд зогсдог С.Дашдооров, Багшийн дээдийн Л.Түдэв холцруутай бор банди хороогоор ид эргэлдэж, Гайтав аль хэдийн мандчихсан, Явуухулан, Эрдэнээ хоёр шүлэг, өгүүллэг, тууж хэвлүүлчихсэн биднээс догь амьтад байцгаасан юмдаг.

-Утга зохиолын хөгжлийн нэгэн үеийг Д.Сэнгээтэй холбож ярьдаг, их ч юм хийсэн гэдэг?

-Юу үнэн бэ, тэр үнэн. Дашзэгвийн Сэнгээ гэдэг чинь зүгээр л дээлтэй гал явсан юм. Дайчин уянгалаг бичнэ. Ерөөл магтаал руу хадуурсан монгол найргийн амыг амьдрал руу залсан хүн нь Сэнгээ. Тэр хүн С.Эрдэнэ, Д.Мягмар, Б.Явуухулан, Л.Түдэв, М.Ширчинсүрэн, Д.Гомбожав бидний бүгдийн багш. Бидэнтэй жил гаруйхан ажиллаад бүгдийнх нь түүврийг гаргасан. Монголын утга зохиолын хөгжлийг алхам өөд татсан гавьяа түүнийх. Д.Сэнгээ утга зохиолд юу ч хийгээгүй, “До” яамны тагнуул, түүний шавь нар дайсны цэргүүд гэх ухааны юм ярьдаг хүн байдаг л юм гэсэн. Сэнгээ хэн байсныг юу хийснийг өөр хэн ч биш бид батлана. Хэрвээ бидний хэдэн буурай юмыг алтан үе мүүдээ багтааж гийгүүлдэг нь үнэн бол багшийг хааш нь хийх болж байна?

-Горькийн сургуулийн сониноос яриач. Та хэний нь шавь юм бэ?

-Явуухулан 59 онд төгсөж, би 60 онд Москвад очсон юм. “Өнөө үеийнхэн коммунизмд аж төрнө” гэсэн лоозун гудамжинд гэрэлтэж Хрущёв Сталины хамаг хэргийг уудалчихсан, коммунизмын тавагны түрүүч нь байсан болов уу гуанзанд талх үнэгүй. Гагарин тэнгэрт нисээд газарт Орос орон хөл алдан баярлаж, цагийн сиймхий “Дулаарлын үе” балчир оюутныг тосчээ. Сургууль яахав, сурсан, сурах юу байхав хугацаа дууссан. Е.Долматовскийн семинарт орох гээд багтсангүй. Сергей Смирновын хэсэгт төгссөн. Цэдэндорж бид хоёр явсан юм. “Сургагч” маань түрүүлээд ирчихсэн л дээ.

-Яасан юм бэ?

-Д.Тарва дээд курс төгсөж биднээс түрүүлэн буцах болоод бид үдэж мах чанаж ганц нэг шил юм мулталж гадуур жаахан гараад ирсэн чинь байранд цагдаа ирчихэж. Манай ангийн ахлагч Н.Тереховын хэлэх нь, Цэдэндорж цонхоор лонх, чулуу шидэж хүүхдийн тэрэг түрээд явж байсан нэг хүүхнийг онож сүйд хийх дөхсөн, оросуудыг колоничлогч гэж хэлсэн юм гэнэ. Зуны амралтаар ирэхэд нь буцаагаагүй. Уг нь тэнд Цэдэндорж “Морин хуур” энэ тэр гээд жигтэйхэн сайхан бичиж байсан даа.

-Зохиолынхоо санааг яаж олдог вэ, бидний үе гэхэд амьдралыг бичнэ гэдгээр хүмүүжсэн. Амьдрал ямар хамаа байна, сэрэхүй сэтгэхүй гэх хандлага өнөөдөр давамгайлаагүй юм гэхэд багагүй байна?

-Хужирт сумын наадмаар суман дэлтэй хонгор морь унасан хүрэн торгон дээлтэй нэг сайхан “амьтныг” хараагүй бол би “Сумын наадам” бичихгүй

Суусрын гүйдэл шиг салхи шанхаар наадан сэвэлзсэнээс

Суурь хөлгөн асрын шашир цацаг дэрвээ юу

гээд эхлэхгүй байсан.

Баянхонгорын намар Шинэ жинст орж. Гурван бамбуугаар явж илгээлтийн эзэн Сүхбат гэдэг охины гэр, Надмид авгайнд бууж саатаагүй бол “Сэгс цагаан богдын” тухай зүүдлэх ч үгүй байсан. Би бол агаараас “юмаа” авчихдаг дээд онгодтон биш амьдрал түшиж шад мөр холбодог мохоо найрагч. Тэр жил Өмнөговьд “Уран үгсийн чуулган” болсон. Биднээс гадна Казах Олжас Сулейменов, Нивхи Владимир Санги Хонгорын элсэн дээр хөрвөөж, өнгө гэрлийн хувилгаан болсон говьд бие сэтгэл бадарч явлаа. Хатан Сэврэй уулын бэлд нутгийн нэг ахимаг анчин янгирын тухай ярихыг сонсож, янгирын сүрэг хад оройдон цахилахыг харж яваад нийслэлд ирмэгц Явуу “Тэхийн зогсоолоо” бичсэн юм.

-Явуу гэснээс Явуу та хоёрыг таагүй харилцаатай байсан гэдэг. Бурхадын зодоон гэгч л байсан юм болов уу даа?

-Бид хоёр гуч гаран жил сайхан нөхөрлөсөн. Үзэг төдийгүй хундага нэгтэй явсныг минь хүмүүс мэднэ. Энэ тухайд сая гаргасан дуртгалын номондоо ч би биччихсэн байгаа. Бидний хоорондын зөрөө найрагчдын хооронд биш намын үүрийн дарга, намын гишүүн хоёрын л дунд бослон юм.

-Та Хятадад айхавтар удаан жасааллаа. Ирээд харвал Монгол маань хэр өөрчлөгдөж вэ?

-Адаглаад айлууд малтай, хотынхон өөрийн гэх сууцтай болж. Сэргэжээ. Наад зах нь нэг найзаа таарахад ороод цай уучих газартай болж. Харин арай л олдоо юу даа. Гэхдээ сэргэхэд учир бий л дээ. Хотоор явахад миний мэт нь орох газраа олохоо байж. Хаягийг нь уншаад мэдэхгүй юм. Юу ч гэж байгаа юм, хаанах ч юм нэг хаяг. Хамаагүй яваад орчихсон чинь өнөөх хаяг нь “Зоригийг егүүтгэсэн хүн орж ирж өчгөө мэдүүлнэ үү” гэсэн байвал яах юм?!

-Ойрдоо юу бичиж байна?

-Хархорин хотын тухай дуурь Д.Лувсаншаравтай нухаж байгаа.

Д.Цоодол

“Монголын мэдээ” 2000.3.18 №201

Би юу ч туурвидаггүй, бичдэг

-Таныг манай уншигчид сайн мэдэх хэдий ч яриагаа унасан газар, угаасан уснаас тань эхэлбэл ямар вэ?

-Түүний нэрийг Монголд мэдэхгүй хүн байхгүй гэж бичдэг. Энэ тодотгол лав надад таарахгүй. Намайг мэдэхгүй хүн Монголд зөндөө бий. Яагаад гэвэл би чинь ХХ зууны хүн. ХХ зууны уншигчид ч бас бүрэн мэдэж байгаагүй. Яруу найргийн их танхимд суудаг уншигчид л мэддэг байсан. Шинэ зууны залуучуудын дунд миний уншигчийн хүрээ их явцуухан байгаа. Тийм ч байх ёстой.

-Тэгвэл бүр ч олзуурхмаар биш үү. Уншигчид таныг сайн мэдэх боломж олдож байна шүү дээ.

-Би Өвөрхангай аймгийн Бүрд сумын хүн. Улаанбаатараас 300 км зайтай даа, миний нутаг.

-Хуучнаар бол?

-Түшээт хан аймгийн Эрдэнэдалай гүний хошуу. Жинхэнэ төв халхын нутаг. Манай сумаас 17 км-т Монгол Улсын төв цэг бий. Бас Монгол уулын өвөр Өндөр гэгээний ширээлсэн газарт Улаанбаатар хотын суурийг тавьсан гээд гэрэлт хөшөө босгосон байгаа. Хотын дарга нар жил бүр очиж хүндэтгэл үзүүлдэг. Тэгэхээр би, би ч гэж манай нутгийнхан бүгд Улаанбаатарын унаган иргэн гээд зүтгэвэл буруудах юмгүй байгаа биз дээ.

-Төрсөн бууцан дээр чинь биш биз дээ.

-Манай сумын нутаг л даа. Харин би Эрээн гэж сайхан уулын зүүн суга Хондын бууцанд эхээс мэндлээгүй, ойчсон юм.

-Таны уран бүтээлч болох зам театраас л эхэлсэн юм байна шүү дээ?

-Театрыг “Миний уран бүтээлийн академи” гээд байдгийн минь учир тэр л дээ. Тэнд гурван жил болохдоо урлагийн олон сайхан томчуудтай бүгдтэй нь танил болсон. Тэд оройд театрт цуглана, театрын буфетэнд пиво ууна. Би тэдэнтэй хамт ууж, идэж явна гэдгээ хүмүүст харуулах санаатай.

-Утга зохиолд орсон тань хэдийд юм бэ?

-Театрт гурван жил болоод Зохиолчдын хороонд “Цог” сэтгүүлийн нарийн бичгийн даргын ажилд орсон. Сэнгээ гэдэг дарга намайг өөд татсан юм. Тэр үед Зохиолчдын хороод

“Сэнгээгийн гурав дахь өдөр” гэж байлаа. Долоо хоногийн гурав дахь өдөр залуучууд ирж шүлгээ уншина. Гологдоод загнуулаад, зарим нь магтуулаад л.

-Нэртэй зохиолчдоос хэн хэн байв?

-Бид бүгд залуу, нэг үеийнхэн. С.Эрдэнэ, Б.Явуухулан, Л.Түдэв, С.Дашдооров гээд олуул байсан. Нэг жил бидний бүгдийнх нь номыг Сэнгээ дарга гаргасан. Залуучуудыг дэмжсэн юм шүү, тэр хүн. Сэнгээгийн гурав дахь өдрийнхөн үл бүтэх гээд биднийг загнаж хүртэл үзсэн. Тэглээ гээд амьдрал үргэлжилдгээрээ л үргэлжилсэн. Боодолтой, боодолгүй олон чулуугаар шидүүлж үзсэн дээ. Тэндээс нэг юм их сайн ойлгож авсан.

-Юуг тэр вэ?

-Магтаалаас хол байх хэрэгтэй гэдгийг.

-Магтаалд дургүй хүн байдаг юм уу?

-Тэр ерөөсөө нэг их олигтой юм биш. Одоо хүртэл хорвоо дээр сүүдэр чирээд явж байгаа минь миний нуруун дээрх ачааны бараан нь илүү байсан болохоор миний зовлон, жаргал тэнцэж явдаг юм болов уу гэж санадаг.

-Та өөрийгөө ямар нэг зүйлтэй адилтгадаг уу?

-Улаан, хөх хоёр өнгөтэй харандаа байдаг даа, би түүнтэй л.

-Яахаараа заавал улаан, хөх гэж?

-Хөх нь монгол гэж байгаа юм. Улаан нь би. Би чинь нэг хэсэг улаан коммунист байлаа шүү дээ.

-Та ер нь анхны шүлгээ хэдийд бичсэн юм бэ?

-Дунд сургуульд байхдаа ерөөл уншдаг, жүжгийн дугуйланд тоглодог, шүлэг бичдэг саваагүй нэгэн байж. Хэдийгээр хүн авах юм байгаагүй ч түүнийгээ хаяагүй яваад байж. Яруу найргийн халдварыг нэлээн багадаа авсан шиг байгаа юм. Манай нутаг айрагтай, найртай, хүмүүс нь цэцэн цэлмэг, их шооч. Шүлэг бичдэг нэг нимгэн дэвтэртэй байснаа санадаг. Тэр нь ч алга болсон. Тэгээд анхны гэж хэлэх, санах ч юм байдаггүй.

-Тэгвэл анх хүнд хүрсэн шүлэг гэвэл?

-Театрт ирээд “Алтан намар” гэж шүлэг бичсэнд Мяасүрэн ая хийж, Загдсүрэн дуулсан. Өнгөрсөн жил 40 жил нь боллоо гээд байсан биз дээ.

-Таныг “Учиртай гурав”-ын Юндэнд дуулж байсан гэж сонссон санагдана?

-Суман дээр нэг удаа Юндэн болдог юм. Тайзан дээр “Ижил хоёр шувуу шиг...” гэж дуулаад Нансалмаагаа тэврэх гэсэн гар хүрдэггүй. Бүдүүн, том биетэй Нансалмаа таарсан хэрэг.

Тиймэрхүү л Юндэн байсан шүү дээ.

-Залуу хүнийг хөглөдөг нэг зүйлийг хайр сэтгэл гэж олон хүн ярьдаг. Таны хувьд?

-Би хувьдаа хайр сэтгэлийг ганцаардлаас дүрвэсэн ханьслын тэмүүлэл гэж тодорхойлдог.

-Та тэгээд хэдийд анх ганцаардлаас дүрвэв?

-Өө, би олон удаа дүрвэх гэж оролдсон.

-Аль нь анхных гэдгийг тодорхойлж чадахгүй байгаа хэрэг үү?

-Аа тийм. Би хайрын мэргэжилтэн биш юм билээ. За, энэ бол наргиа.

-Уран бүтээлчийн хувьд авьяас, хөдөлмөр хоёрын аль нь чухал бэ?

-Зарим хүн багахан авьяастай байхад юунд ч хүрч болно гэдэг. Минийхээр бол худлаа юм шиг.

-Танд аль нь илүү байв?

-Аль аль нь хомс байх аа. Би сандал дээрээ тогтдоггүй хүн. Ер нь ч яруу найрагчдыг бөөрөнхий бөгстэй, тогтворгүй гэдэг юм шүү дээ. Тийм болохоор цаг их алдсан. Тэгээд ч хүн хэзээд нэг байран дээрээ биш өөрийгөө шинээр нээж, байн байн тэсэрч байх ёстой юм билээ. Жишээ нь, Сэнгээгийн гурав дахь өдрийнхний ахны ном бүгд тааруухан гарсан. Гэтэл Явуухулан Горький төгсөөд “Мөнгөн хазаарын чимээ”-тэй ирсэн. Өөрөөр хэлбэл, Явуу өөрийгөө шинээр нээж чадсан. Намдаг гэж том зохиолч байлаа. Хилс хэргээр долоон жил шоронд суугаад гарч ирээд “Магсар дарга” гэж жүжиг бичээд. Бид хоёр түүнийг нь үүрээд олон найруулагчид очиж уншсан. Театр хүлээж авдаггүй. Тэгээд сүүлд нь Сэнгээ дарга Намдаг гуайд Зохиолчдын хороонд өрөө гаргаж, цалин өгөөд роман бичүүлэхээр суулгасан. Тэр нь “Цаг төрийн үймээн”. Энд Намдаг гуай өөрийгөө дахиад нээсэн. Үүнийхээ дараа нөгөө л алдартай “Хярааны хонхорт”, “Оролмаа” гээд мундаг жүжгүүдээ бичсэн юм шүү дээ.

-Та харин өөрийгөө хэзээ нээсэн бэ?

-Би ер нь өөрийгөө одоо болтол нээж чаддаггүй гэж боддог. Хүн төрөлхтний араншин юм уу даа. Өөрийгөө таньдаггүй. Хүнийг л таних, нээх гээд зүтгээд байдаг. Өөрийгөө нээх их хэцүү байдаг юм болов уу даа. Монголын уран зохиолд оруулсан миний хувь нэмэр гэвэл Горькийгоос хэдэн найраглалтай ирсэн минь. Уянгын богино найраглал. Горхи, эсвэл шанд ч юм уу.

-Найраглалуудыг чинь хүмүүс сайн мэднэ. Анхных нь?

-Анх “Аюур” гэж найраглал бичсэн юм. Улсын сайн малчдын хоёрдугаар зөвлөлгөөн ч бил үү болсон юмдаг. 1950-иад онд Сэнгээ дарга “Чи тэр хүний, чи энэ хүний тухай бич” гээд оноож өгсөн, бидэнд. Надад Баянхонгорын “Улаан чих” Аюур гэдэг хүн таарсан. Тэр хүн сумандаа анх жингийн нэгдэл гэдгийг байгуулсан юм билээ.

-Та тавин найраглал бичнэ гэж ам алдсан тал бий байх аа. Хэлсэндээ хүрсэн үү?

-Бичсэн шүү. Гэхдээ тэр дотроос тав нь арай гайгүй болсон болов уу гэж боддог.

-Нэрлэх үү?

-Хар цас, “Шарлингийн хар Хас”, “Хөх даалимбан тэрлэг”, “Сэгс цагаан богд”, “Гэргий буюу зүрхний бичлэг”

-”Сэгс цагаан богд” чинь эзэнтэй найраглал уу. Ингэж олон хүн асуудаг байсан гээ биз дээ?

-Үүсгэвэр дүртэй.

-Ганцаардлаас дүрвэх тэмүүллийн тань ямар нэг үетэй холбоотой юм биш биз дээ?

-Үгүй, наадах чинь албан томилолт дундуур таарсан. 1969 онд Баянхонгор аймгийн Шинэжинст суманд нэг айлд буусан юм. Надмид гэж тэмээчин авгай, 17 настай охинтой.

-Наад хариултыг тань өмнө нь уншсан юм байна. Гэхдээ хүмүүс арай өөрийг хүлээгээд байдаг юм биш үү?

-Нэг удаа “Оргил”-д амарч байхад уулзалт гэж юм боллоо. Хүмүүс янз бүрийн юм асуугаад. Тэгэхэд нэг нь “Тэр тэмээчинтэй ямар холбоотой байсан. Та тэнд хоцорсон гэл үү. Тэр хүүхэн хоёр хүүхэдтэй нэг нь таных гэсэн үнэн үү” гээд салдаггүй. Тэгэхээр нь “Би тэнд ганцаараа байгаагүй. Ардын Их Хурлын тэргүүлэгч гишүүн С.Удвал гэрчтэйгээр тэр айлд 1969 оны аравдугаар сарын 15-нд 30 минут саатсан. Түүнээс хойш би Баянхонгор яваагүй. Зөвлөлтийн зохиолчидтой хамт Говь-Алтай явахдаа Баянхонгорын нутаг дээгүүр ниссэн. Тэр үед л олдоогүй бол миний хүүхэд биш” гэж байж нэг юм дуугүй болгосон шүү.

-Та ер нь хэн бэ?

-Их Монголын хугархай.

-Яруу найрагчдыг үг зохиодог, тэр нь яг байсан юм шиг хэрэглэгдээд явчихдаг гэдэг. Таныг ч энэ тал дээр нэлээд дээгүүр орох хүн гэхийг нэг биш удаа сонссон юм?

-Би үг зохиогоод байдаг хүн биш. Буурлуудынхаа чих рүү цутгасан үгсээс л зууж ирж байгаа нь тэр. Ринчен гуай монгол хэлийг гурав орчим сая үгтэй гэж хэлдэг байсан. Социализмын үед “Үнэн” сонины долоо хоногийн дугаарыг тоолсон 500-гаад үг байсан гэж байгаа. Одоо улам цөөрсөн, 300 хүрч байгаа болов уу.

-Та “Улаан гэрийн хоригдол” нэртэй дурсамжийн ном бичсэн. Түүнээс хойш амьдрал үргэлжилсээр байгаа хойно дурсамж ч бас зузаарч байгаа биз дээ?

-Тийм ээ, “Бор гэрийн Богд” гэсэн нэртэйгээр үргэлжлэлийг нь бичихээр төлөвлөчихсөн байгаа.

Миф

Унадаг унаа нь жийп

Д.Пүрэвдорж гуай үнэхээр жийп машинтай юм билээ. Унаагаа танилцуулахдаа, Миний уран бүтээлийн “Хөх үндэсний гал” найргийн хурим болсон. Манай Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар, нутгийн зөвлөл, сумын захиргаа намайг уран бүтээлийн байр, унах унаатай бол гэж хишиг хайрласан юм. Тэгээд би шинэ “морьтой” болчихоод байна гэлээ. Өмнө нь тэр “ОPEL”-той байжээ. 18 жилийн хур туршлагатай жолооч гэнэ. Гэсэн ч “Би муу жолооч” хэмээн адруу загнахаа мартсангүй. Замын цагдаагийнхан түүнийг жолооч хэмээн андуураад явуулаад байдаг юм байх. Хашир жолооч хавь ойрын бүх машиныг найр тавьж өнгөрүүлээд, замын бөглөө таарвал мөргүүлчихээргүй газар зогсох хообийтой. Ээлжит замын бөглөрлийн үеэр арынх нь тэрэг дохиогоо хангинуулаад байхаар нь мань эр бууж очоод, “Миний хүү яараад байвал түрүүлээд дөхөж бай даа” гэсэн чинь жолооч залуу писхийтэл инээгээд чимээгүй болсон гэнэ билээ.

Уудаг архи минь наполеон

Пүдо /Түүнийг ойр дотнын хүмүүс нь ингэж дууддаг/ тамхи яаж татахыг яруу тодоор үзүүлэх юм. Тэр нэгэнтээ тамхи угсруулж татсаар муушиг тоглож хожжээ. “Бактериологийн зэвсэг хэрэглэсний хүчинд...” гэж дараа нь наргиа болгосон аж. “Тамхи таваад тавин жил боллоо” гэж надад тэр ёслол төгөлдөр мэдэгдлээ. 16 насандаа туулайн хоргол татсанаар тамхи татах түүхэн замналаа эхэлжээ. “Сайхан эгчийн дэргэд ганц хоёр гаанс тамхи уугиулаад эр хүн болсоноо харуулсан шиг суух ч...” гэж нухацтай хэлээд донжтой хөхрөнө. Одоо бол өдөрт хайрцаг тамхи “идчихдэг” болжээ. Гэсэн ч тэр удаан жилийн нөхрөөсөө татгалзаж магадгүй гэнэ. “Тамхи, архины самбарыг буулгахаар энэ хороос гарах болов уу гэж бодоод байгаа” хэмээн тас тас хөхөрч суусан. Тэр бас лонхны дайсан биш. “Залуудаа бол юу олдсоныг нь ууж явлаа” гэсэн. Эрүүл мэндийн шалтгаанаар хатуу идээнээс холдоод хорь гурай жил болсон гэх. Гэсэн ч “Найз нөхдийн хүрээнд мөстэй виски юм уу, ганц хоёр хундага наполеон шимж чадна” гэлээ. Цагаан архи амсдаг ч үгүй юм байх. Сархадтай холбоотой сонин дурсамж нэг бус.

-Чимэд, Явуухулан, Гайтав, Эрдэнэ нартай наргиж суусан юм. Бид диваажинд очих уу яах вэ гэж ярилцлаа. Чимэд “Үгүй ээ би очихгүй. Миний таньдаг хэдэн бүсгүй бүгд тамд байгаа” гэхэд, Гайтав “Би очно. Бэлэн юман дээр, тэнд чинь л очье” гэж билээ хэмээн Пүдо дурсав. Түүний “Би диваажинд очихгүй” шүлэг нь эндээс эхтэй нь лав.

Энгэрийн минь үзэг автомат

Одоо тэр “паркер”, “шаффер” үзгээр гангардаг болсон. Ц.Балдоржийн бэлэглэсэн “шаффер”

үзгээр “Улаан гэрийн хоригдол” хэмээх дурсамжийн номоо бичжээ. Харин анхны Ерөнхийлөгч П.Очирбатын бэлэг “шаффераар” шинэхэн туужаа бичээд дуусч буй. “Элчин сайд Цахилгаан “монблан” гэдэг гайхалтай сайхан үзэг бэлэглэсэн. Хайрцаг нь манай ээжийн хөлийн авдар шиг юм билээ” хэмээн сэтгэл хангалуун дурсав. “Тосон балаар бичнэ гэхээр модоор бичиж байгаа юм шиг санагддаг. Бэхтэй хамт сэтгэл, цус хоёр минь урсч байгаа юм шиг сэтгэгдэл төрдөг юм” хэмээн хуучилсан. Түүний ширээн дээр нь компьютер харагдав. “Сурвалжлагч нарт харуулах гэж тавьсан юм” гэж наргиа болгоно билээ. “Миний гар нооргийг хармаар байгаа бол амны хаалт хэрэгтэй” гэж зөвлөв. Гар нооргоо улаан эрээн болтол нь засварлаж кирилл, монголоор оруулга хийдэг тул бохир нооргоос нь хамрын ханиад ч хүртэх болзошгүй юм байх: “Хөх даалимбан тэрлэгээ” гурван жил бодоод, жил засварлаж байж зүүнээс гаргасан гэдэг. Харин “Сэгс цагаан богд” нь ганцхан сарын дотор мэндэлсэн түүхтэй.

Эхнэрийн минь ажил дипломатч

Найрагчийн гэргий Чанцал Гадаад хэргийн яаманд насаараа ажилласан нэгэн. Пүдо “Манай хүн орос, хятад, францаар хэдэн үг мэддэг. Монголоор бас цөөхөн үг мэднэ” хэмээн эхнэрээ “муулав”. Багагүй хуагцааг урьд, хойд хөршид өнгөрөөснийгээ “Улаан хэрэм, цагаан хэрэм хоёрын наана, цаана 11 жил айл болон амьдарч, аж төрөн суув” хэмээн хошигнох дуртай. Найрагч маань эхнэрээ даган Хятадад долоон жил амьдарчээ. Үүнийгээ тайлбарлахдаа “Муу эр эхнэрээ дагадаг, мухар үхэр эвэртэйгээ дагадаг” хэмээн оршил хэлэв. “Гадаад яамныхан өчнөөн олон удаа гадагшаа дотогшоо явна. Энэ хүн чинь надаас уяатай. Би утга зохиолын аргамжаанаас уяатай” хэмээн “муу” эр өөрийгөө цагаатгав. Энэ мэтийг бодолцож үзээд тэр “аргамжаагаа” аван харьд ажиллах боломж эхнэртээ олгожээ. Тэнд Пүдо тогоо барьсан гэнэ билээ. Хоолны талаар туршлагатай эзэгтэй нартай ч ном хаялцах даг. Мань эр цуйван хийхдээ ч чихрээр амталдаг нь урд зүгийн нөлөө биз. Хоол бол хийсвэрлэн бодохын үр дүн” хэмээн томъёолов. Өрнө зүгийнхэн шорлогны махыг дарсаар амталдаг бол Пүдо түүнийг нь айргаар орлуулах жишээтэй. Уянгын шүлэгч, уянгын халилаа орхихгүй. Түүний бодлоор хуурсан гурил, айрагны тостой, будаатай, шийртэй гэх мэт нутаг, нугын цай нь мөнөөхөн уянгын халилын сонгодог жишээ ажээ.

Ийнхүү уянгаар дүүрэн амьдрахад нь багад нь тохиолдсон хоёр учрал нөлөөлсөн гэнэ.

-Манай аав намрын нэгэн цас бударсан өдөр хос морьтой явсан. Биднийг орхиод явж байгаа нь тэр. Харин ээж минь хойноос нь сүү өргөөд хоцорч билээ. Энэ зураг насан туршид минь мартагдаагүй гэнэ. Нэг удаа тэр ангирын нулимсыг мэдэрчээ.

-Хонь хариулж явсан юм. Дэгдээхэйгээ дагуулсан ангир голын захад нарлаж байтал элээ дэгдээхэйг нь шүүрчихлээ. Эх ангир дагаж нисэн ганганасаар үрийнхээ өдийг зулгааж хаяхыг нүдээрээ харж билээ. Тэгэхэд би жигүүртний нулимс гэдгийг харах шиг болсон. Ангирын дуунаар зүрхний минь ховдолд унасан нулимс өнөө хүртрэл эгшээгүй юм шиг санагддаг хэмээн өгүүлэв. Харин найрагчийн эмзэг сэтгэлийн уянгаар бидний сэтгэл хөглөгддөг. Магадгүй үүний төлөө л хөөрхий эх, ангир хоёрыг хорвоо золиосолсон ч юм билүү.

“Урамшил” хэмээх хашлага бүлэг

Эл номыг бэлэгшээлийг эрхэмлэж үзэг нэгт нөхдийн үгээр хашив.

Уран бүтээлийн хөл алдсан харгуйд нөхрийнхөө мөрийг нөхөөсгүй сэтгэлээр түших оюуны хүч, сэтгэлийн тамиртай, олныхоо хүчинд би онох алдахын алинд ч ганцаардаагүй юм шүү. Магтаалд хөөрцөглөж малгай шилэнд шидэн дарцаглах нас минь намаршсан болохоор бэргэхийн цээрийг алхахаас би үл эмээв.

Миний дөрөөнд сүү өргөсөн, сүүдэр унагасан алин боловч урлахуй, оршихуйн билүүнд намайг нийлж мохоолыг ирлэж, монгол найргийн өртөөлд өлзийгөө өгсөн гэдгийг хоргомжгүй өчсү.

Академич Хорлоогийн Сампилдэндэв /доктор профессор/ Лхамсүрэнгийн Хүрэлбаатар, доктор (Ph) Жигжидийн Амараа нар умгар бор гэрт минь багтахааргүй углуургатай судалгаа бичсэнийг машид хичээнгүйлэн өгүүлье.

Яруу найрагт холч хүлэг, хонины морь аль нь байдаг. Аргамагийн шандасгүй би вээр аргал усанд уншигчаа явгалаагүйдээ азархана.

Ч.БИЛИГСАЙХАН

Доктор, профессор

Үг эзэгнэх эрдэм

“Үг бол утгын утсанд хэлхэх эрдэнэс мөн. Онож хэлсэн үгийн тунгалаг талстын цаанаас шүлгийн санаа нэвт гэрэлтэх ёстой. Ардын хэл үгсийн их далай. Чухамхүү тэр далайгаас оновчит үгийг олж, ончтой газар нь тавьж сурахыг үг эзэгнэх эрдэм гэвэл зохилтой. “Эерүү үг эхийн элбэрэлтэй, эзэрхэг догшин үг сумын хөнөөлтэй гэдэг” хэмээн БНМАУ-ын төрийн шагналт яруу найрагч Дэндэвийн Пүрэвдорж бичсэн байдаг.

Д.Пүрэвдоржийг яруу найрагчийнх нь хувиар хамгийн товчоор тодорхойлон хэлье гэвэл чухам “үг эзэгнэх эрдэм эзэмшсэн хүн” гэхэд бүрэн болмоор санагдана. Түүний яруу найргийн хамгийн содон шинж нь үгийн зүсийг үнэхээр нийлүүлж чаддаг явдал юм.

Яруу найрагч алдрыг авчрахад анхны шаг нь болсон “Алтан намар” шүлгээс нь аваад уран бүтээлийнх нь сүмбэр оргилуудын нэг болох “Хар цас” найраглал хүртэлх жижиг том бүх шүлэг найраглал нь чухам оновчтой цэцэн үг хэлээрээ уншигчдын сэтгэл зүрхийг эзэмдэж байдаг билээ.

“Навчсыг алтлан сэржигнүүлсэн

Намрын хонгор салхи юмаа

Нандин сэтгэлийг минь булаасан

Найз хонгор чи минь юмаа...”

гэж тэртээ 1950-иад оны эхээр “Алтан намар” гэдэг дууны шүлэгтээ бичсэн бол 1980-аад оны эхээр бичсэн “Хар цас” найраглалдаа

“...Орос цэрэг өнөр олуулаа

Ой мод шиг өндийн босож

Бохирч сөхрөх өвдөггүй юм шиг

Босоогоороо үхэж байсан юм

Бод л доо тэр дайны талбарт

Борооны дусал газарт уналгүй

Шивээлсэн жадны үзүүрт бутарч

Шинелийн хормойд хатаж байсан юм...”

гэж бичсэн билээ. Хүн төрөлхтнийг нөмөрсөн хар үхэл-дэлхийн хоёрдугаар дайны аймшигт сүр, хор хөнөөлийг энэ хэдхэн мөрөнд ч гэсэн хичнээн тодорхой оновчтой илэрхийлснийг бэлхнээ харж болох байна. Ийм оновчтой үг хэллэгээр түүний яруу найргийн бүтсэн байдаг юм. Энэ бол Д.Пүрэвдоржийн яруу найргийн нэг дэх содон өвөрмөц шинж нь юм. Энэ тухайд жишээ татан тайлбарлах юм бол бараг бүх шүлгээс нь иш татаж болно. Харин энэ удаа Зайсан толгой дээрх Зөвлөлтийн дайчдын хөшөөн дээр шигтгэсэн хоёр мөрийг нэмж иш татаад л зогсьё. “Энд зөвлөлтийн дайчдын дурсгалыг тэнгэрт нартай хамт мөнхлөв, газарт галтай цуг дархлав” гэж бичсэн байдаг. Онож хэлсэн мөр гэдэг ганцдаггүйн жишээг үүгээр бүрнээ гаргаж болно.

Д.Пүрэвдорж 1952 оноос анхны шүлгүүдээ хэвлүүлж эхэлсэн бөгөөд тун удалгүй “Улаан оч” гэдэг томхон хэмжээний туульсын найраглал бичлээ. Манай эх орон даяар өрнөж байсан нэгдэлжих хөдөлгөөн манай олон зохиолчийн онгодыг бадрааж зохиол туурвилын баялаг сан хөмрөг бүтээсэн билээ. Түүний нэг нь энэхүү “Улаан оч” найраглал бөгөөд дараа нь түүнээ залган үргэлжлүүлж “Талын туяа” гэдэг шүлэглэсэн тууж бичсэн юм. Ийнхүү уран бүтээлийнхээ бараг анхны алхмаас эхлэн найраглал бичиж эхэлсэн явдал Д.Пүрэвдоржийг хожим нь энэ төрлөөр Монголын яруу найргийн түүхэнд нэрээ багтай үлдээх бахархалт замд шулуутгасан бизээ. 1980-аад оны эх хүртэл бичсэн найраглалууд нь бүтээлээс бүтээлд агуулга, хэлбэр, ур чадал, утга санааны хувьд төгөлдөржсөөр байв. 1969 онд “Хар цас”-аа, дараа нь цувруулан “Сэгс цагаан богд”, “Хөх даалимбан тэрлэг” зэрэг шилдэг найраглалаа бичиж эдгээр бүтээлээрээ 1981 онд БНМАУ-ын төрийн шагнал хүртсэн билээ.

1967 онд “Сэлэнгийн зам” гэж бэсрэгхэн найраглал бичиж тэндээ:

“...Талын хүн би

Талдаа л эргэнэ

Ариухан тал минь

Алтанхан тал минь

Миний тал

Миний хүүгийн тал

Аавын тал

Түүний аавын тал

Түмэн үеийн тал

Талын хүн би

Талдаа л жаргана”

гэж шүлэглэсэн байдаг.

Энэ найраглал нь яруу найргаар дүр бүтээх, санаагаа хэлбэрт захирагдалгүй оновчтой илэрхийлэх, ахиуллын аргаар төгөлдөр утга илтгэх зэрэг хожим нь түүний найраглалуудын үндсэн шинж болсон өвөрмөц барилаараа ихээхэн ялгарч байсан билээ. “Сэлэнгийн зам”-аас ийнхүү Д.Пүрэвдорж “олз”-той ирж манай яруу найргийн амьдралд тэмдэглэлт үйл явдал болсон олон найраглалаа бичсэн юм. Д.Пүрэвдорж яруу найргийн амин сүнс болсон уран санааг соргог олж түүнээ ургуулан бодож гүйцээн шүлэглэж жинхэнэ яруу найраг бүтээх талаар үлгэртэй найрагч билээ. Тэрбээр “Модны ур үндсийг нэг хүн олоод түлэхийн ч аргагүй эд хэмээн хаяж байхад, нөгөө хүн ихэд олзуурхан олон талаас нь шинжин үзсээр орсон буур сийлэн омог сүрийг өвч илтгэж бишрүүлнэ. Сүхбаатарын талбайд очсон минь тоо алдсан. Гэтэл зуны нэг нарлаг өдөр түүгээр зорчин явтал, засгийн газрын ордон их хөлгөн асар мэт, их талбай наадмын дэвжээ мэт сэтгэлд буув. Түүнээс үүдэн Сүхбаатарын хөшөөг харахад нийгэм алгасан хурдалсан эзэн хүлэг хоёрыг хүний манлай, хүлгийн магнай хэмээн эх орныхоо алдар цолыг төрийн асрын өмнө дуудмаар санагдсан. Ийнхүү “төрийн түмэн-эх” найраглал бүтсэн юм” гэж нэгэнтээ бичсэн байдаг. Ингэж түүний найраглалууд ямар нэг онцгой сэтгэл хөдлөл, догдлолын эрч хүчээр бүтдэг учраас ч хэллэг дүрслэл нь уран оновчтой болдог бололтой. Чухам ийм сэтгэлийн хүчээр бүтсэн олон найраглал үргэлжлэн бичсээр байна. Түүний сүүлийн жилүүдэд бичсэн “Шарлингийн хар Хас”, “Хорьдугаар зуун”, “Ширмэн цөгцний дууль” зэрэг найраглалууд нь мөн л манай яруу найргийн наяд оны өнгө амьсгааг илэрхийлэх гол жишээ болсоор байна.

1980 онд бичсэн “Хорьдугаар зуун” гэдэг найраглал нь хэмжээ, утга санааны далайц, ур хийцийн хувьд ихээхэн содон бүтээл болсон билээ. “Хорьдугаар зуун” өөрөө “Би буянаас төрсөн”, “Би нүгэлээс төрсөн” хэмээн өгүүлэн өчиж буй маягаар шүлэглэж энэ зууны нүгэл хилэнц, итгэл бахархлыг уянгын дүрээр товойлгон гаргасан нь уран сайхны аргаар үйл

явдлыг нэгтгэн дүгнэхийн нэгэн том үлгэр болсон юм.

“...Хорьдугаар зуун миний

Хорвоотой золгосон

Хоёр гарын

Нэг нь жаргал

Нөгөө нь зовлон

Хорьдугаар зуун миний

Хорвоо дээр гишгэсэн

Хоёр хөлийн

Нэг нь “тамд”

Нөгөө нь “диваажинд”

гэхчилэн энэ зууны амьдралын зөрчил тэмцлийг яруу найргийн хэлээр дурайтал гаргасан билээ. Бүхэл бүтэн зууны тэх тусмаа сайн муу үйл дээд зэргээр урван хөрвөж хүн төрөлхтний сэтгэл санааг асар их догдлуулж байгаа энэ хорьдугаар зууны үйл явдалд үнэлэлт өгнө гэдэг тун ч төвөгтэй мөртөө зоригтой санаа билээ. Ертөнцийн танин мэдэх марксист-ленинист реализмын аргаар замнасан манай үеийн жинхэнэ зохиолчид л үүнийг хийж чадах нь лавтай. Тийм ч учраас хүн төрөлхтөний амьдрал коммунизмын жаргалтай үе рүүгээ эрс шийдэмгий замнан явааг сэтгэл бахархан олж харсан Д.Пүрэвдорж найрагч уг найраглалдаа

“Би хорьдугаар зуун

Би социализмын зуун

Эдлэн жаргах

Эрх чөлөө авчирсан

Эзэгнэн бадраах

Энхийн гал асаасан

Би хорьдугаар зуун...”

хэмээн эрин үеийнхээ агуулгыг тодорхойлсон билээ.

Д.Пүрэвдоржийн найраглалуудын сэдэв санаа маш баялаг юм. Өнөөгийн эх орныхоо амьдралын явцаас сэдэвлэсэн олон найраглал (“Талын туяа”, “Сэлэнгийн зам”, “Зэсэн уулын

бичээс”, “Шарлингийн хар Хас”, “Сайн цагийн мянган бурхад”, “Гэргий”, “Сэгс Цагаан Богд”) бийгээс гадна хүн төрөлхтний хувь заяа, дайн энхийн асуудлыг сэдэж тавьсан (“Хар цас”, “Хөх даалимбан тэрлэг”, “Хорьдугаар зуун”, “Ширмэн цөгцний дууль” зэрэг) улс төр иргэний уянгын зэрэг олон шилдэг найраглалыг тэрбээр бүтээжээ.

Д.Пүрэвдорж “Хөх даалимбан тэрлэг” найраглалынхаа сэдэв санааг хэрхэн олж яаж санаагаа ургуулан бодож бичсэн тухайгаа саявтархан “Цог” сэтгүүлд (“Цог” 1982 оны №3) бичжээ. Тэгээд эцэст нь “Энд би хоёр зүйл санаа голлон хэлснээ эцэст дахин тодруулъя. Нэгдүгээрт, амьдралын үзэгдэл явдалуудаас утга учрын учгийг олж уран сайхнаар ургуулан бодох, хоёрдугаарт, баатрынхаа дүрийг оноон олж, тэр дүрдээ уусан шингэсэн үндсэн дээр дотоод сэтгэлийн нь өчгийг сонсох ийм хоёр санааг онцлон хэлмээр байна” гэжээ. Энд дурдсан нэгдэх санааны тухайд бид өмнө бяцхан жишээ татаж ярьсан билээ. Харин хоёр дахь санаа нь буюу дүрдээ уусан шингэж дотоод сэтгэлийн нь өчгийг сонсох тухайд задлан яривал их зүйл байна. Ер нь Д.Пүрэвдоржийн урлах эрдмийн бас нэг гол онцлог шинж нь энэхүү дүрдээ хувилж, чаддаг эрдэм нь юм. Ингэж найраглалынхаа дүрдээ хувилж түүний бодол сэтгэхүйгээр дүрслэн шүлэглэнэ гэдэг бол уран чадварын том сургууль эзэмшсэн гэсэн үг юм.

“Ширмэн цөгцний дууль” найраглалдаа (1979) эзгүй хондоос ширмэн цөгц олоод ургуулан бодож улмаар өнөөгийн жанжлах үзэлтнүүдийн хорт санаа тэртээ олон арван жилийн өмнө хэрхэн нууцаар хэрэгжиж байсныг уран сайхны аргаар дүрслэн гаргажээ. Амраг Буянай, авааль гэргий Оюунан-аа нарын хиргүй сайхан сэтгэлийг бузарлаж гашуудлын хар далайд үйлгэсэн тэр өвгөн хятадын бузар гар өнөө ч сарвалзсаар байна. Найрагч маань

“Харахад халгүй

Харийн энэ цөгцийг

Хар санааны хэвэнд

Хаадын зарлигаар цуггаачид

Өргөн хорвоод биднийг

Өөхөн дэнтэй унтрааж

Өлзийт үүдийг минь хааж

Өрхий минь бүтээх байжээ”

гэж өнөөдрийн өндөр ухамсраар өөрийн санаагаа лавшруулжээ. Буянай, Оюунан-аа нарынхаа дүрд уусан шингэж тэгснээрээ тэднийхээ хайр сэтгэл эх оронч санааг яруу найрагч маань зохиолын тухайн нөхцөл байдал дундуур урнаар зайгуулан гаргаж чадсан нь энэ найраглалын уран сайхны ололт болсон билээ. Ийнхүү үйл явдалтай буюу туульсын найраглалаа бүтээхдээ дүрдээ хувилж улмаар түүнийхээ сэтгэлд хүрч чин зүрхний нь үгийг хэлүүлж чаддаг болохоор түүний найраглал хүнд хүрч тэдний сэтгэл санаанд хадагдан амьдарч чаддаг билээ.

Алс говийн хязгаар “Сэгс Цагаан Богд”-ын тэмээчин бүсгүйн сэтгэл зүрхний үгийг уншигч олонд нээн гаргасан нь түүний “Сэгс Цагаан Богд” гэдэг найраглал алдаршихын үндэс болсон билээ. Энэ найраглалыг өнөөдөр Монгол орны аль ч хязгаарт хүмүүс цээжээр уншсаар байдаг юм. Өнөөгийн хөдөө нутгийн малчдын санаа бодолд энэ найраглал үнэхээр нийцсэн билээ. Энэ нь тэдний бодол санааг зөв нээж урлан дүрсэлсэн найрагчийн авьяас чадварын хүчин гэдэгт маргах зүйлгүй. Ийнхүү бэсрэг хэлбэртэй туульсын найраглал бичиж утга зохиолын энэ төрлийг ард олны хайр хүндэтгэлд хүргэж чадсан энэ чадвар Д.Пүрэвдоржийн яруу найргийн хоёр дахь содон шинж гэж бодож байна.

Д.Пүрэвдоржийн яруу найргийн гурав дахь содон шинж нь түүний дууны яруу найрагт нь биежин цогцолсон юм шиг санагддаг.

Анхны нь бичсэн шүлэг дуу болон тархсанаас хойш эдүгээ хүртэлх гуч гаруй жилийн дотор Д.Пүрэвдорж олон арван шилдэг дууны шүлэг бичжээ. Ер нь дууны шүлэг гэдэг ямар нэг хэмжээгээр хэмжээ хэмнэл үнэхээр зохицож чадсан төгөлдөр шүлэг байдаг юм шиг санагддаг. Манай нэрт яруу найрагч агсан Б.Явуухулан нэгэнтээ таны шүлгэнд хөгжмийн зохиолчид ая хийх дуртай байх юм, тэр ямар учиртай вэ? Зарим шүлгэнд тань хоёр гурван ая ч гарсан байх юм гэхэд “Би дууны үг бичиж байна гэж бодож бичдэггүй. Харин жинхэнэ сайн шүлэг л болгох юмсан гэж бодож бичсэн шүлгүүдэд ая хийсэн байх нь их тааралддаг” гэж хариулж байсан. Д.Пүрэвдоржийн богино шүлгүүдийг ажиглаж байхад хэлбэр, хэмжээ, хэмнэлийн хувьд үнэхээр зохицсон бөгөөд дууны шүлэгт их тохиромжтой юм шиг санагддаг. Тэгээд ч олон шүлэг нь дуу болон ард олонд тархсан бололтой. Түүний дууны шүлгийн онцлог нь юу байна вэ? Юуны өмнө дуу бол хүнд тухайн өгүүлж байгаа цаг юмуу үйл явдлынхаа тухай төсөөтэй аяс санааг төрүүлж байх шаардлагатай байдаг бололтой. Энэ утгаар Д.Пүрэвдоржийн дууны шүлэг уг өгүүлж буй зүйлийнхээ аясыг оносон үгээр илэрхийлэх талаараа маш гарамгай юм. “Дөрвөн цагийн тал” гэж ихэд тархсан дууны ганцхан бадгийг авч үзье.

“Янагийн сайхан харц шиг

Яргуй нүдлэн мишээж

Ханшийн ногоо нярайлсан

Хаврын тал нялхарна”

гэж хаврын тухай өгүүлжээ. Энд орсон үг бүр хаврын шинэ, аяс намуун байдал, ургаж төлжих шинжийг нь бүгдийг илтгэн гаргаж чадахуйц тийм үгс байна. Яргуйн нүдэлснийг янагийн харцтай зүйрлэсэн, ногоог “нярайлсан” гэсэн энэ бүхэн үг бүрийг хичнээн онож тавьсныг илтгэхээс гадна хаврын тухай хачин уянгалаг сайхан сэрэл сэтгэлгээ төрүүлж чадаж байгаа нь гайхалтай. Ингэж өгүүлж буй зүйлийнхээ тухай төсөөтэй уянгалаг санаа төрүүлж чадахуйц үгсийг сонсож олж шүлэглэдэг учраас түүний дууны шүлэг ихэд алдаршжээ.

Д.Пүрэвдоржийн дууны шүлгийн өөр нэг содон шинж нь түүний шүлгийн хайрцагт бий. Дууны бараг бүх шүлэг нь Монголын уламжлалт шүлгийн хэлбэр болсон ягштал толгой холбож дотоод хэмнэл цохилтыг тааруулсан байдгийг хатуу мөрдсөн нь ажиглагдана. Тэр

байтугай толгой сүүл хоёрыг холбож бичсэн нь ч их бий. “Алтан шар зам” дуунд

“Үүрийн цагаан туяа юу

Амар сайхан тал байна

Үерийн усны шаагиа юу

Амуу тарианы шаргиа байна...

гэхчлэн зургаан бадаг шүлгийг цөмийг толгой сүүл ягштал холбож бичжээ. Ийнхүү хайрцаглаж бичих нь ая хийхэд тун хялбар бололтой. Дууны шүлгүүдэд нь олныг уриалж дуудсан дайчин бадрангуй аяс нэвт байдаг нь олон түмэнд дуулагдах нэг жигүүр нь болдог ажээ.

“Биднийг дуудаж байна” дуунд

“Анхны шангаар үр амилж

Атрын шимээр түрүү өргөж

Намрын тал тариа атгаад

Намайг чамайг нааш ир гэж байна

Залуу найзаа замд гарья

Заавал тийшээ хамт явъя”

гэх мэтчилэн хөдөө нутагт очиж ажиллаж амьдрахыг уриалан дуудсан байдаг. Энэ нь нөгөө талаар цаг үеэ илэрхийлэх амьсгал нэвт байгааг харуулж байна. Ер нь дууны шүлэг цаг үетэйгээ их нягт холбоотой зохиогддог бололтой. Д.Пүрэвдоржийн дууны олон шүлэг цаг үеэ ингэж тусгаж чадсан байдаг төдийгүй тэр цаг үеийнхээ шалгуурыг даваад үлдэж чаддаг нэг увдистай. Энэ нь түүний ур чадал утга санааны нягт зохицолдоонд байдаг ажээ.

Ер нь яруу найрагч цаг үеэ илэрхийлж урлан бүтээдэг нь хууль жамтай хэрэг биз ээ! Харин уран бүтээлдээ амьдруулан гаргасан тэр цаг үе нь дараа дараагийн үеийнхэнд гоо сайхны тов тодорхой сэтгэлгээ төрүүлж уран дүрээр амилан босч байвал тэр бүтээл цаг үеийн шалгалтыг давж мөнхөрдөг бизээ! Д.Пүрэвдорж “Хар цас” найраглалдаа өгүүлсэнчлэн:

“Сурагчийн цүнхийг хоёрдугаар дайнтай

Сургууль руугаа үүрч явсан”

Тэр үеийнхээ тухай тодорхой дүрсэлсэн билээ. Тэрбээр уран бүтээлийн амьдралын гуч гаруй жилийн хугацаанд “Хаврын дуу” (1956), “Улаан оч” (1958), “Шүлгүүд” (1960), “Талын туяа” (1962), “Жигүүрт цагаан гэр” (1966), “Түмэн баатрын дурсгал” (1968), “Нар тойрсон зам”

(1970), “Хээрийн цай” (1972), “Сэгс цагаан богд” (1976), “Зэсэн уулын бичээс” (1980), “Алган дээр буусан од” (1982) гэсэн яруу найргийн арав гаруй түүвэр “Бужаагийн ярьсан домог”, “Бяцхан аялал” зэрэг хүүхдэд зориулсан дөрвөн ном хэвлүүлжээ.

Д.Пүрэвдоржийн яруу найргийг ширхэгчлэн унших юм бол яруу найрагчдын хувь тавилан ёсоор намтар түүх, амьдрал, дүр төрх ер аль бүгд нь цөм түүнд шингэн уусчээ. 1933 онд Өвөрхангайн Бүрд суманд төрж 1965 онд ЗХУ-ын М.Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургууль төгссөн зэрэг бид бүхний түүний намтрын худаснаас олж үзэх бүхэн цөм яруу найрагт нь шингэсэн байна.

Д.Пүрэвдоржийн оновчтой уран, цэцэн цэлмэг хэллэг, санаатай яруу найраг нь Монголын яруу найргийн “цэцэрлэгт хүрээлэнд” өвөрмөц содон үнэр амт бүхий аль ч талаараа хүмүүсийг дэргэдээ байнга татах тийм цэцэгс болон дэлгэрчээ. Түүгээр ч зогсохгүй тэдгээр цэцэгсийн үндэс өөр бусад хажуугийн залуу цэцэгст шим шүүсээ өгсөөр байнам. Зөвлөлтийн яруу найраг судлаачид өөрсдийнхөө яруу найрагчдын тухай бичихдээ, ялангуяа утга зохиолд тодорхой хувь нэмрээ оруулж улмаар олон түмнийг өөрийн нөлөөнд багтай оруулж чадсан тийм нэр хүндтэй том яруу найрагчдынхаа тухайд “өөрийн сургуулийг би болгосон яруу найрагч” гэж бичсэн нь тааралддаг. Монголын шинэ үеийн яруу найргийн хувьд тийнхүү өөрийн сургуулийг бий болгосон яруу найрагч хэдэн арваар тоологдох биш хэрнээ ч хүний гарын арван хуруунд багтан тоологдох, хэмжээтэй төрөн гарсан нь эргэлзээгүй. Тэдний нэг нь бидний энд товчхон танилцсан яруу найрагч Д.Пүрэвдорж гэдэгт эргэлзэх хүнгүй бизээ. Яруу найргийн залуу халаа дотор Д.Пүрэвдоржийн яруу найргийн арга барил, содон соргог тал өөрөөр хэлбэл суралцаж болох эрдмээс нь аль болохоор их хүртэх гэсэн тийм залуу олон байгаа нь харагдсаар байна. Харин тэдэнд хандаж Д.Пүрэвдорж:

-”Хорвоо бүх талаараа ав адилхан хоёр хүнийг хэзээ ч төрүүлдэггүй юм шүү” гэж байнга зөвлөж байх нь сонсогддог. Үнэхээр ч ав адилхан хоёр яруу найрагч төрж гэмээнэ нэг нь илүүдэх нь гарцаагүй. Тийм учраас яруу найрагчийг дууриах биш түүний уран чадвараас бүтээлчээр сурах хэрэгтэй юм. Тийнхүү бүтээлчээр сурвал зохих эрдэм БНМАУ-ын төрийн шагналт яруу найрагч Д.Пүрэвдоржид энэ хэдхэн хуудсанд дурдсанаас хавьгүй олон бий гэдэгт хэн ч үл эргэлзэнэ. Д.Пүрэвдорж үг эзэгнэх эрдэмд үнэхээр мэргэжсэн яруу найрагч.

Д.ЦЭНД

Монгол улсын төрийн шагналт, профессор

Д.Пүрэвдоржийн “Чингис” шүлгийн тухай

Оршил. Д.Пүрэвдорж анхны хэвлэгдсэн “Алтан намар” шүлгээрээ (1954) уншигч түмэндээ хүрсэн ховорхон авьяастай яруу найрагчдын нэг билээ. Энэ шүлэгт нь хөгжмийн зохиолч Мясүрэн ая зохиож, тэр дуу өдгөө 40 гаруй жил радиогийн алтан санд орж, орон даяар түгэн дуулсаар байгааг хэн бүхэн сайн мэдэж байгаа. Гэвч яруу найрагчийн төгөлдөр алдрыг авчирсан гол бүтээлийн нэг нь “Чингис” шүлэг (1962) гэж би үздэг юм. Үүний учир уг шүлгийн тухай өгүүлье.

Зохиосон түүх. 1961-1963 онд миний бие Москва хотноо Утга зохиолын дээд курст,

Д.Пүрэвдорж Утга зохиолын дээд сургуульд суралцаж, оюутны байранд хамт амьдарч байлаа. Энэ үед манай улсын түүхэнд онцлог явдал нэлээд гарлаа. 1961 оны намар ЗХУКН-ын (хуучин нэрээр) 21-р их хурал хуралдаж нэг хүнийг тахин шүтэх үеийн хор нөлөөг шүүмжлэн үзлээ. Уг хуралд МАХН-ын төлөөлөгчид оролцож, 1962 оны эхээр Төв Хорооны бүгд хурлаар маршал Чойбалсанг тахин шүтэж байсан үеийн хэлмэгдлийг цагаатгах их ажлын эхлэл тавьсан нь нийгмийн амьдрал түүхийг эрүүлжүүлэх чухал эхлэл болсон юм. Энэ үеэр манай Улсыг НҮБ-д гишүүнээр элсүүлсэн нь даян дэлхийд цуурайтсан, Монголын нэр хүндийг өргөсөн түүхэн хэрэг явдал боллоо. Тэгж байтал МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны (хуучин нэрээр) 52-р тогтоол гарч, Монголын тулгуур төрийг үндэслэн байгуулагч Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэх шуугиан дэгдлээ. Тогтоолд энэ түүхэн ойг 6-р сард тэмдэглэх, ойд зориулан эрдэм шинэилгээний бага хурал хийж, материалыг товхимол болгон хэвлүүлэх, төрсөн нутаг Дэлүүн болдогт дурсгалын хөшөө босгох, Чингисийн амьдрал үйл ажиллагааг харуулсан шуудангийн марк гаргахыг заасан нь бид бүхний сэтгэлийг их хөгжөөж билээ. Энэ бүх үйл явдал авьяас билэгт яруу найрагч Д.Пүрэвдоржийн онгодыг дуудаж, сэтгэлийн утсыг доргиогоогүй гэж хэлэх үндэс байхгүй гэдэгт итгэнэ. 1962 оны 2-р сард юмсан. Нэг өдөр Д.Пүрэвдорж бид хоёр Бутырийн захаас гар нядалгааны хонины мах авч хоол хийхээр тохиролцон чиглэлийн таксинд суув. Замдаа Д.Пүрэвдорж:

-Би урд шөнө ийм шүлэг бичлээ гээд “Чингис” шүлгээ уншиж өгөв. Үнэхээр өө сэвгүй сайн шүлэг болжээ гэж би дэмжээд:

Оонын халиун зоо шиг халхын уудам талд

Онгин цагаан тамга гэрээ тэр барьсан юм

Онон голын шугуйд хур шиг шаагих адуунаас

Онгон хоёр загалыг мөнгөн хяруунд сойсон юм

гэсэн бадгийг дор нь цээжилж Д.Пүрэвдоржид урам хайрласан билээ. ингэж би энэ мөнхийн бүтээлийн анхны сонсогч, бас анхны шүүмжлэгч (дэмжигч) нь болсон юм.

Хэвлэгдсэн түүх. 1962 оны 5-р сарынд хамт суралцаж байсан зохиолч нөхдөд МЗЭ-ийн Хорооны дуудлага уриалга ирж, тэд маань МЗЭ-ийн 3-р их хуралд оролцохоор Улаанааатрыг зорилоо. Д.Пүрэвдорж, Д.Төмөр-Очир гуайн хүү Т.Галбадрахтай нэг өрөөнд суудаг байсны хувьд хүүгийн захидлыг авч явсан билээ. Нутагтаа очоод хүүгийнх нь захидлыг хүргэж өгөхөөр Д.Төмөр-Очир гуайнд очихдоо “Чингис” шүлгээ унших завшаан гарсныг Д.Пүрэвдорж бахархан хуучилсан юм. Д.Төмөр-Очир гуай уг шүлгийг сонсоод:

Чингис-нумын хөвчинд төрсөн юм

Чингис-сумын зэвэнд төрсөн юм

Чингис-Өэлүн эхээс төрсөн юм

Чингис-өрлөг түүхээс төрсөн юм

гэсэн бадгийн нумын хөвчинд, сумын зэвэнд төрсөн юм гэснийг төрөөгүй юм гэвэл зүйтэй байх гэж зөвлөгөө өгсөн нь үнэхээр хашир ухаантай хүний сайхан сэтгэлийн илрэл болсон байна. Их удалгүй уг шүлэг “Соёл утга зохиол” сонины 1962 оны 6-р сарын 1-ний дугаарт хэвлэгдсэн болно. Энэ шүлгийг хэвлэгдэхэд зарим хүмүүсийн таамаг яриа болох Д.Төмөр-Очир гуайг тусалсан гэж үзэхээс өмнө Намын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоол гарсан нь илүү нөлөөлсөн гэж үзэх нь түүхэн үнэнд ойртох болно.

Хэлмэгдсэн түүх. Д.Пүрэвдорж “Яруу найраг бол баяр гунигийн агшнаас ургасан санааг сэтгэлийн уянга, үгийн ид шидээр гоо сайхны ертөнцөд өргөмжилсөн уран өчиг юм” гэж бичсэн нь буй. “Чингис” шүлэг бол чухам үүний баталгаа болсон бүтээл билээ. Гэтэл МАХН-ын Төв хорооны (хуучин нэрээр) 1962 оны 2-р сарын 3-р бүгд хурлаас “Д.Төмөр-Очир үндсэрхэх үзлийг хөхүүлэн дэмжих гэж эрмэлзжээ” гэсэн дүгнэлт өгч энэ талаар хань хамсаатныг илрүүлэх их ажил эхэллээ. Д.Пүрэвдорж маань “Чингис” шүлгээ Д.Төмөр-Очирын даалгавар зөвлөгөөгөөр бичсэн гэдэг хилс хардлагад өртлөө. Москвад суугаа элчин сайд С.Лувсан гуай Д.Пүрэвдоржийг дуудаж асуугаад Монголд хариу өглөө. Дараа нь бас НХШХ-ны дарга Н.Лувсанравдан дуудаж чи “Чингис” шүлгээ Д.Төмөр-Очирын даалгавараар бичсэн үү?, яах гэж түүнд уншиж өгсөн бэ? гэж асууж байцаасан ч явдал боллоо. Улмаар Үзэл суртлын ажилтны улсын зөвлөлгөөнд (1963 оны 1-р сар) МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Б.Лхамсүрэн “Намын үзэл суртлын ажлын одоогийн зорилт” илтгэлдээ “Үндсэрхэх үзлийн илрэл амь бөхтэй байгаагийн гол илрэл нь Чингис хааны төрсний 800 жилийн ойг тохиолдуулан Д.Төмөр-Очир болон түүнийг аялдан дагагчдын зориуд дэгдээсэн үндсэрхэх үзлийн хэнээрхэл мөн. Сүүлийн үед манай утга зохиолд бидний үзэл сурталд харш, үндсэрхэх үзлийн амьсгал нэлээд гарах болжээ. Чингис хааныг шагшин магтсан яруу найрагч Д.Пүрэвдоржийн шүлэг нь үүний тод илрэл болно” гэж дүгнэснээр Д.Пүрэвдоржийг орон даяар үндсэрхэх үзэлтэн гэж зарласан байна. Уг зөвлөлгөөнд ЗХУКН-ын Төв Хорооны (хуучин нэрээр) нарийн бичгийн дарга Л.Ф.Ильичев хэлсэн үгэндээ “Утга зохиол урлагийн бүтээлийн дээд зэргийн шүүгч нь хэн бэ, утга зохиол урлагийн бүтээлийн дээд зэргийн шүүгч нь ард түмэн, нам хоёр болж таарна шүү дээ” гэсэн нь даарин дээр давс нэмэх гэгж боллоо. Дараа нь 1963 оны 3-р сард МЗЭ-ийн Хорооны 2-р бүгд хуралд тавьсан “Үзэл суртлын ажилтны Улсын зөвлөлгөөний дүн, Монголын зохиолчдын зорилт” илтгэлд Ч.Чимид МАХН-ын үзэл суртал Марксизм-Ленинизмд харш үндсэрхэх үзлийн амьсгал зохиолчдын бүтээлд гарсаар байсныг Үзэл суртлын ажилтны улсын зөвлөлгөөнд эрс буруушаасан билээ. Үүнд “Д.Пүрэвдоржийн бичсэн “Чингис” шүлэгт үндсэрхэх үзлийг баримталж сурталчлах оролдлого илэрхий гарчээ” гэж тэмдэглээд Монголын зохиолчид социалист реализмын аргыг улам тууштай эзэмших явдал бол манай утга зохиолын үзэл суртлын хэмжээг дээшлүүлэх найдвартай арга зам мөн” гэж тодруулан заасан байна. Бас 1964 оны 6-р сард болсон Нийгмийн ухааны багш нарын Улсын зөвлөлгөөнд “Хэл зохиолын багш нарын дотор үндсэрхэх үзэлд татагдан орж хэл зохиолын эртний судар номоос хальт мулт тогтоон авч түүнийгээ монголын соёлын охь манлай болгон сурталчлахыг оролдож гуйвуулдаг байна. ЕБДС-ийн утга зохиолын хичээлийн хөтөлбөрөөс Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдлыг магтан дуулсан Д.Сэнгээгийн “Өвгөн партизаны яриа” шүлгийг хасаад үндсэрхэх үзлийг илэрхийлсэн Д.Пүрэвдоржийн “Чингис” шүлгийг заахаар завдаж байсан байна” гэж буруутгасан байна. Энэ бүхний дүнд Д.Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол”

бүтээлийг хэвлэхийг хорьж “Чингис”, “Тусгаар тогтнол” шүлгийг Хэвлэл утга зохиол хянах газар хориотой бүтээлээр угтаж авлаа.

Төгсгөлд өгүүлэх нь. 1990 он ХҮШ жарны цагаан морин жил Эзэн богд Чингис хааны алтан ургийн түүх, “Монголын нууц товчоо” зохиолын 750 жилийн ойн ЮНЕСКО-гийн шийдвэрээр дэлхий дахинаа тэмдэглэсэн билээ. Энэ их ойд МЗЭ-ийн Хороо зохиолч, яруу найрагчдын дунд уран бүтээлийн уралдаан зарлаж шалгарсан бүтээлүүдээр нь сударчилсан эмхтгэл гаргаж бэлэг барьсан юм. Шилдэг бүтээлийг шалгаруулах уралдааны комисст ажиллаж байхдаа тэр олон бүтээлээс тэртээ 1962 онд Д.Пүрэвдоржийн бичсэн “Чингис” шүлгийг давах бүтээл гараагүйд нэг талаар харамссан боловч нөгөө талаар бахархсан билээ. Тийм ээ! Цагийн шалгалт давсан шилдэг бүтээл мөнхөрдөг жамтай. Д.Пүрэвдорж “Чингис” шүлэгтээ:

Чингис-Өндөр Алтайн зартай юм

Чингис-Өнөөдөр ч гэсэн нэртэй юм

Ямар ч байсан Хангарьд шиг хальж

Ял гавьяа хоёроо хойч үедээ даатгасан юм.

гэж бичсэн нь хойч үе бидэнд эзэн богд Чингис хааны тухай ярих судлах, сурах дээдлэх бичих туурвих ихээс их буйд итгэнэм.

1994 оны 1 сарын 22. Улаанбаатар хот

Дэндэвийн Пүрэвдорж (“ХХ зууны монгол зохиолчид цуврал” №91. УБ)

С.ЭРДЭНЭ

Монгол улсын төрийн шагналт, ардын уран зохиолч

Найрагчийн сэтгэл

Д.Пүрэвдорж бид хоёр бол Монголын орчин үеийн утга зохиолд зулай зулайгаа гишгэж төрсөн ах дүү шиг хоёр билээ. Би түүнээс цөөхөн жилийн түрүүнд мөн яруу найрагчийн нэр зүүсэн юм. Тавиад оны дунд үеэс Пүрэвдорж анхныхаа шүлэг найраглалуудыг хэвлүүлж эхлэн, уншигчдын дунд ойрхон зуур нэрд гарсан. Ингэхээр бид манай утга зохиолын дунд үеийн зохиолчдын дунд зүй ёсоор “толгой холбосон” гэж болно.

Зөвлөлтийн нэрт яруу найрагч Евгений Долматовский Чойжилын Чимидэд бичсэн нэг захидалдаа “Сайхан орны сайхан яруу найрагч явахаас илүү хувь заяа үгүй” гэж бичсэн байдаг. Д.Пүрэвдорж бол миний үеийн сайхан яруу найрагчдын нэг. Утга зохиолд үе үеийнхэн өөрийн онцлог дуу хоолойтой, өөр өөрийн сэтгэлтэй байдаг. Д.Пүрэвдоржийн иргэний болоод яруу найрагчийн сэтгэл нь жинхэнэ монголын ард түмний үр садын сэтгэл, эх орон, ард түмнээ гэсэн насан туршийн ариун санаа амьдрал бүтээлийг нь гуйвуулалтгүй хөтлөн эрийн цээнд хүрснийг шүлэг зохиолынх нь мөр бадаг бүрт яруу сайхан сонсголонтой

уянгалан байдгийг тод тодорхой мэдэж болохоор цэцэн билэгт яруу найрагч билээ. Би анд сайн нөхрийнхөө бичсэн зохиол бүтээлийг алгасалгүй харж, сэтгэл нийцтэй, гаргууд уран ухаалаг мөр бадаг бүрт нь урамших бүрдээ урамшин, өөрөө түүнд нь ямар нэг хамаатай юм шиг баярлан жаргадаг. Ер нь ч бид тус тусдаа өөр барил, амьдрал юмсыг харах өөр өөрийн хараатай гэлээ ч мөн тус тусынхаа бүтээл туурвилын олз омогт ямар нэгэн талаар хамаатайгаа ухаарч, түүндээ бас ч урамшиж, бардамнадаг зантай хүмүүс юм. Тийнхүү нөхрийнхөө олз омгоор бүтээхийн урам зориг ордог тухай бид ярих дуртай. Бидний хүн ёсны үерхэл утга зохиолын үерхэл болж өчнөөн жил өнгөрөхөд хэн хэнд маань бас ч эргэлзэл самгардал тохиолдож байсан үе бий гэлээ ч бие биедээ ухаан чадлынхаа хирээр тус дэм болж явдаг тэр заншил маань алдав ч онож, алгасав ч нөхөж чадах уран бүтээлийн болоод иргэний хатуужил тэсвэр сэтгэлийн хүч сэлбэхэд тус болсоор байна. Бид хэн нэгнийхээ бүтээлийг жинхэнэ нөхөр ёсны болоод хэрдээ туршлагатай, өөрийн толгойтой бүтээлчийн хувиар, эх орон ард түмнийхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа муугүй ухаарсан уран бүтээлчийн хувиар цэгнэн харж, алдсан эндсэн дээрээ хэлэх үгтэй, нэгнийхээ тэр үгийг үг болгож авах савтай гэж би боддог. Энэ бол сайхан хэрэг. Нөгөөтэйгүүр хэн хэнийхээ аятайхан бүтээлд үнэн зүрхнээсээ баяр хөөр болж, нөхөр маань ийм сайхан юм бичсэн байхад би юундаа хоцордог юм гэсэн уралдааны аазгай бүтээлч атаархал төрдөг. Бүтээлч атаархал гэж нээрээ бий шүү. Тэр бол уран бүтээлч хүн ёстой уужим сэтгэлийн үүднээс чөлөөтэй баймаар хар амины өчүүхэн атаа жөтөөнөөс даанч дээгүүр зүйл юм. Жараад оны дундуур Пүрэвдорж “Хар цас”, “Хөх даалимбан тэрлэг” гэдэг хоёр сайхан найраглал бичиж билээ. Би тэр найраглалуудыг нь уншаад баярлахын дээдээр баярлаж, нөхрийнхөө яруу найрагчийн сэтгэл, үг хэлний яруу тунгалаг, дүрслэлийн нарийн нандинг хэзээ хэзээнээс илүү ойлгож, түүнээс нь дутуугүй сайхан өгүүллэг, тууж бичих юмсан гэж хичээж байж билээ. Магадгүй тэр бүтээлч атаархал жараад оны сүүлчийн миний бүтээлд ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн билээ.

Яруу найрагчийн сэтгэлийг ойлгох ч бас хялбаргүй. Бүхэл бүтэн ертөнц учраас тийм юм. Тэр бүхэл бүтэн ертөнцийн мөн чанарыг харуулсан. Найрагчийн бүтээлийн их далайгаас алт сувдыг олж үзсэн уншигчийн баяр жаргал яруу найрагчийн сэтгэлийн халуун илч болж, дулаацуулдагт ерөөс яруу найраг гэгчийн ид шид оршино.

Д.Пүрэвдоржийн энэ номд уран бүтээлийнх нь гучаад жилийнх нь тайлан болох туульсын, уянга туульсын, уянгын, түүх хувьсгалын зэрэг олон янзын сэдэв, хэлбэртэй гучаад найраглал оржээ. Эдгээр найраглал яруу найрагчийн сэтгэлийн бүхэл бүтэн ертөнц, иргэний мөн чанарыг нь тольдон харуулсан яруу дуулал мөн. Ийнхүү миний бие анд сайн нөхрийнхөө номыг уншигч олонд толилохын баярыг бэлэгдэн энэхүү товчхон оршил үгийг бичсэн хэрэг бөлгөө.

“Хөх даалимбан тэрлэг” түүврийн өмнөх үг. УБ. 1984

Б.ЯВУУХУЛАН

Монгол улсын төрийн шагналт яруу найрагч

Сэгс цагаан богдын учир

Алс Африкийн Климинжирогийн цаст уулыг Эрнест Хэмингуэй зүүдэлдэг байжээ. Хэмингуэй залуу зандан үедээ энэ ууланд арслан бар агнаж явсан хүн билээ. Хэмингуэй хожмын дурдатгал зохиолууддаа энэ уулыг олон дахин дурсан бичсэн байдаг. Үүнээс болоод ч тэр үү Эрнест Хэмингуэйн зохиолыг уншихлаар Климинжиро уул нүдэнд үзэгдэн, Климинжиро гэдэг нэр сонсохлоор Эрнест Хэмингуэйн үсэн буурал дүр нүднээ буудаг билээ. Юу ч болсон цасан уул цал буурал зохиолч хоёрын дүр ийнхүү зохицжээ.

Энэ тухай үл өгүүлэн өгүүлэх нь: уншигч таны өмнө манай нэрт яруу найрагч Дэндэвийн Пүрэвдоржийн “Сэгс цагаан Богд” гэдэг шүлэг найраглалын шилмэл түүвэр дэлгээтэй байна.

Энэ сайхан яруу найрагчийн уран бүтээлийн тухай товч өгүүлэх хүндтэй үүрэг надад ногджээ. Том бөгөөд өргөн цараатай юмын тухай өгүүлэхэд цөөн үг хомсдох нь бий. Яруу найрагчийн “Алтан намар” гэдэг анхны шүлэгт нь хөгжмийн зохиолч Мяасүрэн ая оруулж олонд дэлгэрснээс хойш “Хаврын дуу”, “Улаан оч”, “Талын туяа”, “Шүлгүүд”, “Түмэн баатрын дурсгалд”, “Жигүүрт цагаан гэр”, “Нар тойрсон зам” зэрэг шүлэг найраглалын эмхтгэлүүд нь нийтлэгдэж манай яруу найргийн хөгжилд мэдэгдэхүйц нэмэр хандив оруулж уншигч олны хайр талархлыг хүлээжээ.

Д.Пүрэвдоржийн уран бүтээлийн сэдэв санааны цар хүрээ маш өргөн, урлах эрдмийн хувьд өвөрмөц билээ. Богино хэлбэрийн уянгын дууны үгээс эхлээд шүлэг, дууль, найраглал, магтуу, дуурийн цомнол цөм бий. Богд уулын аман дахь Зайсан толгой дээрх хөшөөнд “Энд Зөвлөлтийн дайчдын дурсгалыг тэнгэрт нартай хамт мөнхлөв. Газарт галтай хамт дархлав” гэсэн хөшөөний үг нь бий.

Д.Пүрэвдорж нь яруу найргийн энэ олон хэлбэрээр эх орон нам засаг, ард түмнийхээ хөдөлмөр жаргал, Зөвлөлт-Монголын ард түмний ган бат найрамдлыг магтан дуулсан юм. Төрж өссөн нутаг “Эрээн уулынхаа тухай” шүлэгтээ:

Өөрөө ойчоод анх уйлаагүй

Өчүүхэн зориг минь тэнд бий

Өрөөлийн дэмгүй өндийж босоод

Өөрийгөө шагнасан урам минь бий.

Уулын хүйтэн шандад нь

Уруулын минь улбаа бий

Усыг нь уух гэж тонгойход

Ургаж үлдсэн дүр минь бий гэж орчлонд анх өлмий тавьсан эх нутгаа сэтгэлд ургам магтан дуулжээ. Д.Пүрэвдоржийн уран бүтээлд богино хэлбэрийн найраглал чухал байр эзэлдэг. Түүний “Хөх даалимбан тэрлэг”, “Гэргий”, “Төрийн түмэн эх”, “Сэгс Цагаан Богд”, “Хар цас” зэрэг найраглалыг нь үй олон уншигчид сайн мэддэг билээ. “Хар цас” найраглалдаа

дэлхийн хоёрдугаар дайнд Зөвлөлтийн ард түмэн улаан арми хэрхэн баатарлаг ялсан тухай бичихдээ:

Хорьдугаар зууны бүх төмрөөр

Хоёрдугаар дайн буудсан бус уу

Уулыг тал болтлоо дайтаж

Улаан арми давшсан бус уу гэж бичсэн юм.

Д.Пүрэвдоржийн уран бүтээлийн өнгө зүс хэлний өвөрмөц байдлыг уран зурагтай харьцуулан жишвэл монгол хавтгай зурагтай төстэй юм шиг санагддаг. Энд нэг жишээ болгон “Говийн өндрөөс зурсан зураг” гэдэг шүлгийн хэдэн бадгийг уншаад үзье.

Орой дээр мандсан тэр нарыг

Огторгуйд өргөсөн тооно гэвэл

Арван зүгтээ цацсан туяа нь

Алтан мөнгөн унь нь байв

Өргөн сайхан өргөө гэвэл

Өнгө ч сайтай, амьдрал ч сайтай

Өөдөлж яваа айл байв

Үүл суусан өмнө хаяагий нь

Үүд дарсан тотго гэвэл

Халдаж болохгүй алтан босгыг нь

Харуулын цэрэг манаж байв гэж зураглан өгүүлжээ.

Бас “Сэгс Цагаан Богд” найраглалд нь ийнхүү олон өнгийн хавтгай зураг мэт зураглалууд их бий.

Өчүүхэн энэ оршлын эхэнд Алс Африкийн Климинжиро уулыг дурссан минь учиртай. Авьяас билиг төгс уран бүтээлчийн уран бүтээл эсвэл тэнгис далайтай, эсвэл тэнгэр газар, уул устай уялдан зүйрлэгдэж, тэр нь уг уран бүтээлчийн уран бүтээлийг тод томруун илэрхийлдэг билээ.

Д.Пүрэвдоржийн уран бүтээл “Сэгс Цагаан Богд”-той уялдан сэтгэлд бууж байна. Сэгс Цагаан Богдын учир ийм юм.

Монгол улсын төрийн шагналт

яруу найрагч Бавуугийн Лхагвасүрэн

Номын тотгонд өргөх үг

Тэр жил японуудтай говь төслийн экспедицийн бүрэлдэхүүнд оролцож Өвөрхангайн Бүрд сумийн нутагт Эрээн уулын энгэрт хэжиж явахдаа Хажуу худаг гэдэг гадаад энгэртээ төгөл модтой дотоод хормойдоо налгар хондтой ургах нар тоссон аманд очиход минь энд Дэндэвийн Пүрэвдорж төрсөн юм гэж нутгийн буурал өвгөн надад гайхуулж билээ...

Ийнхүү би цэцэн цэлмэг найрагч Д.Пүрэвдоржийн

“Хажуу худгийн налгар хондонд

Хана шийрлэсэн буурь минь бий...”

гэж дуулсан “мөр” дээр нь гишгэж үзсэн юмсан. Д.Пүрэвдорж найрагч тэнд нар тосон унасан юм билээ... Эрхэтгүй би вээр яруу найрагч ухаантай юм тул, их найрагчийн тухай сэрдхийн бодож, Эрээн уулын бэлд хатгасан майхан дотор, түүний тухай бодлоор хөрвөөж

“Хавар намартаа цасан сархиагт

Харлаг тахь шиг эрээн уултай нь”

Шөнөжин шивнэлдэн хонож билээ...

Эрээн уулнаас би асууруун: - Багадаа ямар хүүхэд байсан бол гэлээ.

Эрээн уул өгүүлрүүн: Зовхи нь өдрийн өрх шиг дандаа татаастай зүггүй хүүхэд байсан. Дүүтэйгээ хоёулхнаа эхийнхээ хоёр талд сүүний туяа татуулан зүүгдэн дүрлийсэн дөрвөн алаг нүд гялалзуулж өссөн... хөөрхөн хүүхдүүд байсийм гэв.

Би асууруун: Найрагч болохын суу заль нь таньд мэдрэгдэж байсан болов уу?

Эрээн уул өгүүлрүүн: их үгтэй, хурц хурдан зантай. Насандаа ахадсан ухаалаг хүүхэд байсан. Жигүүрээ дэлгэж эхлүүт эрдмийн мөр хөөж, хот руу гарч өгсөн дөө!

Би асууруун: Эрээн уул тандаа, эргэж дандаа ирдэг үү?

Эрээн уул өгүүлрүүн: Ирэхээр барах уу, уул зүүд үздэг юм. Ирэхгүй өнжсөн жилээ шүлэг алдар хоёр нь зүүдэнд ирдэг, их санахын үед өөрөө хүрээд ирдэгийм...

Нутаг амьтай хүү шүү!

-Ийн ярилцсаны дараа надад нэгэн дурсамж буув. Миний бие нэгэн шалдар амьтан 1968 онд Зохиолчдын хорооны үлгэрийн танхимд ажиллах болсон юм... Ингэж аз тохиож, Бурхад хэмээн холоос бодогддог байсан том зохиолчдын дэргэд буруу зөв хоёртой нь хутгалдаж эхлэж билээ. Нэгэн өдөр Зохиолчдын хорооны аж ахуйн хашаанд очиж, “Бор” ажил хийж, мод хураалаа. Үд болж байхад аж ахуйн хашаан доторхи гэрээс сайхан ааштай нэгэн хөгшин, - Хүүхдүүд цай уу? гэж бидний хэдийг гэртээ залав.

Хос Аюуш, бурхан хоймороо залсан тэр цэмцгэр гэрт ууж идэж удаан ярьж сууж билээ... Тэр хөгшин –Миний нэг хүү “улсын худалч”, нөгөө нэг нь бөмбөг цохьдог хүн гээд л ярьж гарсан... тэр буурал хөгшин яруу найрагч Д.Пүрэвдорж гуайн ижий Довдмаа гуай байж билээ... Найрагч Д.Пүрэвдоржоос нь “банга” хүртэж явсан өдөр бий, найрагчийг төрүүлсэн ижий нь гарын цайг ууж баярлаж явсан өдөр надад бий...

Эрээн уулнаас би асууруун: Д.Пүрэвдорж найрагчийг “урд газрын цустай” гэж зарим хүмүүс дайрч байхыг би сонссон...

Эрээн уул хэлрүүн: Алдас хийж байна тэр хүмүүс чинь... Аав нь алаг нүдэн Дашдорж гэж дээлтэй Бурам явсийм...

Би асууруун: Хийсэн бүтээсэн бүхний нь дотроос юунд их баярладаг бол та?

Эрээн уул хэлрүүн: Их хэцүү цагт, эзэн богд Чингист анх шүлгээ өргөсөнд нь баярладаг гэвэй...

Ийн ярилцсаны дараа надад нэг дурсамж буув. Бэгзийн Явуухулан багш таалал болсноос хойш хоёр жилийн дараа миний хоёр дахь ном гарах болоход “муу нэрт” надад номыг минь редакторлах дуртай хүмүүс ховор байсан цагт Д.Пүрэвдорж найрагч: -Явуу анхны номыг нь редакторласан юм, найрагч нөхрийнхөө шавийн номыг би үзэж өгье! Янз бүрийн ярианд би өртсөн ч, Явуугийн зай миний сэтгэлд үлдсэн юм шүү! гэж билээ... Тэгээд номонд минь оршил бичиж сайтар уншиж болгоож өгч билээ. Тэхэд би хэдэн жилийн дараа Д.Пүрэвдорж найрагчийн номонд оршил бичиж сууна гэж даанч зүүдэлсэнгүй явжээ... Он цаг гэж...

-Явуу багшийн “Бидний хүсэл”, “Цэнхэр мандлын тэнгэр дор”, Д.Пүрэвдорж найрагчийн “Хаврын дуу”, “Таван од” гэдэг түүврүүдийг уншиж суухад элбэг торгоор байдаг л нэг дээл оёсон юм шиг санагддаг. Гэтэл эд маань Камчаткийн саахалт галт уулс шиг дэлбэрцгээж, шүлгэн галаар тургиж, ойр орчмын бяд муутайхан найрагчийг дарсан юм байна гэж надад бодогдсон... Явуу багш “Мөнгөн хазаарын чимээн” найргийн өргөөний дэргэд жингэнэж, “Хар ус нуурын шагшуурга”, “Тэхийн зогсоол”, Д.Пүрэвдорж найрагчийн “Шүлэг найраглал”, “Жигүүрт цагаан гэр” түүврүүд, “Хар цас”, “Хөх даалимбан тэрлэг” гараад ирэх үед тавь, жараад оны монголын яруу найргийн “шинэ хавар” эхэлсэн гэхэд хүн гайхахгүй... Найрагчийн шинэ хаврыг түүчээлж ирсэн олон галт уулсын тод нэг нь Д.Пүрэвдорж найрагч юм. Түүний шүлгийн тухай нэгэн зураач анд минь, -Д.Пүрэвдорж гуайн шүлгийг уншихаар, өнгө зөөлөрсөн дорнын торгон зураг дээрхи шувуу нь жиргэж, эрвээхэй нь хөдлөх шиг болдог гэсэн... Нэгэн жүжигчин, Д.Пүрэвдорж гуайн шүлгийг уншихад, хэл бүдрэх нэг гийгүүлэгч ч байдаггүй, цээжнээс Орхоны хүрхрээ шиг асгаран буудаг гэсэн... Нэгэн урлаг судлаач, Д.Пүрэвдоржийн шүлэг найраглал, Турфаны ханын зураг шүү дээ! гэсэн сэн... Эдгээр хүмүүс

шүлгийн нь цэлмэг, яруу, уянгалаг, хэмнэл тэгшийн тухай ярьсан хэрэг...

Шүлгийн нь доторхи хүүрнэлийн аяз, үйл явдлын ээдрээ бодлынх нь биз! Монголын яруу найрагчдад үгээр шүлэг бүтээгчид мэдээж олон. Түүний дотроос үгээс үг бүтээж шүлэглэдэг яруу найрагч ганцхан Д.Пүрэвдорж найрагч гэхэд маргах хүн цөөхөн гэдэгт би итгэж байна. Ийм найрагч аливаа орны уран зохиолд цөөхөн заяадаг бололтой юм билээ... Өнөө үед хүн – яруу найрагч хоёрын тэнцэлийн тухай хүмүүс их ярих болж... Хүний хувьд гуниглах цаг, гутрах үе, үнэн худал аливаад өртөх үед сэтгэлээ аварч чадах, сэтгэлийн хат “дархлалтай” болсон хүн бол Д.Пүрэвдорж найрагч юм. Тэр нуур цөөрөм толион дээрээ инээдээр давалгаалж, гүндээ орчилдон байдаг нэгэн тэвчээрт бодьгал бөлгөө.

Найргийн дархчуулын өрөөнд, ухааны дөщ, урын алх хоёр зүрх мэт цохилон байх нь яруу тунгалаг найрлыг дуурсгана. Монголын яруу найргийн дунд дурдахгүй орхивол, орон зай нь хэнээр ч нөхөж үл болох яруу найрагч Д.Пүрэвдорж билээ... Түүний оюун билгийн нуруу дээгүүр монголын яруу найрагч гэдэг олон шавьтай байдаг.

Зүтгэж ивээж, жигүүр ургуулсан шавь нараас нь гадна, бүтээлийн нь шавь нар гэж бас байдаг. Ийм шавь нараар бол баян найрагч. Арга буюу монголын яруу найргийн оргилуудын бэлийн нэгэн би вээр яруу найрагч Д.Пүрэвдоржийг “багш” хэмээн туршид дуудмуй! Үүнийгээ би аливаа нэгэн билбүүрдэл бус монголын яруу найрагт гүн хүндэтгэлтэй хандах сэтгэлийн зарлигаа дагаж байна хэмээн бодно.

Номын нь өмнөх үгийг бичиж суухдаа, ерөөлийн чихрийг амандаа хүлхэж, сэтгэлийн сүүгээ асган бичсэнийг уншигч авгай нар болгоох болтугай.Эрээн уул надаас асууруун:

-Миний элгэнд өссөн хүү, найргийн том уул мөн үү? гэлээ...

Би хэлрүүн:

-Би түүний хэмжээг тогтоох нэгэн бишээ. Сүрд нь дарагдах толгод билээ би... Тэрээр талдаа жижигхэн толгод, найрагтаа өндрийн өндөр уул билээ.... Та хоёр орой оройгоо харалцан суунам билээ гэвэй би...

Яруу найрагч Монгол улсын төрийн шагналт, ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн өлмий бат оршиж, найргийн хураар саамшиж, гэгээн хур асгаж яваг!

1997 оны Цагаан шүүдрийн намар цаг

Table of Contents

- [“Угтал” хэмээх ацаг бүлэг](#)
- [“Ургамал” хэмээх эгшиг бүлэг](#)
- [“Уймрал” хэмээх гийгүүлэгч бүлэг](#)
- [“Учрал” хэмээх цацлага бүлэг](#)
- [“Уцаарлал бичээс” хэмээх хаялага бүлэг](#)
- [“Учирлал” хэмээх дайвар бүлэг](#)
- [“Урамшил” хэмээх хашлага бүлэг](#)